

**МОНГОЛ УЛС ДАХЬ
ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ
БАЙДЛЫН ТАЛААРХ ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИССЫН
10 ДАХЬ ИЛТГЭЛ**

**УЛААНБААТАР ХОТ
2011 ОН**

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасны дагуу Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2011 оны илтгэлийг Комиссын 2011 оны 4 дүгээр сарын 15,18-ны өдрийн хурлаар хэлэлцэж Улсын Их Хуралд өргөн барьж байна.

2001 онд Монгол Улсад хүний эрхийн үндэсний байгууллага байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш өдгөө нэгэн арван өнгөрчээ. 10 дахь жилийнхээ ой дээр Комисс өнгөрсөн хугацаанд хүний эрхийн салбарт анхаарч ажилласан үндсэн асуудлууд, дэвшүүлсэн санал зөвлөмж, тэдгээрийн хэрэгжилтийг үнэлж цэгнэх нь өнөөгөө тодорхойлж, ирээдүйгээ харахад чухал билээ. Ийм учраас Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2011 оны илтгэлд өмнөх 9 удаагийн илтгэлээр Комиссын гаргасан зөвлөмжүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийлээ.

Энэ удаагийн илтгэлийг боловсруулахдаа Хүний эрхийн Үндэсний Комиссын зөвлөмжийн мөрөөр холбогдох байгууллагуудаас авсан арга хэмжээний талаарх мэдээлэл, статистик тоо баримт, ажлын тайлан, Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох зөвлөл, хороодод бэлтгэн хүргүүлсэн Монгол Улсын Засгийн газрын илтгэл, тэдгээрийг хэлэлцэж Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан зөвлөмж, дүгнэлт, иргэний нийгмийн байгууллагуудын мэдээлэл, судалгаа, хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээ баримт болон Комиссын хийсэн шалгалт, судалгааны үр дүн, цуглуулсан мэдээлэл, иргэдээс тус Комисст гаргасан гомдлыг эх сурвалж болгон бэлтгэлээ.

Илтгэл дөрвөн үндсэн бүлгээс бүрдэнэ. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт амьд явах, халдашгүй дархан байх, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх эрх зэрэг хүний салшгүй эрх;

Хоёрдугаар бүлэгт төрийн үйл хэрэгт оролцох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал цуглаан зохион байгуулах зэрэг улс төрийн эрх;

Гуравдугаар бүлэгт хөдөлмөрлөх, үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх, нийгмийн халамж хамгаалалд хамрагдах зэрэг эдийн засгийн эрх;

Дөрөвдүгээр бүлэгт үндэстний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, ахмад настан зэрэг бүлгийн эрхийг багтаасан болно.

Илтгэлд тусгасан асуудлуудад үндэслэн, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дүгээр зүйлийн 13.1-д заасны дагуу 7 зүйл санал, зөвлөмж гаргалаа.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

1. ХҮНИЙ ХУВИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

1.1 Цаазаар авах ял ба амьд явах эрх

Хүний эрхийн Үндэсний Комисс амьд явах эрх, ял шийтгэл ба хүний эрх гэсэн сэдвийн хүрээнд цаазаар авах ялын талаар 2007, 2009 онуудын илтгэлдээ тусгаж цаазаар авах ялтай холбоотой 3 санал, зөвлөмжийг Улсын Их Хуралд өргөн барьж, Хууль Зүйн Байнгын Хорооны 2008, 2010 оны хуралдаанаар хэлэлцүүлсэн болно.

2007 оны илтгэлийг Хууль Зүйн Байнгын Хорооны хуралдаанаар хэлэлцэж, тус хорооны 2008 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 6 дугаар тогтоолоор Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн тайлагналтад анхаарч, олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийг хангах, хариуцдаг салбар, хороодтой ажлын уялдааг ханган, Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлд тусгасан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, санал зөвлөмжийн биелэлтийг Хууль Зүйн Байнгын Хороонд ирүүлэхийг Засгийн газарт даалгасан байна.

2009 оны илтгэлийг Хууль Зүйн Байнгын Хорооны хуралдаанаар хэлэлцэж, тус хорооны 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 13 дугаар тогтоолоор цаазаар авах ялын талаар Комиссоос гаргасан санал, зөвлөмжийн тухайд шууд үүрэг болгон заагаагүй ч Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлд дурдсан хүний эрхтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарсан зөрчил, дутагдлыг арилгах, Хүний эрхийн Үндэсний Комиссоос гаргасан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан байна.

Комиссын 7 дахь илтгэлд орсон “Үндсэн хуулиар баталгаажсан эрх” бүлэг сэдвийн хүрээнд амьд явах эрхийн талаар тусгаж, түүнтэй холбогдуулан дараах санал, зөвлөмжийг гаргасан байна.

Зөвлөмж: Цаазаар авах ялыг гүйцэтгэх огноог нууцалж, цогцсыг ар гэрт нь хүлээлгэж өгөхөөс татгалзаж буй нь гэр бүлийн гишүүдийг сэтгэл зүйн дарамтад оруулж, хүнлэг бусаар хандахад хүргэж байгаа тул ял гүйцэтгэх огноог ил болгож, цогцсыг ар гэрт нь өгөх эрх зүйн зохицуулалтыг бий болгох; (2008)

Цаазаар авах ялыг гүйцэтгэх ажиллагаа нь Төрийн нууцын тухай хуулиар¹ төрийн нууцад хамаарсан хэвээр байгаа бөгөөд эрх зүйн зохицуулалт өөрчлөгдөөгүй байна.

¹ Төрийн нууцын тухай хууль, 1995 он

Зөвлөмж: *Цаазаар авах ялын талаарх Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр болон Шүүхийн стратеги төлөвлөгөөний холбогдох заалтыг хэрэгжүүлж, цаазаар авах ялыг Эрүүгийн хуулиас хасах асуудлыг судлан шийдвэрлэх;* (2010)

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын иргэн амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно” хэмээн заажээ.

Цаазаар авах ял нь харгис хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжилсон, амьд явах эрхийг хязгаарладаг гэж үздэг. Тийм ч учраас дэлхийн улс орнууд энэ ялыг хэрэглэхийн эсрэг түүнийг халах шийдвэрийг сүүлийн жилүүдэд олноор гаргаж байна. Сүүлийн 20 жилд цаазаар авах ялыг халах шийдвэрийг дэлхийн 129 орон гаргасан бөгөөд 89 орон бүрмөсөн цуцалж, 10 орон дайны гэмт хэргээс бусад тохиолдолд оноохыг хориглож, 30 орон² практикт хэрэглэхээ зогсоож, сүүлийн 10 гаруй жил ийм ял гүйцэтгээгүй байна. 68 орон цаазаар авах ялыг хэрэглэж байгаа ч дотоодын хууль тогтоомжоороо цаазаар авах ял оногдуулдаг зарим төрлийн гэмт хэргийнхээ тоог цөөрүүлсэн байна. Монгол Улс өнөөдрийн байдлаар Эрүүгийн хуулийн 7 төрлийн онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд цаазаар авах ялыг шүүхээс оногдуулахаар хуульчилсан хэдий ч бусдыг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар, санаатай алах гэмт хэрэгт ихэвчлэн энэ ялыг оногдуулж байна.

2001-2010 он хүртэлх хугацаанд улсын хэмжээнд анхан шатны шүүхээс цаазаар авах ялыг оногдуулсан судалгааг үзэхэд 2001 онд 23, 2002 онд 19, 2003 онд 22, 2004 онд 23, 2005 онд 30, 2006 онд 24, 2007-2008 онуудад тус бүр 26, 2009 онд 11, 2010 онд 19, 2011 оны эхний 3 сарын байдлаар 4 хүнд буюу нийт 227 хүнд цаазаар авах ял оногдуулсныг дээд шатны шүүх 166 хүний ялыг хэвээр баталжээ.³

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж 2010 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд 8 бүлэг шалтгаан, хоёр онцгой нөхцөлд тулгуурлаж цаазаар авах ялыг халах саналаа илтгэж, Монгол Улсад цаазаар авах ялыг түдгэлзүүлж хориг (мораториум) зарласан байна. Үүнээс хойш 2010-2011 оны эхний 4 сарын байдлаар анхан болон дээд шатны шүүхийн шийдвэрээр цаазаар авах ялаар шийтгүүлсэн ялтнуудын ялыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт зааснаар уучлал үзүүлсэн 14 ялтан 30 жилийн хугацаатайгаар хорих ялаа гянданд эдэлж байна. Онцгой дэглэмтэй хорих ангид нийт 63 ялтан ял эдэлж байгаагаас 1994 оноос хойш Ерөнхийлөгчийн уучлалд хамрагдаж, ял нь өөрчлөгдсөн 34 ялтнаас энэхүү 17 жилийн

² Эмнести Интернэйшнл, тайлан, УБ., 2010 он

³ Улсын Дээд Шүүхийн Судалгааны төвийн албан бичиг, 2011.04.04 №6/1191, №5/900

хугацаанд 8 ялтан өвчний улмаас болон өөр бусад байдлаар нас барсан ба 2 ялтны дэглэм буурч өөрчлөгджээ.⁴

2010 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн чуулганы Цаазаар авах ялыг халахыг дэмжсэн санал хураалтад Монгол Улсын Засгийн газар дэмжсэн санал өгсөн ба Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамнаас боловсруулж буй Эрүүгийн хуулийн төсөлд цаазаар авах ялыг ялын төрлөөс хассан байна. Мөн Ерөнхийлөгчийн Тамгын Газраас Эрүүгийн хуульд цаазаар авах ялтай холбоотой 7 зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулжээ. Одоогоор Эрүүгийн хуульд өөрчлөлт ороогүй, цаазаар авах ялыг халах асуудлыг хуульчлан баталгаажуулаагүй байна.

Зөвлөмж: *Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын II нэмэлт болох “Цаазаар авах ялыг халах тухай” протоколд Монгол Улс нэгдэн орох боломжийг судлах; (2010)*

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, Гадаад Бодлогын Байнгын Хорооны 2010 оны 10 дугаар сарын 12, 27-ны өдрүүдийн хуралдаан (тус хуралдаанууд хаалттай хуралдсан), Улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын Хорооны 2010 оны 10 дугаар сарын 19, 26-ны өдрүүдийн хуралдаан (хаалттай хуралдсан)-аар тус тус Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Нэмэлт II Протоколд нэгдэн орох асуудлыг дэмжсэн шийдвэр гаргажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар Цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколд нэгдэн орох тухай хуулийн төслийг хэлэлцээд тус хуулийн төслийг дэмжиж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлжээ.

Мөн Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын анхдугаар илтгэлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны хуралдаанаар 2010 оны 11 дүгээр сарын 5, 8-ны өдрүүдэд хэлэлцээд гаргасан зөвлөмжид “Оролцогч улс цаазаар авах ялтай холбоотой статистик тоо баримтыг нийтэд нээлттэй болгож, цаазаар авах ялаар шийтгүүлсэн 44 хүний талаарх мэдээллийг Хороонд өгч, цаазаар авах ялыг арай хөнгөн ялаар солих, цаазаар авахуулсан хүний гэр бүлийнхнийг холбогдох мэдээллээр хангах хэрэгтэй. Мөн цаазаар авах ялыг төрийн нууцад хамруулахаа больж, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Нэмэлт II Протоколд нэгдэн орох зэрэг цаазаар авах ялыг устгахад чиглэсэн хүч чармайлтаа үргэлжлүүлэхийг Оролцогч улсаас хүсч байна. Цаазаар авах ялтай этгээдтэй олон улсын стандартад нийцүүлэн харьцаж

⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тоо бүртгэлийн тасгаас ирүүлсэн судалгаа, УБ., 2011.04.08.

байгаа эсэхэд Оролцогч улс хяналт тавих хэрэгтэй” гэсэн байгааг ч анхаарах шаардлагатай гэж үзсэн.

Иймээс 2010 он бол Монгол Улс цаазаар авах ялаас татгалзахад бодитой алхам хийсэн жил боллоо гэж Хүний эрхийн Үндэсний Комисс дүгнэж байгаа ба цаашид Улсын Их Хурлаас цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколд нэгдэн орох тухай хуулийн төслийг батална гэдэгт найдаж байна.

1.2 Хувь хүний халдашгүй байх эрх

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрх

Комиссоос хуулийн байгууллагуудын хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааг чадваржуулах, байгууллага хоорондын уялдаа холбоог нягтруулах болон эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор 10 жилийн хугацааны Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд хуулийн байгууллагуудад чиглэсэн дараах зөвлөмжүүдийг хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийн байдлыг дүгнэн гаргаж байна. Үүнд:

Комиссын 2003, 2004, 2006, 2009 онуудын ээлжит илтгэлүүдэд Хууль тогтоомж, дүрэм, журмуудад өөрчлөлт оруулах чиглэлээр дараах зөвлөмжийг хүргүүлсэн.

Зөвлөмж: Эрүүдэн шүүх болон хэрцгий, хүнлэг бус харьцах явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсооход хуулийн байгууллагын ажилтнуудын ажлыг үнэлэх, дүгнэх, албан тушаал ахиулах, алдар цол олгох шалгуур үзүүлэлтүүд, заавар журмыг хянан үзэх; (2007)

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2011 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 38 дугаар тушаалаар “Үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталж, мөн 2004 оны 35 дугаар тушаалаар цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн ажил, мэргэжлийн ур чадвар, түвшинг тогтоон үнэлэх шалгалтын удирдамжийг батлан мөрдүүлжээ.

Уг журамд “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын ажил хэргийн чадвар, мэргэжлийн түвшинг үнэлэн тогтоож, үйл ажиллагаагаа явуулахдаа хүний эрх, эрх чөлөө, тэгш эрх, шударга ёсыг чанд сахин, гадны нөлөөнд үл автан, хуулийг нэг мөр хэрэглэж, цаашид тухайн албан тушаалыг эрхлэн гүйцэтгэх боломжтой эсэхэд дүгнэлт өгч, эрх олгуулах”-д чиглэнэ гэсэн заалтуудыг оруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон алба хаагчдын ажлын үзүүлэлтийг сар тутамд үнэлж, дүгнэж хэвшсэн нь сайшаалтай үзүүлэлт болсон ч 2002 оноос хойш зарим заавар, журмуудыг шинэчлээгүй, (“Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн талоны загвар, хэрэглэх журам”, “Цагдаагийн байгууллагаас гэмт хэргийн

талаарх гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх заавар”) хуучин заавар, журмуудыг даган мөрдөж байгаа учраас Комиссын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна гэж дүгнэлээ. Албан тушаал ахих, цол хэргэм олгох шалгуур үзүүлэлтүүдэд хүний эрхийн зөрчлийн талаар тусгайлан заагаагүй байна.

Зөвлөмж: Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорьж, мөрдөх журмыг аль болох хязгаартай хэрэглэх талаар, олон улсын гэрээний заалтуудыг дотоодын хууль болон хэрэгжүүлж буй дүрэм, журам, зааварт өөрчлөлт оруулах замаар хорьж мөрдөх дээд хугацааг багасгах боломжийг судлан хэрэгжүүлэх. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69 дүгээр зүйлд заасан хорьж мөрдөх хугацааг 18 сараас хэтрүүлэхгүйгээр, насанд хүрээгүй хүмүүсийг 6 сараас хэтрүүлэхгүйгээр тогтоох; (2007/2010)

Хуульд заасан цагдан хорьж мөрдөх хугацаа дуусмагц хоригдогчийг нэн даруй суллах журмыг хуульчлах шаардлагатай; (2007)

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтуудын нилээд хэсэг нь шүүхээс өмнө буюу шүүхээр хэлэлцэлгүй хоригдсон болон захиргааны журмаар эрх нь хязгаарлагдсан хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн байдаг. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авсан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдын эрхийг тодорхойлсон олон тооны зохицуулалт байдаг хэдий ч олон улсын гэрээний заалттай уялдахгүйгээр зохицуулагдсан заалтын нэг нь сэжигтэн яллагдагчийг хорьж мөрдөх хугацааны талаарх асуудал байнгын маргааныг дагуулсаар ирсэн. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн эдгээр заалтуудын талаар Комисс 3 удаагийн илтгэлдээ санал, дүгнэлт өгч, зөвлөмж гаргажээ.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69 дүгээр зүйлийн дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд цагдан хорьж мөрдөх хугацаа, түүнийг сунгах журмыг зохицуулж байна. Хуулийн энэ зүйл, заалтын дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг сэжигтнээр цагдан хорих, яллагдагчаар цагдан хорих гэж хоёр ангилж, онцгой тохиолдолд цагдан хорьж болох олон улсын гэрээний заалтыг үл хэрэгсэн бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжтой байхад хавтгайруулан хэрэглэдэг жишиг өнөөдрийг хүртэл байсаар байна.

Сэжигтэн, яллагдагчийг хорьж мөрдөх, түүний хугацааг сунгах тухай хуулийн заалтын зарим хэсэгт Улсын Их Хурлаас 2007 оны 8 дугаар сарын 9-ний өдөр өөрчлөн найруулж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсэгт “...хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан яллагдагчийг цаашид хорьж мөрдөх зайлшгүй шаардлагатай бол шүүх хорьж мөрдөх хугацааг тухай бүр 30 хүртэл хоногоор сунгах бөгөөд яллагдагчийг хорьж мөрдөх хугацаа хүндэвтэр гэмт хэрэгт 4 сараас, хүнд гэмт хэрэгт 12 сараас, онц хүнд гэмт хэрэгт 24 сараас хэтэрч болохгүй,

мөн хуулийн 69 дүгээр зүйлийн 69.4 дэх хэсэгт "...6 төрлийн онц хүнд гэмт хэргийн яллагдагчийг илүү хугацаагаар хорьж мөрдөх шаардлагатай бол шүүх 6 сар хүртэл хугацаагаар нэмж сунгаж болно" гэсэн заалтыг баталсан байна.

Эдгээр заалтуудаас харахад онц хүнд гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан этгээдийг дээд тал нь 30 сар хүртэл хугацаагаар хорьж, мөрдөхөөр байгаа боловч мөрдөн байцаалт болон прокурорын хяналтын шатанд хугацаа дуусахаас 3-7 хоногийн өмнө шүүхэд хэргийг шилжүүлдэг, шүүх түүнийг үргэлжлүүлэн хорих шийдвэр гаргадаг хэрнээ шүүхийн хорьсон хугацааг цагдан хоригдсон 30 сарын хугацаанаас гадуур тооцож, яллагдагчийг тарчлаан зовоодог, залхаан цээрлүүлдэг энэ байдлыг таслан зогсоох шаардлагатай.

Комисст иргэдийн ирүүлсэн гомдлын судалгаанаас үзэхэд 2009-2011 онуудад нийт 5 яллагдагчаас хүнд болон, онц хүнд гэмт хэрэгт хуульд заасан хугацаанаас илүү хугацаагаар цагдан хоригдсон тухай гомдол ирүүлснийг шалгахад 7-24 хоног илүү хугацаагаар шүүгчийн захирамжаар, шүүхийн тогтоолоор хоригдсон болох нь тогтоогдож байжээ.

Харин дээрх 69 дүгээр зүйлийн 69.10 дахь хэсэгт "Сэжигтэн яллагдагчийг цагдан хорих хугацааг сунгах асуудлыг шийдвэрлэхдээ шүүгч шаардлагатай гэж үзвэл, эсхүл өмгөөлөгч хүсэлт гаргасан бол өмгөөлөгч, прокурорыг байлцуулна"⁵ гэсэн заалтыг нэмсэн нь сэжигтэн, яллагдагчийн эрхийг хангах, оролцогч талуудын санаа бодлыг сонсох, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой заалт болсон гэж үзэж байна.

Өнөөдрийн хуулийн зохицуулалтаар гэмт хэрэгт сэжиглэн бусдыг баривчилж, хорьж болох үндэслэлүүдийг тодорхой заасан хэрнээ буцаагаад суллах, бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэж болох нөхцөл, журмыг зохицуулж өгөөгүй байгаа нь иргэдэд ихээхэн чирэгдэл, үл ойлголцол маргаан, эргэлзээг төрүүлж байна. Үүнээс үүдэн хуулийн байгууллагын ажилтнуудаас гэм буруу нь эцэслэн тогтоогдоогүй сэжигтэн, яллагдагчийн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, эс өөрчлөх нь тухайн хэргийн мөрдөн байцаагч, прокурорын үзэмжийн асуудал болж хувирсан байна. Зөвлөмжийн дагуу энэ хуулийн зохицуулалтыг өнөөдрийг хүртэл хийгээгүй байна.

Улсын хэмжээнд сэжигтэн, яллагдагчийг цагдан хорьж байгаа тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилийн байдлаар Шүүхийн тайлангаас үзэхэд 2008 онд 5 921 хүнийг цагдан хорих зөвшөөрөл олгож, 293 хүнийг цагдан хорих зөвшөөрөл олгохоос татгалзсан, 2009 онд 6 155 хүнийг цагдан хорих зөвшөөрөл олгож, 328 хүнийг цагдан хорихоос татгалзсан, 2010 онд 4 918 хүнийг цагдан хорих зөвшөөрөл олгож, 262

⁵ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн нэмэлт өөрчлөлт, "Төрийн мэдээлэл" сэтгүүл, 2008 он.

хүнийг цагдан хорихоос татгалзсан ба бусад хүмүүст нийтэд нь цагдан хорих зөвшөөрлийг олгон хорьжээ.

Энэхүү тоон үзүүлэлт нь тухайн жилд хорих ялаар шийтгүүлсэн хүмүүсийн тоон үзүүлэлтээс жилд дунджаар хорихоос өөр төрлийн ял шийтгүүлэх боломжтой 2500-3000 хүнийг сэжигтэн, яллагдагчаар цагдан хорьж байгаа үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл, манай эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд иргэнийг гэмт хэрэг үйлдсэнийг нь нотолж байгаад хорьдог бус, харин нотлохын тулд хорьдог гаж тогтолцоо оршиж байна. Иймд цаашид иргэдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, хууль тогтоомжоороо энэ төрлийн харилцааг нарийвчлан зохицуулах нь зүйтэй байна.

***Зөвлөмж:** Эрүүдэн шүүгдсэн, хэрцгий хүнлэг бус харьцаанд өртөж, бие эрхтэн, эрүүл мэнд, амь насаараа хохирсон тохиолдолд хохирлыг барагдуулах, нөхөн төлбөр олгох тухай хууль тогтоомжийн заалтыг боловсронгуй болгож, бодит хохирлын зэрэгцээ эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалт бий болгох; (2007)*

Эрүүдэн шүүсэн, хэрцгий хүнлэг бусаар харьцсан төрийн албан хаагчдад хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох; (2007)

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1984 оны конвенцид манай улс 2000 онд нэгдэн орж, олон улсын хамтын нийгэмлэгүүдийн өмнө үүрэг хүлээсэн. Үүнээс хойш эрүү шүүлттэй тэмцэх, түүнийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх талаар тодорхой зарим нэг ажлыг хийж эхэлж байгаа боловч эрүү шүүлтэд өртсөн хохирогчийг тодорхойлох, хохирлын хэмжээг зөв тогтоох, хохирлыг нөхөн төлүүлэх талаарх олон улсын гэрээний заалт болон түүний хэрэгжилтийн талаар шүүхийн практикт тогтсон ойлголтгүй, шүүгч нар өөр өөрийн үзэмжээр шийдвэрлэсээр байна.

“Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах тухай Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” Улсын Дээд Шүүхийн 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 45 дугаар тогтоолоор “эрүүдэн шүүгдсэн” гэдэгт юуг ойлгох, “сэтгэл санааны үр дагавар” гэдэгт ямар хохирлыг тооцох вэ зэргийг нарийвчлан тайлбарласан байдаг ч, түүнийг нь шүүхийн практикт тэр бүр хэрэгжүүлэхгүй байна.

Хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас байцаан шийтгэх ажиллагааны явцад эрүүдэн шүүгдэж, хэрцгий, хүнлэг бус харьцаанд өртөж, сэтгэл санаа, эрүүл мэнд, амь насаараа хохирсон явдлыг хамруулж үзэхээр тогтоолд тайлбарласан хэдий ч энэ төрлийн иргэний нэхэмжлэлийг шийдвэрлэж байгаа шүүхийн практикаас харахад

сэтгэл санааны хор хохирлыг хэрхэн тооцож шийдвэрлэхээ мэддэггүй, хохирогчийн хүсэмжилсэн мөнгөн дүнд тохирсон бодит үр дагавар шаардаж, ямар үндэслэлээр хасч байгаагаа тайлбарлахгүйгээр шийдвэрээ гаргадаг.

Нийгмийн хөгжлийн өнөөгийн үед бичигдсэн хуулийн заалтаас илүүтэйгээр зайлшгүй зохицуулах шаардлагатай зохицуулалтууд олноор гарч ирж байгаагийн нэг баримт бол сэтгэл санаа, эрүүл мэндийн хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх аргачлалыг боловсруулан гаргаж, мөрдөх талаар эрх зүйн зохицуулалт хийх нь тулгамдсан асуудлын нэг болж байна. Манай улс эрүүдэн шүүгдсэн болон хэрцгий хүнлэг бус харьцаанд өртөж эрүүл мэнд, сэтгэл санаагаараа хохирсон иргэнд учирсан хохирлыг шударгаар барагдуулах, нөхөн төлүүлэх талаарх эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Үүний зэрэгцээ хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд бусдыг эрүүдэн шүүсэн, хүнлэг бусаар харьцсан төрийн албан хаагч, тэр дундаа цагдаагийн байгууллагын болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба+ хаагч нарт тооцох хариуцлагын механизмыг сайжруулах, үр дүнтэй тогтоолцоог бий болгох нь конвенцийн заалтын дагуу улс орнуудад хүлээлгэсэн биелүүлбэл зохих гол үүргийн нэг мөн. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн заалтын дагуу энэ төрлийн гэмт хэргийн субъект нь төрийн эрх бүхий тусгай албан тушаалтан байдаг. Өөрөөр хэлбэл, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж, албадлага хэрэглэх эрх бүхий төрийн тусгай албан тушаалтан байх ёстой. Манай Эрүүгийн хуульд “Мэдүүлэг өгөхийг албадах” гэсэн зүйл ангийг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр “Эрүү шүүлт тулгах”⁶ хэмээн нэрийг нь өөрчилсөн боловч энэ нь конвенцийн шаардлагын дагуу тавигдаж байгаа зарим нэг заалтыг бүрэн тусгалгүйгээр баталсан байдаг.

Эрүүгийн хуульд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж, мэдүүлэг өгөхийг албадан эрүү шүүлт тулгасан бол тодорхой албан тушаал эрхлэх эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч, таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх,⁷ энэ хэргийн улмаас хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл, их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх,⁸ энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ⁹ гэсэн заалтыг нэмж оруулжээ.

⁶ 2008 оны 2 дугаар сарын 1-ны өдрийн хуулийн нэмэлт өөрчлөлт.

⁷ 2002 оны Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлийн 251.1 дэх хэсэг.

⁸ Мөн хуулийн 251 дүгээр зүйлийн 251.2 дахь хэсэг.

⁹ Мөн хуулийн 251 дүгээр зүйлийн 251.3 дахь хэсэг.

Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадсан үйлдэл санаатай хийснээр бүрдэл төгсдөг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй хүндэвтэр гэмт хэрэг, харин албадсан хууль бус үйлдэл, шахалтын улмаас хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл, их хэмжээ (гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 125-аас дээш дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх)-ний хохирол учирсан бол мөн зүйлийн 2 дахь зүйлд заасан хүнд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг бий болгодог.

2008 оны Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр¹⁰ мөн зүйлийн 3 дахь зүйлд энэ хэргийн улмаас хохирогч нас барсан бол 10-15 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан нь онц хүнд гэмт хэргийн бүрэлдэхүүний ангилалд энэ гэмт хэргийг оруулж өгсөн нь конвенцийн заалтын дагуу “Эрүү шүүлт тулгах” гэмт хэрэгт хуулиар зохих шийтгэл тогтоох бөгөөд чингэхдээ энэ нь онц аюултай гэмт хэрэг гэдгийг харгалзан үзнэ¹¹ гэсэн заалттай нийцэж байна. Эрүүгийн хуулиар энэ гэмт хэргийн субъектүүдийг хязгаарлагдмал хүрээнд зөвхөн хэрэг бүртгэгч¹², мөрдөн байцаагч¹³ гэж нэр заан оруулж өгснөөрөө хуулиар олгогдсон эрх мэдэл бүхий бусад субъектүүдийн хувьд бусдад эрүү шүүлт тулгасан гэх үйлдэл дээрээ хөнгөн гэмт хэргээр зүйлчлэгдэн ял завших боломжийг олгож байна гэж үзэж болохоор байна. Эрүүдэн шүүх зөвшөөрөл олгосон, хатгасан, хамтран оролцсон, хамжсан зэрэг үйлдлийг эрүүдэн шүүхэд хамтран оролцсон гэж эрүүгийн хариуцлага хүлээлгэж байхаар конвенцид заасан боловч энэ талаар манай Эрүүгийн хуульд өнөөдрийг хүртэл тусгаагүй байх тул цаашид хууль тогтоомжид оруулах нь зүйтэй юм.

Зөвлөмж: Эрүүдэн шүүсэн болон хэрцгий хүнлэг бусаар харьцсан тухай гомдол мэдээллийг түргэн шуурхай шалгаж, гэм буруутай этгээдэд шударга ял шийтгэл оногдуулах, ийм төрлийн хэргийг албан тушаалын эсрэг гэмт хэрэгт тооцож, тусгайлан зүйлчилж шийдвэрлэх журмыг боловсронгуй болгох; (2007)

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт зааснаар “Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба нь цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн болон тагнуулын байгууллагын ажилтны үйлдсэн хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна” гэж 2007 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулж, “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн харьяаллыг тодорхой тогтоож өгсөн.

¹⁰ 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдөр Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.

¹¹ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт.

¹² Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан хэрэг бүртгэлт явуулах эрх бүхий албан тушаалтан.

¹³ Эрүүгийн хэргийн урьдчилсан мөрдөн байцаалт, түүнчлэн эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх эрх бүхий төрийн албан тушаалтан.

Тус албанд 2002-2010 он хүртэл 8 жилийн хугацаанд “Эрүү шүүлт тулгах” Эрүүгийн хуулийн тусгай ангийн 251 дүгээр зүйлээр нийт 46 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 8 хэргийн зүйлчлэл өөрчлөгдөн өөр зүйлээр шийдвэрлэгдсэн, 5 хэргийг харьяаллын дагуу шилжүүлсэн, 1 хэргийг түдгэлзүүлсэн байна. Дээрх хэргүүдээс 31-ийг нь прокурорын хяналтад яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлснээс 24 хэргийг прокурор хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байх бөгөөд эдгээрийн хууль зүйн үндэслэлийг судлахад 8 хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, 3 хэргийг нэмэлт нотлох баримт цуглуулах бүхий л ажиллагааг хийсэн боловч сэжигтэн, яллагдагч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон болох нь нотлогдоогүй гэсэн үндэслэл зааж, үлдсэн хэргүүдийн зүйлчлэлийг өөрчлөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 99 дүгээр зүйл буюу “Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах” гэмт хэргээр хөнгөрүүлэн хэрэгсэхгүй болгожээ.

Мөн 6 хэргийг “Өршөөлийн тухай хууль”-д хамруулж, өршөөл үзүүлсэн байна. Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 10 хэрэгт прокурор яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлснээс 5-ыг нь шүүх шийдвэрлэж, зохих ял шийтгэл оногдуулсан бол үлдсэн хэргүүдийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Өнөөдрийн байдлаар 4 хэрэг прокурорын хяналтад хянагдаж байна. Манай хуулийн байгууллагууд эрүү шүүлтийн эсрэг гэмт хэргийг хянах, шийдвэрлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон гэрээний заалтуудыг аль ч шатандаа хэрэглэж хэвшээгүй, эрүү шүүлтийн талаар нэгдсэн ойлголтгүй, хэргийн шийдвэрлэлт хангалтгүй байгааг дээрх тоо баримт харуулж байна.

Өнгөрсөн 8 жилийн хугацаанд давхар зүйлчлэлийг хэрэглэж, шийдвэрлэсэн нэг ч хэрэг байхгүй байна.

***Зөвлөмж:** Онц хүнд гэмт хэргээс бусад гэмт хэрэгт сэрдэгдэж буй этгээд оршин суух тодорхой хаягтай, гэр бүлтэй, үл хөдлөх хөрөнгөтэй, эрхэлсэн ажил албатай, оргон зугаахаар завдаж байгаагүй тохиолдолд баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг аль болох хэрэглэхгүй байх хэрэглэсэн тохиолдолд суллахыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарт үүрэг болгосон заалт оруулах; (2007)*

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад “... шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорих нийтлэг журам байх албагүй бөгөөд шүүх хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны аль ч шатанд байлцах, шаардлагатай тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд биечлэн байх баталгаа гаргаж өгсөн бол тухайн этгээдийг суллаж болно” гэж зааснаас үзэхэд аливаа гэмт хэрэгт сэжиглэгдэн, шалгагдаж байгаа этгээдийг цагдан хорих асуудал нь нийтлэг журам байх албагүй бөгөөд гарцаагүй тохиолдолд маш богино хугацаагаар хэрэглэхийг шаарддаг.

Манай улсад цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг урьтал болгож хэрэглэж, хэрэг хүлээлгэдэг нөхцөл байдал үргэлжилсээр байгаа нь Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын "... хэргийг нь шүүхээр таслан шийдвэрлэх хүнийг цагдан хорих явдал нийтлэг журам байх ёсгүй" гэсэн заалтыг зөрчиж, оршин суух тодорхой хаяг, гэр бүл, үл хөдлөх эд хөрөнгө, ажил албатай хүмүүсийг ихэнх тохиолдолд оргон зайлж болзошгүй, хүнд гэмт хэрэг үйлдсэн, гэсэн шалтгаанаар цагдан хорьж байна.

Зөвхөн 2010 онд гэхэд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 853 сэжигтнийг баривчлах тухай материалыг шүүх хүлээн авч, 797 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 56 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзсан байна.

Аймаг, нийслэлийн, дүүргийн шүүхүүд 2010 онд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлийн дагуу 2 391 хүнийг сэжигтнээр, 2 527 хүнийг яллагдагчаар татан цагдан хорих зөвшөөрлийг олгож, 262 хүнд цагдан хорих зөвшөөрөл олгохоос татгалзсан байна.

Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурор нарын хамтарсан 2008 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн "Баривчлах, цагдан хорихтой холбогдсон зарим ажиллагааг зохицуулах тухай журам"-д "...гэмт хэргийн ангилал, сэжигтэн, яллагдагчийн хувийн байдлаас шалтгаалан цагдан хорих шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох үндэслэлтэй байвал зөвхөн тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурор энэ тухай саналаа шүүхэд танилцуулж шийдвэрлүүлнэ. Прокурор энэхүү саналыг гаргахдаа мөрдөн байцаагчийн санал, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзана. Энэ талаар прокурор санал гаргаагүй тохиолдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох талаар шүүхэд ирүүлсэн хүсэлтийг прокурорт шилжүүлнэ" гэсэн нь байцаан шийтгэх ажиллагааны явц дахь прокурорын эрх хэмжээ, хүний эрхийн халдашгүй байх эрхийн хамгаалалтыг хэрхэн хангаж ажиллах талаар тодорхой заасан хэдий ч тэр бүр бүрэн утгаараа хэрэгжихгүй байна.

Зөвлөмж: Уулзах зөвшөөрөл олгож буй тогтолцоог өөрчилж, уулзах зөвшөөрлийг хорих зөвшөөрөл олгосон шүүгч өгдөг болгох, зөвхөн хоёрхон өдөрт уулзалт зохион байгуулж байгаа болон эргэлт, уулзалт хэмээх 2 тусдаа ойлголт бий болгож, журамласныг өөрчлөх; (2007)

Ямар нэгэн шалтгаанаар хоригдсон хүмүүс ар гэрийнхнээсээ эргэлт, уулзалт авах нь эдгээр хүмүүсийг эрүү шүүлтэд өртөж байгаа эсэхэд хяналт тавих нэг хөшүүрэг болж өгдөг.

Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдын 2007 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 78 дугаар тушаалаар "Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам"-ыг шинэчлэн

баталжээ. Энэ журмын 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх хэсэгт “...сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалтын дагуу эрх бүхий албан тушаалтан албан ёсны зөвшөөрлийг үндэслэн 7 хоногт 2 удаа өдрийн 10:00-17:00 цагийн хооронд уулзалтыг зохион байгуулах бөгөөд цагийн хуваарийг хорих байрны дарга батална”. Мөн журмын 5 дугаар зүйлийн 5.5.2 дахь хэсэгт зааснаар “...шүүхээр хэрэг нь шийдэгдэж, шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон этгээдийн уулзалтыг хорих байрны дарга шийдвэрлэнэ” гэсэн заалтуудыг мөрдлөг болгон цагдан хорих байруудад уулзалтыг зохион байгуулжээ.

Уулзалтын зөвшөөрлийг тухайн этгээдийн шалгагдаж байгаа хэрэг мөрдөн байцаалтын шатанд байгаа бол хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа мөрдөн байцаагч, шүүхээр хэрэг нь шийдвэрлэгдэхээр хүлээгдэж байгаа тохиолдолд тухайн хэргийг хүлээн авсан шүүгч олгодог. Анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдсан тохиолдолд эрүүгийн хэрэг дүүргээс давж заалдах шатны шүүхэд ирээгүй гэх шалтгаанаар 10 хоногоос нэг сар хүртэлх хугацаанд уулзалт хийх зөвшөөрөл олгогддоггүй байна. Өнөөдрийн байдлаар уулзалтын зөвшөөрлийг цагдан хорих зөвшөөрөл өгсөн шүүгч олгодог журамд шилжээгүй хэвээр байна.

Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Цагдан хорих 0461 дүгээр ангийн даргын 2009 оны тушаалаар уулзалтад очиж буй хүмүүсээс нэг удаа 1 000 төгрөгийн хураамж авч, дотоод үйлчилгээндээ зарцуулдаг байх бөгөөд 2010 онд нийтдээ 5 578 сэжигтэн, яллагдагч ар гэрийнхнээсээ уулзалт авчээ. Цаашид эргэлтээр ирсэн ар гэрийнхэнд төр үйлчилгээ үзүүлснийхээ төлөө төлбөр шаарддаг тогтолцоог өөрчлөх нь зүйтэй юм.

***Зөвлөмж:** Эрүүгийн ял шийтгэлийн бодлогыг боловсронгуй болгох замаар, анх удаа гэмт хэрэг үйлдсэн этгээдийг аль болох нийгмээс тусгаарлахгүйгээр засан хүмүүжүүлэхэд онцгой анхаарч, гэмт хэргийн хохирлоо нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан бол хорих ял оноосон тогтоолыг биелүүлэхийг хойшлуулдаг, ялыг тэнсдэг журмыг өргөн хэрэглэх хуулийн зохицуулалтыг бий болгох; (2009)*

Улсын Их Хурлын 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаар Эрүүгийн хуулийн 55 дугаар зүйлд нэмэлтээр 55.1.1 дэх заалтад “Эрүүгийн хуулийн тусгай ангид заасны дагуу хорих ял оногдуулж болох гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд гэмт хэргийн хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан бол шүүх тухайн этгээдийн хувийн байдал, үйлдсэн хэргийнх нь шинж чанарыг харгалзан Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хорих ялын доод хэмжээнээс доогуур хорих ял оногдуулж болох боловч, ийнхүү хөнгөрүүлэн оногдуулах хорих ялын доод хэмжээ нь энэ хуулийн тусгай ангид тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан хорих ялын доод хэмжээний гуравны хоёроос хэтрэхгүй байна” гэсэн өөрчлөлт оруулжээ.

Шүүхийн тайлангийн тоон судалгаанаас үзэхэд 2008 онд хорих ял шийтгүүлсэн 6150 хүнээс хорих ялыг биечлэн эдлүүлсэн 3 011, тэнссэн 2 517, шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 555, өршөөл үзүүлсэн 67 хүн байсан бол 2009 онд хорих ял шийтгүүлсэн 5 742 хүнээс хорих ялыг биечлэн эдлүүлсэн 3 074, тэнссэн 2 013, шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 305, өршөөл үзүүлсэн 350 хүн, мөн 2010 онд хорих ял шийтгүүлсэн 5 537 хүнээс хорих ялыг биечлэн эдлүүлсэн 2 543, тэнссэн 2 444, шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 434, өршөөл үзүүлсэн 116 иргэнийг тус тус хамруулжээ. Зөвлөмжийн дээрх заалт практикт тодорхой хэмжээнд хэрэгжсэн байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ тухайн гэмт хэрэгт оногдуулах ялаас хөнгөрүүлж, (Эрүүгийн хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх заалт) хорих ял оногдуулсан талаарх судалгаагаар 2008 онд 3 011 хорих ял шийтгүүлэгчийн 12,3 хувь, 2009 онд 3 074 хорих ял шийтгүүлэгчийн 14,5 хувь, 2010 онд 2 543 хорих ял шийтгүүлэгчийн 18,4 хувьд нь хорих ялын доод хэмжээнээс доогуур ял шийтгэл оноосон байна. Хуулийн дээрх заалт амьдралд нэн шаардлагатай байсныг дээрх тоон үзүүлэлт харуулж байгаа бөгөөд жил бүр тодорхой хувиар энэ зүйлийг хэрэглэж, шийдвэрлэсэн гэмт хэргийн шийдвэрлэлт өссөн тоон үзүүлэлттэй байна. Цаашид, шүүхээс анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн болон бусдад учруулсан хохирлыг нөхөн төлсөн, хэргийн нөхцөл байдал, тухайн этгээдийн хувийн байдал зэргийг зайлшгүй харгалзан үзэж, хуулийн энэхүү заалтыг хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Зөвлөмж: Ял шийтгэлтэй байдлын талаарх хуулийн заалтуудыг судлан үзэж, нэг мөр болгох, ял шийтгэлийн лавлагааг зөвхөн хууль тогтоомжид тусгайлан заасан тохиолдолд олгодог болгох; (2010)

Тухайн үед эрүүгийн гэмт хэрэг үйлдэж, гэм буруу нь шүүхээр эцэслэн тогтоогдож, ял шийтгэл хүлээсэн этгээд шүүхээс оногдуулсан ялаа тодорхой хугацааны дотор эдэлж, дууссаны дараа нийгэмд эргэн орохдоо ямар нэгэн буруу үр дагавар, хязгаарлалтуудыг өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар дагуулах эрсдэлтэй байдаг. Энэхүү хандлага нь хууль ёсны зайлшгүй буюу хууль бус шаардлагаар илрэн гарах боломжтой. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 78 дугаар зүйлд ялгүй болох нөхцлүүдийг тодорхойлон зааж өгчээ.

Өнөөдөр манай улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиудад ял, шийтгэлийн тухай асуудлыг өөр өөрөөр зааж, хуулийн заалтуудыг илтэд зөрчсөн заавар, журам гаргаж, тухайн цаг хугацаанд ял шийтгүүлж байсан иргэнийг бүх насаар нь ялтайд тооцож, Эрүүгийн хуулийн ялтай байх гэсэн заалтыг гажуудуулж, эрүүгийн хариуцлагыг зөвхөн Эрүүгийн хуулиар тодорхойлох зарчимтай зөрчилдөж байгааг хуульчлах шаардлагатай болжээ.

Монгол Улсын хуулиар тодорхой ажил, албан тушаалд томилогдох буюу сонгогдох, түүнд нэр дэвшихэд ялгүй байх хуулийн зохицуулалт байгаагийн зэрэгцээ Засгийн газрын тогтоол, байгууллагуудын дарга, албан тушаалтны шийдвэр, заавар, журмууд зарим төрийн байгууллага болон аж ахуй, хувийн компани, гадны хөрөнгө оруулалттай үйлдвэр, аж ахуйн газрууд нь хуулиас давсан эрх эдэлж, ажилд орохыг хүссэн иргэд, шалгалт өгөх оюутан, залуусаас хүртэл ял, шийтгэлийн лавлагааг шаарддаг бичигдээгүй хууль өнөөдрийг хүртэл үйлчилсээр байна. Цагдаагийн Ерөнхий Газрын Мэдээлэл судалгааны төвөөс гаргасан мэдээнээс харахад 2009 онд 183 500 хүн буюу өдөрт дунджаар 749 хүн, 2010 онд 230 000 хүн буюу өдөрт дунджаар 939 хүнд ял, шийтгэлийн лавлагааг олгосон байна.

2008 оны Улсын Дээд Шүүх, Цагдаагийн Ерөнхий Газар болон Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын хамтарсан 547, 494, А/113 дугаар захирамж, тушаалаар “Шүүхээр ял шийтгэгдсэн хүмүүсийн тоо бүртгэлийг хөтлөх, лавлагаа авах заавар”-т нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Нийслэлийн Цагдаагийн Газраас 2011 оны 3 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан “Захиргааны хяналт ба тулгамдсан асуудал” сэдэвт зөвлөгөөнөөр ял, шийтгэлтэй байдлын талаарх лавлагаа нь хөдөлмөрлөх эрхийг хязгаарлаж, ялангуяа хорихоос суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх, тэднийг ажил, амьдралтай болгоход саад учруулснаар эргээд гэмт хэрэг үйлдэх замаар амьдралаа залгуулахад хүргэж байна. Иймээс урьд ял шийтгэгдсэн эсэх лавлагааг зөвхөн хууль болон хуульд нийцүүлэн гаргасан журамд заасан тохиолдолд олгодог байхад анхаарч, зохих зохицуулалт хийх шаардлагатайг тэмдэглэжээ.

Тус зөвлөгөөнөөс ял, шийтгэлийн лавлагааг зөвхөн эрүүгийн эрх зүйн үүднээс өгч байхаар зөвлөмжийн төсөлд тусгаж, санал авахаар Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар, Нийслэлийн прокурор, Шүүхэд хүргүүлсэн байна.

Дээрх байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн зөвлөмжөө эцэслэн боловсруулж, Хууль Зүй, Дотоод Хэргийн Яаманд уламжлах, мөн аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөмжийг хүргүүлэхээр төлөвлөснөө хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй байна.¹⁴

Зөвлөмж: Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шүүн таслах үйл ажиллагаа явуулахдаа сэжигтэн яллагдагчийн насанд хүрээгүй хүүхдийн эрх ашгийг сайтар хамгаалж, асран хамгаалагч харгалзан дэмжигчийг заавал тогтоож байх насанд хүрээгүй, бага насны хүүхэдтэй ганц бие эмэгтэйчүүд болон эцэг эх нь хоёулаа ял шийтгүүлж байгаа тохиолдолд, хүүхдийн эрх ашгийг харгалзан үзэж ял шийтгэлийг тэнсэх хойшлуулах боломжийг нэмэгдүүлэх; (2010)

¹⁴ Нийслэлийн Цагдаагийн Газрын судалгаа, мэдээлэл, УБ., 2011.03.31.

Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа эмэгтэйчүүдийн хорих 0407 дугаар ангиас ирүүлсэн (2011 он) судалгаагаар бол тус хорих ангид хорих ял эдэлж байгаа 363 эмэгтэйгээс 1-18 насны хүүхэдтэй, нөхөр нь өөр хорих ангид ял шийтгэл эдэлж байгаа 11, 88 нь өрх толгойлсон буюу нөхөргүй, нийт 99 эмэгтэйн 196 хүүхэд бусдын асрамжид үлдсэн байна. Эрүүгийн Байцаан Шийтгэх хуулийн 188 дугаар зүйлийн 188.1 дэх хэсэгт "...шүүх сэжигтэн, яллагдагчийн хүүхдийг харгалзан дэмжих ...талаар үүрэг хүлээнэ, баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийн асрах хүнгүй, бага насны хүүхэд..."-ийг харгалзан дэмжүүлэхээр төрөл садны буюу бусад хүмүүст, эсвэл зохих байгууллагад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар шилжүүлэн өгнө" гэсэн заалтын хэрэгжилт муу байна. Энэ талаар шүүхээс гаргасан статистик судалгаа ч байхгүй байна.

Цаашид Монгол Улсын олон улсын гэрээ Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу "Нийгмийн хамгааллын улсын буюу хувийн байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна" гэснийг удирдлага болгож, шүүхээс насанд хүрээгүй бага насны хүүхэдтэй болон эцэг, эх нь хоёулаа ял шийтгүүлэх тохиолдолд хорих ялыг хойшлуулах зэрэг арга хэмжээг түлхүү хэрэглэж байх нь зүйтэй юм.

Зөвлөмж: Урьдчилан хорих бүх байруудад аттестатчилал явуулж, хуулийн шаардлага, стандарт хангаагүй байруудыг засварлах, боломжгүй хэсгийг нь хаах; (2005)

Өнөөдөр улсын хэмжээнд 25 цагдан хорих байр, 478 хорих өрөөтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаагаас 15 нь тусдаа байртай, 5 нь аймгийн цагдаагийн газар, хэлтсийн подвальд, 5 нь цагдаагийн байранд¹⁵ ажиллаж байна.

Эдгээр цагдан хорих байруудын өрөөний талбай 24-1 629 м² байгаа бөгөөд тогтоосон багтаамжийн хувьд нэг хүнд оногдох талбайн хэмжээ хуульд нийцэж байгаа мэт харагдах боловч даац хэтрэх тохиолдолд энэ стандарт зөрчигдсөөр байна. Жишээ нь: Цагдан хорих төвд 2011 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн байдлаар 710 хүн хоригдож байсан ба нэг хүнд ногдох талбайн хэмжээ 2,2 м² байлаа. Зарим тохиолдолд түүнээс бага талбай нэг хүнд ноогддог байна. Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Цагдан хорих 0461 дүгээр анги нь сүүлийн жилүүдэд даац байнгын хэтрэлттэй байдгаас гадна агааржуулалт, гэрэлтүүлгийн хувьд хүний амьдрах орчин нөхцөлд тохирохгүй, уушигны өвчлөл өндөртэй, олон улсын жишиг стандартад нийцэхгүйгээр үйл ажиллагаа явуулж байсан учраас Улсын Их Хурлын 2006 оны 54 дүгээр тогтоолоор Цагдан хорих шинэ байр барих шийдвэр гаргажээ.

¹⁵ Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын Нэгдсэн тоо бүртгэлийн тасгаас ирүүлсэн судалгаа, 2011.04.08.

Шийдвэрийн дагуу 1000 хүний багтаамжтай, олон улсын стандартад нийцсэн эмнэлэг, гал тогоо, эргэлт, уулзалтын болон өмгөөлөгч, мөрдөн байцаагчийн тусгай өрөөнүүдтэй, камерын хяналттай, шинэ барилгыг нийслэлийн Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт барьж, ашиглалтад оруулаад байна.

Цагдаагийн байгууллагын газар, хэлтсийн подвалд үйл ажиллагааг явуулдаг Говь-Алтай, Дорнод, Дорноговь, Орхон, Сэлэнгэ аймгуудын Цагдан хорих байруудыг яаралтай өөрчлөн өөрийн гэсэн байртай болох асуудлыг холбогдох байгууллагууд нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байна.

Зөвлөмж: *Сэжигтэн, яллагдагчийг орон нутгаас нь өөр газарт шилжүүлэн хорьдог хууль бус арга ажиллагааг таслан зогсоох; (2005)*

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 142 дугаар зүйлд байцаалт явуулах газар, цаг хугацааны талаар заахдаа "...байцаалтыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явагдаж байгаа газарт явуулах ба шаардлагатай бол байцаагдаж байгаа этгээдийн байгаа газарт явуулж болно", мөн хуулийн 180 дугаар зүйлд "...мөрдөн байцаалтыг уг гэмт хэрэг гарсан газарт явуулна" гэж тус тус заасан ба сэжигтэн, яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг мөрдөн байцаалт явуулж байгаа газрын харьяаны цагдан хорих төвд хэрэгжүүлэх ёстой.

Сэжигтэн, яллагдагчийг орон нутгаас нь хол аваачиж хорих нь хууль ёсны эрх ашигт нь сөргөөр нөлөөлж, сэтгэл зүйн хувьд дарамт учруулж байгаагаараа эрүү шүүлтийн нэг илрэл болно. Цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ авагдаж байгаа этгээдийн талаарх байршлын тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлан гаргасан Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогцод "...Хэрэв саатуулагдсан буюу хоригдсон этгээд хүссэн хийгээд боломжтой бол түүний байнга оршин суудаг газарт нь ойр дөт орших саатуулах буюу хорих газарт байлгана"¹⁶ гэж заасан.

Сэжигтэн, яллагдагчийг хэрэг үйлдсэн газраас нь өөр газарт шилжүүлэн хорих нь өмгөөлөгчтэйгээ уулзах, хууль зүйн туслалцаа авах, ар гэрийнхнээсээ эргэлт уулзалт авах, хэрэгт нь хяналт тавьж байгаа прокурортой уулзах, өргөдөл гомдол гаргаж шийдвэрлүүлэх гэх мэтийн эрхүүдээ эдлэхэд бэрхшээл учирч, эрх нь зөрчигдөхөд хүрдэг.

Манай улсад сүүлийн үед эрүүгийн нөхцөл байдал хүндэрсэн олон тооны онц ноцтой гэмт хэрэг гарсан гэдэгтэй уялдуулан нэн ялангуяа дуулиан шуугиан ихтэй хэрэгт холбогдогсдыг Төв, Дархан-Уул, Сэлэнгэ, Өвөрхангай аймгийн цагдан хорих

¹⁶ "Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын Цогц"-ын 20 дугаар зүйл, 1988 он.

байранд аваачиж хорьдог хууль бус арга, ажиллагаа нилээд гарах болсныг урьд жилийн илтгэлүүдэд гаргаж тавьж байсан.

Эрүүгийн хэргийг шалгах нутаг дэвсгэрийн харьяаллын тухай хуулийн заалтыг цагдаагийн байгууллагын ажилтнууд ноцтойгоор зөрчиж, 2008 онд өөр аймаг, хотоос 41, 2009-2010 онд тус бүр 32 сэжигтэн, яллагдагчийг Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Цагдан хорих 0461 дүгээр ангид авчирч хорьжээ. Харин Ганц худаг дахь цагдан хорих төвд бусад аймгийн цагдан хорих байрнаас 2008 онд 68, 2009 онд 79, 2010 онд 62 сэжигтэн, яллагдагчийг шилжүүлэн хорьсон¹⁷ байна. Цаашид сэжигтэн, яллагдагчийг өөр газарт шилжүүлэн хорих үйл ажиллагааг таслан зогсоож, зайлшгүй шаардлагатай тохиолдолд хориход баримтлах эрх зүйн нарийвчилсан зохицуулалт хийх шаардлагатай.

Зөвлөмж: Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх, эрүүлжүүлэх үйл ажиллагаанд тавих прокурорын байгууллагын хяналт, үйл ажиллагааг тогтмолжуулах, чанар үр нөлөөг дээшлүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг цаг тухайд нь арилгах, хариуцлага тооцох ажлыг эрчимжүүлж, илэрсэн зөрчил дутагдлын талаар олон нийтэд ил тод мэдээлж байх; (2007)

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх үйл ажиллагаанд эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагчийн эрхийг хангуулах, эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар харьцах явдлыг гаргуулахгүй байхад прокурорын хяналтыг чиглүүлж, хяналт тус бүрийн чиглэлээр жилд 2 удаа улсын хэмжээнд нэгдсэн шалгалтыг Улсын Ерөнхий Прокурорын Газраас хийж, илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ авч хэвшсэн байна.

Улсын Ерөнхий Прокурорын Зөвлөлийн 2011 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд 2011-2016 онд хэрэгжүүлэх ерөнхий хөтөлбөрийг батлан гаргаж, Улсын Ерөнхий Прокурорын Газарт бие даасан Хэвлэл мэдээллийн албыг Прокурорын байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй, шударга, иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр хүргэж байх зорилгоор байгуулжээ. Түүнчлэн 2011 оны 3 дугаар сарын 9-ний өдөр Улсын Ерөнхий Прокурорын албан даалгавраар аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн нийт прокуроруудад мөрдөн шалгах ажиллагаа, ял эдлүүлэх ажиллагаа, мэдээлэл, дүн шинжилгээ, бодлого төлөвлөлт, тамгын хэлтсийн үйл ажиллагааны чиглэлд хүний эрхийг сахин хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хүнд суртал, шударга бус үйл ажиллагааг таслан зогсооход цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, ажлыг эрчимжүүлэх зорилгоор Прокурорын байгууллагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг үндэслэн нийт прокуроруудад албан үүрэг өгсөн байна.

¹⁷ Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Цагдан хорих 0461 дүгээр ангийн судалгаа, 2010.03.28.

Прокурорын байгууллагын зүгээс эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагчийг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу баривчилж, тэдэнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авахдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлд зааснаар мөрдөн байцаагч сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих тогтоолд, тэднийг цагдан хорьж байгаа газар үндэслэлийг тодорхой зааж, тогтоолыг прокурорт хүргүүлж, прокурор нь шүүхэд биечлэн танилцуулж, шийдвэрлүүлж байгаа ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа боловч шүүхээс прокурорын саналыг авалгүйгээр таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, прокурорын саналыг хүлээж авахгүй буцаах явдал гарч байгаа нь эрүүгийн хэргийг илрүүлэхэд сөргөөр нөлөөлж байгаа тухай дүгнэсэн байна. Тухайлбал 2009 онд шүүхээс прокурорын саналыг авалгүй цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилсөн 34, прокуророос гаргасан саналыг үндэслэлгүй гэж үзэн буцаасан 154 тохиолдол гарсан байна. Дээрх шалтгаанаас болж зарим хэргийн яллагдагч оргон зайлсан тохиолдол цөөнгүй гарсан тухай Улсын Ерөнхий Прокурорын Газрын тайланд дурдсан байна.

Цагдан хорих байрны үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой хоёр журмыг Улсын Ерөнхий Прокурорын Газраас 2010 онд боловсруулан мөрдүүлж ажиллаж байгаа бөгөөд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хууль зүйн үндэслэлийг улсын хэмжээнд жил бүр хоёроос доошгүй удаа шалган судалж, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналтын ажлын аргачилсан заавар гарган цагдан хоригдож буй хүмүүстэй 14 хоног тутамд прокурор биечлэн уулзаж, санал хүсэлтийг нь шийдвэрлэж байх талаар тусган хэрэгжүүлжээ.

Зөвлөмж: Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг бэхжүүлэх, чадавхийг дээшлүүлэх, үйл ажиллагааг нь сайжруулах; (2007)

Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг бэхжүүлэх, чадавхийг дээшлүүлэх, үйл ажиллагааг нь сайжруулах зэрэг шат дараалсан тодорхой арга хэмжээ авсан байна. Үүнд:

2003 оны Засгийн газрын 11 дүгээр тогтоолоор тус алба нь ажлын тусгай байртай болсон бөгөөд 2004 оноос тус албаны төсвийг Улсын Ерөнхий Прокурорын багцад багтаан тусад нь батлуулдаг болсон байна. Мөрдөн байцаах албаны эрх зүйн орчин, үйл ажиллагааны бие даасан байдал, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх талаар дэс дараалалтай арга хэмжээ авч ажиллуулсны үр дүнд мөрдөн байцаах ажлын түвшин улсын дундаж ба түүнээс дээш хэмжээнд хүрсэн байна гэж Улсын Ерөнхий Прокурорын Газраас дүгнэжээ.

Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд 2002-2008 онд тус алба үйл ажиллагаагаа хэвийн явуулахад зориулан компьютер, техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийсэн байна. 2011 онд Улсын Ерөнхий Прокурорын

шийдвэрээр Мөрдөн байцаах албаны байрыг төрийн тусгай хамгаалалтад авах ажил хийгдсэн байна.

Мөн ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх зорилгоор олон тооны сургалт, судалгааны ажлуудыг алба дотроо болон Хүний эрхийн Үндэсний Комисс, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн “Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх” төсөлтэй хамтран “Эрүү шүүлтээс ангид байх эрх” сэдэвт сургалтыг Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Архангай, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Говь-Алтай, Ховд, Увс, Баян-Өлгий аймаг, Улаанбаатар хотод бүсчлэн зохион байгуулсан ба сургалтын явцад эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчид болох сэжигтэн, яллагдагч, гэрч, хохирогч нарыг хамруулан нийт 929 хүнээс асуулга авч, судалгаа хийн дүгнэсэн байна.

Зөвлөмж: Шүүгчийн шийдвэргүйгээр сэжигтнийг баривчилж, халдашгүй чөлөөтэй байх эрхийг нь зөрчиж байгаа зөрчлийг таслан зогсоож, зөвхөн шүүгчийн шийдвэрээр сэжигтэн, яллагдагчийг баривчилдаг журамд шилжих; (2010)

Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газраас ирүүлсэн судалгаагаар бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлээр сэжигтнээр баривчлагдсан иргэдийн тоон үзүүлэлтээс үзэхэд 2008 онд 835 хүн баривчлагдсанаас 350 хүн суллагдаж, 485 хүн үргэлжлүүлэн цагдан хоригдсон, 2009 онд 736 хүн баривчлагдсанаас 278 нь суллагдаж, 458 хүн үргэлжлүүлэн цагдан хоригдсон, 2010 онд 703 хүн баривчлагдсанаас 233 нь суллагдаж, 470 хүн үргэлжлүүлэн цагдан хоригдсон байна. Үүнээс үзэхэд, сэжигтнээр баривчлагдсан хүмүүсээс дунджаар 30-40 хувь нь суллагдаж байгаа нь сэжигтнээр баривчлах ажиллагаа нь хэт олон хүнийг чирэгдүүлсэн, үндэслэл муутай тогтоол гаргадаг, шүүгчийн шийдвэргүйгээр баривчилдаг байдал арилаагүйтэй холбоотой. Цаашид энэхүү харилцааг зохицуулсан, тусгайлсан журам гаргах нь зүйтэй байна.

Зөвлөмж: Баривчлах, Цагдан хорих байруудыг эмч, мэргэжилтэн, эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангаж, эдгээр газруудад хоригдогсад бие эрхтэн, эрүүл мэнд, амь насаараа хохирч байгаа ноцтой зөрчлийг таслан зогсоох; (2007)

“Цагдан хорих байрны дотоод журам”-ын дагуу шинээр цагдан хоригдож байгаа сэжигтэн, яллагдагч нарыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулан гэмтэл, архаг хууч өвчин зэргийг эрт илрүүлэн хүндрэлээс урьдчилан сэргийлж байна. Эмч, эмнэлгийн ажилтнууд хорих өрөөний чийг, дулаан, цэвэрлэгээ үйлчилгээ, сургалт, сурталчилгаа, хоригдогч нарт олгож байгаа хоол хүнсний бүтээгдэхүүнд тогтмол хяналт тавьж, улирал тутамд Нийгмийн эрүүл мэндийн төвд хоолны дээжийн илчлэгийн хэмжээг тодорхойлуулан ажиллаж хэвшжээ.

Эмнэлгийн ажилтнууд хууль журамд заасны дагуу сэжигтэн, яллагдагчдыг 14 хоног тутамд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, нарийн мэргэжлийн эмчилгээ, оношлогоо хийхийн зэрэгцээ шаардлагатай үед орон нутаг дахь нэгдсэн эмнэлэгт гэрээний дагуу үзүүлж, дээд шатлалын эмнэлэгт шилжүүлэн эмчилгээний асуудлыг шийдвэрлэж хэвшсэн байна. Гэвч судалгаагаар сүүлийн гурван жилийн хугацаанд улсын хэмжээнд Цагдан хорих байранд нийт 14 хүн өвчний улмаас нас барсан судалгаа гарчээ.

Цаашид Баривчлах, Цагдан хорих байруудын эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, стандартад нийцүүлэх (эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүн эмнэлгийн үйлчилгээг энгийн хүний адил нөхцөлөөр эдлэх эрхтэй) боломжит хэлбэрээр эм, тариа болон оношлогооны орчин үеийн техник худалдан авах, суурилуулах төсвийг нэмэгдүүлж, эмч нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулан мэргэжлийн зэргийг нэмэгдүүлж, чадавхжуулах шаардлагатай байна.

Зөвлөмж: Тагнуулын Ерөнхий Газрын ажилтнуудын гүйцэтгэх болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажилд хөндлөнгийн хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг бий болгож, Тагнуулын байгууллагын үйл ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах; (2007)

“Эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг хамтран зохион байгуулах тухай” Хүний эрхийн Үндэсний Комисстой байгуулсан санамж бичгийн дагуу Тагнуулын Ерөнхий Газраас дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Тагнуулын Ерөнхий Газрын Мөрдөн байцаах хэлтсээс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахдаа хүний эрх, эрх чөлөөг хангах зорилгоор Монгол Улсын болон гадаад иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор нийслэлийн өмгөөлөх зөвлөлтэй хамтран ажиллаж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалтыг үндэслэн өмгөөлөгч, орчуулагчийг тогтмол оролцуулан ажиллаж, байгаагийн үр дүнд шүүх, прокурорт шилжүүлсэн хэргүүдэд оролцогчдын зүгээс ямар нэгэн санал, гомдол гараагүй байна.

Мөрдөн байцаах хэлтсээс эрхлэн гүйцэтгэх ажилтнуудын хууль, эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-д заасан тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажилтнууд эрүүгийн хэрэгт хойшлуулшгүй ажиллагаа явуулахдаа хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахад нь туслах зорилгоор “Хойшлуулшгүй ажиллагааны арга” товхимол гаргаж, төвийн болон орон нутгийн гүйцэтгэх ажилтнуудад хүргүүлсэн ба төвийн газар, хэлтсийн ажилтнуудад тусгайлсан сургалтуудыг явуулсан байна.

Тагнуулын Ерөнхий Газраас өөрийн эрхлэх ажлын хүрээнд олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, хамтын ажиллагаатай улс орнуудаас тодорхой чиглэлээр мэргэжилтнүүд урьж, ажилтнуудын дунд мэргэжлийн сургалт явуулсан ба ажилтнуудыг гадаадын байгууллагын сургалтад хамруулж чадавхийг нь дээшлүүлжээ.¹⁸

Тагнуулын Ерөнхий Газрын болон төв, орон нутгийн газар, хэлтсүүдийн жил, улирлын төлөвлөгөөнд хүний эрхийг хамгаалах чиглэлээр тодорхой асуудлуудыг тусган хэрэгжүүлж ирсэн байна. Үүний үр дүнд ажилтнуудын хууль, эрх зүйн мэдлэг, боловсролд болон эрхэлж байгаа ажлынхаа хүрээнд хүний эрх, эрх чөлөөг дээдлэн ажиллах талаар ахиц гарчээ.

Прокурорын байгууллагаас Тагнуулын Ерөнхий Газрын ажилтнуудын гүйцэтгэх болон, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажилд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл журмын дагуу байнгын тасралтгүй хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд Тагнуулын байгууллагын мөрдөн шалгах үйл ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн явуулж байгаа гүйцэтгэх ажилд бүрэн хяналт тавих зорилгоор Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг боловсруулан холбогдох Хууль Зүй, Дотоод Хэргийн Яаманд хүргүүлсэн байна.

Хүн худалдаалах гэмт хэрэг

Зөвлөмж: Монгол Улсын нэгдэн орсон “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц”-ийн нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол”-ын зарим зүйл заалтуудтай уялдуулан үндэсний хууль тогтоомжоо, тухайлбал, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Хилийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль зэрэг холбогдох бусад хуулиудын зарим зүйл, заалтыг нийцүүлэх; түүнчлэн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг хуулийг батлан гаргах; (2010)

Төрөөс сүүлийн жилүүдэд Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын баримт бичгүүдийг гаргах ажлыг дэс дараатай авч хэрэгжүүлсэн байна.

Улсын Их Хурал 2008 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан Үндэстэн

¹⁸ Тагнуулын Ерөнхий Газраас ирүүлсэн судалгаа, мэдээлэл, 2011.03.31.

дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд (Палермогийн протокол) нэгдэн орсныг соёрхон баталж, мөн 2008 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаараа Эрүүгийн хуулийн тусгай ангийн “Хүн худалдах, худалдан авах” 113 дугаар зүйлийг “Хүн худалдаалах” болгон өөрчилж, тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оноох ялын санкцийг өөрчилж, чангаруулж тогтоожээ.

Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 1.5.9-д “...хүүхдийг дамлан худалдах, тэднийг аюултай нөхцөлд албадан хөдөлмөр хийлгэх, тэднийг бэлгийн мөлжлөг болон хууль бус үйл ажиллагаанд ашиглах зэрэг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгана” гэснийг Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 17/15 тоот зөвлөмжөөрөө дэмжин баталсан. “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.4 дэх хэсэгт “...иргэдийг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүчирхийллээс хамгаалагдах нөхцөлийг сайжруулах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлнэ” гэж заажээ.

Хүний эрхийн Үндэсний Комисс нь Швейцарийн Хөгжлийн Агентлаг, Хүний Аюулгүй Байдлын Судалгааны төвийн захиалгаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаарх холбогдох хууль тогтоомжид судалгаа хийж, өнөөдрийн мөрдөж байгаа Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх, Садар самуунтай тэмцэх тухай, Зар сурталчилгааны тухай, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих тухай, Гэр бүлийн тухай хуулиуд нь нэгдэн орсон гэрээний заалтуудтай уялдахгүй байхын зэрэгцээ эдгээр хуулиуд нь хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх найдвартай баталгаа болж чадахгүй байгааг судлан тогтоож, дээрх зөвлөмжийг гаргасан байна.

Энэ ажлын хүрээнд Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдын 2010 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 92 дугаар тушаалаар Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай бие даасан хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулжээ. Ажлын хэсгийг тус яамны Төрийн нарийн бичгийн дарга ахлан ажиллаж, холбогдох судалгаа, дүгнэлт гаргасны үндсэн дээр хуулийн төслийг бэлэн болгон Засгийн газарт хэлэлцүүлэхээр холбогдох байгууллагуудаас санал авч байна.

Мөн ажлын хэсэг Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн төсөл түүнтэй уялдуулан бусад хуулийн давхардал, тодорхой бус зохицуулалтыг залруулах зорилгоор Эрүүгийн болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Садар самуунтай

тэмцэх тухай зэрэг нийт 7 төрлийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.¹⁹

Иймд Улсын Их Хурлаас энэхүү бие даасан хуулийг цаг алдалгүй батлан мөрдүүлэх нь Монгол Улсаас нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, хүлээсэн үүргээ биелүүлэх, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм.

Зөвлөмж: Холбогдох байгууллагуудын дотоод үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог дүрэм, журмуудыг судлан шинжилж, шинэчлэх арга хэмжээг авах, Хил хамгаалах байгууллагын дотоодод үйлчилдэг нууцын зэрэглэлгүй дүрэм, журмыг судлан шинжилж ялангуяа, хилийн шалган нэвтрүүлэх боомтод үйлчилдэг дүрэм, журмуудыг өөрчлөх, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болон эрсдэл бүхий охид, эмэгтэйчүүдийг таньж мэдэх, хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийн талаарх дүрэм, журмыг хэрэгжүүлэх; (2010)

Комиссын зөвлөмжид тусгасан энэ ажлын хүрээнд Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамнаас “Хохирогчийг хамгаалах байр, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6040:2009 Монгол Улсын стандартыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран боловсруулж, Стандартчилал, хэмжил зүйн газраар батлуулан 2010 оны 1 дүгээр сарын 18-ны өдрөөс уг стандартыг хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн байна. Тус стандартыг баталснаар энэ чиглэлийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих боломжтой болсноос гадна хохирогчийн аюулгүй байдал хангагдах, улмаар үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын үйлчилгээний нэр төрөл, чанар сайжрахад чухал ач холбогдолтой болжээ. Стандартын хэрэгжилтийн байдалд одоогоор хяналт, үнэлгээ хийгдээгүй байна.

Мөн Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамнаас 2011 онд багтаан хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдлөг болгохоор “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээний удирдамж”-ийг батлан гаргахаар Хүйсийн тэгш эрхийн төв төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан удирдамжийн төслийг боловсруулан бэлэн болгожээ. Уг удирдамжийн төсөлд хохирогчийн бүртгэл, баримтжуулалт, эрүүл мэндийн үйлчилгээ, хууль зүйн туслалцаа, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ, хөгжлийн дэмжлэг туслалцаа, холбон зуучлах болон хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, мэргэжлийн ёс зүйн асуудлыг багтаасан байна.

¹⁹ Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамны албан бичиг, 2011.02.11, №4/8.

Уг удирдамж батлагдан гарвал энэ чиглэлээр ажиллах байгууллага хохирогчид нэгэн ижил арга зүйгээр үйлчилгээ үзүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулан, давхардлыг арилгахад тустай юм. Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамнаас санаачлан Стандартчилал, Хэмжил Зүйн Газрын 2009 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 47 дугаар тогтоолоор баталсан “Хохирогчийг хамгаалах байр, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”-ын талаарх стандартыг эс тооцвол, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар төрийн холбогдох байгууллагуудаас тусгайлан гаргасан дүрэм, журам байхгүй, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг батлан гаргасны дараа хийгдэнэ гэсэн хүлээлтийн байдалтай байна. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудалтай холбоотойгоор хилийн шалган нэвтрүүлэх боомтод үйлчилдэг дүрэм, журмуудыг өөрчлөн шинэчлэх ажил хийгдээгүй, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болон эрсдэл бүхий охид, эмэгтэйчүүдийг таньж мэдэх, хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаарх дүрэм, журам байхгүй хэвээр байна.²⁰

Зөвлөмж: Бусдыг худалдсан этгээдүүдийн хэргийг түргэн шуурхай шалган шийдвэрлэж, ял завшуулахгүй байх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, түүний мөн чанарын талаарх хичээлийг хуулийн байгууллагын ажилтнууд болон эрх зүйн боловсрол олгодог их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр, ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын төлөвлөгөөнд оруулан баталж мөрдүүлэх; (2010)

Их, дээд сургуулиудын хүрээнд:

Хүн худалдаалах гэмт хэргийг түргэн шуурхай шалган шийдвэрлэх, гэмт этгээдийг ял завшуулахгүй байх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход эрх зүйн боловсрол олгодог их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хүн худалдаалах гэмт хэргийн талаар хичээл оруулах асуудал Комиссын илтгэлд чухлаар тавигдсан. Хилийн Цэргийн Дээд Сургуулийг эс тооцвол эрх зүйн боловсрол олгодог их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусгайлан тусгагдсан зүйл одоогоор байхгүй байна. Хүйсийн Тэгш Эрхийн Төв төрийн бус байгууллагаас “Хүн худалдаалах гэмт хэрэг” сэдэвт сургалтын гарын авлагыг боловсруулан уг гарын авлагын хүрээнд 2008-2009 оны хичээлийн жилээс эхлэн Цагдаагийн Академи болон Хилийн Цэргийн Дээд Сургуулийн сургалтын хөтөлбөрт уг хичээлийг тусган зааж эхэлсэн боловч, Цагдаагийн Академийн 2011-2012 оны хичээлийн жилийн сургалтын төлөвлөгөөнөөс уг хичээл 1 хичээлийн жилд оюутны авах хичээлийн кредит цагийн норм хэтэрсэн гэх шалтгаанаар хасагдсан байна. Харин Хилийн Цэргийн Дээд Сургуулийн сургалтын төлөвлөгөөнд тусгасан ёсоор энэ хичээл 3 дахь жилдээ 3 дугаар дамжааны оюутнуудад жилд дунджаар 48 цаг орж байгаагаас лекц 24 цаг, семинар 16 цаг, бие даалт 8 цаг байна.

²⁰ Хил Хамгаалах Ерөнхий Газрын албан бичиг, 2011.02.14, №1-2/505.

Эрх зүйн боловсрол олгодог их, дээд сургуулиас бусад дээд боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт энэ чиглэлийн хичээлийг тусгах асуудлаар Хүний Аюулгүй Байдлын Судалгааны Төв төрийн бус байгууллагаас санаачлан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын 2009 оны 86 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр сургалтын гарын авлага боловсруулан гаргаж, их, дээд сургуулиудын 50 багшийг сургагч багшаар бэлтгэн сертификат олгох ажил хийгджээ. Хичээл 2011-2012 оны хичээлийн жилээс эхлэн зарим сургуульд орж эхэлсэн талаарх мэдээллийг Хүний Аюулгүй Байдлын Судалгааны Төв төрийн бус байгууллагаас ирүүлсэн боловч яг хэдэн их, дээд сургуульд хичээл орж байгаа талаар албан ёсны тоо гараагүй байна.

Ерөнхий боловсролын сургуулиудын хүрээнд:

2008 оны 7 дугаар сард Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамнаас Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлж байгаатай холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн түүх, нийгмийн ухааны хичээлийн агуулга, хөтөлбөрт хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр багц сэдэв оруулах асуудлаар ажлын хэсэг байгуулан ажиллаж, тус ажлын хэсгийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтын гарын авлага, материалыг боловсруулан гаргаж, нийгмийн ухааны 30 гаруй сургагч багшийг тусгайлан бэлтгэжээ.²¹ Уг сэдэв ерөнхий боловсролын сургуулийн түүх, нийгмийн ухааны хичээлийн хөтөлбөрт тусгагдан 9 дүгээр ангиудад орж эхэлсэн байна.

Хуулийн байгууллагын ажилтнуудад чиглэсэн сургалтын хүрээнд:

Хүн худалдаалах гэмт хэргийн талаар хуульчид харилцан адилгүй санал, ойлголтоотой, тухайн хэргийн талаарх байцаан шийтгэх ажиллагааны туршлага болон энэ төрлийн гэмт хэргийн тухай мэдлэг, мэдээлэл дутмаг зэргээс нилээд хэрэг бусад төрлийн төсөөтэй гэмт хэргийн зүйлчлэлээр зүйлчлэгдэн шийдвэрлэгдэж байгаагаас ял завших явдал гарч байгааг Комисс өмнөх илтгэлдээ онцлон тэмдэглэж, хуульчдын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхэд онцгой анхаарахыг зөвлөмжид тусгасан байна.

Хуульчдын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, тэдэнд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх ур чадварыг эзэмшүүлэх асуудалд олон улсын донор байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллагууд ихээхэн анхаарч, тодорхой чиглэлээр сургалтуудыг явуулж иржээ. Тухайлбал Монгол дахь Азийн сангийн дэмжлэгтэйгээр Иргэдэд туслах хүний эрхийн төв 2009-2011 онд 168 хуульчийг хамруулан сургасан байна. Энэхүү сургалт нь Палермогийн Протоколын талаарх

²¹ Хүний Аюулгүй Байдлын Судалгааны Төв төрийн бус байгууллагатай хийсэн уулзалтын тэмдэглэл, 2011.02.22

хуульчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нийгэм, сэтгэл зүйн онцлог болон олон улсын гэрээ, конвенцийг шүүхийн практикт хэрхэн хэрэглэх боломжийг хуульчдад таниулах сургалтыг явуулсан нь чухал ач холбогдолтой болжээ.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос Швейцарийн Хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Хүний Аюулгүй Байдлын Судалгааны Төв төрийн бус байгууллагатай хамтран 2008 онд 5 бүсийн 700 хуульчийг хамруулан бүсчилсэн сургалтыг зохион байгуулсан. Түүнчлэн Хүний Эрх Хөгжил төв, Экпат Үндэсний сүлжээ, Хүйсийн Тэгш Эрхийн төв, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний төв зэрэг төрийн бус байгууллагаас төрийн байгууллагуудтай хамтран хуульчдын дунд удаа дараа сургалт, семинар зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн байна.

Үүнээс үзэхэд хуульчдад чиглэсэн тэдний чадавхийг сайжруулах сургалт, семинар тодорхой хэмжээнд хийгдэж буй хэдий ч төрийн албаны халаа, сэлгээнээс шалтгаалан, бэлтгэгдсэн, мэргэшсэн хүмүүс ойр ойрхон солигддог нь хүндрэл үүсгэдэг байна.²²

Шинэ төрлийн гэмт хэргийн гаралт, олон улсад анхаарал татаж буй асуудлуудад тулгуурлан хуулийн байгууллагын ажилтнуудыг сургах, давтан сургах ажилд тухайн байгууллагууд мэдрэмжтэй хандаж, жил бүрийн сургалтын төлөвлөгөөгөө явцуу сэдвийн хүрээнд батлан гаргахаа больж, гүйцэтгэлд нь хяналт, үнэлгээ хийх шаардлагатай болжээ. Мөн хуульчдад кредит олгох сургалт явуулдаг Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн ажлаа эрчимжүүлж, цаг үетэйгээ зохицон мэдрэмжтэй ажиллах цаг нь болсон байна.

Зөвлөмж: Гадаадын иргэнд Монгол Улсын иргэн, харьяат хүүхдийг үрчлэх журамд яаралтай өөрчлөлт оруулах; (2010)

1999 оноос өнөөдрийг хүртэл Монгол Улсын харьяат нийт 220 хүүхэд 13 улсын харьяат гэр бүлд үрчлэгдсэн байна.²³ Үүнээс 122 эрэгтэй, 98 эмэгтэй хүүхэд байх бөгөөд насны хувьд 95 хувь нь 0-6 насны хооронд байна.

Монгол Улс 1998 онд “Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай” Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцид нэгдэн орсноор Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх асуудлыг дотоодын хууль тогтоомж болон бусад эрхийн актуудад анх тусгасан. Тухайлбал Гэр бүлийн тухай хууль, Хууль Зүй, Дотоод Хэргийн сайд, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2011оны 100/32 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэнд

²²“Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр”-т хийсэн үнэлгээний тайлан, УБ., 2010 он, 34 дэх тал.

²³ “Иргэдийн хүн худалдаалах гэмт хэрэгт өртөхөөс хамгаалах асуудал”, 2011 он, 68 дахь тал.

Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам” зэрэг эрх зүйн актаар өнөөдөр зохицуулж байна.

Энэхүү үрчлэлтийн журам нь Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцид нийцэж байгаа ч зарим асуудлыг бүрэн, тодорхой тусгаж зохицуулаагүй тул Комиссоос Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах зөвлөмжийг гаргасан.

“Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх” журамд нэмэлт өөрчлөлт одоогоор ороогүй байна. Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамнаас уг журамд нэмэлт өөрчлөлт оруулах журмын төслийг боловсруулан Хууль Зүй, Дотоод Хэргийн сайд, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар Хууль зүй, Дотоод Хэргийн Яаманд хүргүүлэхээр бэлтгэсэн байна. “Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх журамд нэмэлт өөрчлөлт ороогүй байгаа нь Гэр бүлийн тухай хуулийн шинэчлэн найруулах ажил удаашралтай байгаатай холбоотой байна.

Зөвлөмж: Гадаадын иргэнтэй гэр бүл болох асуудлыг зуучилдаг хувь хүн болон хуулийн этгээдийг нарийн судлан шалгаж, хууль зөрчиж үйл ажиллагаа явуулсан тохиолдолд хуулийн хариуцлага хүлээлгэн, үйл ажиллагаа явуулах дүрэм журмыг нь хуульд нийцүүлэх, түүнчлэн зуучлалын үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдэд тусгай хөтөлбөрийн дагуу сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах; (2010)

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад “Гэр бүл зуучлал”-ын нэрийдлээр охид, эмэгтэйчүүдийг гадаадын иргэдтэй тодорхой төлбөртэйгээр гэрлүүлэх үйл ажиллагаа явагдаж байна. 2003-2007 оны хооронд гадаадын иргэнтэй гэрлэсэн Монгол иргэдийн тоо 446 хүнээр буюу 54.1 хувиар өсч, тэдгээрийн 90-95 хувийг эмэгтэйчүүд эзэлсний олонх нь буюу 70 хувь нь Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдтэй гэр бүл болсон байна.²⁴

Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын бүртгэлээс ирүүлсэн мэдээгээр 2003 онд 530, 2004 онд 679, 2005 онд 697, 2006 онд 821, 2007 онд 976, 2008 онд 780, 2009 онд 733, 2010 оны 9 дүгээр сарын байдлаар 338 монгол иргэн гадаадын иргэнтэй гэрлэжээ.

Зарим нэг судалгаанаас харахад хууль бус гэрлэлт зуучлалын компани, хувь хүмүүсээр зуучлуулсан иргэдийн олонх нь харийн нутагт очиж, хүчирхийлэл дарамтад өртөж, байнгын боолчлолын байдалд орон, эрх ашиг нь зөрчигдөж хүн худалдаалах

²⁴ Швейцарийн Хөгжлийн агентлаг, Хүний Аюулгүй Байдлын Судалгааны Төв, Гадаадын иргэнтэй гэр бүл болж буй талаарх судалгаа, УБ., 2008 он.

гэмт хэргийн хохирогч болох эрсдэл өндөр байна.²⁵ Одоогоор шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдэд зуучлалаар гэр бүл болсны улмаас хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хэрэг шийдвэрлэгдээгүй ч энэ асуудлаар хохирогч болсон 45 иргэн Хүйсийн Тэгш Эрхийн төвд, 2 иргэн Хүний Эрх, Хөгжил Төвд хандаж, хуулийн болон сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээнд хамрагдсан байна.

Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын гадаадын иргэдтэй гэр бүл болсон Монгол иргэдийн гэр бүлийн байдлын бүртгэлээс үзэхэд, 1998-2010 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 6 077 хүн гадаадын иргэнтэй гэр бүл болж, мөн хугацаанд 452 иргэн гэр бүлээ цуцлуулжээ.

Монгол эмэгтэйчүүд Зуучлах товчоо буюу хэн нэгний тусламжтайгаар тодорхой хэмжээний мөнгө төлж гадаадын иргэнтэй гэр бүл болж, харийн нутагт хүчирхийлэл дарамтад өртөх жишээ, баримт гарсаар атал гэр бүл зуучлалын үйл ажиллагааг эрхэлдэг эдгээр хувь хүмүүс, болон хуулийн этгээдийн талаар нэгдсэн тоо баримт, судалгаа өнөөдрийг хүртэл улсын хэмжээнд байхгүй байна.

Монгол Улсад гэр бүл зуучлалын үйл ажиллагааг ямар нэгэн байдлаар зохицуулсан хэм хэмжээ байхгүй, гэр бүл зуучлал болон танилцуулах үйл ажиллагааг хариуцсан төрийн ямар нэгэн байгууллага байхгүй, иргэд хувийн шугамаар, танил талаараа уг ажиллагааг явуулж байна.²⁶ Эдгээр нь тодорхой хаяг, тогтмол байршилгүй, нууцлагдмал байдлаар үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн бөгөөд түүнийг хянадаг, хариуцлага тооцдог байгууллага ч байхгүй байна. Иймд энэ байдлыг зохицуулах эдийн засгийн зохицуулалт, хяналт тавьдаг байгууллага байх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Зөвлөмж: *Донорын тухай хууль болон холбогдох дүрэм, журмуудыг нягтлан үзэж, шаардлагатай бол олон нийтэд энэ талаар мэдээлдэг журмыг бий болгох; (2010)*

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын мэргэжилтнүүдийн гаргасан судалгаагаар дэлхийн хэмжээнд зөвхөн бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг жилд ойролцоогоор 68 мянган удаа хийдэг бөгөөд үүнээс 7 мянга нь хууль бусаар буюу эд эрхтэнг нууцаар худалдан авч хийлгэсэн байдаг байна. Сүүлийн жилүүдэд дэлхий дахинаа хүний эд эрхтний худалдаа нь хүн худалдаалах гэмт хэргийн бие даасан нэг төрөл болжээ.

Монгол Улс 2000 онд Донорын тухай хуулийг батлан гаргасан. Үүнтэй холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссоос Донорын тухай хууль болон түүнийг

²⁵ Швейцарийн Хөгжлийн агентлаг, Хүний Аюулгүй Байдлын Судалгааны Төв, Гадаадын иргэнтэй гэр бүл болж буй талаарх судалгаа, УБ., 2008 он.

²⁶ Хүний Аюулгүй Байдлын Судалгааны Төв, “Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэхэд зар сурталчилгаа нөлөөлж байгаа байдал”, 2010 он.

хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журмууд нь хүний эд эрхтэнг хууль бус наймаанд өртөхөөс сэргийлэхэд чиглэж буй эсэхийг сайтар нягтлан үзэх шаардлагатайг өмнөх илтгэлд зөвлөсөн байдаг.

Эрүүл Мэндийн Яам Донорын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулж, хуулийн төсөл, концепцийг боловсруулж, холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлжээ.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага хүний эд эрхтэнг худалдаалах гэмт хэрэг гарч буйг нэгэнт хүлээн зөвшөөрч, амьд хүнийг донор болгон худалдаалахтай тэмцэхийг уриалж байгаа өнөө үед Монгол Улсад энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг цаг алдалгүй зохион явуулах шаардлагатай хэвээр байна.

Зөвлөмж: Хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж буй зар сурталчилгаа, нэвтрүүлгүүдэд дүн шинжилгээ хийж, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд тухайн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай цаашид хамтран ажиллах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (2010)

“Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэхэд зар сурталчилгаа нөлөөлж байгаа байдал”-ын талаарх судалгааг Хүний Аюулгүй Байдлын Судалгааны Төв, Хууль зүйн Үндэсний Хүрээлэнтэй хамтран 2009 оны 6 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн 3 дугаар сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн байна. Энэ судалгааны хүрээнд зар сурталчилгааны талаарх хууль, тогтоомжийн биелэлтийг судлахын зэрэгцээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж буй зар сурталчилгаанд дүн шинжилгээ хийж, хуульд нэмэлт оруулах санал, зөвлөмж гарган холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

Улаанбаатар хот болон Дорноговь аймгийн Замын-Үүд, Эрдэнэт, Дорнод аймгийн Чойбалсан хотыг хамруулсан судалгааны үр дүнд тулгуурлан бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл, зар түгээдэг байгууллагуудыг оролцуулан хэлэлцүүлэг зохион явуулж, зар сурталчилгаанд хяналт тавих байгууллага, албан тушаалтны уялдаа холбоог сайжруулах, тэдний хамтын ажиллагааг нэгтгэх чиглэлээр санал, зөвлөмж гаргасан нь чухал ач холбогдолтой болжээ.

Тус судалгаагаар зар сурталчилгаа нь биеэ үнэлэхийг зохион байгуулах болон хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэхэд хүргэж болзошгүй ямар нэгэн хяналтгүй байгаагийн зэрэгцээ зар сурталчилгааг түгээх хамгийн хүчтэй хэрэгсэл болох телевиз, радио, сонин нь хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаггүй, хариуцлагагүй байгааг тогтоожээ.²⁷ Түүнчлэн Экпат Үндэсний Сүлжээ төрийн бус байгууллагаас ТМ, ТВ-8 зэрэг телевизийн чатуудад илгээсэн мессежийн агуулгад судалгаа хийхэд

²⁷ “Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэхэд зар сурталчилгаа нөлөөлж байгаа байдал” судалгаа, УБ., 2010 он.

явуулсан мессеж зарын 90 хувь нь садар самууны агуулгатай байжээ.²⁸ Ийнхүү хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж буй зар сурталчилгаанд цөөнгүй байгууллага дүн шинжилгээ хийж, тодорхой санал, зөвлөмжүүдийг тусгасан байх бөгөөд эдгээр бодлогын шинжтэй санал, зөвлөмжүүдийг ажил хэрэг болгон хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Зөвлөмж: 2005 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Засгийн газрын 234 дүгээр тогтоолоор баталсан “Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр”-ийг шаардлагатай бол шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх, Үндэсний зөвлөл, түүний ажиллах нөхцөл бололцоо болон хөтөлбөрт заасан заалтуудыг хэрэгжүүлэх төсвийг яаралтай шийдвэрлэж, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх; (2010)

Засгийн газар 2005 оны 11 дүгээр сарын 30 -ны өдрийн 234 дүгээр тогтоолоор “Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр”-ийг батлан гаргасантай холбогдуулан Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 141 дүгээр тушаалаар Үндэсний зөвлөлийг байгуулан ажилласан. Уг зөвлөлийг Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны Төрийн нарийн бичгийн дарга ахалдаг бөгөөд холбогдох төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын нийт 36 төлөөллөөс бүрддэг.

Комиссын 2008 оны илтгэлд Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа төдийлөн хангалтгүй, хойрго байгааг анхааруулснаас хойш хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа харьцангуй тогтмолжиж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд тодорхой ахиц дэвшил гарч байна. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, Үндэсний зөвлөлд техникийн дэмжлэг үзүүлэх, улмаар зөвлөлөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Үндэсний зөвлөлийн зохицуулагч байгууллагыг бий болгон ажиллуулж байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах болон Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулахад ихээхэн хувь нэмэртэй ажил болжээ. Зохицуулагчаар Экпат Үндэсний Сүлжээ төрийн бус байгууллага сонгогдон ажиллаж байна.

Хөтөлбөрт тусгагдсан зарим үйл ажиллагааг төрийн бус байгууллагаар гэрээлэн, зарим гүйцэтгүүлж байгаа нь хөтөлбөрийн хүрээнд гарч байгаа нэг ахиц дэвшил болжээ. Тухайлбал, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамнаас хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2010 онд “Хамгаалах байрны үйлчилгээний удирдамж”-ийн төсөл боловсруулах ажлыг Хүйсийн Тэгш Эрхийн Төв төрийн бус байгууллагатай гэрээлэн, санхүүжилт олгон гүйцэтгүүлжээ.

“Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2010-2012 оны үйл

²⁸ “Иргэдийг хүн худалдаалах гэмт хэрэгт өртөхөөс хамгаалах асуудал”, УБ., 2010 он, 13 дахь тал.

ажиллагааны төлөвлөгөөг зөвлөлөөс хэлэлцэн, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2010 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 96 дугаар тушаалаар батлуулжээ. Хөтөлбөрийн хүрэн дэх үйл ажиллагааны давхардлыг арилгах, зохицуулах ажлыг сайжруулах зорилгоор хөтөлбөрийн 2010 оны тэргүүлэх чиглэлийг батлан, хэрэгжүүлэгч ба санхүүжүүлэгчдэд санал болгосон байна.

Гэвч “Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-т тусгасан үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу явагдахгүй байна. “Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр”-ийг 3 үе шаттайгаар 2015 он хүртэл хэрэгжүүлэхээр хөтөлбөрт заасан бөгөөд 2009 онд Экпат Үндэсний Сүлжээ төрийн бус байгууллагаас хөтөлбөрийн эхний шатны (2006-2008) зорилтын хэрэгжилтэд судалгаа хийсэн бөгөөд хөтөлбөрийн эхний шатны зорилт, үйл ажиллагаа нь бүрэн хэрэгжээгүй гэсэн үнэлгээ өгчээ.²⁹

Нөгөө талаар Үндэсний зөвлөл тогтвортой үйл ажиллагаа явуулахад санхүүгийн хүндрэлтэй, үйл ажиллагааны зардал хүрэлцдэггүй байна. Үндэсний Зөвлөлийн үйл ажиллагааг тогтворжуулахад Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан ихээхэн дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа ч Үндэсний Зөвлөлийг үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулахад чиглэсэн болон хөтөлбөрт заасан заалтуудыг хэрэгжүүлэх улсын төсөв хангалтгүй хэвээр байна. Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулан 2006 оноос Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайдын төсвийн багцад жилд дунджаар 20 гаруй сая төгрөг тусгадаг нь төсвийн санхүүжилт хангалтгүй, хөтөлбөрийн ихэнх үйл ажиллагаа гадаад орон, олон улсын байгууллагын дэмжлэг, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар хэрэгжиж байгааг харуулж байна.

Цаашид хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлэх талаар Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам идэвхтэй үйл ажиллагаа явуулж, Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг улам эрчимжүүлэн тогтмолжуулах шаардлагатай.

Зөвлөмж: Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэн ажилладаг Цагдаагийн байгууллагын бүтцийг өргөжүүлэх; эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулахдаа бусад төрлийн гэмт хэргийн хохирогч нараас тусад нь тусгайлсан өрөө, тасалгаа ашиглах; (2010)

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2010 оны 394 дүгээр тушаалаар Улсын Мөрдөн Байцаах Газарт “Хүн худалдаалах болон зохион байгуулалттай гэмт хэрэг мөрдөх тасаг”-ийг байгуулсан байна.³⁰ Байгуулагдсанаас хойш 18 хохирогч, 13

²⁹“Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр”-т хийсэн үнэлгээний тайлан, УБ., 2010 он, 10 дахь тал.

³⁰“Хүн худалдаалах гэмт хэргээс иргэдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх мэдээлэл”, УБ., 2011 он.

холбогдогчтой 8 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаа явуулжээ.

Тус тасагт 1 тасгийн дарга, 4 мөрдөн байцаагчийн орон тоо батлагдсан боловч одоогоор тасгийн дарга, 3 мөрдөн байцаагчтай ажиллаж байна. Өрөө тасалгааны хүрэлцээгүйгээс нэг өрөөнд 4 мөрдөн байцаагч ажиллаж байгаа бөгөөд энэ нь гэмт хэргийн хохирогчдын хувь хүний нууцтай холбоотой асуудлыг шалгаж, шийдвэрлэхэд хүндрэл учруулдаг тул ажиллах нөхцөл, бололцоогоор бүрэн хангах асуудлыг Улсын Мөрдөн Байцаах Газар, түүний удирдлагууд анхаарах шаардлагатай байна.

Уг нь тус тасгийг байгуулах болсон хэрэгцээ, шаардлагаас үзэхэд тус тасаг нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг мөрдөн шалгах талаар өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулах шаардлагатай атал үйл ажиллагаа нь төдийлөн хангалттай биш байгаа нь хүн хүчний нөөцийн хязгаарлагдмал байдал, тодорхой дэмжлэг дутмаг байгаатай холбоотой.

2010 оны 1 дүгээр сард Хүйсийн Тэгш Эрхийн Төв төрийн бус байгууллагын хэрэгжүүлсэн төслийн дэмжлэгтэйгээр Улсын Мөрдөн Байцаах Газарт хохирогчоос мэдүүлэг авах өрөөг нээн, анхан шатны шаардлагатай тоног төхөөрөмжийг бий болгожээ. Хохирогчоос мэдүүлэг авах өрөөг амжилттай ажиллуулснаар гэмт хэргийн хохирогч, тэр дундаа хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг байцаах, аюулгүй байдал, нэр төр, нууцлалын асуудал болон гэмт хэрэгтэнг таниулах үйл ажиллагаанд чухал дэвшил гарах билээ. Гэвч тус өрөөг зориулалтын дагуу бүрэн дүүрэн ашиглахгүй, гэмт хэргийн бүх хохирогчдыг байцаах өрөө болгон ашиглаж байгааг даруй өөрчлөх шаардлагатай байна.

Зөвлөмж: Гадаадад зорчих баримт бичиг олгох, хилээр нэвтрүүлэх асуудлыг хяналтанд авдаг, тогтмол бүртгэлтэй болгох тогтолцоонд шилжих; хараа хяналтгүй хүүхдүүдийн талаарх мэдээллийг хилийн шалган нэвтрүүлэх албад, иргэний бүртгэл мэдээллийн байгууллагуудад мэдээлдэг болох; (2010)

Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх асуудлыг 1993 оны Хилийн тухай хуулиар зохицуулдаг.

Хилийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.11 дэх хэсэгт “Улсын хилийн болон хил орчмын дэглэм, хилийн боомтоор нэвтрүүлэх журмыг сахиулахад хяналт тавихын тулд зайлшгүй шаардлагатай бүртгэл хөтөлж, энэ зорилгоор Үндсэн хуульд харшлахгүй мэдээллийн тогтолцоог ашиглах” талаар заасныг баримтлан хил нэвтрэх, орох зорчигчдын асуудлыг зохицуулах тухай хувь хүнтэй холбоотой мэдээлэл, хөдөлгөөний талаар нэгдсэн сүлжээг бүрдүүлэн ажиллаж иржээ. Иргэний Бүртгэл Мэдээллийн Улсын Төвийн иргэний бүртгэл мэдээллийн сүлжээнд 5 боомт холбоотой

байсныг нэмж, байнгын ажиллагаатай 20 шалган нэвтрүүлэх боомтыг холбосон нь хилээр нэвтэрч буй хүний бүртгэл цаг тухайдаа хяналтад орж байгаа нь сайшаалтай байна.

Өмнөх илтгэлд дурдсан анхаарал татсан зарим асуудал хэвээр байна. Хүүхдэд олгож буй төрсний гэрчилгээ зураггүйгээс уг гэрчилгээ гадаадад зорчих гэж буй хүүхдийнх мөн эсэхийг тогтооход хүндрэлтэй, хавсралтаар яваа хүүхдийн талаар гадаадад зорчиж буй хүүхдийг өөр бусад хүний (асран хамгаалагч) паспортод нь хавсралт бичиж гаргах боломжтой байна. Хилийн шалган нэвтрүүлэх боомтын ажилтан нь зөвшөөрөгдсөн баримт бичгээс бусад зүйлийг шаардах эрх байдаггүйгээс хилээр дамжин өнгөрч байгаа насанд хүрээгүй хүүхэд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох боломжийг бүрдүүлэхгүй гэх баталгаагүй байна.³¹

Хил Хамгаалах Ерөнхий Газраас гаргасан тоон мэдээллээс үзэхэд 2007 онд 40393 хүүхэд гадагшаа зорчиж, тэднээс 1 281 хүүхэд буцаж ирээгүй байна.³² 2006 онд 26 118 хүүхэд гадагш зорчсоноос 22 523 хүүхэд буцаж ирсэн, 2010 онд 55 276 хүүхдээс 52 620 нь буцан ирж, 2 656 хүүхэд эргэж ирээгүй байна.³³ Жил бүр гадагшаа зорчих хүүхдийн тоо өсөхийн хэрээр эх орондоо буцаж ирээгүй хүүхдийн тоо нэмэгдэж байгааг судалгаанаас харж болох ч, хүүхдүүд буцаж ирээгүй шалтгааныг шалган тогтоодог тогтолцоо манайд байхгүй байна.

Хил хамгаалах байгууллага хараа хяналтгүй хүүхдийг онцгойлон авч үзээгүй ч хилийн боомтуудаар нэвтэрч буй насанд хүрээгүй хүн, тэдгээрийн асран хамгаалагчийн талаар бүртгэл хөтөлж, хяналт тавьдаг журмыг мөрдөн ажиллаж, хилээр хүүхэд дагуулан гарч буй насанд хүрсэн хүний гадаад паспорт дээр хэдэн хүүхэд дагуулж гарч байгаа тухай тэмдэглэл хийдэг болжээ. Цаашид жирэмсэн эмэгтэйн бүртгэлийг ч ийм байдлаар хийх нь энэ төрлийн гэмт хэргээс сэргийлэхэд чухал ач холбогдолтой болно.

Насанд хүрээгүй иргэдийн зорчих асуудалд хяналтыг улам сайжруулах ялангуяа хараа хяналтгүй хүүхдийн талаарх мэдээллийг хилийн шалган нэвтрүүлэх албад, иргэний бүртгэл мэдээллийн байгууллагууд харилцан солилцдог болох шаардлагатай байна. Энэ талаар Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр мэдээлэл бэлтгэсэн байна. Уг мэдээлэлд насанд хүрээгүй иргэнийг гадаадад дагуулан зорчсон иргэдтэй тухайн хүүхэд эргэж орж ирсэн эсэхийг тооцдог болох, ийм үүргийг тухайн иргэдэд хуулиар хүлээлгэх, гадаад паспорт олгох, хугацааг нь сунгах, төрсний гэрчилгээ болон гадаад паспортын үйлдвэрлэл, нууцлалыг сайжруулж, эдгээр баримт бичгийг хуурамчаар үйлдэх боломжийг хаах, гадагш зорчихдоо өмнө нь дагуулж гарсан хүүхдийн талаарх

³¹ “Иргэдийг хүн худалдаалах гэмт хэрэгт өртөхөөс хамгаалах асуудал”, 2010 он, 11 дэх тал.

³² Хил Хамгаалах Ерөнхий Газрын статистик мэдээ, 2011 он.

³³ Мөн талд.

бодит мэдээллийг шаардах, хянах эрхийг Хил Хамгаалах Ерөнхий Газар, Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын бүрэн эрхэд хамруулах талаар Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай болон Иргэний бүртгэлийн тухай холбогдох хуульд өөрчлөлт оруулах байдлаар зохицуулах, насанд хүрээгүй иргэнд үндэсний гадаад паспорт олгох зэрэг асуудлыг тусгажээ.

Зөвлөмж: Хуулийн байгууллагууд болон төрийн, төрийн бус бусад байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, үнэн зөв мэдээллээр шаардлагатай тохиолдолд ямар нэгэн саадгүйгээр нийгэм, олон нийтийг хангах, хуулийн заалтад харшлахгүй бол бусад тохиолдолд хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; Түүнчлэн энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хүрээнд хамтарсан судалгааны ажлыг зохион байгуулах, эрсдэл бүхий бүлгүүд болон тэдгээрийн талаарх мэдээллийг нэг мөр болгон гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулах; (2010)

Одоогоос 10 гаруй жилийн өмнө хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар цөөхөн тооны төрийн бус байгууллагууд болон хандивлагч орнууд анхааран ажиллаж байсан бол өнөөдөр 30 гаруй төрийн бус байгууллага, 12 хандивлагчийн тусламжтайгаар 1-5 жилийн хугацаатай 13 төсөл, хөтөлбөр хэрэгжсэн байна. Өнөөгийн байдлаар хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр 2 байгууллага хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээ, 5 байгууллага хуулийн зөвлөгөө, 4 нь сэтгэл зүйн зөвлөгөө, 10 орчим байгууллага сургалт явуулах, чадавхи бэхжүүлэх үйлчилгээ эрхэлж байна.³⁴ Төрийн бус байгууллагаас Хүний Аюулгүй Байдлын Судалгааны Төв, Хүйсийн Тэгш Эрхийн Төв, Хүний Эрх Хөгжил Төв, Экпат Үндэсний Сүлжээ идэвхтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэ чиглэлээр ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, хоорондын уялдаа холбоо сүүлийн жилүүдэд сайжирч байна. Ялангуяа төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудын төлөөлөл ажилладаг Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан “Үндэсний зөвлөл”-ийн үйл ажиллагаа тогтворжиж, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон байгууллагууд улирал бүр тогтмол уулзаж, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаж байгаа нь сайшаалтай байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн чиглэлээр ихэнх ажлыг төрийн бус байгууллагуудаас санаачлан төрийн холбогдох байгууллагуудтай хамтран тэдний дэмжлэгийг авах чиглэлээр олон ажил зохион байгуулжээ. Ялангуяа хамтарсан сургалт, судалгааны ажлууд нилээд хийгдсэн байна. 2005-2009 оны байдлаар төрийн бус байгууллагууд бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр олон улсын байгууллага, гадаад орнуудын 12 санхүүжүүлэгчээс урт, богино

³⁴ “Иргэдийг хүн худалдаалах гэмт хэрэгт өртөхөөс хамгаалах асуудал”, 2011 он, 11 дэх тал.

хугацааны 13 төсөл хэрэгжүүлжээ. Төслийн хүрээнд хийгдсэн ажлуудыг тоймлон үзвэл 47 судалгаа, 33 гарын авлага, сурах бичиг боловсруулж, 66 төрлийн сурталчилгааны материал, мэдлэг, хандлага, чадавх нэмэгдүүлэх 450 сургалтад 11 000 хүн хамруулж, 417 уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, 96 630 хүнийг кампанит ажилд хамруулж, 5 378 хүнд үйлчилгээ өгсөн байна.³⁵

Төрийн байгууллагаас зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагатай гэрээлэн хийж гүйцэтгүүлсэн нь хамтын ажиллагааны чухал алхам болсон байна. Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамнаас хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг хүртээмжтэй байдлаар зохион байгуулах ажлын хүрээнд орон нутгийн иргэд, албан хаагчдын оролцоо, саналд тулгуурласан мэдээлэл, сурталчилгааны агуулга, хэлбэрийг тодорхойлох зорилгоор Дорнод, Сэлэнгэ аймагт болон Нийслэлийн дүүргүүдийн зарим зорилтот бүлгүүдэд мэдээлэл, сурталчилгааны төслийг Эрин Үе Хөгжил төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлсэн байна.

Энэ хугацаанд хүн худалдаалах асуудлаар олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран нэлээд судалгаа хийжээ. Ялангуяа Швейцарийн Хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Хүний Аюулгүй Байдлын Судалгааны Төвөөс хийсэн судалгааг энд дурдаж болно. “Гадаадын зарим орны хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжид хийсэн харьцуулсан судалгаа”, “Орон нутагт гарч буй хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл”, Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн талаарх олон нийтийн ойлголт”, “Хараа хяналтгүй хүүхдийн талаарх судалгаа”, “Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэхэд зар сурталчилгаа нөлөөлж байгаа байдал” зэрэг судалгааг холбогдох төрийн байгууллага болон мэргэшсэн судалгааны байгууллагуудтай хамтран үндэсний хэмжээнд явуулжээ.

Үүнээс үзэхэд, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа сайжирч, төрийн бус байгууллагуудын зарим санал, санаачлагыг төрөөс дэмжиж хамтран ажиллаж байгаа нь сайшаалтай ч цаашдын хамтын ажиллагааг улам сайжруулахад анхаарах зарим асуудалд байгаа нь Үндэсний хөтөлбөрийн үнэлгээний тайлангаас харагдаж байна.

...Хүн худалдаалахтай тэмцэх асуудлаар удаа дараа хурал, цуглаан, зөвлөгөөн хийж, олон санал, дүгнэлт гаргадаг боловч төрөөс үүнийг ажил хэрэг болгоход бага анхаардаг. Төрийн бус байгууллагаас хэрэгжүүлсэн төсөл, хийсэн судалгааны дүн, санал, зөвлөмжөө хүргүүлдэг боловч төр бодлого шийдвэртээ тусгах, тэдгээрийг эргэн харж, ашиглахгүй байна...

³⁵ “Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр”-т хийсэн үнэлгээний тайлан, УБ., 2010 он, 29 дэх тал.

“Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр”-т хийсэн үнэлгээний тайлангаас...

Иймд төрийн болон төрийн бус байгууллага, хууль хяналтын байгууллагууд хамтын ажиллагаагаа улам сайжруулж, үйл ажиллагаагаа уялдуулахын зэрэгцээ төрөөс олон ажлыг санаачлан хэрэгжүүлэх, энэ чиглэлд санхүүжилтийг харамгүй гаргах нь зүйтэй байна.

Зөвлөмж: Хараа хяналтгүй, тэнэмэл, биеэ үнэлдэг насанд хүрээгүй хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах ажлыг эрхлэн явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулан, хяналтын тогтолцоог үр өгөөжтэй болгоход хамтран ажиллах; (2010)

Хараа хяналтгүй, тэнэмэл, биеэ үнэлдэг насанд хүрээгүй хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах ажлыг эрхлэн явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын хоорондын уялдаа муу байгаа талаар өмнөх илтгэлд дурдагдаж байсан. Ялангуяа Мэдээллийн нэгдсэн сүлжээ байхгүй, хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудад ирсэн, гарсан, шилжсэн талаар хяналт тавих нэгдсэн тогтолцоогүй байгаа нь эдгээр хүүхэд хүн худалдах, үндэстэн дамнасан зохион байгуулалттай аливаа гэмт хэргийн золиос болох эрсдэлтэй хэвээр байна.

Хүний Аюулгүй Байдлын Судалгааны Төв төрийн бус байгууллагаас санаачлан хараа хяналтгүй иргэд, хүүхдийн албан ёсны, нэгдсэн судалгааг Монгол Улсад анх удаа хийсэн нь хараа хяналтгүй иргэд, хүүхэд зэрэг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох эрсдэлтэй хүмүүсийн мэдээллийн санг үүсгэх, тэднийг уг хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой судалгаа болжээ. 2010 оныг хүртэл ийм судалгаа манай улсад хийгдэж байгаагүй бөгөөд Хүүхдийн Төлөө Үндэсний Газар, Цагдаагийн Ерөнхий Газар болон Нийслэлийн Цагдаагийн Газрын дэргэдэх Хүүхдийн Халамж Үйлчилгээний Төв, Хүний Аюулгүй Байдлын судалгааны төв хамтран явуулснаараа онцлог байна.

Судалгаагаар улсын хэмжээнд 706 тэнэмэл иргэн үүнээс 456 буюу 64,6 хувь нь нийслэлд, 250 буюу 35,84 хувь нь орон нутагт бүртгэгдсэн бөгөөд нийт иргэдийн 85,2 хувийг 11-17 насны хүүхдүүд эзэлж байна.³⁶

Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам орон гэргүй хүмүүс, хүнд нөхцөлд буй хүүхдийн нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг ханган ажиллуулдаг төрийн захиргааны төв байгууллагын хувьд эцэг эхийн хараа хяналтаас гадуур “гудамжны”

³⁶ Хүний Аюулгүй Байдлын Судалгааны Төвийн “Хувь заяа төслийн хүрээнд хийсэн судалгаа”, УБ., 2010 он, 10 дахь тал.

гэх тодотголтой хүүхэдгүй болох зорилт тавин, хүүхдийг урлагаар дамжуулан нийгэмд төлөвшүүлэх “Хөгжим хүүхдийн хөгжилд” төслийг амжилттай хэрэгжүүлж, загвар төсөл бий болгожээ. Төслийн хүрээнд Хүүхдийн халамж, Үйлчилгээний Төвд бүртгэлтэй, олон жил гэрээсээ дайжсан 45 хүүхдийг тусгай байранд байрлуулан, Латин Америкийн сая сая хүүхдийг сонгодог хөгжмөөр дамжуулан нийгэмшүүлсэн “El Systema” хөтөлбөрийн туршлагад үндэслэн нийгэмшүүлэх үйл ажиллагааг шат дараалан хэрэгжүүлж байгаа талаар мэдээлэл ирүүлжээ.

Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам “Хөгжим хүүхдийн хөгжилд загвар төсөл”-д тулгуурлан гудамжинд байгаа болон шинээр бий болж болзошгүй хүүхдүүдийг нэгэн адил хамруулах замаар хараа хяналтгүй хүүхдийн тоог цөөрүүлэх, эцэг, эхийн хараа хяналтаас гадуур хүүхдүүдийг нийгэмшүүлэх чиг үүрэг бүхий “Хүүхдийн Хөгжил, Хамгааллын Төв” төсөвт байгууллагыг тус яамны дэргэд байгуулахаар төлөвлөсөн байна.

Иймд энэ асуудлын хүрээнд Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам холбогдох байгууллагуудтай хамтран хараа хяналтгүй, тэнэмэл гэгдэх хүүхдийн талаарх улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох асуудлыг анхааралдаа авч ажиллах шаардлагатай байна.

1.3 Өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрх

Зөвлөмж: Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг, улсын төсвөөс санхүүждэг өмгөөлөгч бий болгож ажиллуулах журмыг судалж хэрэгжүүлэх; (2010)

Хууль зүйн үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг сайжруулах зорилгоор “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолоор баталсан бөгөөд энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр төлбөрийн чадваргүй иргэдэд эрүүгийн хэргийн бүх шатанд хууль зүйн туслалцаа үзүүлэх, харьяа нутаг дэвсгэрийнхээ иргэдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх, эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй “Эрх зүйн туслалцааны төв”-ийг нийт 30-ыг байгуулан, 2008 оноос 21 аймаг, Нийслэлийн 9 дүүрэгт тогтвортойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Одоогоор Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн өмгөөлөгчид төлбөрийн чадваргүй иргэдийг ямар нэг төсвийн санхүүжилтгүйгээр сайн дурын үндсэн дээр иргэд, байгууллагын хүсэлтээр өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байна. 2010 оны байдлаар төлбөрийн чадваргүй 290 иргэн өмгөөлүүлэх хүсэлтээ Монголын

Өмгөөлөгчдийн Холбоонд гаргасан ба үүнээс 265 иргэнд өмгөөлөгч томилох өмгөөллийн үйлчилгээ үзүүлжээ. Одоогийн байдлаар Монголын Өмгөөлөгчдийн Холбоо төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөгч томилох журам боловсруулж байна.

Зөвлөмж: Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь өмгөөлөгчийн оролцооны талаарх хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгож, өмгөөлөгчийн эрх үүргийг нэмэгдүүлэх, өмгөөлөгч өөрөө нотлох баримт цуглуулах, бүрдүүлэх эрх хэмжээтэй болгох боломжийг судлан хэрэгжүүлэх, өмгөөлөгчдийн ёс зүйн асуудлыг анхаарах; (2010)

Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдын 2011 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 25 дугаар тушаалаар Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлыг хэсэг байгуулсантай холбоотойгоор Монголын Өмгөөлөгчдийн Холбооны дэргэд ажлын хэсэг байгуулжээ.

Энэхүү ажлын хэсэг нь эрүүгийн хэргийн талаар өмгөөллийн үйл ажиллагаа явуулахад тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг танилцуулах, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчийн мэтгэлцэх боломж, оролцоог бүрэн хангахуйц эрх зүйн шинэ зохицуулалт бий болгох үзэл баримтлал, тодорхой томъёоллыг бэлтгэх, судалгааны үндсэн дээр одоо мөрдөж буй Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарласан зүйл, заалт, хэм хэмжээний талаар дүгнэлт санал боловсруулах, цахим хуудсаар дамжуулан, өмгөөлөгчдөөс санал авах ажлыг гүйцэтгэж байна.

Тухайн асуудлаар прокурор болон цагдаагийн байгууллагатай хамтарсан зөвлөгөөнийг 2010 онд хийсэн ба 2011 оны “Шударга ёс, хөгжил, дэвшил” форумд Өмгөөлөгчдийн Холбооноос тусгайлан өмгөөлөгчийн эрх, үүргийг нэмэгдүүлэх, өмгөөлөгч өөрөө нотлох баримт цуглуулах, бүрдүүлэх эрх хэмжээтэй холбоотойгоор санал боловсруулан оролцохоор бэлтгэж байна.

Монголын Өмгөөлөгчдийн Холбооны ээлжит 12 дугаар их хурлаас өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн асуудлыг хянан хэлэлцдэг Сахилгын хорооны дэргэд тусгайлан ажлын албыг орон тооны 2 ажилтантайгаар байгуулж, өмгөөлөгчдийг мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргахгүй, ёс зүйтэй ажиллуулах талаар ихээхэн анхаарч байна. Сахилгын хорооны ажлын алба өмгөөлөгчдийн мэргэжлийн ёс зүйн асуудалтай холбоотой гомдол ирсэн тохиолдолд уг гомдлыг шалган нотолж баримтжуулан, тус хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, ёс зүйн зөрчил гаргаж буй өмгөөлөгчдөд арга хэмжээ авч зөрчил гаргасан өмгөөлөгчдийн талаар “Өмгөөлөгч” сэтгүүл болон өөрийн цахим хуудсанд байнга мэдээлэл гаргаж байна. Энэ нь өмгөөлөгчдийг мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргахгүй байх урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэрэгсэл юм.

Сахилгын арга хэмжээ авагдсан 44 өмгөөлөгчийн 61,3 хувь буюу 27-д нь сануулах сахилгын шийтгэл, 29,5 хувь буюу 13-д нь 3 сар хүртэл хугацаагаар өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, 9 хувь буюу 4 өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналыг Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдад уламжилжээ.

Сахилгын хороонд ирүүлсэн гомдлын 42 буюу 38,5 хувийг гэрээ хэлцэлд заасан өмгөөлөх үүргээ биелүүлээгүй буюу хангалтгүй биелүүлсэн гэх гомдол, 18 буюу 16,5 хувийг өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүй зөрчсөн тухай, 22 буюу 20,1 хувийг өмгөөлөгч хууль бус үйл ажиллагаа явуулсан гэх гомдол, 13 буюу 11,9 хувийг өмгөөлөгч бусдыг доромжилсон, дарамталсан гэх гомдол, 7 буюу 6,4 хувийг өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хурлыг хойшлуулсан тухай гомдол, 4 буюу 3,6 хувийг өмгөөлөгч үйлчлүүлэгчийнхээ эсрэг талын хүмүүсийн нэр төрийг гутаасан гэх гомдол эзэлж байна.

Үүнээс үзвэл өмгөөлөгч үүргээ биелүүлээгүй буюу хангалтгүй биелүүлсэн, өмгөөлөгчийн ёс зүйгээ зөрчсөн, өмгөөлөгч хууль бус үйл ажиллагаа явуулсан тухай 3 төрлийн гомдол нь нийт гомдлын 82 буюу 75,1 хувийг эзлэж байгаа нь өмгөөлөгчдөөс үйлчлүүлэгчдийнхээ нийтлэг эрх ашгийг төдийлөн сайн хангаж чадахгүй байгаа нь харагдаж байна.

Сахилгын хороо Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгчийн ажлын албатай хамтран холбооны гишүүний татварын өрийг төлүүлэхэд анхааран ажилласнаар 235 өмгөөлөгчид холбогдох 45.5 сая төгрөгийн татварыг нөхөн барагдуулжээ. Цаашид өмгөөлөгчийн ёс зүй, сахилгыг чанд сахин хуулийн дагуу ажиллахад анхаарах шаардлагатай байна.

Зөвлөмж: Хөдөө орон нутаг дахь өмгөөлөгчийн тоог нэмэгдүүлж, өмгөөлөгчөө сонгох эрхийг байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдод олгох; (2010)

Хүн ам төвлөрсөн сумд болох Дорноговь аймгийн Замын-Үүд, Өвөрхангай аймгийн Хархорин, Завхан аймгийн Тосонцэнгэл, Сэлэнгэ аймгийн Мандал, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Ховд аймгийн Булган сумын Засаг Даргын Тамгын Газрын дэргэд Эрх зүйн туслалцааны төв байгуулагдаж, 2010 оны 10 дугаар сараас үйл ажиллагаагаа эхлээд байна. Эдгээр төвүүдийг тухайн сумын Засаг Даргын Тамгын Газруудаас байр, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн "Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх" төслөөс техник, тоног төхөөрөмжөөр ханган ажиллах нөхцөлийг нь бүрдүүлсэн. Ховд аймгийн Булган, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Эрх зүйн туслалцааны төвд ажиллах өмгөөлөгчдөд олгох цалингийн төсөв хүрэлцэхгүйгээс шалтгаалан эдгээр төвд ажиллах өмгөөлөгч нар гэрээ байгуулалгүй ажиллаж байна.

Монголын Өмгөөлөгчдийн Холбооноос авсан мэдээллээр нийт өмгөөллийн эрх олгосон 1590 хүнээс өмгөөлөгчөөр ажиллаж байгаа 1247, өмгөөллийн эрхээ түдгэлзүүлсэн 152, өмгөөллийн эрх нь хасагдсан 230 өмгөөлөгч байгаа ба нийслэлд үйл ажиллагаа явуулдаг 1044, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 203 өмгөөлөгч байгаа бол 2005 онд 152, 2006 онд 122, 2007 онд 132, 2008, 2009 онуудад тус бүр 168, 2010 онд 206 өмгөөлөгч хөдөө орон нутагт ажиллаж байна. Аймгуудаар нь авч үзвэл:

д/д	Салбар зөвлөл	2005	2006	2007	2008	2009	2010
1	Архангай аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	6	5	5	6	6	6
2	Баянхонгор аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	4	3	2	4	3	8
3	Баян-Өлгий аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	4	3	2	2	2	6
4	Булган аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	2	3	2	3	6	6
5	Говь-Алтай аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	4	3	3	4	4	4
6	Говьсүмбэр аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	5	2	2	2	2	2
7	Дархан-Уул аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	15	13	13	19	18	19
8	Дорноговь аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	5	2	5	7	8	8
9	Дорнод аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	11	3	11	11	12	15
10	Дундговь аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	10	5	5	6	6	7
11	Завхан аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	4	4	3	4	4	6
12	Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Өмгөөлөгчдийн зөвлөл	2	0	1	1	1	1
13	Сүхбаатар аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	5	4	4	6	6	7
14	Сэлэнгэ аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	11	12	9	9	9	10
15	Сэлэнгэ аймгийн Мандал сумын Өмгөөлөгчдийн зөвлөл	5	0	4	4	4	4
16	Орхон аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	18	18	22	24	24	27
17	Өвөрхангай аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	6	6	7	10	9	14
18	Өмнөговь аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	4	5	5	7	7	8
19	Увс аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	5	5	4	8	8	11
20	Төв аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	6	6	6	6	6	7
21	Ховд аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	7	8	5	10	8	11
22	Хөвсгөл аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	4	4	4	7	6	8
23	Хэнтий аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл	6	8	6	6	6	7
24	Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Өмгөөлөгчдийн зөвлөл	3	0	2	2	3	4

Нийт	152	122	132	168	168	206
------	-----	-----	-----	-----	-----	-----

Өмгөөллийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.8 дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгч жилд хоёр удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх, хууль зүйн туслалцаа үзүүлэхээр заасан байдаг.

Улсын Их Хурал 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Нотариатын тухай хуулийг шинэчлэн баталж өмгөөлөл болон нотариатын эрхтэй байсан хуульчдад аль нэг эрхийг дагнан сонгох хуулийн зохицуулалт хийжээ. Үүнтэй уялдан 2011 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар өмгөөллийн эрхээ хадгалж үлдэх саналыг орон нутгаас 4, хотоос 5 хүн Монголын Нотариатчдын Танхимд ирүүлсэн бол Монголын Өмгөөлөгчдийн Холбоонд 100 өмгөөлөгч өөрийн өмгөөллийн эрхийг түдгэлзүүлэх санал ирүүлсэн байна. Иймээс хөдөө орон нутагт ажиллаж байсан өмгөөлөгчид нотариатын эрхтэйгээ үлдэх үзэгдэл давамгайлснаар өмгөөлөгчдийн тоонд сөргөөр нөлөөлөх, орон нутагт ажиллах өмгөөлөгчийн хүртээмжийг багасгахад нөлөөлжээ.

Өмгөөлөгчөө сонгох эрхийг байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдод өмгөөлөгчдийн лавлагаагаар дамжуулан чөлөөтэй сонгох зарчимд үндэслэн олгож байна.

Зөвлөмж: Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлж буй эрх зүйн туслалцааны хүртээмжийг дээшлүүлж, энэ чиглэлээр ажиллаж буй эрх зүйн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагааг чанаржуулах; (2010)

Эрх зүйн туслалцааны төвд гол төлөв аймгийн хууль зүйн хэлтэс, сум, дүүргийн эрх зүйн асуудал хариуцсан нэгжид түшиглэн, өмгөөлөгч болон эрх зүйн сургалт, сурталчилгааны ажилтан гэсэн 2 орон тоотой ажиллаж байгаа бөгөөд одоогоор өмгөөлөгчдийг гэрээний үндсэн дээр ажиллуулж байгаа ба тухайн аймаг, сум, нийслэлийн дүүргийн хууль зүйн асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн эрх зүйн сургалт, сурталчилгааны асуудлыг давхар хариуцан ажилладаг.

Эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчдийн цалин Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамны жилийн төсөвт сууж байгаа бөгөөд өмгөөлөгчийн нэг сарын үндсэн цалин 240,000 төгрөг байна. Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх өмгөөллийн үйлчилгээний зардалд 2008 онд 15 сая, 2009, 2010 онуудад 78,3 сая, 2011 онд 98,2 сая төгрөгийг баталжээ. Нийгмийн даатгалын тухай хуулийн холбогдох заалт, тус төвийн өмгөөлөгчдийн санал, хүсэлтийг үндэслэн өмгөөлөгчдийн байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувийг 2011 онд төлөхөөр төсөвлөсөн. Гэвч шинээр нэмэгдсэн өмгөөлөгчдийн цалин төсөвт тусгагдаагүй байсан тул энэ онд мөн өмгөөлөгчдийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх боломжгүй, өмнөх оны адил зөвхөн цалинг олгох боломжтой байна.

Эрх зүйн туслалцааны төвүүдийн урсгал зардалд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн "Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх" төслөөс нэг сард 120 ам.доллар олгодог. Үүнтэй уялдан төслийн хугацаанд Эрх зүйн туслалцааны төвийг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлж хэвшихгүй тохиолдолд "Хүний эрхийн Үндэсний Комиссын чадавх бэхжүүлэх" төслийн хүрээнд орон нутагт ажиллаж байсан Хүний эрхийн Үндэсний Комиссын итгэмжлэгдсэн төлөөлөгч нарын адил санхүүжилтгүйн улмаас үйл ажиллагаа шууд зогсож болзошгүйг холбогдох байгууллагууд анхаарах хэрэгтэй.

Одоогийн байдлаар Монгол Улсын хэмжээнд Эрх зүйн туслалцааны төв нь 34 өмгөөлөгч, 31 эрх зүйн ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр төвд 2010 оны байдлаар нийт 16 956 иргэн хууль зүйн туслалцаа авахаар ханджээ. Үүнээс 2 081 иргэн өмгөөллийн туслалцаа авахаар хандсанаас 1 794 хүнд холбогдох 1 615 хэрэгт үнэ төлбөргүй өмгөөллийн туслалцаа үзүүлснээс 1399 хүнд холбогдох 1 262 хэргийг бүрэн шийдвэрлүүлжээ. Түүнчлэн иргэд хоорондын 40 маргааныг эвлэрүүлэн зуучилсан байна.

Баян-Өлгий (1 523), Сэлэнгэ (1 227), Архангай (1 051), Өмнөговь (1 068) аймаг, Налайх (920), Сүхбаатар (926), Баянзүрх (676) дүүргийн Эрх зүйн туслалцааны төвд хамгийн олон иргэн хууль зүйн туслалцаа авахаар ханджээ. Баянхонгор, Орхон, Хэнтий аймаг, Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн өмгөөлөгчид бусдаасаа олон хэрэг дээр ажиллаж, өмгөөллийн туслалцаа үзүүлсэн байна.

Төвүүд төлбөрийн чадвартай, иргэний болон захиргааны хэрэг, сонирхлын зөрчилтэй зэрэг шалтгаанаар 287 хэргийг хүлээн авахаас татгалзсан байна. Энэхүү үндэслэлээр Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Эрх зүйн туслалцааны төв хамгийн их буюу 168 хэргийг хүлээн авахаас татгалзжээ.

Өмгөөллийн туслалцаа үзүүлсэн 1613 хэргээс 123 буюу 7,6 хувь нь онц хүнд, 488 буюу 30,2 хувь нь хүнд, 837 буюу 51,9 хувь нь хүндэвтэр, 165 буюу 10,2 хувь нь хөнгөн гэмт хэрэг эзэлж байна.

Өмгөөлөгч авахаар хүсэлт гаргасан 1999 иргэнээс 105 буюу 5,3 хувь нь Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хэрэг бүртгэлтийн шатанд, 766 буюу 38,3 хувь нь мөрдөн байцаалтын шатанд, 85 буюу 4,3 хувь нь прокурорын хяналтын шатанд, 897 буюу 44,9 хувь нь анхан шатны шүүхэд, 114 буюу 5,7 хувь нь давж заалдах шатны шүүхэд, 32 буюу 1,6 хувь нь хяналтын шатанд өмгөөлөгч авах тухай өргөдөл гарган хандсан байна.

Өмгөөллийн туслалцаа үзүүлсэн эрүүгийн хэргийг төрөлжүүлбэл бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг хамгийн өндөр буюу 34 хувьтай байна. Мөн бусдын

бие махбодид санаатай гэмтэл учруулах (13,1 хувь), танхайрах (13,6 хувь), дээрэмдэх (17 хувь) зэрэг өмчлөх эрхийн эсрэг болон бусдын амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг дийлэнх хувийг эзэлсэн хэвээр байна.

Хууль зүйн анхан шатны зөвлөгөө, лавлагаа өгөх чиглэлээр 2010 онд 8 469 иргэнд хууль зүйн анхан шатны зөвлөгөө, 3 649 иргэнд хууль тогтоомжийн талаарх лавлагаа мэдээлэл өгч тусалсны зэрэгцээ 2 781 иргэнд хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичиг боловсруулж өгчээ.

Өмнөговь, Баян-Өлгий, Увс, Сэлэнгэ аймаг, Налайх, Баянзүрх дүүргийн Эрх зүйн туслалцааны төвүүд хамгийн олон иргэнд хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгч тусалсан бол Архангай, Сэлэнгэ аймаг, Сүхбаатар дүүргийн туслалцааны төвийн өгсөн лавлагаа бусад аймаг, дүүрэгтэй харьцуулахад хамгийн их байна. Мөн Баян-Өлгий аймгийн Эрх зүйн туслалцааны төв эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичиг боловсруулснаараа тэргүүлсэн. Иймээс орон нутаг дахь иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилтэд тодорхой байдлаар эерэгээр нөлөөлж байна гэж үзэх үндэслэлтэй.

Эрх зүйн туслалцааны төвүүдийн тайлангаас үзэхэд иргэд ихэвчлэн нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгал, хөдөлмөрийн эрх зүйн харилцаа, газрын харилцаа, тэр дундаа өмчлөх, эзэмших эрхийн ялгаа, өвөлжөөний маргаан, гэр бүлийн маргаантай холбоотой (гэрлэлт цуцлалт, хүүхдийн тэтгэвэр тогтоолгох эрх, үрчлэлт гэх мэт) холбоотой асуудлаар зөвлөгөө авахаас гадна шүүхэд нэхэмжлэл, хариу тайлбар, хүсэлт гаргах, өргөдөл (гэр бүл салах, ажиллаж байснаа тогтоолгох гэх мэт), өмгөөллийн, зээлийн, барьцааны болон худалдах, худалдан авах гэрээ зэрэг эрх зүйн ач холбогдол бүхий анхан шатны баримт бичиг боловсруулахад туслалцаа хүсдэг ажээ.

Эрх зүйн хөтөч ном, шинээр батлагдсан болон иргэдэд түгээмэл хэрэглэгдэх хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөгөөт, захиалгат болон зайны хэлбэрээр эрх зүйн албан бус сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран 508 удаа 22 000 гаруй иргэнийг хамруулан зохион байгуулжээ.

Зарим аймаг эрх зүйн мэдээлэл бүхий “Аялах хайрцаг”-ийг айл өрх, байгууллагад аялуулж, сумдад эрх зүйн мэдээллийн танхимыг байгуулан аймгийнхаа хэмжээнд ухуулагч-сургагчдыг ажиллуулж, тэднийг жил бүр мэргэшүүлэх сургалтад хамруулдаг, иргэд болон төрийн албан хаагчдад эрх зүйн сургалт явуулдаг тогтсон өдөртэй болсон зэрэг ач холбогдолтой ажлуудыг зохион явуулж байна.

Төвийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан сургалт, сурталчилгаа нь ихэвчлэн хүүхдийн эрхийг хамгаалах,

тамхины хяналт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн халамж (Хүний хөгжил сангийн тухай хууль), гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, хүн худалдах гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх, мал хулгайлах гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх, архивалттай тэмцэх болон хүний эрхийг хамгаалах зэрэг сэдвүүд зонхилсон байна.³⁷

Орон нутгийн анхан шатны нэгжид ажиллаж, амьдарч байгаа хүмүүсийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэхээр сургалт, сурталчилгааг зохион байгуулснаар жилээс жилд тус төвүүдээр үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэх хандлагатай байна.

Төвүүдийн 2010 онд хийсэн ажлыг өмнөх онтой харьцуулбал:

Он	Нийт хандсан	Өмгөөллийн туслалцаа		Эрх зүйн албан бус сургалт, зөвлөгөө, лавлагаа			
		Хүлээн авсан хэргийн тоо /хүн/	Шийдвэрлэсэн хэргийн тоо	Сургалтын тоо	Оролцогч -дын тоо	Зөвлөгөө	Лавлагаа
2009	19 831	1 982/2 278	1 594/1 843	823	46 052	10 449	4 363
2010	16 956	1 615/1 794	1 262/1 399	508	22 064	8 469	3 649

Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 125 дугаар тушаалаар Эрх зүйн туслалцааны төвийн тайлан, бүртгэлийн маягтыг шинэчилж, мөн 2010 оны 126 дугаар тушаалаар Эрх зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаанд мөрдөх чанарын шалгуур үзүүлэлт, түүний биелэлтийг тооцох аргачлалыг тус тус баталсан нь эдгээр төвүүдийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, сайжруулах, мэдээлэл илүү үнэн бодитой гарахад чухал алхам болжээ.

Үүний зэрэгцээ эрх зүйн дээд боловсрол олгож буй төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургуулиудын дэргэд байрлах Хууль зүйн клиник төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлж байна. Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургуулийн Клиник сургалтад 1999-2007 онд 300 орчим оюутан хамрагдаж, хууль зүйн дараах үйлчилгээ үзүүлжээ. Үүнд:

- Эрх зүйн асуудлаар лавлагаа өгөх;
- Шүүхэд төлөөлөх;
- Нэхэмжлэл, өргөдөл, гомдол, гэрээний төсөл боловсруулах;
- Хууль тогтоомж сурталчлах;
- Шүүхийн өмнөх шатанд оролцогчдын эрх ашгийг хамгаалах зэрэг болно.

³⁷ Аймаг, сум, нийслэлийн дүүргийн эрх зүйн туслалцааны төвийн товч танилцуулга, төвийн ажилчдын судалгаа, төвүүдийн ажлын тайлан, 2010 он.

Тус төвөөс хууль зүйн туслалцаа авсан хүмүүсийн 17 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй, 54 хувь нь тэтгэврийн насны иргэд, 9 хувь нь өрх толгойлсон эмэгтэй, 7 хувь нь оюутан, 13 хувь нь эрхэлсэн ажилгүй иргэд байжээ.³⁸

Мөн гадаадын хандивлагч байгууллагуудын дэмжлэгтэйгээр нийслэлийн зарим дүүрэгт хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх үйлчилгээг дадлагажигч оюутнууд гүйцэтгэж байна.

www.mongolianlaws.com цахим хуудсанд болон Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургуулийн практик сургалтын тэнхимээс эрхлэн ажиллуулдаг “Хууль зүйн зөвлөгөө өгөх төв” онлайнаар хууль зүйн төлбөргүй зөвлөгөө өгдөг системийг ашиглалтад оруулсан байна. Иргэдэд үйлчлэх хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой уг систем нь тус практик сургалтын тэнхимийн хууль зүйн клиник сургалтад хамрагдаж, холбогдох чиглэлээр мэргэшиж буй төгсөх ангийн оюутнууд (багшийн удирдлаган дор) судалгаа хийж, 7 хоногийн дотор хариултыг тухайн иргэний дээрх цахим хуудсанд тэмдэглүүлсэн и-мэйл рүү явуулах замаар хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх шинэ алхмыг хийсэн байна.

Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдын 2010 оны 175 дугаар тушаалаар Эрх зүйн туслалцааны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан. Үүний дагуу ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөг ажлын хэсгийн ахлагчаар батлуулан ажиллаж байгаа нь хууль зүйн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сайшаалтай арга хэмжээ болно.

³⁸Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургуулийн практик сургалтын тэнхим www.lawclinic1999.blogspot.com үзсэн 2011.03.28.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

2. УЛС ТӨРИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

2.1 Сонгох, сонгогдох эрх

Комисс Улсын Их Хурлын болон орон нутгийн 2004 оны сонгуулийн үйл явцад дүн шинжилгээ хийж, үр дүнг 2005 оны илтгэлдээ тусган, 7 зүйл бүхий зөвлөмж гаргасан. Зөвлөсөн асуудлын дийлэнх нь 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан байна. Эрх зүйн зохицуулалт боловсронгуй болсонтой холбоотой Улсын Их Хурлын болон орон нутгийн 2004 оны сонгуулийн үеэр гарч байсан, Комиссын илтгэлд дурдсан зөрчил 2008, 2009 онуудын сонгуулийн үеэр харьцангуй багасчээ. Түүнчлэн сонгуулийн үйл явцад хяналт тавих иргэний нийгмийн байгууллагуудын чадавх нэмэгдэж, мэргэжлийн түвшний үйл ажиллагаа явуулах болсон нь чухал алхам болжээ.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт “Санал хураалтын дүнгийн талаар маргаан гарвал санал хураалт явуулсан өдрөөс хойш тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэнэ” гэсний “эцэслэн” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14 дахь хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ...” гэж заасныг зөрчсөн гэсэн шийдвэрийг Үндсэн Хуулийн Цэц гаргажээ. 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр гарсан уг шийдвэрийг Улсын Их Хурал 2010 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн байна. Үндсэн Хуулийн Цэц маргааныг 2011 оны 1 дүгээр сарын хуралдаанаараа эцэслэн шийдвэрлэж, тогтоол гарган Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийг хүчингүй болгожээ. 2008 оны сонгууль, удаах нөхөн сонгуулиудын үеэр санал хураалтын дүнгийн талаар маргаан нилээд гарсан боловч хуулийн дээрх заалтын улмаас иргэдийн хэргээ шүүхээр шийдвэрлүүлэх эрх зөрчигдөж байсан. Ийм байдлыг залруулж, хүний эрхийг хамгаалахад Үндсэн Хуулийн Цэцийн шийдвэр чухал үүрэгтэй байна.

Зөвлөмж: Сонгуулийн хэсэг, тойргийн хороодыг байгуулахад нам, эвсэл, нам бусчуудын төлөөллийн тэнцвэрт байдлыг хангаж, хороодыг байгуулах үйл явцыг ил тод болгох; (2005)

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.3 дахь заалтад "Тойрог, салбар, хэсгийн

хороодын бүрэлдэхүүнд сонгуульд оролцогч аль нэг нам, эвслийн төлөөлөл давамгайлахыг хязгаарлах бөгөөд эвсэлд нэгдэн орсон намуудын төлөөллийг эвслийн төлөөллөөр тооцох", 14.3.4 дэх заалтад "Сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга нэг намын гишүүн байхыг хориглох", 14.3.5 дахь заалтад "Сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд төрийн улс төрийн албан тушаалтныг оруулахыг хориглох" гэсэн заалтууд оржээ.

Монгол Улсын Их Хурлын 2008 оны сонгуулийн тухайд Сонгуулийн Ерөнхий Хороо хуульд заасан хугацаанд буюу сонгууль явуулахаас 40 хоногийн өмнө (2008 оны 5 дугаар сарын 19-ний өдөр) сонгуулийн тойргийн хорооны бүрэлдэхүүнийг цахим хуудсанд байршуулж, нийтэд мэдээлсэн байна. Сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо, тойргийн хороодын бүрэлдэхүүн, түүнд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг Сонгуулийн Ерөнхий Хороо тухай бүр өгч байжээ.

Сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд орж ажиллах нам бусчуудын асуудал анхаарал татаж байна. Хуульд заасны дагуу сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд орж ажиллах нам бусчуудын төлөөллийг тухайн орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид санал болгодог. Аль нэг улс төрийн намын харьяалалгүй иргэн тойргийн хорооны бүрэлдэхүүнд ажиллах нь сонгуулийг ил тод, шударга явуулахад чухал ач холбогдолтой. Харин намын харьяалалгүй иргэнд тавигдах шалгуур, томилох журмыг хуульд нарийвчлан заагаагүй нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд олонх болсон нам эвсэл давуу байдлаа ашиглаж, өөрийн эрх ашигт үйлчлэх этгээдийг тойргийн хорооны бүрэлдэхүүнд оруулах нөхцөл бий болгох сул талтай байна. 2008 оны сонгуулиар ийм нөхцөл байдал үүссэн байж болохыг илтгэх баримтыг иргэний нийгмийн байгууллага дэлгэн тавьжээ. Иймд цаашид сонгуулийн хороонд нам бусчуудын төлөөллийг оролцуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Зөвлөмж: Сонгуулийн хороодод ажиллах хүмүүсийн эдийн засгийн болон эрх зүйн баталгааг сайжруулж, мэдлэг боловсролтой, шударга, зохих дадлага туршлагатай иргэдийг сонгуулийн хороодын үйл ажиллагаанд татан оролцуулах арга механизмыг бий болгох; (2005)

Монгол Улсын Их Хурлын хууль тогтоомж, Сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "Сонгуулийн хороодын гишүүн ёс зүйн дүрэмтэй байх бөгөөд түүнийг Улсын Их Хурал батална" гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 25 дугаар тогтоолоор Сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн дүрэм батлагдсан. Тус дүрэм сонгуулийн үйл явцад түгээмэл гардаг, сонгуулийн хорооны гишүүний зүй бус үйлдлийг хориглож, гишүүнд үүрэг хүлээлгэсний зэрэгцээ ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд сонгуулийн хорооны гишүүнд сануулах, гишүүнээс нь огцруулах арга хэмжээ авахаар заасан нь зохистой зохицуулалт болжээ. Түүнчлэн Сонгуулийн хороо, хорооны гишүүний үйл

ажиллагааг хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалах, үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах эрх зүйн баталгаа бий болгох зорилгоор Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт "Сонгуулийн хороодоос сонгуулийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгахад төрийн албан хаагч, нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, ухуулагч, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч хөндлөнгөөс оролцох, саад учруулахыг хориглоно", 14.6 дахь хэсэгт "Сонгууль зохион байгуулж явуулах хугацаанд тойрог, салбар, хэсгийн хороодын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд дээд шатны сонгуулийн хорооны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажилд шилжүүлэх, захиргааны санаачилгаар ажлаас халахыг хориглоно" гэж тус тус заасан. Сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсэгт "Энэ хуулийн 14.6-д заасныг зөрчсөн төрийн албан хаагчид Цагдаагийн байгууллагын тухай, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулах ба бусад албан тушаалтныг 200 000-250 000 төгрөгөөр торгоно" гэж заасан байна.

Сонгуулийн хорооны гишүүний үүрэгт ажлаа зохих ёсоор хэрэгжүүлэх нөхцөлийг бий болгох үүднээс Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэгт "Сонгуулийн хороодын бүрэлдэхүүнийг ажлын шаардлага, зардлын хэмжээг харгалзан үндсэн ажлаас нь түр чөлөөлүүлж ажиллуулна" гэж заасан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны сонгуулиар нийт 2 058 сонгуулийн хороо байгуулагдаж тэдгээрт ажилласан 18 363 хүн, Улсын Их Хурлын 2008 оны сонгуулиар нийт 2 062 сонгуулийн хороо байгуулагдаж, тэдгээрт ажилласан 20 174 хүн тус бүрт 108 000 төгрөгийн урамшуулал олгожээ.³⁹

Хэдийгээр сонгуулийн хороонд ажиллах иргэдийн эрх зүй, эдийн засгийн баталгааг бий болгох талаар төрөөс анхаарч байгаа боловч сонгуулийн хороодод ажиллагсад тэр бүр зохих ёсоор, шударга ажиллаж чадахгүй байгааг иргэний нийгмийн байгууллагууд шүүмжилж байна.⁴⁰ Тухайлбал 2008 оны сонгуулийн 20 хорооны (тойрог, салбар хэсгийн хороод) хурлын дэгтэй танилцаж, нээлттэй ажиллах тухай хуулийн заалтыг тусгасан талаар хяналт хийсэн иргэний нийгмийн байгууллагын тайланд нийт 20 хорооны 7 нь хуралдааны дэгээ огт батлаагүй буюу дэггүйгээр хурлаа явуулж байсан, мөн 7 хороо нь дэгээ баталсан боловч хуралдааны нээлттэй байдлын талаар огт дурдаагүй, харин 6 нь дараах байдлаар нээлттэй байдлаа томъёолсон байсныг дурджээ. Үүнд:

³⁹ Сонгуулийн Ерөнхий Хорооны албан бичиг, 2010.12.22, №138.

⁴⁰ Нээлттэй Нийгэм Форум, "Бодлогын асуудал" мэдээлэл, №1, 2010 оны 5 дугаар сар, 11 дэх тал.

- Төв аймгийн 14 дүгээр тойргийн хорооны дэгийн 8 дугаар зүйлийн 8.8-д “Хорооны хуралдааныг нээлттэй, хаалттай хийж болно.”
- Хэнтий аймгийн 18 дугаар тойргийн хорооны дэгийн 1 дүгээр зүйлийн 1.5-д “Хуралдаан нээлттэй болох бөгөөд хуралдааны шийдвэрийг гаргах үед зөвхөн хорооны бүрэлдэхүүн байж гаргана.”
- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар тойргийн хорооны дэгийн 1.3-т “Хуралдаанд холбогдох хүмүүс, сонгогчдын төлөөлөл, хэвлэл, мэдээлэл, радио телевизийн ажилтныг урилгаар оролцуулж болно.” гэж тус тус заажээ.

Улсын Их Хурлын 2008 оны сонгуулийн үеэр Сонгуулийн Ерөнхий Хороо хуулийн дээрх заалтуудыг бүрэн дүүрэн биелүүлээгүй талаар төрийн бус байгууллагууд тэмдэглэсэн байна.⁴¹ Тухайлбал 2006 оны 12 дугаар сарын 27-ны өдөр баталсан Сонгуулийн Ерөнхий Хорооны хуралдааны дэгд “Хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзан хорооны гишүүдийн гуравны нэгийн саналаар хуралдааныг хаалттай явуулж болно” гэж заасан ч хуралдааныг гишүүдээсээ санал хураалгүйгээр хаалттай явуулж, хуралдаанд оролцох хүсэлт гаргасан хөндлөнгийн байгууллагыг байлцуулаагүй баримтыг Нээлттэй Нийгэм Форумын мэдээллийн хуудсанд тэмдэглэсэн байна. Сонгуулийг чөлөөтэй, шударга явуулах үндсэн нөхцөл болсон ил тод байдлын зарчим бүрэн дүүрэн хэрэгждэггүй нь нэг талаас мэдлэг боловсролтой, шударга, зохих дадлага туршлагатай иргэдийг сонгуулийн хороодын үйл ажиллагаанд татан оролцуулж чадахгүй байгаатай холбоотой.

Зөвлөмж: Сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргах эрх бүхий албан тушаалтны үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, нэрийн жагсаалтын үнэн зөв эсэхэд тавих сонгуулийн хороодын болон хөндлөнгийн хяналтыг үр дүнтэй, оновчтой болгох; (2005)

Улсын Их Хурлын болон орон нутгийн 2004 оны сонгуулийн үеэр явуулсан Комиссын судалгаагаар төрийн албан хаагчийн санаатай үйлдэл, санамсаргүй хайнга ажиллагаа, нэрийн жагсаалтад тавих хөндлөнгийн хяналт дутмаг байдал нь нэрийн жагсаалтыг хуулийн хугацаанд нь гаргахгүй байх, сонгогчдын мэдээллийг буруу оруулах, байхгүй хүмүүсийг бүртгэлд авах, орох ёстой хүнийг орхигдуулах зэрэг зөрчлүүд гарах шалтгаан болж байна гэж үзсэн.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргах эрх бүхий албан тушаалтны үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх талаар хэд хэдэн чухал заалт Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад орсон байна. Тухайлбал, сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргах журмыг нарийвчилсны дээр (20 дугаар зүйл), мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 20.1-д заасныг зөрчсөн аймаг, нийслэлийн иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн албаны даргыг 150 000 - 250 000 төгрөгөөр, 20.4-т заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн

⁴¹ Мөн тэнд.

бичгийн даргыг 200 000-250 000 төгрөгөөр, 20.10-т заасныг зөрчсөн буруутай этгээдийг 200 000-250 000 төгрөгөөр торгоно." гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт "Сонгогчийг нэрийн жагсаалтад бүртгээгүй буюу буруу бүртгэсэн байвал сонгогч, сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч тухайн хэсгийн хороонд гомдол гаргах эрхтэй" гэж, 52 дугаар зүйлийн 52.1.4 дэх заалтад сонгуулийн хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцох үндэслэлийг тодорхойлж "сонгуулийн хороодын гишүүн, бусад байгууллагын албан тушаалтан энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, ...журмыг зөрчсөн нь тойргийн сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр байвал" гэж, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт "Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ", 55.2 дахь хэсэгт "Энэ хуульд заасан зөрчил гаргаж, захиргааны хариуцлага хүлээсэн нь уг этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй", 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт "Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад эд хөрөнгийн болон бусад хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд Иргэний хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэсэн зохицуулалтыг хуульд тусгажээ.

Сонгогчдын нэрийн жагсаалтад тавих сонгуулийн хороодын болон хөндлөнгийн хяналтыг сайжруулах үүднээс жагсаалтыг Иргэний Бүртгэл Мэдээллийн Улсын Төв үйлдэж санал авах өдрөөс 3 сарын өмнө Сонгуулийн Ерөнхий Хороонд ирүүлэх, Сонгуулийн Ерөнхий Хороо цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд дэлгэн үзүүлэх эрх зүйн зохицуулалт бий болгосон нь чухал ач холбогдолтой болжээ.⁴²

Улсын Их Хурлын 2008 оны сонгуулийн үйл явцаас харахад Сонгуулийн Ерөнхий Хорооны цахим хуудсанд байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалтад нэр нь байхгүй иргэд хаашаа хандаж, бүртгүүлэхээ мэдэхгүй төөрөлдөх тохиолдол олон гарсан тухай Нээлттэй Нийгэм Форум төрийн бус байгууллага мэдээлжээ.⁴³ Түүнчлэн иргэний нийгмийн байгууллагууд сонгогчдын нэрийн жагсаалтад хяналт тавих боломжгүй байсан тухай дээрх эх сурвалж мэдээлснийг тэмдэглэх нь зүйтэй.

2010 оны 7 дугаар сараас эхлэн Монгол Улсын иргэний бүртгэлийг шинэчлэх ажлыг зохион байгуулсан нь сонгогчдын нэрийн жагсаалтыг үнэн зөв гаргахад чухал ач холбогдолтой арга хэмжээ болсныг цохон тэмдэглэж байна. Бүртгэлийг 2 үе шаттай зохион байгуулж, эх орондоо болон гадаад улсад оршин сууж буй нийт иргэдээ хамруулсан бөгөөд энэ ажил одоогийн байдлаар 90 орчим хувийн гүйцэтгэлтэй байна.

⁴² Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг.

⁴³ Нээлттэй Нийгэм Форум, "Бодлогын асуудал" мэдээлэл, №1, 2010 оны 5 дугаар сар, 4 дэх тал.

Зөвлөмж: Улсын Их Хурлыг сонгох сонгуулийн тойргуудын сонгогчдын тоо эрс зөрүүтэй байгаад дүгнэлт хийж, тойргуудын цэсийг шинэчлэн тогтоох; (2005)

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт "Улсын Их Хурлын 76 гишүүнийг сонгох сонгуулийг олон мандаттай тойргоор зохион байгуулж явуулна" гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2007 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 98 дугаар тогтоолоор Монгол Улсын нутаг дэвсгэрийг сонгуулийн 26 тойрогт хуваасан боловч зөвлөмжид заасан зөрчлийг арилгаагүй байна. Тойрог тус бүрийн нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоог тухайн тойргийн мандаттай харьцуулж үзэхэд зарим тойргийн сонгогчдын тоо 2 дахин зөрүүтэй байна.⁴⁴ 2 мандаттай сонгуулийн 8 дугаар тойргийн (Дундговь аймаг) сонгогчдын тоо 27 506 байхад, мөн 2 мандаттай сонгуулийн 20 дугаар тойргийн (Орхон аймаг) сонгогчдын тоо 54 987 байгаагаас харж болно. Ийм зөрүү нийслэлийн 22 ба 25 дугаар тойргуудад ч гарчээ.⁴⁵

Зөвлөмж хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авсан боловч хангалтгүй байна.

Зөвлөмж: Засгийн эрх барьж буй нам, хүчин төрийн өмч хөрөнгө (унаа машин, байр), төсвийн мөнгийг (цалин, томилолт) сурталчилгаанд ашиглаж, төрийн албан хаагчдыг сурталчилгаанд дайчилж буй нь сонгуулийн тэгш байдлын зарчмыг алдагдуулах нэг том нөхцөл болж буйг анхааран авч үзэх; (2005)

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлд заасанчлан нам, эвсэл, тэдгээрийг дэмжигч, нэр дэвшигч болон нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, ухуулагч, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч сонгуулийн сурталчилгааны явцад төрийн болон бусад өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын чанартай ажил, үйлчилгээ явуулах, төрийн байгууллага, түүнчлэн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг төлбөртэй буюу төлбөргүйгээр сурталчилгааны материал хэвлэх, олшруулах, тээвэрлэх зэргээр сурталчилгаанд аливаа хэлбэрээр ашиглах, төрийн жинхэнэ албан хаагчийг сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр татан оролцуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглосон байна.

Улсын Их Хурлын 2008 оны сонгуулийн үеэр ажилласан Шударга Сонгуулийн Төлөө иргэний нийгмийн хяналтын сүлжээнээс явуулсан мониторингийн дүнгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь харагдаж байна. Сонгогчдын Боловсрол Төвөөс нийтдээ 172 удаагийн арга хэмжээнд ажиглалт хийхэд давхардсан тоогоор

⁴⁴ Сонгуулийн Ерөнхий Хороо, 2008 оны Улсын Их Хурлын сонгуулийн дүн, Дүн шинжилгээ хийсэн Хүний эрхийн Үндэсний Комисс.

⁴⁵ Улсын Их Хурлын сонгуулийн 4 мандаттай 22 дугаар тойргийн (Баянзүрх, Налайх дүүрэг) сонгогчдын тоо 158 460 байхад, мөн 4 мандаттай 25 дугаар тойргийн (Баянгол дүүрэг) сонгогчдын тоо 87 390 байжээ.

187 төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн сурталчилгаанд ажиллаж, төрийн өмчийн 85 тээврийн хэрэгсэл ашигласан гэсэн судалгааг гаргасан байна.⁴⁶

Үүнтэй ижил мониторингийн ажлыг Улсын Их Хурлын 2004 оны сонгуулийн үеэр Сонгогчдын Боловсрол Төв, Глоб Интернэшнл төрийн бус байгууллагууд хамтран явуулсан бөгөөд мониторингийн үр дүнг Комисс 2005 оны илтгэлдээ тусгаж байсан. Тухайлбал мониторингийн хүрээнд нийтдээ 556 удаагийн арга хэмжээнд ажиглалт хийхэд сонгуулийн кампанит ажилд нийт 1 788 төрийн албан хаагч ажиллаж, төрийн өмчийн 1 033 тээврийн хэрэгсэл ашигласан гэсэн дүгнэлтийг Комисс илтгэлдээ оруулсан.⁴⁷

2008 оны тоо баримтыг 2004 оныхтой харьцуулахад сонгуулийн кампанит ажилд төрийн өмчийн тээврийн хэрэгсэл, төрийн албан хаагчийг дайчлах явдал буурсан нь харагдаж байна. Ийм үр дүн нэг талаас эрх зүйн зохицуулалт боловсронгуй болсон, нөгөө талаас Улсын Их Хурлын 2008 оны сонгуулиар төрийн албан хаагч сонгуулийн сурталчилгаанд дайчлагдан ажиллаж байгаа эсэхэд Төрийн Албаны Зөвлөлийн орон нутгийн салбар зөвлөл, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж байсантай холбоотой юм.

Зөвлөмж: Худал хуурмаг амлалт өгөх, мөнгө, бэлэг тараах замаар сонгогчдыг татах болон сонгогчдын саналыг авах зорилготой бусад булхай зөрчлийг таслан зогсооход чиглэсэн заалтыг сонгуулийн хуульд тусгах; (2005)

1992 онд баталсан Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийг 2005 оны 12 дугаар сард шинэчлэн найруулахдаа тус хуулийн 37 дугаар зүйлд сонгуулийн сурталчилгааны үеэр дараах үйл ажиллагаа явуулахыг хориглосон.

Үүнд:

- Шашны зан үйл ашиглах;
- Сонгогч, түүний гэр бүл, насанд хүрээгүй хүүхэд, байгууллага, хамт олонд техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, мөнгө, эм тариа, хүнсний болон бусад эд бараа төлбөргүй тараах, хөнгөлөлттэй үнээр худалдах;
- Төлбөргүйгээр буюу хөнгөлөлттэй үнээр ахуйн болон эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн үзлэг явуулах;
- Биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, төлбөрт таавар, бооцоот болон мөрийтэй тоглоом зохион байгуулах;
- Сонгогчдын саналыг татах зорилгоор хүлээн авалт, дайллага, цайллага, сонгуулийн бус олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах;

⁴⁶ Сонгогчдын Боловсрол Төв, “Сонгуулийн кампанит ажлын мониторинг” 2008 оны 4 дүгээр сарын 21-ээс 6 дугаарын сарын 12-нд явуулсан 5 долоо хоногийн мониторингийн дүн. Дүнг нэгтгэсэн Хүний эрхийн Үндэсний Комисс.

⁴⁷ Хүний эрхийн Үндэсний Комисс, Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2005 оны илтгэл, Төрийн мэдээлэл сэтгүүл, № 24, 523 дахь тал.

- Сонгогчдын саналыг худалдан авахад чиглэсэн бусад аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулах зэрэг болно.

Худал хуурмаг амлалт өгөх, мөнгө, бэлэг тараах замаар сонгогчдыг татах болон сонгогчдын саналыг авах зорилготой бусад зөрчлийг таслан зогсооход чиглэсэн заалтыг сонгуулийн хуульд тусгах тухай Комиссын зөвлөмж хэрэгжсэн байна. Гэвч хуулийн эдгээр заалтууд амьдрал дээр төдийлөн хэрэгжихгүй байгаа нь Улсын Их Хурлын 2008 оны сонгуулийн үеэр иргэний нийгмийн байгууллагуудын эвслээс явуулсан судалгааны дүнгээс харагдаж байна.⁴⁸ Дээрх судалгааны тайланг нэгтгэж үзэхэд сонгуулийн үеэр үнэ төлбөргүй эмнэлгийн үзлэг (Өмнөговь, Өвөрхангай аймаг, Сүхбаатар дүүрэг), нийтийг хамарсан шоу цэнгүүн, тэмдэглэлт баяр (“Хүмүүс” сонины уншигчдын “Сайн үйлсийн аян” шоу тоглолт, Хөвсгөл Шинэ Зуун клубын 1 жилийн ойд зориулсан бөхийн барилдаан, гар бөмбөг, язгуур урлагийн тэмцээн, Дорнод аймагт “Одонтой мянган ээжийн баяр”, Ховд, Дорнод аймагт төгсөгчдийн баяр) зохион байгуулах, сугалаа явуулах (Хөвсгөл аймагт 57 гэрийн сугалаа), сургалтад хамруулах (Сүхбаатар дүүрэгт 18-аас дээш насны охидыг хамарсан зөөгчийн сургалт, Дорнод аймагт 6 сурагчийг Америкийн Нэгдсэн Улсад, Хан-Уул дүүрэгт 3 сурагчийг Япон Улсад тэтгэлэгээр сургах, Ховд аймагт 200 оюутны төлбөрийг төлөхөөр амалсан) болон гар утасны нэгж, хүнсний бараа сэлтийг тараасан зөрчлүүд илэрсэн байна.⁴⁹

Зөвлөмж: Улсын Их Хурлын болон орон нутгийн 2008 оны сонгуульд цагдан хоригдож байгаа хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэд оролцох нөхцөлийг бүрдүүлэх, улмаар гадаад улсад амьдарч буй Монгол иргэдийн сонгох эрхийг хангахад чиглэсэн шат дараатай арга хэмжээ авах; (2008)

Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн болон орон нутгийн 2008, 2009 оны сонгуулиар гэм буруу нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй, цагдан хоригдож байсан иргэдэд сонгох эрхийг эдлүүлэх арга хэмжээ аваагүй байна. Дашрамд дурдахад хүний аливаа эрхийг хязгаарлаж буй үндэслэл бодитой, гарцаагүй, тэнцвэртэй байх ёстой бөгөөд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйлийн дагуу ээлжит сонгуулийн хугацаанаас богино хугацаагаар хорих ял шийтгүүлсэн этгээд сонгох эрхээ эдлэх боломжтой байх нь зохистой болохыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Хороо зөвлөжээ.⁵⁰ Ээлжит сонгуулийн хугацаанаас хамаарч, 4 хүртэлх жилийн хугацаагаар хорих ял шийтгүүлсэн этгээдийг сонгуульд оролцуулдаг практик дэлхийн улс орнуудад хэвшиж байна.

⁴⁸ Сонгогчдын Боловсрол Төв, “Сонгуулийн кампанит ажлын мониторинг” 2008 оны 4 дүгээр сарын 21-ээс 6 дугаарын сарын 12-нд явуулсан 5 долоо хоногийн мониторингийн дүн, дүнг нэгтгэсэн Хүний эрхийн Үндэсний Комисс.

⁴⁹ Мөн тэнд.

⁵⁰ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Хороо, 25 дугаар ерөнхий зөвлөмж, 14 дүгээр догол мөр.

2008, 2009 онуудын сонгуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэд хараат бусаар саналаа өгөх боломжийг бүрдүүлэх талаар дорвитой ажил хийгээгүй байна. Сонгуулийн Ерөнхий Хорооны 2008 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор баталсан Улсын Их Хурлын сонгуулийн хэсгийн хорооны болон санал авах байрыг бэлтгэх заавар, мөн Хорооны 2009 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 5 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хэсгийн хорооны болон санал авах байрыг бэлтгэх зааварт “саналын хайрцгийг хөгжлийн бэрхшээлтэй сонгогч саналаа өгөх боломжтой байдлаар байрлуулна”, “санал тэмдэглэх бүхээгийг хөгжлийн бэрхшээлтэй болон бусад сонгогч саналаа нууцаар тэмдэглэх боломжтой байдлаар бэлтгэнэ” гэж заасан боловч энэ заалт хэт ерөнхий, ямар байдлаар хэрэгжүүлэх нарийвчилсан зааварчилгаа байхгүй байгаагаас хэрэгжилт нь хангалтгүй байна. Мөн тэргэнцэртэй иргэнийг санал авах байранд орох, гарахад дэмжлэг үзүүлэх налуу тавцан бэлтгэх, саналын хуудсыг брайль үсгээр хэвлүүлэх зэрэг тусгай хэрэглэгдхүүнийг бий болгох зардал сонгуулийн санал хураах байр бэлтгэх, тохижуулах гэсэн төсвийн зардлын ангилалд тусгагдаагүй байна.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцох эрхтэй” гэсэн заалт байсныг 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон нь сонгуулийн эрх бүхий олон мянган иргэний эрх зөрчигдөхөд хүрсэн. Харин Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд оруулахаар боловсруулж буй шинэчилсэн найруулгын төслийн 5 дугаар зүйлийн 5.11-дэх хэсэгт “Гадаадад түр буюу удаан хугацаагаар зорчин яваа дипломат төлөөлөгчийн болон консулын газарт бүртгэлтэй Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгуульд оролцуулах ажлыг...зохион байгуулна” гэж заасан нь дэвшилттэй алхам болжээ.

Цаашид цагдан хоригдож байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй, гадаадад амьдарч буй иргэдийнхээ сонгох эрхийг баталгаатай хангаж, сонгууль бүх нийтийн байх зарчмыг хэрэгжүүлэх талаар дорвитой арга хэмжээ авах шаардлагатай байна.

2.2 Үйлдвэрчний эвлэлийн байгууллагад эвлэлдэн нэгдэх эрх

Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно.

(Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван зургадугаар зүйлийн 16.10 дахь хэсэг)

Зөвлөмж: “Үйлдвэрчний Эвлэлүүдийн эрхийн тухай хуульд: Үйлдвэрчний Эвлэлийн сонгуульт ажилтны нийгмийн хамгааллын асуудал болон эрх зүйн баталгааг хангах, энэхүү хуулийн зүйл заалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тухай хуульд тусгаж өгөх; Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн этгээдийн статусыг тодорхойлж, эрх, үүргийг Хөдөлмөрийн тухай хуультай нийцүүлэн нарийвчлан тогтоох, энэ хуулийн биелэлтэд хяналт тавих механизмыг бий болгох; (2007)

Сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхийн харилцааг Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай, Төрийн бус байгууллагын тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиудаар зохицуулж байна. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хууль 1991 онд баталсан ба энэ хууль өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Тус хуулийн 6 дугаар зүйлд сонгуульт ажилтны эрхийн баталгааг хуульчилсан боловч түүнийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар тусгаагүй байгаа нь цаг үеэсээ хоцрогдсон, ерөнхий шинжтэй учир үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажилтны эрхийг хамгаалах үр дүнтэй зохицуулалт болж чадахгүй байна.

Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны дүрэмд зааснаар Монголын Үйлдвэрчний Эвлэлийн холбоо нь нийгэмд болон гишүүн байгууллагууддаа үйлчилдэг, ашгийн бус байгууллага юм. Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын хуулийн этгээдийн статус ч тодорхой бус хэвээр байна. Хэдийгээр үйлдвэрчний эвлэлийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан тусдаа хуультай боловч үйлдвэрчний эвлэлийг байгуулах, үйл ажиллагааг нь хөтлөн явуулахад Төрийн бус байгууллагын тухай хуулийг баримталж байгаа нь хүндрэл бэрхшээлийг дагуулж байна гэж Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо үзэж байна.

Өнөөгийн практикт хөдөө орон нутагт Улсын бүртгэлийн алба байхгүйгээс орон нутагт байгуулагдаж буй Үйлдвэрчний Эвлэлийн хороог нийслэлд бүртгэж байгаа нь ихээхэн чирэгдэл учруулж байна. 1991 оны Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хуулийг шинэчлэж, сонгуульт ажилтан, анхан шатны байгууллагын эрх хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар гишүүн байгууллагынхаа санал, хүсэлтийг хүлээн авч, бусад улс орны үйлдвэрчний эвлэлийн хууль, эрх зүйн зохицуулалтыг судлан ажиллаж байгаа бөгөөд энэ санаачлагыг Улсын Их Хурал, Засгийн газраас дэмжих, хамтран ажиллах шаардлагатай байна. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хуулийг орчин үеийн нөхцөл байдал, хөдөлмөрийн харилцааны өөрчлөлттэй уялдуулан шинэчлэх, боловсронгуй болгох нь иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

Зөвлөмж: Үйлдвэрчний Эвлэлийн идэвхтэн сонгуультныг мэдлэг туршлагатай, чадварлаг ажилтнаар сэлбэх, тэдний бүтээлч идэвхийг өрнүүлэх замаар Үйлдвэрчний Эвлэлийн байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх, нөлөө, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглүүлсэн үзүүлэлтээр тодорхой урамшуулал олгох журам тогтоон ажиллах; (2007)

2010 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо нь 35 гишүүн байгууллагатай, үүний 13 нь мэргэжил үйлдвэрлэлийн, 22 нь нутаг дэвсгэрийн үйлдвэрчний эвлэлийн холбоод юм. Үйлдвэрчний эвлэлийн анхан шатны 2000 орчим хороо ажилладаг ба нийтдээ 209 000 гишүүнтэй.⁵¹ Үндэсний үйлдвэрлэл сэргэж, ажлын байр нэмэгдэхийн хамт үйлдвэрчний эвлэлийн байгууллагад гишүүнээр элсэж буй хүмүүсийн тоо өсөн нэмэгдэж байна. Тухайлбал 2010 онд тус байгууллагад шинээр 26 387 гишүүн элсэж, 1 242 хүн гишүүнээс гарчээ. Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны 20 орчим гишүүнд 1 сонгуульт ажилтан оногдож байгаа бөгөөд сонгуульт ажилтан нь хамтын гэрээ байгуулж, түүнээс үүдэн бусад арга хэмжээ, хамтын гэрээний биелэлтийг дүгнэх, анхан шатны хорооны даргад тодорхой асуудлуудыг тавьж шийдвэрлүүлж байна.

Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо нь хүний нөөцийн менежментийн шинэ хандлага, арга барил нэвтрүүлэх замаар чадварлаг, ёс зүйн төлөвшилтэй, хүмүүсийн эрх ашгийн төлөө тэмцэж чадах мэргэшсэн боловсон хүчинтэй болох, тэдгээрийг идэвхжүүлж, тогтвортой ажиллуулах стратегийн зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Мөн хөдөлмөрийн харилцааны асуудлаар мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх хүрээнд 2008-2010 онд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, Олон Улсын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны Ази, Номхон Далайн Байгууллага, Японы Олон Улсын Хөдөлмөрийн Сан, Солонгосын Олон Улсын Хөдөлмөрийн Сан, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан, Нидерландын Хөдөлмөрийн Яам, Европын Холбоо, Фридрих Эбертийн Сантай хамтран ажиллахаас гадна дотоод дахь нөөц бололцоог ашиглан Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны харьяа Хөдөлмөрийн Дээд Сургуульд хөнгөлөлттэй сурах боломжийг нэмэгдүүлж, 119 идэвхтэн сонгуультан ажилтнуудыг (давхардсан тоогоор) хөнгөлөлттэй сургалтад хамруулан оролцуулж, мэдлэг, чадварыг нь нэмэгдүүлэхэд анхаарч байна.

Үйлдвэрчний эвлэлийн идэвхтэн сонгуультанд ажлын үр дүнг нь харгалзан урамшуулал олгох талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалтгүй байна. Энэ талаар үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудын удирдлагууд нэгдсэн бодлого, шийдвэр гараагүй, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх эдийн засгийн хөшүүрэг бий болоогүй байна. Мэргэжил Үйлдвэрлэлийн Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо болон Нийслэлийн үйлдвэрчний эвлэлийн холбоодын дарга нарын 2010 оны ээлжит уулзалтаар үйлдвэрчний эвлэлийн идэвхтэн сонгуультнуудыг

⁵¹ Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт 2009-2010, УБ., 2010 он, 50 дахь тал.

урамшуулах механизмыг бий болгох саналыг оруулахад, гишүүн байгууллагын удирдлага үндсэн ажлаа хийж байгаа хүмүүсийг урамшуулах шаардлагагүй гэж үзэн дэмжээгүй байна. Ийм учраас үйлдвэрчний эвлэлийн бүх шатны байгууллагууд өөр өөрийн онцлогийг харгалзан урамшуулах механизмыг бий болгох санаачлага гаргажээ.

Зөвлөмж: Аж ахуйн нэгж, байгууллагын ажлыг дүгнэхэд үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон үйлдвэрчний эвлэлийн байгууллага байгуулах эрхийг хэрэгжүүлэхэд ямар боломж, нөхцөлөөр хангасан, үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтын гэрээгээ хэрхэн байгуулж, дүгнэж байгааг нэг гол үзүүлэлт болгодог журам тогтоох; (2007)

Аж ахуйн нэгж, байгууллагын жилийн ажлын үр дүнг салбар, орон нутаг, улсын хэмжээнд төр, засгийн байгууллага, нийгмийн зөвшлийн талууд, орон нутаг шалгаруулахдаа үйлдвэрчний эвлэлийн эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон үйлдвэрчний эвлэлийн байгууллага байгуулах эрхийг хэрэгжүүлэхэд ямар боломж, нөхцөлөөр хангасан, үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтын гэрээгээ хэрхэн байгуулж, дүгнэж байгаа асуудлыг харгалзан үзэх байдал нь тухайн шатны үйлдвэрчний эвлэлийн байгууллагын оролцоо санаачлагаас хамааран харилцан адилгүй байна.

Улс, салбар, орон нутгийн түвшинд хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талуудаас зохион байгуулсан хамтарсан уралдаант шалгаруулалтад дээрх нөхцөлийг харгалзан үзэх жишиг тогтоох хандлагатай байна. Тухайлбал Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо нь Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газартай 2010 онд байгуулсан хамтран ажиллах гэрээнд нийгмийн хариуцлагатай аж ахуйн нэгж, байгууллагыг жил бүр шалгаруулахаар заасан ба тус ажлын хүрээнд ажилтны эвлэлдэн нэгдэх эрхийг хангасан байх үзүүлэлтийг журамд тусган ажиллаж байна.

Зөвлөмж: Албан бус салбарт ажиллагсдад эрх ашгаа хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэх талаар сурталчилгаа хийж, улмаар албан бус салбарт ажиллагсдын байгууллагаас нийгмийн хэлэлцээрт оролцох боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна; (2007)

Олон Улсын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны Ази, Номхон Далайн Байгууллагаас Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоотой хамтран “Албан бус эдийн засагт ажиллагсдыг үйлдвэрчний эвлэлд зохион байгуулах нь” төслийг 2008 онд хэрэгжүүлжээ. Төслийн эхний шатанд хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, зохистой хөдөлмөр, хөдөлмөрийн маргааныг шуурхай зохицуулах зэрэг сэдвээр 2007-2009 онд 246 удаа, давхардсан тоогоор 6 046 хүн хамруулан сургалт зохион байгуулжээ.⁵²

⁵² Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны албан бичиг, 2011.03.03, №01/89, 4 дэх тал.

“Албан бус эдийн засагт ажиллагсдын эрхийг хамгаалах нь” төсөл хоёр байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд хийгдэх үйл ажиллагаа болон өргөжиж 2013 он хүртэл үргэлжлэхээр болсон нь сайшаалтай юм. Хамтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны гишүүд, ажиллагсдын эрх зүйн хамгаалалтыг сайжруулах, хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг үр дүнтэй шийдвэрлэх бүтэц буюу хөдөлмөрийн маргааныг шуурхай зохицуулах салбар хорооны үйл ажиллагааг чадавхжуулах, гишүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх төрөл бүрийн сургалт семинар зохион байгуулах ажлуудыг төлөвлөн амжилттай хэрэгжүүлж байна.

Засгийн газраас 2011 оныг “Хөдөлмөр эрхлэлтийн жил” болгон зарласантай холбогдуулан Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамтай хамтран албан бус салбарт ажиллагсдын эрхийг хамгаалах чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Хөтөлбөрт албан бус эдийн засгийн салбарт ажиллаж байгаа иргэдийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалтыг бий болгох, тэдний эвлэлдэн нэгдэх эрхийг дэмжих, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах чиглэлээр сургалт, судалгаа, сурталчилгааны олон төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Албан бус салбарт ажиллагсдын эрх ашгаа хамгаалах, эвлэлдэн нэгдэх талаар бодитой нөлөөллийн үйл ажиллагаа явуулаагүй байгааг цаашид төрөөс анхаарах хэрэгтэй байна.

Зөвлөмж: Ажил олгогчид, ажиллагсадад олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах; (2007)

Мэргэжил олгох, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх сургалтын 148 байгууллагыг шалгаруулснаас, хөдөө орон нутгийн 75 байгууллага 4 хүртэл мэргэжил олгох, 2 хүртэл мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, нийслэлийн 73 байгууллага 2 хүртэл мэргэжил олгох, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх сургалтын байгууллагаар шалгарч, гэрээ байгуулан Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Сангаас санхүүжилт авч, эрхийн бичгийн болон түр сургалтыг зохион байгуулжээ.

Хөдөлмөрийн харилцаатай холбоотой олон улсын гэрээ, конвенц, дотоодын хууль тогтоомжийг сурталчлан таниулах талаар Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамнаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хангалтгүй байна. Харин энэ талаар Монголын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Холбоо, Монголын Ажил олгогч Эздийн Нэгдсэн Холбоо санаачлагатай ажиллаж байна.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан хөдөлмөрийн харилцаан дахь 16 суурь конвенцийг сурталчлах хүртээмжийн асуудал муу байгаа бөгөөд учир

нь сурталчлах ажлын хүрээнд конвенцуудын гарын авлага эрхлэн гаргахыг Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамнаас дэмжээгүйтэй шууд холбоотой юм.⁵³

Комиссоос өгсөн зөвлөмжийн хүрээнд Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо сүүлийн 5 жилийн хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогчид болон ажилтнуудад зориулан Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гэрээ, конвенц, Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтуудыг 2007-2009 онд өөрийн нөөц бололцоогоо ашиглан 3 600 гаруй аж ахуйн нэгжид 4 100 гаруй оролцогчидтойгоор (давхардсан тоогоор) зохион байгуулсан байна.⁵⁴

Тус холбоо нь хэрэгжүүлж буй ажилдаа тухай бүрт сургалтад оролцогчдоос сургалтын дараа “сэтгэгдлийн хуудас” үнэлгээг авдаг нь тухайн сургагч багш нарт цаашид ажлаа сайжруулах, сургалтыг чанаржуулахад чухал түлхэц болдог байна.

Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо “Сургалтын нэгдсэн гаргалгаа-2010”, “Нэг өдрийн сургалт”-ын удирдамж боловсруулан, цаашид тогтмол сургалт зохион байгуулах бодлогоо тодорхойлжээ. 2010 онд тус холбооны Сургалт арга зүйн төв “Зохист хөдөлмөр” сургалтыг өөрийн байранд 58 удаа, анхан шатны хороо, холбоодын хүсэлтийн дагуу үндэслэн ажлын байранд 74 удаа зохион байгуулсаны үр дүнд 48 хороог шинээр байгуулжээ.

Харин Засгийн газар, холбогдох яам, агентлаг, ажил олгогчид, ажиллагсдад олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах талаар хангалтгүй ажиллаж байна. Цаашид олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулдаг төрийн бус болон боловсролын байгууллагуудыг бодлого, зохицуулалт, санхүүгийн хувьд дэмжиж, сургалт, сурталчилгааны ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх нь зохистой юм.

2.3 Тайван жагсаал, цуглаан зохион байгуулах эрх

Монгол Улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь хэсэг)

⁵³ Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбооны Хөдөлмөрийн харилцааны газрын даргатай хийсэн ярилцлага, 2011.03.15.

⁵⁴ Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбооны Сургалтын албаны даргатай хийсэн ярилцлага, 2011.03.15.

Зөвлөмж: Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг шинэчлэх (жагсаал, цуглааныг зохион байгуулахад олгож буй зөвшөөрлийн систем, хугацаа, зөвшөөрөл олгох эрх бүхий субъект, уг хуульд хамрагдахгүйгээр зохион байгуулагддаг жагсаал, цуглааныг хянан үзэх; (2005)

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, иргэд, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагууд жагсаал, цуглаан хийх замаар үзэл бодлоо илэрхийлэхдээ улс төрийн буюу орон нутгийн засаг захиргааны удирдлагаас бүртгэл нэрийн дор зөвшөөрөл авдаг тогтолцоог өөрчлөх, нийтийг хамарсан үймээн самуун, хууль бус жагсаал цуглааныг таслан зогсоох, зэвсэг хэрэглэх зохицуулалтыг боловсронгуй болгож, энэ үйл ажиллагаанд хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахгүйгээр хүний эрхийг хүндэтгэж ажилладаг арга барилд сургах тухай; (2009)

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж, Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайд тайван жагсаал, цуглаан хийхийг хориглосон заалтыг хүчингүй болгосны зэрэгцээ жагсаал, цуглаан зохион байгуулахад “зөвшөөрөл авна” гэснийг “бүртгүүлнэ” гэж өөрчилжээ. Хэрэг дээрээ агуулга огт өөрчлөгдөөгүй нь жагсаал, цуглааныг бүртгүүлээгүй бол албадан тараах тухай хуулийн заалтаас харагдаж байна.

Иргэд, байгууллага тайван жагсаал, цуглаан зохион байгуулах тухайгаа орон нутгийн цагдаагийн байгууллагад (нийслэлд дүүргийн, аймаг, сумын цагдаагийн газар, хэлтэс, тасаг) мэдэгддэг байхад л хангалттай. Энэ нь жагсаал цуглааны тайван байдлыг хангах үүргийг цагдаа хариуцаж байгаатай холбоотой юм. Цагдаагийн бие бүрэлдэхүүн зайлшгүй шаардлагатай бусад ажиллагаанд оролцох болсноос хүчний хувьд тухайн арга хэмжээг зохицуулах боломжгүй, өөр жагсаал, цуглаан давхацсан тохиолдолд бүртгэхгүй байх хуулийн зохицуулалт хийх ёстой гэж Хүний эрхийн Үндэсний Комисс үзэж байна.

Зөвлөмж: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийг судлан үзэж цагдаагийн байгууллагыг шаардлагатай тоног төхөөрөмж, тусгай хэрэгслээр хангаж, ажиллах нөхцөл бололцоог нь хангаж өгөх; (2009)

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2010 оны 173 дугаар тушаалаар “Жагсаал, цуглааны үед нийгмийн хэв журам хамгаалах тухай”, “Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед нийгмийн хэв журам хамгаалах тухай”, “Онц байдал зарласан үед нийгмийн хэв журам хамгаалах тухай”, “Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх тухай”, “Албаны нохой хэрэглэх тухай” журмуудыг шинэчлэн баталж мөрдүүлжээ.

Цагдаагийн байгууллагыг онцгой байдлын үед хэрэглэх шаардлагатай тоног төхөөрөмж, тусгай хэрэгслээр хангах зорилгоор Цагдаагийн Ерөнхий Газрын 2010 оны төсвийн болон төсвийн бус орлогоор дуулга малгай 230, хутганаас хамгаалах

хантааз 500, өвдөг, тохойн хамгаалалт 400, газ эсэргүүцэгч буюу хорт утаа цэвэршүүлэгч баг 160 ширхэгийг тус тус худалдан авсан байна.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон үед цагдаагийн болон бусад хүчний байгууллагуудын харилцан ажиллагааг зохицуулах ерөнхий төлөвлөгөөний дагуу дадлага, сургалтыг Зэвсэгт Хүчний Жанжин Штаб, Хил Хамгаалах Ерөнхий Газар, Онцгой Байдлын Ерөнхий Газартай хамтран зохион байгуулж 1 733 албан хаагч, 79 тээврийн хэрэгслийг оролцуулан зохион байгуулжээ.

Зөвлөмж: *Иргэдийг жагсаал, цуглаан зохион байгуулах зэргээр үзэл бодлоо илэрхийлэхдээ улс орны аюулгүй байдал, нийгмийн хэв журам, бусдын эрх, эрх чөлөө, хууль журмыг хүндэтгэн биелүүлдэг болгох талаар ухуулга сурталчилгааны ажлыг эрчимтэй, үр дүнтэй зохион байгуулах; (2009);*

Иргэдээс зохион байгуулж буй жагсаал, цуглааны үеэр төрийн хууль тогтоомжийг дагаж мөрдөх, нийгмийн хэв журмыг даган биелүүлэх талаар уг үйл ажиллагааг зохион байгуулагчидтай уулзаж, санамж бичиг, зөвлөгөө өгөх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд хандсан сурталчилгаа, сэрэмжлүүлэг явуулах ажлыг тухай бүр зохион байгуулж ажиллаж байна.⁵⁵ Цаашид тайван жагсаал, цуглаан хийх талаар иргэд олон нийтэд хандсан ухуулга, сурталчилгааны ажлыг хийх хэрэгтэй гэж үзэж байна.

Тайван жагсаал, цуглаан хийх талаар ухуулга сурталчилгааны ажлыг иргэд, олон нийтэд дан ганц цагдаагийн байгууллага бус мөн жагсаал, цуглааныг бүртгэдэг тухайн шатны Засаг Даргын Тамгын газрууд⁵⁶ анхааран ажиллах нь зүйтэй.

Зөвлөмж: *2008 онд болсон үймээн самууны үеэр амь насаа алдсан иргэдийн ар гэр, үр хүүхдэд болон эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон цагдаагийн ажилтнууд, иргэдэд төрөөс хохирлыг нь барагдуулж, нөхөн төлбөр олгох ажлыг шуурхай зохион байгуулах; (2009)*

Олон нийтийн эмх замбараагүй байдлын улмаас 5 иргэн амь насаа алдаж, онцгой байдлын албаны 4, цагдаа, дотоодын цэргийн 393 алба хаагч, түүнчлэн 401 иргэний бие эрхтэнд гэмтэл учирч, 155 иргэн, 118 аж ахуйн нэгжид 11,291,6 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирсан байна.⁵⁷ Эдгээр алба хаагчдаас 77 алба хаагчийг эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлж, 6 алба хаагчийн оношлогооны төлбөрт 450 мянган төгрөг, 4 алба хаагчийн эмчилгээний төлбөрт 2 581,3 сая төгрөг, 2 алба

⁵⁵ Цагдаагийн Ерөнхий Газрын албан бичгийн хавсралт, 2011.03.30, №1/99, 6 дахь тал.

⁵⁶ Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг.

⁵⁷ Төрийн мэдээлэл сэтгүүл, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, УБ., 2009 он, №15(588), 345 дахь тал.

хаагчийн сувиллын зардалд 380 мянган төгрөг, нийт 12 алба хаагчид 3,411,3 сая төгрөгийн тусламжийг үзүүлжээ.⁵⁸

Улсын Их Хурлаас “Хохирогчид нөхөх олговор олгох тухай” хуулийг батлан гаргаж 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад заасан нөхөх олговрын хэмжээгээр амь насаа алдсан 5 иргэний ар гэрт нь тус бүр 50,0 сая төгрөг, эрүүл мэндээрээ хохирсон цагдаагийн байгууллагын 397 алба хаагчид 442,5 сая төгрөг, Төрийн албаны тухай хуулийн дагуу 423 цагдаагийн алба хаагчид 42,3 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгож, 84 алба хаагчийг Цагдаагийн Ерөнхий Газрын харьяа амралт, сувилалд сувилуулах арга хэмжээ авч, 9 алба хаагчийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсад эмчилгээнд явуулахад 54,9 сая төгрөг, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын тушаалаар 10 алба хаагчийн ар гэрт 2,5 сая төгрөгийн тусламж, нөхөх олговрыг тус тус олгожээ.⁵⁹ Цаашид эрүүл мэндээрээ хохирсон цагдаагийн албан хаагчдын эрүүл мэндийг бүрэн хэмжээгээр сэргээхэд шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй.

Зөвлөмж: *Үймээн самууны хэрэгт холбогдсон олон зуун иргэд нэн ялангуяа, хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, анх удаа гэмт хэрэгт холбогдон ял шийтгүүлсэн хүмүүст өршөөл үзүүлэх асуудлыг хуулийн хүрээнд даруй шийдвэрлэх; (2009)*

2008 оны 7 дугаар сарын 1-ний үймээний хэрэгт 721 хүн баривчлагдаж 280 гаруй хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял шийтгэл оноожээ.

Монгол Улсын Их Хурлаас 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдөр “Өршөөл үзүүлэх тухай хууль” батлан гаргаж, үймээн самууны хэрэгт холбогдсон хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, анх удаа гэмт хэрэгт холбогдон ял шийтгүүлсэн хүмүүсийн ялыг өршөөн хэлтрүүлж суллажээ.

2.4 Үг хэлэх, хэвлэн нийтлэх мэдээллийн эрх чөлөө

Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх..... эрх чөлөөтэй.

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16.16 дахь хэсэг)

⁵⁸ Мөн тэнд.

⁵⁹ Цагдаагийн Ерөнхий Газрын албан бичиг, 2011.03.30, №1/99.

Зөвлөмж: Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд сэтгүүлчийн мэдээллийн эх сурвалжийг хамгаалахтай холбогдсон зохицуулалт нэмж оруулах; (2008)

Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар нэн даруй хэлэлцэж батлах; (2008)

Улсын Их Хурлаас 1998 оны 8 дугаар сарын 28-ны өдөр баталсан Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд сэтгүүлчийн мэдээллийн эх сурвалжаа хамгаалах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газар Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн найруулах, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төсөл боловсруулж байна. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар нэн даруй хэлэлцэж батлах гэсэн Комиссын зөвлөмж хэрэгжээгүй байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

3. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ

3.1 Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх

Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй.

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг)

Зөвлөмж: Барилга, байгууламжийн зураг төсөл, зөвшөөрөл, барилгын хийц бүтээгдэхүүний чанар, стандарт, норм, ажлын технологи, үе шаттай холбоотой заалтуудыг амьдралд хэрэгжүүлэхэд тавих мэргэжлийн хяналтыг хэвшүүлэх; (2005)

Энэ зөвлөмжийн хүрээнд холбогдох байгууллагууд анхаарлаа хандуулж асуудлыг шийдвэрлэх талаар ажиллаж байгаа боловч зөрчил, дутагдал, шийдэгдээгүй асуудал цөөнгүй байна.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот нь хуучнаар Зөвлөлт Холбоот Улсын Москва хотын “Гипрогор” институтэд 1954, 1961, 1975, 1986 онуудад боловсруулагдсан Хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар хөгжиж, өнөөгийн Улаанбаатар хотын дүр төрхийг бүрдүүлсэн бөгөөд Монгол Улсын үндэсний мэргэжилтнүүдээс бүрдсэн баг 4 дэх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд дүгнэлт өгч, улмаар Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх 5 дахь ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 28 дугаар тогтоолоор батлуулсан байна.⁶⁰

Гэвч ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад хүн амын ердийн болон механик өсөлтийг зөв тооцоолж чадаагүй, гэр хорооллын суурьшлыг төлөвлөлтөд оновчтой тусгалгүй орхигдуулсан нь одоогийн хот байгуулалтын тулгамдсан асуудал үүсэх шалтгаан болж, улмаар тухайн үед хийгдсэн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх үндсэн зарчмууд, хөгжлийн хандлага бодит байдалтай нийцэхгүй болсноор хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд хугацаанаас өмнө тодотгол хийх зүй ёсны шаардлага бий болжээ. Тухайлбал, 1975 онд боловсруулсан 3 дахь ерөнхий төлөвлөгөөгөөр Нийслэлийн хүн

⁶⁰Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын Дэд бүтцийн хяналтын улсын газрын 2005-2010 онуудад хийсэн ажлын талаарх мэдээлэл, 2010 он.

амыг 2000 он гэхэд 400.0 мянган хүн байхаар тооцоолж, хүн амын механик өсөлтийг хязгаарлах чиглэл баримталсан боловч бодит амьдрал дээр хүн ам 400,0 бус 500,0 мянга болж нэмэгдсэн бөгөөд энэ хэрээр хот байгуулалт алдагдаж эхэлжээ.

2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар Нийслэлийн 9 дүүргийн 132 хороонд 273,2 мянган өрхийн 1106,7 мянган хүн ам байнга оршин сууж байна.⁶¹

Нийслэлийн Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газар хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөлгүйгээр Буянт-Ухаа хорооллын зураг төсөл боловсруулан баталж, магадлал хийгдээгүй ерөнхий төлөвлөгөөгөөр орон сууцны барилга угсралтын ажил эхлүүлсэн, Дарь-Эхийн гэр хорооллын ерөнхий төлөвлөгөөг үерийн ус зайлуулах байгууламжийн төлөвлөлтөд тусгаагүй, үерийн далан дээр барилга барих төсөл зохиож, үер усны аюулд өртөх нөхцөлийг бүрдүүлэхээр төлөвлөснөөс гадна эдгээр хорооллуудын оршин суугчдад үйлчлэх соёлын ордон, кино театр, эрүүл мэндийн төв, хүүхдийн цэцэрлэг, сургууль, хорооллын доторхи авто зам, замын уулзвар, гарц, хөдөлгөөний зохицуулалтыг зураг төсөлд тусгаагүй зэрэг нь иргэдийн ая тухтай, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж байна.

Сүүлийн үед Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүдэд төрийн өмчийн мэдлийн эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн эзэмшил газарт газар олгох, барилга барих явдал газар авчээ. Хүүхдийн тоглоомын талбайд орон сууц, үйлчилгээний барилга барих, шинээр орон сууц барихдаа ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, авто машины зогсоолгүй шийдэж орхигдуулах, барилгуудын хоорондын зай хэмжээ хэт ойрхон байгаагаас гадна Улаанбаатар хотын ундны эх үүсвэрүүд, Туул голын эрүүл ахуй, хамгаалалтын бүсэд орон сууц, барилга байгууламж барих зөвшөөрөл олгосны дагуу иргэд, аж ахуйн нэгжүүд барилга барих, Нийслэлийн Засаг даргын захирамж гараагүй байхад зөвшөөрөлгүй барьсан барилгад нөхөж захирамж гаргах зэрэг явдал ихэсчээ.

Хотын төвийн гудамж, нийтийн эзэмшлийн зам, талбай, явган хүний зам дээр Түргэн үйлчилгээний цэг, павильонд газар олгосон буюу зөвшөөрөлгүй барьсныг цэгцлэх ажил хийгдэж байгаа боловч бүрэн дуусаагүй, инженерийн шугам сүлжээн дээр буюу тэдгээрийн хамгаалалтын зурваст газар олгосноор шугам таслах, гэмтээх, улмаар осол гарах нөхцөлийг бүрдүүлсэн, орон сууцны барилгуудын 1 дүгээр давхрын төлөвлөлт, зориулалтыг өөрчилж, үйлчилгээ явуулж байгаа нь барилгын бат бөх чанарыг алдагдуулан, эрсдлийг дагуулж буй тул 1960-1980-аад онуудад газар хөдлөлтийг тооцоогүй баригдсан орон сууцны барилгуудад дахин төлөвлөлт хийж, шинэчлэх шаардлага бий болжээ.

⁶¹ Нийслэлийн Статистикийн газрын дарга Ч.Баянчимэгийн ярилцлагаас, “Нийслэл таймс” сонин, 2010.11.01, № 214/406, 5 дахь тал.

Газар хөдлөлтөд хамгийн өртөмтгий, өртөгдсөн үедээ аюултай үр дагавар ихтэй объектын нэг бол барилга, байгууламж юм. Газар хөдлөл судлаачдын олонх нь “Газар хөдлөлт хүн алдаггүй, барилга байгууламж л үүнийг хийдэг” гэж хэлжээ. Хот байгуулалтын хувьд тухайн газар, чичирхийллийн хүчийн 6 ба түүнээс доош баллд хамрагдаж байвал нэн тохиромжтой, 7-8 баллд хязгаарлагдмал тохиромжтой, 9 ба түүнээс дээш баллын ангилалд тохиромж муутай гэж үздэг байна.

Улаанбаатар хотын газар хөдлөлтийн бичил бүсийн зургаар барилгажсан нийт талбайн 25 хувь нь 6 баллын бүсэд, 52 хувь нь 7 баллын бүсэд, 23 хувь нь 8 баллын бүсэд хамаарагдаж байгаа гэсэн судалгааг гаргасан байдаг. Нийслэл Улаанбаатар хотод орон сууцны зориулалтын нийт 77 246 барилга байгаагийн 540 барилга нь 2004-2007 онд баригдсан бол 2008 онд 7 000 орчим айлын орон сууц ашиглалтанд орсон байна.⁶²

2010 оноос хойш иж бүрэн орчны тохижилт, үйлчилгээний барилга байгууламжтай 75 000 айлын орон сууц бүхий, 18 хороолол хотхоныг барьж байгуулах төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлж байна. Энэ бүхнээс үндэслэн одоо байгаа болон баригдаж буй барилга байгууламжуудад нарийвчилсан судалгаа явуулж, боломжит хүчтэй газар хөдлөлтийн хэмжээ, давтагдалт болон түүнээс үүсэх доргилт нь хэрхэн үйлчлэх, ямар аюул учруулж болохыг урьдчилан тогтоож байх зайлшгүй шаардлага гарч байна.

Онцгой Байдлын Ерөнхий Газраас газар хөдлөлтийн гамшгийн талаар гаргасан судалгаагаар Улаанбаатар хотын хэмжээнд 6-7 баллын газар хөдлөлтөд нурах 1950-1960-аад онуудад баригдсан орон сууцны 263 барилга байгаагаас Сонгинохайрхан дүүрэгт 19, Хан-Уул дүүрэгт 69, Баянзүрх дүүрэгт 25, Баянгол дүүрэгт 29, Чингэлтэй дүүрэгт 54, Сүхбаатар дүүрэгт 65 барилга бүртгэгджээ.

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын Дэд бүтцийн хяналтын газраас сүүлийн 5 жилд хот байгуулалтын болон барилгын хяналтын талаар хийсэн шалгалтын дүнгээс үзэхэд давхардсан тоогоор 38 600 гаруй зөрчил дутагдал илэрсний 60,3 хувь нь шинээр барьж байгаа барилгатай холбоотой зөрчил эзэлж байгааг дотор нь ангилахад 16,2 хувь нь объектын техникийн баримт бичгийн бүрдүүлэлтэд, 21,4 хувь нь зураг төсөл боловсруулалтад, 62,4 хувь нь барилга угсралтын ажлын үе шатанд гарсан зөрчил эзэлсэн байна.

Сүүлийн жилүүдэд барилгын салбар дахь хөрөнгө оруулалт эрчимтэй өсөн нэмэгдэж, жил тутам олон мянган орон сууц ашиглалтанд орж байгаа нь сайшаалтай байгаа боловч шинээр баригдаж буй барилга байгууламжийн чанар, бат бөх байдалд

⁶² Нийслэлийн Барилга хот байгуулалтын төлөвлөлтийн газрын цахим хуудас, http://cud.ub.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=121%3A2010-08-24-10-06-51&catid=1%3Alatest-news&Itemid=82 үзсэн, 2011.03.10.

тавих мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтыг сайжруулж, барилгын болон барилга барих журам стандартыг хатуу мөрддөг болгоход онцгой анхаарах шаардлагатай байна.

Нийслэлийн дүүргүүдийн Засаг дарга, Газрын алба хууль тогтоомж зөрчин барилга байгууламж, үйлчилгээний зориулалтаар газар эзэмших эрх олгож байна. Тухайлбал Хан-Уул дүүргийн Засаг дарга нийтийн эзэмшлийн бүс болох Төв цэнгэлдэх хүрээлэнгийн хойно, төмөр замын урд талд 11,8 га газрыг нийтийн орон сууцны барилга барих зориулалтаар, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалтын бүс Богд хааны ордон музейн хойд талд үйлчилгээний зориулалтаар 16 000 м² газар эзэмших эрх олгожээ.⁶³

Төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, эмнэлгийн эдэлбэр газарт орон сууц, үйлчилгээний зориулалтаар газар олгох, барилга барих, барилгуудын хоорондын зай хэмжээг ойртуулан, нарны эзвэрлэлтийн хугацааг тооцоогүй ерөнхий төлөвлөгөө, барилгын ажлын зураг төсөл баталсан, томоохон үйлчилгээний төвүүдийг гудамжны улаан шугаманд оруулан, явган хүний зам, ногоон байгууламжгүй барьсан, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, авто машины зогсоол дээр барилга барихаар газар олгосон, авто замын харааны гурвалжин дотор үзэгдэх орчинг хязгаарлан барилга барих зэрэг нийтлэг зөрчил, дутагдал байгаа нь хот төлөвлөлтийн бодлого алдагдаж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчихөд хүргэж байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2002 оны 138 дугаар, 2005 оны 264 дүгээр, 2006 оны 350 дугаар захирамжаар хотын төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай 20-30 жил ашиглагдсан орон сууцнуудын барилгын дээвэр дээр нийт 124 монсардны барилга барих зөвшөөрөл өгснөөс ихэнх нь баригдаж дууссан байна. Эдгээр барилгуудыг барихдаа давхар нэмж болох эсэх талаар эцсийн техникийн шийдэл гараагүй байхад зураг төслийг боловсруулсан, угсралтын ажил гүйцэтгэхдээ барилгын үндсэн даац болох багана, дам нурууны холбоос бэхэлгээг дутуу чанаргүй гүйцэтгэснээс оршин суугчдын аюулгүй байдал хангагдаагүйгээс гадна барилга угсралтын ажлыг ихэнхи тохиолдолд зөвшөөрөлгүй эхэлсэн нь холбогдох байгууллагаас хийсэн хяналт, шалгалтын явцад илэрчээ.

Иймд барилгын дээвэр дээр барьсан монсардан давхарууд хүний ая тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг хангахгүй байна гэсэн үндэслэлээр 2008 оны 3 дугаар сард улсын байцаагчийн гаргасан дүгнэлтийн дагуу цаашид барилга угсралтын ажлыг зогсоох шийдвэр гаргаж, Зам Тээвэр, Барилга, Хот Байгуулалтын Яам болон холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдэд мэдэгдсэн байна. Сүүлийн үед барилга угсралтын компани, аж ахуйн нэгжүүд цаг хугацаа хэмнэх, барилгаа хурдан ашиглалтанд өгөх, чанарын бус тооны хойноос хөөцөлдөн, хүйтний улиралд

⁶³ Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын Дэд бүтцийн улсын хяналтын газрын 2005-2010 онуудад хийсэн ажлын талаарх мэдээлэл.

барилгын ажил хийх болсон нь тэдгээрийн чанарт муугаар нөлөөлж байна. Олон улсын судалгаа, стандартаар хасах 5 хэм хүрч хүйтэрсэн тохиолдолд цемент болон бетон цутгах ажлыг хийхгүй байх дүрэмтэй байдаг байна.

Нийслэл Улаанбаатар хотод 1950, 1960-аад онуудад баригдсан зарим нэг орон сууцны барилгуудын чанар муудаж, хүн амьдран суух боломжгүй болсон байруудыг холбогдох газраас дүгнэлт гаргуулан буулгаж, оршин суугчдыг шинэ байранд оруулах ажил хийгдэж байгаа бөгөөд Баянзүрх дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх Цэргийн 44 дүгээр байр, Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны 21 дүгээр байр, Баянгол дүүргийн хуучнаар “Төмөр замын” гэгдэх 2 давхар шар байрууд тухайлбал 17, 18 дугаар байруудыг буулган оронд нь 9-12 давхар орон сууцны барилга барьсан буюу барихаар төлөвлөж, одоо амьдарч байгаа айл өрхүүдийг шинэ тохилог орон сууцаар хангаж байгаагаас гадна хотын төвийн хэсгийг шинэчлэн барилгажуулах санал санаачлагын хүрээнд Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны I-40 мянгатын 15-17 дугаар байруудыг шинэчлэн барих ажлыг эхний ээлжинд 48, 72 айлын 2 орон сууцыг барьснаар 42 айл өрхийг шинэ сууцанд оруулах, хотын төвийн хэсгийн барилгажилтын нягтралыг нэмэгдүүлэх боломж бүрдсэн байна.

Ашиглалтанд ороод он удаан жил болж, бат бөх байдал, чанар нь муудаж, газар хөдлөлт, үер ус, салхи зэрэг байгалийн гамшгийн үед нурж унах, иргэдийн амь нас, эрүүл мэндэд хор хохирол учруулах магадлалтай болсон орон сууц, үйлчилгээний газруудыг нэг бүрчлэн тогтоож, ашиглалтаас гаргах ажлыг эрчимжүүлэх шаардлага тулгарч байна.

Улаанбаатар хотын орчим нийт 20 гаран оршуулгын газар байгаагаас ихэнх нь хотын суурьшлын бүсийн салхины дээд талд байрлалтай, Самбалхүндэв, Алтан-Өлгий, Орос, Казах иргэдийн оршуулгын газрууд хотын суурьшлын бүс дотор орсноор айл өрхүүд талийгаачийн шарилтай хаяа зэрэгцэн амьдарч, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байна. Иймээс оршуулгын газрыг хотын бүсээс гаргах, хуучин оршуулгын газруудыг цэгцлэх, шарилыг чандарлах орчин үеийн шинэ дэвшилтэт аргуудыг өргөн нэвтрүүлэх, үнэ ханшийг хямдруулах, зардал чирэгдлийг багасгах шаардлага тавигдаж байна.

Зөвлөмж: Барилга, шатахуун түгээх станц барихад газар олгож буй болон зөвшөөрөл өгч буй өнөөгийн эмх замбараагүй, хяналтгүй байдалд дүгнэлт хийж, Барилгын тухай хууль (1998 он)-ийн биелэлтэд хяналт тавих чиг үүргээ холбогдох байгууллагууд биелүүлэх; (2005)

Улаанбаатар хотын хүн ам өсөн нэмэгдэж, хот өргөжин тэлэхийн хирээр тухайн үеийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хотын гадна төлөвлөн барьж байгуулсан шатахууны агуулахууд хотын суурьшлын бүс дотор орсон, мөн зарим нефтийн агуулахад хот төлөвлөлтийн норм, дүрмийг зөрчин, хот дотор шинээр газар олгож

барилснаас 27 нефтийн агуулах хотын суурьшлын бүсэд үйл ажиллагаа явуулж байна.⁶⁴

Нийслэлд 175 шатахуун түгээх станц ажиллаж байна. Шатахуун түгээх станц нь үндэсний стандартад заасны дагуу гэр хорооллоос 50 метр, хоорондоо 60 метрээс доошгүй зайтай, галын аюулгүй байдлыг бүрэн хангасан байх ёстой атал тавигдаж буй шаардлагыг хангаагүй 57 шатахуун түгээх станц, хот суурин газар ажиллуулахыг хориглодог ил сав бүхий 3 шатахуун түгээх төв иргэдийн амь насанд илэрхий заналхийлж, үйл ажиллагаа явуулж буйг нэн даруй зогсоох шаардлагатай байна.

Тэсэрч дэлбэрэх, гал түймэр гаргах орчин тойрондоо нэн аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, түгээх, худалдаалах журмыг хүн амын аюулгүй байдалд нийцүүлэн гаргаж, биелэлтийг нь чанд мөрддөг, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах хэрэгтэй байна. Нийгэм хурдацтай хөгжиж, хотжилт эрчимтэй явагдаж байгаа энэ үед Улаанбаатар хотод хүн амын хэт төвлөрөл үүсч, хотын хөгжлийн цаашдын ирээдүй, нийгмийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх бодлогын чанартай арга хэмжээг тухай бүрт нь авахгүй явж ирснээр нийгмийн хөгжлийн хурд, хүн амын механик өсөлтийг хотын бүтээн байгуулалт гүйцэхгүй болсон байна.

Дээрх байдлаас үзэхэд Улаанбаатар хотын хот байгуулалтын бодлого алдагдаж, өвлийн улиралд агаарын бохирдлоос үүдэн гамшгийн байдалтай болох, хавар зуны улиралд үер усны аюулд автах, мөн газар хөдлөлтийг тооцоогүй баригдсан барилгуудаас шалтгаалан Нийслэл Улаанбаатар хотын иргэд эрсдэлийн байдалд амьдрахад хүрч байна.

Зөвлөмж: Нийслэлийн авто замуудыг хоногийн автомашины урсгал, нэвтэрч өнгөрөх тээврийн хэрэгслийн тоо, хөдөлгөөний ачааллаас хамааран ангилалтай болгох, тэмдэг гэрэл дохио тавих, инженерийн байгууламжаар хангах, явган хүнд зориулсан аюулгүй байдлыг хангасан хонгил-гарцыг шаардлагатай уулзваруудад бий болгох; (2005)

Улаанбаатар хотод 427,6 км урт зам, том, жижиг нийлсэн 61 гүүр, гүүрэн гарц байгаагийн 80 орчим хувь нь 20-иос дээш жилийн насжилттай буюу ашиглалтын хугацаа нь дууссан байна.⁶⁵

2009 оноос эхлэн Нийслэлд "Зам тээврийн оновчтой систем" нэртэй төслийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын зээлээр хэрэгжүүлж эхэлсэнээр 47 уулзварт шинээр гэрлэн дохио, 26 уулзварт теле камер, 52 цэгт мэдрэгч

⁶⁴ Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын Дэд бүтцийн улсын хяналтын газрын 2005-2010 онуудад хийсэн ажлын талаарх мэдээлэл.

⁶⁵ Нийслэлийн Авто замын газрын дарга Д.Одын хэвлэлд өгсөн ярилцлага, www.ulaanbaatar.mn 2011.03.10.

суурилуулахаас эхний ээлжинд 28 уулзварт гэрлэн дохио тавих болсноос хөдөлгөөний нягтрал ихтэй Эх Нялхсын Эрдэм Шинжилгээний Төв, Соёл, Урлагийн Их Сургуулийн урд талын замын уулзвар зэрэг 8 газар гэрлэн дохио шинээр суурилуулсан байна.

Манай улсад сүүлийн 3 жилийн дунджаар жилд 600 орчим хүн зам тээврийн ослоор амь насаа алдаж, 3 000 гаруй хүн гэмтэл авч, эрүүл мэндээрээ хохирч байгаа нь замын чанар, нөхцөлөөс зохих хэмжээгээр шалтгаалж байна. Нийслэлийн авто замын сүлжээний урт 2008-2010 онд 9 хувиар өссөн байхад хөдөлгөөнд оролцож байгаа автомашины тоо 75 хувиар өсч, зарим ачаалал ихтэй уулзвар, гарц, гүүрээр нэгж хугацаанд нэвтрэх тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн тоо нэмэгдсэн нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг улам бүр хүндрүүлж байна.

Нийслэлийн Авто Замын Газар 2010 онд улсын төсвөөс 4,065 тэрбум, нийслэлийн замын сангийн 6,467 тэрбум, өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэй 65,076 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 67,3 км авто зам, 509,9 метр урт гүүрийг нийслэлд шинээр барих буюу өргөтгөл шинэчлэлт хийхээр төлөвлөснөөс Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн урд талд явган зорчигчид зориулсан нүхэн гарц, Маршалын гүүр зэргийг шинээр барин ашиглалтад оруулж, Гурвалжингийн гүүрийг шинэчлэн засварласан байна.⁶⁶

Хөдөлгөөний ачааллыг бууруулах, аюулгүй байдлыг хангах зорилгоор Тээврийн товчоо болон Нарантуул захаас урагш төмөр замын дээгүүр Хан-Уул дүүрэг хүртэл гүүрэн гарц баригдаж байна.⁶⁷

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хот доторх төмөр замын гарам орчмын хөдөлгөөний аюулгүй байдал алдагдаж, осол гарах, улмаар хүний амь нас эрсдэх, иргэд эрүүл мэндээрээ хохирох явдал нэмэгдсэн нь анхаарал татах болжээ. Төмөр замын Цагдаагийн хэлтсийн гаргасан мэдээгээр төмөр замын гарам дээр 2009 онд зам тээврийн 10 осол гарч, 5 хүн нас барж, 7 хүн хүнд, хөнгөн гэмтсэн, 2010 онд зам тээврийн 14 осол гарч, 6 хүн нас барж, 8 хүн гэмтэл авсан, 2011 оны эхний 3 сарын байдлаар 4 осол тус тус гарсан байна.

Монгол-Оросын Хувь Нийлүүлсэн Нийгэмлэг Улаанбаатар Төмөр Замаас ирүүлсэн мэдээгээр 2005-2010 онд Замын Цагдаагийн Газрын урд талын 406 дугаар гарам дээр 31 удаа, Толгойт өртөө орчмын 396 дугаар гарамд 66 удаа авто тээврийн хэрэгсэл, галт тэрэгтэй мөргөлдөх, шүргэгдэх зэрэг хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлсөн осол, зөрчил гарсан байна. Мөн хот болон авто замын төлөвлөлт, шинэчлэлтийн бодлогод төмөр зам болон авто гармын онцлогийг уялдуулдаггүйгээс

⁶⁶ Нийслэлийн Авто замын газрын ажлын тайлан, УБ., 2010 он.

⁶⁷ Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газраас авто замын салбарт хийсэн шалгалтын дүн, УБ., 2010 он.

төмөр зам, гармын ойртох хэсэгт барилга байгууламж барьсан нь гарманд ойртон ирэх тээврийн хэрэгслийн жолооч, галт тэрэгний машинч нарт үзэгдэх орчин, аюулгүйн зай хязгаарлагдаж харагдах болсон байна.

Төмөр замын 396 дугаар гармын урд талаар үйлдвэр, үйлчилгээний газрууд шинээр барьж байгуулсан, 406 дугаар гармын урд талд “Баян Монгол” болон бусад орон сууцны хорооллууд баригдсанаар гармуудаар өнгөрөх авто тээврийн хэрэгслийн тоо 2004 онд 5 740, 2011 онд 41 155 болж өссөн нь осол зөрчил гарах бас нэг шалтгаан болж байна. Иймээс төв суурин газрын авто болон төмөр замын аюулгүй байдлыг хангахад шинжлэх ухааны үндэслэлтэй, тооцоо судалгаатай хандаж, тээврийн хэрэгслийн болон явган зорчигчийн хариуцлагыг сайжруулж, явган зорчигчийн эрсдэлийг аль болох багасгах зорилгоор замын тэмдэг, тэмдэглэгээг шаардлагатай бүхий л газарт байрлуулж, нүхэн болон гүүрэн гарцыг аюул ачаалал ихтэй замын хэсгүүд болон авто болон төмөр замын огтлолцол дээр барьж байгуулах, зам тээврийн осол, зөрчлийн байдалд тогтмол судалгаа дүгнэлт хийж, түүнд нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авч байх шаардлагатай байна.

Зөвлөмж: Химийн хорт болон аюултай бодис нэвтрүүлэх эрх бүхий боомтуудад мэргэжлийн лаборатори ажиллуулах, химийн бодисыг хадгалах, устгах цэгүүдийг тогтоох, ашиглалтад тавих хяналтыг сайжруулах, химийн бодисын хор хөнөөлийн талаар иргэдэд мэдээлэл хүргэх ажлыг шуурхай зохион байгуулах; (2008)

Улсын Их Хурал химийн бодист тавих хяналтыг сайжруулах зорилгоор 2006 онд Химийн хортой болон аюултай бодисын тухай хуулийг шинэчлэн баталж, тус хуулийн дагуу химийн бодисыг импортлох тусгай зөвшөөрлийг зөвхөн Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам олгох болсон нь химийн бодисын импортод тавих хяналтын нэгдсэн тогтолцоог бий болгоход чухал алхам болсон байна. Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоолоор “Монгол Улсад ашиглахыг хориглосон болон хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт”-ыг баталж, Засгийн газрын 2006 оны 296 дугаар, 2007 оны 65 дугаар тогтоолоор Монгол Улсын хилийн Дорноговь аймаг дахь Замын-Үүд боомт, Буянт-Ухаа боомт, Дорнод аймаг дахь Баянхошуу боомт, Сэлэнгэ аймаг дахь Сүхбаатар боомт, Сэлэнгэ аймаг дахь Алтанбулаг боомт, Сүхбаатар аймаг дахь Бичигт боомтуудаар химийн бодисыг импортолж болохоор журамлажээ.

2007 онд Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамнаас хийсэн химийн бодисын ашиглалт, аюултай, хортой хог хаягдлын улсын нэгдсэн үзлэг, тооллогоор Монгол Улсын хэмжээнд нийт 944 нэр төрлийн 8 368 959,2 кг химийн бодис бүртгэгдсэн байна.

Засгийн газрын 2007 оны 201 дүгээр Улсын нэгдсэн үзлэг, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолд химийн хорт болон аюултай бодисыг нэвтрүүлэхээр зөвшөөрөгдсөн хилийн боомтыг шаардагдах лабораторийн болон хяналтын тоног төхөөрөмжөөр хангах талаар заасны дагуу 2008 оноос эхлэн эдгээр боомтуудад Гаалийн Ерөнхий Газрын мэргэжлийн лабораториуд байгуулагдан ажиллаж байна.

Химийн бодисын хэрэглээнд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр Байгаль Орчин, Аялал Жуулчлалын болон Гадаад Харилцааны сайдын 2009 оны 334/104 дүгээр хамтарсан тушаалаар “Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах тухай”, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайд, Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн сайд, Эрүүл Мэндийн сайдын 2009 оны 63/67/87 дугаар хамтарсан тушаалаар “Пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг турших, ашиглах тухай” журам, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын болон Эрүүл Мэндийн сайд, Онцгой Байдлын Ерөнхий Газрын даргын 28/40/29 дүгээр хамтарсан тушаалаар “Химийн хорт ба аюултай бодисын эрсдлийн үнэлгээ хийх тухай” журам, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайд, Эрүүл Мэндийн сайдын хамтарсан 2008 оны тушаалаар “Химийн хорт болон аюултай бодисын ангилалын тухай” журам, мөн “Химийн хорт болон аюултай бодисын ангилалыг ашиглах аргачлал”-ыг тус тус батлан гаргажээ.

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам химийн хорт болон аюултай бодисын ашиглалтад хяналт тавих ажлын хүрээнд Полихлорт бифенилийг⁶⁸ агуулсан тоног төхөөрөмжийн улсын нэгдсэн тооллогыг эхлүүлж, Полихлорт бифенилийн шинжилгээний орчин үеийн лабораторийг 130 сая төгрөгийн санхүүжилтээр Шинжлэх Ухааны Академийн Хими, Хими-технологийн Хүрээлэнтэй хамтран байгуулж, тоног төхөөрөмжөөр хангаснаас гадна “Химийн хорт болон аюултай бодисын шошго, тэмдэг” стандартыг боловсруулан батлуулсан байна.

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайд, Эрүүл Мэндийн сайд, Онцгой Байдлын Ерөнхий Газрын даргын 2009 оны 28/40/29 хамтарсан тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах тухай” журамд химийн хорт болон аюултай бодисын агуулахыг хүн ам оршин суугаа газраас 300-гаас доошгүй метрийн зайд, үер усанд автахааргүй байрлалд байрлуулах ба агуулах нь гал тэсвэржилтийн зэргийг хангахуйц материал, хийцтэй, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цементэн болон плитан), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалга, үерийн далан, хамгаалалтын сувагтай байх, эдгээр бодисыг холбогдох байгууллагын мэргэжилтнүүдийг

⁶⁸ Полихлорт бифенил (ПХБФ) нь байгаль дээр задралгүйгээр олон арван жил хадгалагддаг, үр удамд нөлөөлж, хорт хавдар үүсгэдэг онцгой хортой бодис.

оролцуулан зориулалтын цэгт устгах талаар заасан боловч улсын хэмжээнд тийм зориулалтын цэг байхгүй байна.

Нийслэл хот, Улаанбаатар төмөр замын удирдлагууд төмөр замаар тээвэрлэгдэн ирсэн химийн бодисыг буулгах, хадгалах терминалыг хотын дотор (Толгойт, Хонхор) хүн амд аюултай бүсэд байрлаж байгааг нүүлгэн шилжүүлж Багахангайд шинээр терминал байгуулах талаар хамтран ажиллах тохиролцоонд хүрсэн байна.

Засгийн газар болон холбогдох байгууллагууд сүүлийн жилүүдэд химийн хорт бодисыг импортлох, хадгалах, тээвэрлэх, ашиглах, худалдах, устгах тухай асуудлыг зохицуулсан олон тооны журам, дүрэм гаргаж ажилласан нь сайшаалтай байна. Харин энэхүү дүрэм, журмын хэрэгжилтийг байгууллага, аж ахуйн нэгжүүд хэрхэн хэрэгжүүлж, мөрдөж байгаад тогтмол хяналт тавьж, зөрчил дутагдлыг цаг тухайд нь арилгуулж байх нь чухал байна.

Зөвлөмж: Байгаль орчны хууль тогтоомжийг зөрчигчидтэй хийх тэмцлийг чангатгаж, орчин тойрондоо хортой, аюултай нөлөөлөлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгсдэд тавих хяналт шалгалтыг тогтмолжуулж, хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх; (2005)

Байгаль орчныг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох, байгаль орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах бүтцийг бий болгох чиглэлээр хууль эрх зүйн үндэслэлүүдийг бий болгосон байна. 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдөр Эрүүгийн хуулийн “Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг” бүлэгт “Агаар бохирдуулах, Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих, Газрын хөрс, усыг бохирдуулах, Усны тухай хууль тогтоомж зөрчих, Ойн тухай хууль тогтоомж зөрчих, Байгалийн ургамлын тухай хууль тогтоомж зөрчих, Ой, хээрийн түймэр тавих, Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж зөрчих” зэрэг зүйлүүдийг өөрчлөн найруулж, хүлээлгэх хариуцлагыг чангаруулж, тавигдаж буй шаардлагад нийцүүлсэн байна.

2010 онд Улсын Мөрдөн Байцаах Газрын бүрэлдэхүүнд Байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсийг 10 мөрдөн байцаагчтайгаар шинээр байгуулжээ. Энэ хэлтэс үйл ажиллагаагаа эхэлснээс хойшхи зургаан сарын хугацаанд 85 үйлдэлд хэрэг бүртгэлт хийж, 37 үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгажээ.⁶⁹ Энэ нь төрөлжсөн байгууллага байгуулагдаад удаагүй ч байгаль орчны хууль тогтоомж зөрчигдсөн

⁶⁹ Улсын Мөрдөн Байцаах Газрын Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсийн дарга, цагдаагийн хошууч И.Буян-Єлзийгийн ярилцлага, www.olloo.mn цахим хуудас, 2011.03.25.

үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох, хариуцлага тооцох ажиллагаа идэвхжиж байгааг харуулж байна.

Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр, гэрээний байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, түүнд хамрагдсан байдал, байгаль орчныг нөхөн сэргээх, засч тохижуулах арга хэмжээний биелэлтэд тавих хяналтыг хуульд зааснаар Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газраас эхлэн аймаг, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, сумдын байгаль орчны хяналтын байцаагч хүртэл хэрэгжүүлж, “Хяналтын хуудас” гэсэн шинэ арга зүйг нэвтрүүлэн, хяналт шалгалтын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, шуурхай, аливаа нөлөөллөөс ангид хараат бусаар хэрэгжүүлэх боломж бүрдэж эхэлсэн байна.

Сүүлийн жилүүдэд нийслэлийн бохир усны цэвэрлэх байгууламжийн нөхцөл байдал нилээд анхаарал татсан асуудал болж, бохир ус гадагш гаран, эвгүй үнэр тархаж, гол, хөрсийг бохирдуулж байгаа тухай ихээхэн шүүмжлэлд өртөж байна. Засгийн газар, Нийслэлийн Засаг дарга буюу Улаанбаатар хотын захирагчаас бохир усны цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг сайжруулах, тоног төхөөрөмжийг шинэчлэх талаар ихээхэн анхаарал тавин, зарим арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирсэн байна. Улсын болон орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагаас ч багагүй анхаарч, цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, жил бүр 2-3 удаа дээж аван, шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч ажилладаг болжээ.

Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газраас хууль бусаар бэлтгэсэн модыг Улаанбаатар хот руу нэвтрүүлдэг 9 замыг судлан тогтоож, хяналтын пост байгуулахаар холбогдох газруудад санал тавин, эхний ээлжинд Тахилтын ам, Улиастайн аманд хяналтын 2 постыг байгуулж, Ойн Газар, Цагдаагийн Ерөнхий Газрын Хэв журмыг хамгаалах газар, Нийслэлийн Байгаль Хамгаалах Газар, Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газраас байнгын эргүүл жижүүрийг ажиллуулж эхэлжээ.⁷⁰

Харин хяналтын энэ үйл ажиллагааг тогтмолжуулах, чанар үр нөлөөг нь дээшлүүлэх, иргэд олон нийтийн хүч туслалцааг авах, мэдээлэл өгч хамтарч ажилласан иргэд, байгууллагыг урамшуулан дэмжиж ажиллах шаардлагатай байна.

Зөвлөмж: Байгалийн баялгийг ашиглах зөвшөөрлийн явцыг нээлттэй, олон нийтийн хяналтын доор хийх механизмыг бий болгох; (2005)

2006 онд шинэчлэн найруулсан Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7-д “Төрийн захиргааны байгууллага ашиглалтын тусгай зөвшөөрөл

⁷⁰ Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын албан бичиг, 2011.02.11, №1/297, хавсралт 1.

олгосноос хойш ажлын 7 өдөрт багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд энэ тухай тус тус мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ” гэсний дагуу Ашигт Малтмалын Газар ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг нийтэд мэдээлэх үүрэг хүлээж өдөр тутмын сонинд сар бүрийн эхний долоо хоног бүрт мэдээлдэг болжээ.

Мөн хуулийн 57 дугаар зүйлийн 57.4-д “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан, байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж болзошгүй химийн хорт болон бусад бодисын хэрэглээний талаарх мэдээллийг байгаль орчны болон геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийтэд нээлттэй болгож, тухайн мэдээллийг цахим хэлбэрээр түгээнэ” гэж заасан нь хөдөө орон нутгийн иргэдэд хүртээмжэй эсэх нь тодорхой биш гэж үзэхээр байна. Өөрөөр хэлбэл, зөвхөн төв суурин газрын (аймгийн төв, Нийслэл) иргэд энэ мэдээллийг авч болохоор байна. Иймээс энэхүү хуульд аймаг, Нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн орон нутагт ямар газарт ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон тухай иргэддээ заавал мэдээлэх үүрэгтэй гэж тусгах шаардлагатай байна.

Үүнээс гадна Хүний Эрх Хөгжил Төв төрийн бус байгууллагаас 2010 онд “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээн дэх орон нутгийн иргэдийн оролцоо” мониторинг хийжээ. Мониторингийн тайланд “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т заасан “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нарийвчилсан үнэлгээний тайланд хийсэн шинжээчийн дүгнэлтийг үндэслэн, тухайн төсөл хэрэгжих газрын иргэдийн саналыг харгалзан төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ” гэсэн заалт нь нарийвчилсан үнэлгээн дэх иргэдийн оролцоог Монгол Улсад бүрэн хүлээн зөвшөөрсөн төдийгүй заавал харгалзан үзэх ёстойг харуулж байна. Гэхдээ иргэдийн оролцооны энэхүү заалтыг үл ойшоож, уул уурхайн аливаа төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлэхээс нь өмнө тухайн төсөл, хөтөлбөр хэрэгжих газрын иргэдийн саналыг аваагүйгээс нутгийн иргэдтэй үл ойлголцох, зөрчил тэмцэлд хүрч, энэ нь зарим тохиолдолд зэвсэг хэрэглэсэн мөргөлдөөн, хүн амины хэрэг гарахад ч хүргэдэг байна.”⁷¹ гэж дурджээ.

Мөн тайлангаас “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд иргэдийн оролцоог хангах, иргэдийн санал авах асуудлаар эрх зүйн орчинг бүрдүүлэх тодорхой зохицуулалтуудыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4; 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтууд; Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар, Байгаль орчинд нөлөөлөх байдлын

⁷¹ “Хүний Эрх Хөгжил Төв”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээн дэх орон нутгийн иргэдийн оролцоо” мониторингийн тайлан, УБ., 4 дэх тал.

үнэлгээний комиссын ажиллах журам зэрэгт тусгасан боловч эдгээр заалтуудыг сайжруулах, нэг мөр ойлгох, хэрэгжилтийг сайжруулах шаардлага байсаар байна”⁷² хэмээн дүгнэсэн байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллагын үүрэг оролцоог хуульчилж, иргэний нийгмийн байгууллагын хяналтын механизмыг бий болгоход чухал ач холбогдолтой болжээ. Түүнчлэн энэ хуульд байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэж заасан нь байгаль орчинд учруулсан хохирлыг зөвхөн тухайн сум, дүүргийн Засаг дарга, төрийн байгууллага нэхэмжлэх эрхтэй байсныг өөрчилж төрийн бус байгууллагад энэ эрхийг олгосон нь чухал ач холбогдолтой болсон.

Үүнээс үзвэл байгаль хамгаалах, байгалийн баялгийг ашиглах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллага, иргэдийн хяналт оролцоог дээшлүүлэхэд чиглэсэн эрх зүйн зөв тогтолцоо бүрдэж эхэлсэн байна. Иргэний нийгмийн байгууллагууд ч байгаль хамгаалах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж, улсын болон орон нутгийн чанартай олон байгууллага байгуулж, байгаль орчныг сүйтгэсэн, бохирдуулсан, нөхөн сэргээлт хийгээгүй компани, аж ахуйн нэгжүүдтэй тэмцэл хийж, олон нийтэд нээлттэй болгон, зарим талаар төрийн механизмтай хамтарч эхэлжээ. Саяхан Засгийн газар, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо, Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл (Иргэдийн Альянс Төв)-тэй хамтран ажиллах хэлэлцээр байгуулжээ. Иргэд, иргэний нийгмийн байгууллагын санал санаачлагыг зөв ашиглаж, нийтийн эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллага, иргэдийг дэмжих, урамшуулах, хамтарч ажиллах явдал чухал байна.

Зөвлөмж: Нийслэл хот болон төв суурин газрын агаар, орчны бохирдолтын мэдээг олон нийтэд зориулан тогтмол өгч байх; (2005)

Нийслэл Улаанбаатар хот болон төв суурин газрын агаар, орчны бохирдолтын мэдээг Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд заасны дагуу Монгол Улсын хэмжээнд агаарын чанарын болон орчны хяналт шинжилгээг 33 хяналтын харуулаар тодорхойлж, олон нийтэд тогтмол мэдээлдэг болжээ. Агаарын чанарын хяналт шинжилгээг 1978 оноос эхлэн 2009 он хүртэл агаарт хүхэрлэг хий, азотын давхар ислийн агууламжийг хэмжиж байсан бол одоо есөн үзүүлэлтээр тодорхойлж, Нийслэлийн Агаарын Чанарын Албаны 4 суурин харуул, AQMS-9000 автомат явуулын системийн тусламжтайгаар СО-угаарын хий, NO₂-азотын давхар исэл, SO₂-

⁷² “Хүний Эрх Хөгжил Төв”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээн дэх орон нутгийн иргэдийн оролцоо” мониторингийн тайлан, УБ., 21 дэх тал.

хүхэрлэг хий болон PM10 том ширхэглэлт тоосонцорын агууламжийг хэмжин, “Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2007 стандарттай харьцуулан агаарын чанарын мэдээг боловсруулж, TV-5 телевизийн “Цаг” хөтөлбөр, Нийслэлийн Агаарын Чанарын Албаны цахим хуудас болон www.ulaanbaatar.mn, www.airquality.ub.gov.mn, www.gogo.mn, www.tsag-agaar.mn зэрэг цахим хуудсуудад, электрон самбараар дамжуулан иргэд, олон нийтэд тогтмол мэдээлдэг болжээ.⁷³

Дархан-Уул, Орхон аймгуудад 24 цагийн 8, 14, 20 цагуудад орчны хяналт шинжилгээг хийж, тухайн орон нутгийн телевиз болон www.tsag-agaar.mn цахим хуудсаар дамжуулан нийтэд хүргэдэг байна. Харин энэхүү мэдээллийн ач холбогдлыг зөв ойлгох, үнэлэх, дүгнэх, хэрэглэх, үйл ажиллагаандаа ашиглах талаар иргэд, байгууллагад чиглэсэн сурталчилгааны ажлыг сайтар хийх шаардлагатай байна.

Зөвлөмж: Орчны бохирдлыг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах байгалийн гамшигтай тэмцэх эрх зүйн орчныг эдийн засгийн, нийгмийн болон бусад хөшүүрэг, урамшууллын механизмтай уялдуулан боловсронгуй болгох; (2005)

Үндэсний хэмжээнд хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны тухай, Усны тухай, Рашааны тухай, Агаарын тухай, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай, Ойн тухай, Ашигт малтмалын тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай, Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай зэрэг нийт 30 гаруй хуулиар зохицуулж байна.

2011 онд Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийг батлан гаргаж, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах зорилго, чиглэл, байгууллага, иргэдийн үүрэг, хариуцлага, оролцоо, агаарыг бохирдуулсан этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон нь чухал алхам болжээ. Энэ хуулиар стандартын шаардлага хангасан гэр, орон сууцтай, цахилгаан халаагуур хэрэглэж байгаа, хийн түлшээр ажилладаг халаалттай, нар, салхи, бусад сэргээгдэх эрчим хүч ашиглаж байгаа, стандартын шаардлага хангасан шахмал болон коксон түлш, сайжруулсан зуух, яндангийн шүүлтүүр ашиглаж байгаа, байгаль орчинд ээлтэй амины орон сууцтай айл өрхийн эрчим хүчний үнийг 50 хувиар хямдруулж, зөрүүг улсын төсвөөс санхүүжүүлэх урамшууллын механизмыг тогтоожээ.

Агаарын бохирдлыг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 11 дүгээр тогтоолыг 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталжээ. Уг тогтоолд:

⁷³ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан бичиг, 2011.02.11, №1/297, хавсралт 3.

- Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын цахилгаан эрчим хүчний шөнийн хэрэглээний цагийг хүйтний улиралд оройн 18 цагаас өглөөний 09 цаг хүртэл сунгаж, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуульд заасан нөхцөл, шалгуур хангасан айл өрхөд цахилгаан эрчим хүчний үнийг 50 хувиар бууруулах арга хэмжээ авч, зөрүүг улсын төсвөөс санхүүжүүлэх;
- Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа айл өрхөд жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрөөс дараа оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд эрчим хүчний шөнийн хэрэглээг урамшууллын хэлбэрээр зохицуулахад шаардлагатай бэлтгэл ажлыг 2011 оны 8 дугаар сарын 1-ний дотор авч хэрэгжүүлэх;
- Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхийн цахилгаан эрчим хүчний урамшууллын хөнгөлөлтийн зөрүүг эрчим хүчний байгууллагад олгох;
- Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн аливаа хэрэглээ, үйлчилгээ, үйлдвэрлэлийг дэмжиж урамшуулах;
- 2013-2014 онд шилжих өвөл гэхэд Нийслэлийг агаарын бохирдолгүй хот болгохыг Засгийн газарт даалгажээ.

Энэ мэтээр агаарын бохирдлыг бууруулах талаар багагүй арга хэмжээ авч байгаа боловч нөхцөл байдал сайжраагүй байна. Сүүлийн жилүүдэд гарсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, амьдралд хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд онцгой хариуцлагатай ажиллах, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, хуулийг олон нийтэд сайтар сурталчилах, тайлбарлан таниулах, агаарын бохирдолтой бүх нийтээрээ тэмцэн тавьсан зорилгодоо хүрэх шаардлагатай байна.

Зөвлөмж: Хот суурин газарт өвлийн улиралд цас, мөс цэвэрлэх ажиллах хүч, техник хангамжийг нэмэгдүүлэх, замын эвдрэл гэмтэл, хальтиргаа гулгаанаас болж осол аварга өртөх, гэмтэж бэртэхэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгох; (2005)

Улаанбаатар хотод авто замын хальтиргаа гулгааг арилгах ажлыг дүүргүүдийн Тохижилт үйлчилгээний компаниуд хариуцан ажилладаг бөгөөд Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нийт 300 гаруй зам талбайн үйлчлэгч өдөр тутам нийтийн эзэмшлийн зам талбайн хог хаягдал, цас мөсийг цэвэрлэж, 2008 онд Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр цас цэвэрлэгээний зориулалттай Оросын Холбооны Улсад үйлдвэрлэсэн Камаз маркийн 6 автомашин үйлчилгээнд гаргаж, өвлийн улиралд авто замын хальтиргаа арилгах ажилд цас мөс хайлуулах зориулалтын

бодисыг 2008 оноос эхлэн ашиглаж, 2010 оноос 0,3-0,5 мм хайрга цацан туршиж, хүн хүч, техник хангамжийг нэмэгдүүлэх тодорхой арга хэмжээг авсан байна.⁷⁴

Хэдий тийм боловч өвлийн улиралд хальтиргаа гулгаа ихэсч, дүүргүүдийн Тохижилт үйлчилгээний компаниудын хүчин чадал мөхөсдөж, авто машины осол гарч, иргэд халтирч гэмтэж бэртэх, улмаар амь насаа алдах явдал гарсаар байна.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 63 дугаар тогтоолоор “Хот тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс дагаж мөрдөх журам” батлагдсан. Үүнтэй уялдан Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газрын даргын 2009 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн “Хяналт шалгалтыг эрчимжүүлэх” тухай 221 дүгээр тушаал гарч бүх улсын байцаагчид хяналт тавин холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.⁷⁵

Энэ ажлыг зөвхөн хотын үүрэг мэтээр үздэг хуучин хандлагыг өөрчилж, байгууллага, аж ахуйн нэгжүүд, иргэдийн үүрэг хариуцлагыг тодорхой болгон, тэдний хүч туслалцааг энэ ажилд чиглүүлэх шаардлагатай байна.

Зөвлөмж: Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх; (2008)

Улаанбаатар хотод үйлдвэрийн болон ахуйн гаралтай хаягдал бохир ус цэвэрлэх зориулалттай Ус Сувгийн Удирдах Газрын харьяанд Төв цэвэрлэх, Найрамдал, Нисэх, Био тосгон, Багахангай дүүргийн цэвэрлэх байгууламжууд, байгууллага, аж ахуйн нэгжийн харьяанд “Багануур-Ус” Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын, “Харгиа” ХК, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Сэтгэцийн клиникийн эмнэлэг, Чандмань, Налайх Төрийн өмчит үйлдвэрийн газрын харьяанд 2 цэвэрлэх байгууламж, “Бөхөг” ХХК, “Биокомбинат” Улсын үйлдвэрийн газрын гэсэн 12 цэвэрлэх байгууламж ажиллаж, хоногт 160-170 мянга орчим шоо метр бохир усыг цэвэрлэн гаргаж байгаагийн бараг 140-160 мянган шоо метр бохир усыг зөвхөн Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж цэвэрлэдэг байна.

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжид Испани Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр 11 сая еврогийн өртөг бүхий төсөл хэрэгжиж, дөрвөн насос станц, есөн цацраг тунгаагуурын тоног төхөөрөмжүүдийг шинэчилж, лаг шахах шүүлтүүртэй хоёр шахуургыг шинээр суурилуулснаар засвар үйлчилгээ, ашиглалтын зардал буурч, ил талбайд хаях лагийн хэмжээ 10 дахин багасч, байгаль орчин, хөрс, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлж байна хэмээн Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Комисст мэдээлжээ.

⁷⁴ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан бичиг, 2011.02.11, №1/297, хавсралт 6.

⁷⁵ Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын албан бичиг, 2011.02.10, №03/305, хавсралт 1.

Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газраас цэвэрлэх байгууламжуудын хаягдал бохир усыг цэвэрлэж буй үр дүнд байнгын хяналт тавьж, жил бүр 2-3 удаа дээж авч, шинжилгээ хийн, үнэлэлт, дүгнэлт өгч байна. Гэсэн хэдий ч нийслэл өргөжин тэлж, жил тутам олон зуун барилга, орон сууц ашиглалтанд орж, арьс ширний үйлдвэрүүдийн химийн бодистой бохир ус их ирдэгээс Төв цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагааг хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх зайлшгүй шаардлага байсаар байна.

Зөвлөмж: *Айл өрх, байгууллага бүр хогоо ангилж хаях нөхцөлийг бий болгох, хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих, олон улсын жишигт нийцсэн хогийн нэгдсэн цэгүүдийг бий болгох; (2008)*

Айл, өрхүүд хогоо ангилан хаях боломж нөхцөл одоогоор бүрдээгүй байна. Харин Баянзүрх дүүргийн 1, 7 дугаар хороод, Сүхбаатар дүүргийн 5, 7 дугаар хороодын 5 000 өрхийн дунд хог хаягдлыг анхан шатанд ангилан ялгах, хог хаягдлыг зүй зохистой хаях дадлыг иргэдэд бий болгох, хог хаягдлыг анхан шатанд ангилах туршилтын төслийг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Улаанбаатар хотын нэгдсэн хогийн цэгүүдийг олон улсын жишигт нийцүүлэх, цэгцлэх зорилгоор 2010 онд Хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, менежментийг сайжруулах ажлын хүрээнд байгаль орчинд сөрөг нөлөөгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, ландфиллын аргад түшиглэсэн хог хаягдлын нэгдсэн цэгийг Сүхбаатар, Хэнтий, Дундговь, Дорноговь аймгуудад барьж байгуулсан бол Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэр Нарангийн энгэрт олон улсын жишигт нийцсэн хог хаягдлын төвлөрсөн цэгийг 2009 оны 4 сард ашиглалтанд оруулжээ.

2010 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Улаанбаатар хотын ерөнхий менежер Бүгд Найрамдах Солонгос Улсын Койка байгууллагын удирдлагууд Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэг дээр хог хаягдал ангилан ялгах, хаягдал цаас, гялгар уутаар хатуу түлш (RPF) түлшний үйлдвэр байгуулах төслийн санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд уг үйлдвэрийг 2011 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулахаар төлөвлөжээ.⁷⁶

Дээрх ажлын эхлэл санаачлагыг Засгийн газраас дэмжиж, хог хаягдлыг дахин ашиглах, хог хаягдалтай харьцах иргэдийн мэдлэг, ойлголт, чадварыг сайжруулах шаардлагатай байна.

Зөвлөмж: *Цөлжилттэй тэмцэх бие даасан хууль гаргах асуудлыг судлах; (2008)*

Цөлжилттэй тэмцэх талаар Улсын Их Хурал, Засгийн газраас зарим арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Засгийн газраас 2005 онд “Ногоон хэрэм”, 2010 онд

⁷⁶ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан бичиг, 2011.02.11, №1/297, хавсралт 7.

“Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталж, цөлжилттэй тэмцэх талаарх олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлэх болон хэд хэдэн нийтлэг зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилт дэвшүүлжээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2010 онд “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль”-ийн төслийг боловсруулж, 2011 оны 1 дүгээр сард Засгийн газарт хүргүүлсэн байна. Хуулийн төсөл хөрсийг элэгдэл, эвдрэл, бохирдлоос хамгаалах, нөхөн сэргээх, цөлжилтөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байна.

Уг хуулийг батлан гаргаснаар хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эрх үүрэг, хариуцлагыг зохицуулсан эрх зүйн таатай орчин бүрдэнэ.

Зөвлөмж: *Усны өртгийг нэмэгдүүлэх, байгууллага, айл өрхийг тоолууржуулах замаар усны хэрэглээнд зохистой хяналт тавих, усны эх үүсвэрүүдийг хамгаалах; (2008)*

Засгийн газрын 2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 351 дүгээр тогтоолоор ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээг ус ашиглалтын зориулалтаар ангилж, шинэчлэн тогтоожээ.

Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын түвшинд усны үнийг өртөг зардалд нь ойртуулан тогтоох зорилгоор цэвэр, бохир усны төлбөрийг нэмэгдүүлэх санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн сан, санхүү эдийн засгийн хэлтэс, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо, Шударга Өрсөлдөөн Хэрэглэгчдийн Төлөө Газар зэрэг байгууллагуудад хүргүүлэн, орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагад борлуулдаг усны бөөний үнийг 50 хувиар нэмэгдүүлжээ.

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, 33 дугаар зүйлийн 33.1-ийг үндэслэн усны хэрэглээг зохистой болгох, улсын хэмжээнд усны нөөцийг хэмнэх, усны алдагдлыг бууруулах, усыг арвигч, үр ашигтай зарцуулах горимыг ус ашиглагч бүх төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ, айл өрхөд нэвтрүүлэх, тоолууржуулалтын ажлын хүрээнд аж ахуйн нэгж байгууллагуудыг 100 хувь, айл өрхийн зарим хэсгийг тоолууржуулснаар, албан байгууллага, айл өрхийн усны хэрэглээ жил тутам буурчээ.⁷⁷ Улсын Их Хурлаас 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдөр Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг баталж, энэхүү хууль болон Усны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, тэмдэгжүүлэхээр Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайдын 2009

⁷⁷ Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын албан бичиг, 2011.02.11, №1/297, хавсралт 10.

оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 370 дугаар тушаалаар “Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, тэмдэгжүүлэх журам”-ыг баталж, уг журмаар хамгаалалтын бүсийг тогтоосон нь ач холбогдолтой болжээ. Цаашид гарсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг сайтар хангаж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд усны зохистой хэрэглээнд сургах талаар тодорхой ажил зохиох шаардлагатай байна.

Зөвлөмж: Голын гольдирол өөрчлөх асуудлыг Байгаль орчны яам шийдвэрлэдэг тогтолцоог өөрчилж, гольдирлыг шилжүүлэх болон өөрчлөх асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэр гаргаж байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох; (2008)

Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.8 дахь хэсгийн “Голын голдирлыг түр буюу хэсэгчлэн өөрчлөх, усны урсацын тохируулга хийх, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд мэргэжлийн дүгнэлт гаргах бүрэн эрхийг Усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ” гэсэн заалт хэвээр үйлчилж байгаа тул зөвлөмжийн энэхүү заалт хэрэгжээгүй байна.

3.2 Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх

Хөдөлмөрлөх эрх

Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй.

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэг)

Зөвлөмж: Хөдөлмөрийн норм, үнэлгээг зөв оновчтой тогтоох, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлагыг биелүүлэх, ажил олгогчийн гэм буруугаар ажилтанд учирсан хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн төлүүлэх; (2004)

Хөдөлмөрийн норм, үнэлгээг зөв, оновчтой тогтоох талаар бодитой арга хэмжээ аваагүй байна. Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2001 оны 48 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн норм, нормативыг тогтоох журам” батлагдсанаас хойш энэ журамд ямар нэг өөрчлөлт ороогүй байна. Харин Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт Үндэсний хороогоор 2011 оны 4 дүгээр сарын 5-ны өдрөөс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 140 400 төгрөг болгон нэмэгдүүлсэн байна.

Аж ахуйн нэгж, байгууллагууд ажлын байранд мөрдөгдөх хөдөлмөрийн норм, үнэлгээ, цалин, урамшууллыг нарийвчлан тогтоодоггүй зөрчил түгээмэл байгааг Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын шалгалтын дүн харуулж байна. Тус газраас

2009 онд уул уурхайн салбарт Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-д заасан ажил олгогчоос баталж мөрдүүлбэл зохих баримт бичгүүд, ажил, албан тушаалын жагсаалт, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн норм, норматив, цалингийн сүлжээ, нэмэгдэл хөлс, шагнал, урамшуулал олгох журам байгаа эсэхэд шалгалт хийжээ.

Шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын 80,1 хувь буюу 322 байгууллага нь ажлын байрны тодорхойлолтгүй, 74,8 хувь буюу 301 байгууллага ажил, албан тушаалын жагсаалтгүй, 78,1 хувь буюу 314 байгууллага хөдөлмөрийн норм, нормативгүй, 67,6 хувь буюу 272 байгууллага цалингийн сүлжээ, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал олгох журамгүй үйл ажиллагаа явуулж байгаа зөрчил илэрсэн байна.⁷⁸ Иймд цаашид, хөдөлмөрийн норм, үнэлгээг шинэчлэн тогтоохтой холбоотой Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны санаачлагыг Засгийн газраас дэмжиж, шуурхай арга хэмжээ авах шаардлагатай.

Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг стандартчилах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг хангах талаар зарим арга хэмжээг авч хэрэгжүүлж, 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хурлаар “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийг батлан гаргажээ.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай Үндэсний хөтөлбөр нь 2005-2010 онд 5 зорилтын хүрээнд 23 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт нь 2009 онд 71,45 хувьтай байна. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт явуулах түшиц газар бий болгох хөтөлбөрт тусгагдсан ажлыг хэрэгжүүлэхээр хувийн хэвшлийн байгууллагуудаас боловсруулж ирүүлсэн төслийг дэмжиж ажиллаж байна. Харин энэ хуулийг сурталчлах талаар Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам хангалтгүй ажиллаж байгаа нь тус яамны 2009, 2010 оны үйл ажиллагааны тайлангаас харагдаж байна.⁷⁹

Ажил олгогчийн буруугаас эрх нь зөрчигдсөн, энэ нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нотлогдсон ч хохирлоо зохих ёсоор нөхөн төлүүлж чадахгүй байгаа тохиолдол цөөнгүй гарч байна. Комисс 2004-2010 онд энэ төрлийн 11 гомдол хүлээн авч, шалгаж холбогдох байгууллагуудад 6 шаардлага, 5 зөвлөмжийг хүргүүлэн, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авчээ.

⁷⁸ Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, Уул уурхайн салбарт хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр хийсэн нэгдсэн шалгалтын танилцуулга, УБ., 2009 он, 3 дахь тал.

⁷⁹ Тус яамны 2009, 2010 оны үйл ажиллагааны тайланд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг олон нийт, ялангуяа ажил олгогчдод сурталчлах талаар авсан арга хэмжээний тухай мэдээлэл хангалтгүй байна.

Зөвлөмж: Уул уурхайн нийт албан салбаруудад Хөдөлмөрийн хууль тогтоомжийн заалт болон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын холбогдох конвенцийн хэрэгжилтийн байдалд улсын хэмжээнд үзлэг явуулах; (2005)

2009, 2010 онуудад Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар уул уурхайн салбарын хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны чиглэлээр улсын хэмжээний үзлэг, шалгалтыг зохион байгуулжээ. Шалгалт нь Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай, Нийгмийн даатгалын тухай зэрэг хуулиуд болон тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарсан тогтоол шийдвэр, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, хууль тогтоомжийг сурталчлах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх зорилготой байжээ.

Шалгалтад нийтдээ 21 аймаг, 8 дүүргийн 402 байгууллага, 772 цех тасаг, 22 794 хүн хамрагджээ. Шалгалтанд хамрагдсан уул уурхайн салбарын үйлдвэрүүдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг зохион байгуулан шалгалт авч хэвшээгүй, шаардлагатай байр, тоног төхөөрөмж, сургалтын материал хангалтгүй, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт 60 хувьтай байна гэж дүгнэжээ. Гарсан зөрчлийн дийлэнх нь ажил олгогч, ажилтнууд хууль тогтоомжийн талаарх мэдлэг, ойлголт дутмаг байдагтай холбоотой гэж Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар үзсэн байна.

Зөвлөмж: Уул уурхайн салбарт ажиллагсдыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, Улирлын чанартай үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн ажилтны ажиллаагүй хугацааны нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хураамжийг цалин хөлсний доод хэмжээгээр тооцож ажил олгогч төлж байх талаар Хөдөлмөрийн тухай хуулийн 46.3-д заасныг ашигт малтмал олборлох үйлдвэр, уурхайд чанд мөрдүүлэх; (2005)

Хувиараа гар аргаар ашигт малтмал олборлогсдыг нийгмийн даатгалд хамруулах оновчтой хэлбэрийг сонгож хэрэгжүүлэх; (2005)

Уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүд ажилчдыг нийгмийн даатгалд хамруулах талаар Эрдэс Баялаг, Эрчим Хүчний Яам, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам хамтран ажиллаж, зохих үр дүнд хүрч байна. 2010 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хурлаас Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан Засгийн газар 2010 оны 12 дугаар сарын 1-ний өдөр хувиараа ашигт малтмал олборлогсдын үйл ажиллагааг зохицуулсан журам гаргажээ. Журмын 3 дугаар зүйлд хувиараа ашигт малтмал олборлогсдыг нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, халамжийн үйлчилгээнд хамруулах талаар тусгасан нь ач холбогдолтой болжээ. Түүнчлэн 2010 онд Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам, Эрдэс Баялаг, Эрчим Хүчний Яамнаас Швейцарийн

Хөгжлийн Агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслийн дэмжлэгээр 5 аймгийн 9 сумын 3 216 бичил уурхайчдыг нөхөрлөлийн зохион байгуулалтанд оруулж, 1 800 хүнийг эрүүл мэндийн, 600 бичил уурхайчдыг нийгмийн даатгалд хамруулсан байна. Мөн “Үйлчилгээний ажилчдын ур чадварыг хөгжүүлэх холбоо”-той хамтран ажиллаж, барилгын материалын “100 айл” худалдаа, үйлчилгээний захын 650 албан бус хөдөлмөр эрхлэгчдээс 120 хүнийг нийгмийн даатгалд хамруулж, 60 хүнд нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн дэвтрийг олгуулжээ.⁸⁰

Ажил олгогчид ажиллагсадаа нийгмийн даатгалд бүрэн хамруулдаггүй, огт төлдөггүй эсвэл нийгмийн даатгалын дэвтэр дэх бичилтийг буруу хийдэг зөрчил түгээмэл гарч байна. Тухайлбал, дээр өгүүлсэн Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн нийт ажилчдын 14,9 хувь буюу 2 754 ажилтан нийгмийн даатгалын дэвтэргүй байснаас 0,6 хувь нь нийгмийн даатгалын байгууллагын, 97,6 хувь буюу 2 689 нь ажил олгогчийн, 1,8 хувь буюу 51 нь ажилтны буруугаас олгогдоогүй байсан нь илэрчээ.⁸¹

Ажил олгогч, даатгуулагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог сар бүр хийж, төлбөрийг бүрэн төлж барагдуулаагүйгээс 4 аймаг, 7 дүүргийн 49 байгууллага 464 255,8 мянган төгрөгийн өрийн үлдэгдэлтэй болж, улмаар ажилтнуудын нийгмийн даатгалын дэвтэрт бичилт бүрэн хийгдээгүй, төлөх ёстой шимтгэл дутуу төлөгдсөн байжээ.⁸²

Уул уурхайн салбарын ихэнх үйлдвэрүүд улирлын шинж чанартай үйл ажиллагаа явуулдагаас ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ бус, хөлсөөр ажиллах буюу ажил гүйцэтгэх гэрээг түр хугацаагаар байгуулах, нийгмийн даатгал болон бусад шимтгэл төлөхөөс зайлсхийх зөрчил гарсаар байна. Энэ асуудалд холбогдох байгууллагууд анхаарч, хамтран авах арга хэмжээгээ тодорхойлох шаардлагатай байна.

Зөвлөмж: Хөдөлмөрийн харилцаанд насаар ялгаварлах хандлага байсаар байгаа учир Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд “энэ хууль болон холбогдох хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хүнийг насаар ялгаварлахыг хориглоно” гэсэн хэсэг нэмж оруулах; (2005)

Үндэс угсаагаар ялгаварлан цалин хөлсийг ялгаатай өгч байгааг зогсоох зорилгоор Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 7.2-т заасныг баталгаажуулахын тулд мөн хуулийн 49.2-т “...эрэгтэй, эмэгтэй ажилтанд...” гэсний дараа “болон үндэс, угсаагаар ялгаварлахгүйгээр ...” гэсэн үгс нэмж оруулан найруулах; Дээрх хуулийн 7 дугаар зүйлийн заалтыг баталгаажуулах

⁸⁰ Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны үйл ажиллагааны тайлан, УБ., 2010 он, 26 дахь тал.

⁸¹ Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, Уул уурхайн салбарт хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр хийсэн нэгдсэн шалгалтын танилцуулга, УБ., 2009 он, 7 дахь тал.

⁸² Мөн тэнд.

зорилгоор мөн хуулийн 128 дугаар зүйлд “энэ хуулийн 7 дугаар зүйлд заасныг зөрчсөнтэй холбоотой маргаан” гэсэн хэсэг нэмэх саналын дагуу нэмэлт оруулах; (2005)

Хамтын гэрээ, хэлэлцээрийг ажил олгогч заавал байгуулах шаардлагагүй гэж үздэгээс хамтын гэрээтэй холбоотой зөрчил түгээмэл байгааг анхаарч Хөдөлмөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1-д “... аж ахуйн нэгж, байгууллагын бизнес төлөвлөгөө батлахаас өмнө ...” гэсний дараа “заавал” гэсэн үг нэмэх; (2005)

Шөнийн цагийн нэмэгдэл хөлс, ажлын цагийн асуудлыг Хөдөлмөрийн хуулиар нарийвчлан зохицуулах; (2005)

Комиссын зөвлөмж гарснаас хойш Хөдөлмөрийн тухай хуульд 4 удаа нэмэлт өөрчлөлт орсон (2006 онд 1, 2008 онд 2, 2011 онд 1 удаа) боловч, уг хуульд хөдөлмөрийн харилцаанд нас, үндэс угсаа, хүйсээр нь ялгаварлан гадуурхахыг хориглосон тухай өөрчлөлт ороогүй байна.

3.3 Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн туслалцаа авах эрх

Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн туслалцаа авах эрхтэй.

/Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 6 дахь хэсэг/

Зөвлөмж: *Эрүүл мэндийн байгууллагуудыг оношлогоо, эмчилгээний орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах, эмч мэргэжилтнүүдийн ажлын хариуцлагад эрс өөрчлөлт гаргах, тэдний үйл ажиллагаанд амь бөхтэй байгаа үйлчлүүлэгчдээс шан харамж авах, ялгавартай хандах, танил тал харах зэрэг ноцтой дутагдлыг арилгах; (2004)*

Эрүүл Мэндийн Яам нь ойрын жилүүдэд эрүүл мэндийн салбарын хэмжээнд дүрс оношлогоо, эмнэлгийн эмчилгээний тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх ажлын хүрээнд 2007-2008 онд клиникийн болон нарийн мэргэжлийн төв эмнэлгүүд, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн суурин рентген аппаратуудын 90 хувь, дурангийн аппаратуудын 60 хувийг, 2009 онд 2,3 тэрбум төгрөгөөр Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв, Клиникийн Нэгдсэн 2 дугаар Эмнэлэг, Нялхасын Клиник, Эмгэг Судлалын Төвүүдийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмжүүдийг шинэчилжээ.

Сүүлийн 9 жилд эмнэлгийн тоног төхөөрөмжид хийсэн хөрөнгө оруулалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хөрөнгө оруулалтын чиглэлээр	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын дүн /он, сая төг-өөр/									
	2002	2003	2004	Төсөвт эзлэх хувь	2005	2006	2007	2008	2009	2010
Эмнэлгийн тоног төхөөрөмж	100,0	342,0	40,1	1,3 хувь	175,0	2500,0	6900,0	9437,0	2300,0	3800,0

2006 оноос орон нутаг, байгууллагын түвшинд буюу аймаг, нийслэлийн Эрүүл Мэндийн Газар, тус яамны харьяа төрөлжсөн мэргэжлийн клиник, тусгай мэргэжлийн төвүүд, дүүргийн эрүүл мэндийн нэгдлүүдийн дэргэд ёс зүйн салбар хороодыг байгуулан ажиллаж, үйл ажиллагаа нь тогтмолжсон байна. Эрүүл Мэндийн сайдын 2006 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 135 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Эмнэлгийн ажилтны ёс зүйн хэмжээ” баримт бичгийг батлан салбарын хэмжээнд мөрдөж, эмнэлгийн мэргэжилтний баримтлах ёс зүйн хэм хэмжээ, үйлчлүүлэгчтэй болон нийгэмтэй харилцах горим, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн өвөрмөц асуудлууд, хүлээлгэх хариуцлага зэргийг тусгаж, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хорооны дүрэм, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны үлгэрчилсэн журмыг батлан мөрдүүлжээ.

Эрүүл мэндийн салбар дахь ёс зүй, хариуцлагын тухай ойлголтыг шинээр дахин тодорхойлох, дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн шинэ хандлага, арга барилыг судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх талаар тус яам, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо санаачилга гаргаж, маргааныг албан бус журмаар шийдвэрлэх аргыг салбарын хэмжээнд нэвтрүүлэх үүднээс эвлэрүүлэн зуучлах ёс зүйн ажилтныг бэлтгэж эхэлжээ. Мөн 2006 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Эрүүл мэндийн тухай хуульд дээрх ёс зүйн хороог байгуулан ажиллуулах, ёс зүйн хорооны дүрэм, анагаах ухааны болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах тухай нэмэлт оруулсан байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Эрүүл мэндийн салбар дахь сайн засаглал, ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлж, түүний үр дүнд “Эрүүл мэндийн салбар дахь авлига ба шударга ёсны өнөөгийн байдал” харьцуулсан судалгааг хот, хөдөөгийн 1000 гаруй иргэн, эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд явуулж, тус салбар дахь авилгын тархалт, шалтгаан, үр дагаврын тодруулахыг оролджээ. Уг төслийн хүрээнд “Эрүүл мэндийн байгууллагуудын ил тод байдлыг илтгэх үзүүлэлтүүд” баримт бичгийг Эрүүл Мэндийн сайдын 2007 оны 177 дугаар тушаалаар батлуулан салбар, байгууллага, хувь хүний түвшинд удирдлага болгон ажиллаж ирсэн байна.

“Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг дээдлэгч байгууллага, хамт олон шалгаруулах болзол”-ыг 2007 онд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо баталж, “Ёс зүйг дээдлэгч хамт олон” тэтгэлэгт уралдааныг зохион байгуулж, хот, хөдөөгийн 20 эмнэлгийн байгууллагад ёс зүйг дээдлэх төсөл хэрэгжүүлж, Эрүүл

Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургуулийн сургалтын хөтөлбөрт ёс зүйн 20 цагийн хичээл нэмж оруулахаар тусгаж, нийслэл болон орон нутагт эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг заах 56 сургагч багшийг бэлтгэсэн байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Эрүүл Мэндийн Яамнаас Авлигатай Тэмцэх Газар, Төрийн Албаны Зөвлөл, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газартай хамтран “Монгол Улсад шударга, ил тод байдлыг бэхжүүлэх нь” төслийг 2009, 2010 онуудад хэрэгжүүлэн шинэлэг арга нэвтрүүлэх үүднээс “Эвлэрүүлэн зуучлагч-ёс зүйн ажилтан” бэлтгэх анхан шатны сургалтыг явуулж, 25 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг оролцуулсан байна.

Монгол Улсын Авлигатай Тэмцэх Газраас 2009 онд хийсэн авлигын түвшин тогтоох судалгаагаар авлигад автсан салбаруудыг түвшингээр нь эрэмбэлж, эрүүл мэндийн салбар уг жагсаалтын есдүгээрт орсон байна. Харин “Гурван сарын хугацаанд хэнд хахууль өгсөн бэ” гэсэн иргэдийн санал асуулгын дүнд үнэн хэрэгтээ эмч, багш, төрийн захиргааны албан хаагчид, цагдаа нар хамгийн олон давтамжтайгаар хахууль авсан байна.⁸³

Зөвлөмж: Эрүүл мэндийн тухай (1998) хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1-д заасан “олон нийтийн хяналт”, мөн 35 дугаар зүйлд заасан “төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн мэргэжлийн тусламж, үйлчилгээний төлбөрийг төр хариуцах” тухай заалтуудыг эргэн харж, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад адил тэгш боломж олгосон байхаар тус тус хуульчлах; (2004)

1998 онд батлагдсан Эрүүл мэндийн тухай хуульд 18 удаа нэмэлт, өөрчлөлт орсон боловч Комиссын өгсөн зөвлөмжийн дагуу тус хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 35 дугаар зүйлийн найрууллагад өөрчлөлт ороогүй тул зөвлөмж хэрэгжээгүй байна.

3.4 Зохистой хоол хүнсээр хангагдах эрх

Сүүлийн жилүүдэд Засгийн газар зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг баталгаажуулах үүднээс хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж, хүн амын хүнсний хангамж, амьдралын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогын чанартай арга хэмжээг хэрэгжүүлж эхэлжээ.⁸⁴ 2008 оныг “Хүнсний хангамж, аюулгүй байдлын жил” болгон зарлаж, бодлого, хөтөлбөрүүдийг батлан, хэрэгжүүлэх талаар нилээд арга хэмжээ авчээ. Одоогийн

⁸³ Авлигатай Тэмцэх Газар, “Авлигын түвшин тогтоох судалгаа”, УБ., 2009 он, 26 дахь тал.

⁸⁴ “Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт” Үндэсний гурав дахь илтгэл, УБ., 2009 он, 28 дахь тал.

байдлаар зохистой хоол хүнсээр хангагдах эрхтэй холбоотой “Хүнсний баталгаат байдал” (2009-2016), “Экологийн цэвэр бүтээгдэхүүн” (2006-2015), “Иод дутлын эмгэгтэй тэмцэх” (2007-2012) зэрэг үндсэн хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Түүнчлэн, мах⁸⁵, сүү⁸⁶, чацаргана⁸⁷ зэрэг хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний талаар тусгай бодлого боловсруулжээ. Зарим нэг хөтөлбөр, төслийн явцыг эрчимжүүлэх, хэрэгжилтэнд үнэлгээ хийлгүүлэхээр Монгол Улсын Ерөнхийлөгч Засгийн газарт чиглэл өгч, хэрэгжүүлж байна.⁸⁸

Зөвлөмж: Хүн амыг зохистой хоол хүнсээр хангахад төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг Хүнсний тухай хууль (1999 он)-д тодорхой тусгах; (2005)

Хүнсний тухай хуулийг шинэчлэн найруулах ажлыг Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам 2008 онд эхлүүлсэнээс өөр ажил хийгдээгүй байна.

Зөвлөмж: Импортын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд тавих төрийн хяналт, зохицуулалтыг эрс сайжруулах; (2005)

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын бүрэлдэхүүнд Хилийн мэргэжлийн хяналтын алба байгуулагдаж, бие даан үйл ажиллагаа явуулж байгаа нь импортын хүнсний бүтээгдэхүүнд хяналт тавихад чухал ач холбогдолтой арга хэмжээ болжээ.

Мөн тус газар импортын хүнсний хяналтыг экспортлогчийн үйлдвэр дээр очиж, тухайн улсын эрх бүхий хяналтын байгууллагатай урьдчилан тохиролцсоноор гүйцэтгэдэг болж байгаа нь дэвшилттэй юм. Хүнсний чанар, аюулгүй байдлын талаар судалгаа, лавлагааны статистик мэдээллийн сан бүрдүүлэх талаар Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, Үндэсний Статистикийн Хороо болон бусад холбогдох байгууллагууд хамтран ажиллаж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн Ээлжит Нэгдсэн Хэлэлцүүлэгт Монгол Улсын төрийн бус байгууллагуудын форумас хүргүүлсэн тайланд “Манай улсад жилийн хүнсний бүтээгдэхүүний 80 шахам хувийг нь импортоор хангаж, түүний 40 гаруйхан хувийг гүний болон гаалийн шинжилгээнд хамруулж байна”⁸⁹ гэж дурдсан нь анхаарал татаж байна.

⁸⁵ “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг Засгийн газраас 2010 оны 5 дугаар сарын 20-ны өдөр 23 дугаар тогтоолоор 2010-2021 оныг дуустал 11 жилийн хугацаанд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр баталсан.

⁸⁶ “Сүү” үндэсний хөтөлбөрийг Засгийн газраас 2006 оны 10 дугаар сарын 11-ний өдөр 239 дугаар тогтоолоор 2007-2016 оныг дуустал 10 жилийн хугацаанд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр баталсан.

⁸⁷ “Чацаргана” үндэсний хөтөлбөрийг Засгийн газраас 2010 оны 3 дугаар сарын 10-ны өдөр 60 дугаар тогтоолоор 2010-2016 оныг дуустал 6 жилийн хугацаанд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр баталсан.

⁸⁸ Засгийн газарт чиглэл өгөх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, №250, 2010.11.29.

⁸⁹ “Монгол Улс дахь Хүнсний эрхийн хэрэгжилт” төлөв байдлын тайлан, Хүний эрх, хөгжил төв, УБ., 3 дахь тал.

Үүнтэй ижил мэдээллийг 2008 оны 6 дугаар сард зохион байгуулсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлын тулгамдсан асуудлууд” сэдэвт онол практикийн бага хуралд Улсын Мэргэжлийн Хяналтын Газрын (хуучнаар) дарга өгч байжээ.⁹⁰ Эдгээр мэдээллээс харахад импортын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд тавих төрийн хяналт, шалгалт төдийлөн сайжраагүй байна.

***Зөвлөмж:** Хүнсний аюулгүй байдалд тавьж буй хяналт, шалгалтын үйл ажиллагааг сайжруулж, Улсын мэргэжлийн хяналтын алба болон түүний харъяа байгууллагуудын лаборатори, шинжилгээний газруудын чадавхи, хүчин чадлыг эрс нэмэгдүүлэх; (2005)*

Төв, орон нутгийн хүнсний шинжилгээний лабораториудын тоног төхөөрөмжийг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, боловсон хүчнийг чадавхижуулах; (2008)

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар 2008 оны хөрөнгө оруулалтаар нийт 45 нэрийн 403 багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг худалдан авч, Нэгдсэн Төв Лаборатори, 21 аймгийн мэргэжлийн хяналтын газрын болон хилийн боомтын дэргэдэх 15 лабораторид тус тус суурилуулжээ. Энэ ажилд улсын төсвөөс 2,1 тэрбум төгрөг зарцуулсан байна.⁹¹

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын тусламжаар хүнсний нэмэлтийг тодорхойлох лабораторийг шинээр байгуулж, хүхрийн давхар исэл, бензойны хүчил болон бусад бодисыг тодорхойлдог болжээ.⁹² Түүнчлэн, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын санхүүжилтээр хамгийн сүүлийн үеийн цацрагийн хэмжилтийн багаж тоног төхөөрөмжийг Замын-Үүд, Буянт-Ухаа, Алтанбулаг, Сүхбаатар хилийн боомтод суурилуулж, ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг эхлүүлжээ.⁹³ Хүнсний хяналтын лабораторийн хүчин чадлыг сайжруулах талаар арга хэмжээ авч буй боловч цаашид анхаарах асуудлууд байна. Тухайлбал, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын цахим хуудсанд “Нян судлалын лабораторийн одоогийн хүчин чадлын түвшинд хордлого ба хордлогот халдвар үүсгэдэг зарим нян, агааргүйтэн нянгууд, вирус болон нянгийн хор илрүүлэх шинжилгээг хийх боломжгүй байгаа нь нийт шинжилвэл зохих үзүүлэлтийн 20-30 хувийг эзэлж байна. Иймээс молекул биологи, иммунологийн өндөр мэдрэмжит багажит шинжилгээний аргуудыг нэвтрүүлэх шаардлагатай байна. Ингэснээр хүнс болон антибиотикт дасал болсон нянгуудыг богино хугацаанд, нарийвчлал сайтай,

⁹⁰ 2008 оны 6 дугаар сарын 3-ны өдөр зохион байгуулагдсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлын тулгамдсан асуудлууд” сэдэвт онол практикийн бага хурал дээр Улсын Мэргэжлийн Хяналтын Газрын (хуучин нэрээр) дарга Ц.Шийрэвдамбын тавьсан “Хүнсний аюулгүй байдлын тулгамдсан асуудлууд” илтгэлээс. Цахим хаяг: www.inspection.gov.mn (Хяналт шалгалтын мэдээ хэсэг, 2011 оны 3 дугаар сарын 25-ны өдөр үзсэн.)

⁹¹ Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын албан бичиг, №1/530, 2009.03.05, 3 дахь тал.

⁹² Мөн тэнд.

⁹³ Хүнс, Хөдөө Аж ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамны албан бичиг, №6/562, 2009.02.23, 1 дэх тал.

мэдрэгээр илрүүлж, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөхүйц дүгнэлтийг гаргах боломж бүрдэнэ”⁹⁴ гэж мэдээлжээ.

Боловсон хүчнээ чадавхижуулах талаар Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар 2010 онд “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”, “Сургалтын хөтөлбөр”, “Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг шинээр боловсруулж, хамт олноороо хэлэлцүүлэн, батлуулжээ.⁹⁵ Эдгээр хөтөлбөрүүд батлагдсанаар улсын байцаагчдыг 1-2 хоногийн семинарт хамруулж ирсэн өмнөх арга барил өөрчлөгдөж, урт хугацааны зорилтод чиглэсэн сургалтуудад ажилтнуудаа хамруулах болсон гэж мэдээлж байна.⁹⁶ Түүнчлэн, тус байгууллага “Улсын байцаагчийн хөгжлийг дэмжиж, ёс зүйг дээшлүүлэх” зорилтыг 2010 онд дэвшүүлэн Ёс Зүйн Хороо байгуулсан нь улсын байцаагчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой болжээ. 2010 оноос тус газар бүрэлдэхүүндээ Сургалт, мэдээлэл, үйлчилгээний төвийг байгуулан ажиллуулж байна.⁹⁷

Мэргэжлийн хяналтын байгууллагын хөгжлийг хангах шинэчлэлийн бодлого, улсын байцаагчийн хөгжлийг дэмжих, ёс зүйг дээшлүүлэх зорилтын хүрээнд тус байгууллага “Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандартын хэрэгжилт, улсын байцаагчдын түвшин тогтоох үзлэг”-ийг 2010 онд анх удаа явуулсан нь улсын байцаагчдын мэдлэг, ур чадварын өнөөгийн түвшинг тогтоож, энэ чиглэлээр цаашид баримтлах бодлого, үйл ажиллагааг тодорхойлоход үр өгөөжөө өгчээ.⁹⁸ Энэ мэтээр Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар боловсон хүчнээ чадавхжуулах, хүнсний нэмэлт, биологийн идэвхит бодис, хүнсний гарал үүслийн эх үүсвэрийг таних, тоон хэмжээг тодорхойлох орчин үеийн аргачлалууд, багаж хэрэгслийг ашиглах чадавхийг бий болгох тал дээр анхааран ажиллаж байна.

Зөвлөмж: Монгол хүний физиологийн хэрэгцээнд нийцүүлэн хоол тэжээлийн зөвлөмж хэрэгцээг шинэчлэн өөрчлөх; (2005)

⁹⁴ Полимеразан гинжин урвал /ПГУ/, Пульс-гель электрофорез /ПГЭ/, Саузерн болон вестерн блот гэх мэт молекулын түвшний арга хэрэглэсэн шинжилгээ нь лабораторийн бусад аргаар тодорхойлох боломжгүй бичил биетэн, РНХ, ДНХ болон бусад биологийн субстанцуудыг илрүүлдэг. Уг лабораторийг байгуулснаар хүнс болон антибиотикт дасал болсон нянгуудыг богино хугацаанд, нарийвчлал сайтай, мэдрэгээр илрүүлж, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөхүйц дүгнэлтийг гаргана. Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын цахим хуудаснаас: www.inspection.gov.mn, 2011.03.25.

⁹⁵ Төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын хамт олноор хэлэлцүүлэн санал авч, нэгтгэн боловсруулж, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын даргын 2010 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 164 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

⁹⁶ Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, УБ., 2010 оны гуравдугаар улирлын байдлаар, 168 дахь тал.

⁹⁷ Сургагч багш бэлтгэх, удирдах ажилтнуудын манлайллын ур чадварыг дээшлүүлэх, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газрын улсын байцаагчдын англи хэлний чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн зорилтот сургалтуудыг зохион байгуулжээ. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, УБ., 2010 оны гуравдугаар улирлын байдлаар, 168 дахь тал.

⁹⁸ Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, УБ., 2010 оны гуравдугаар улирлын байдлаар, 169 дахь тал.

Эрүүл Мэндийн сайдын 2008 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 257 дугаар тушаалаар хүн амын хоол тэжээлийн физиологийн нормыг баталжээ. Нормыг тогтоохдоо хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, эслэгийн хоногийн хэрэгцээ, аминдэмийн хэрэгцээ, эрдэс бодисын хэрэгцээ сэрүүний болон зуны улиралд хүн амын бүлгээр, насны бүлгээр, хүйсээр ялгамжтай тогтоосон байна.

Зөвлөмж: Хүнсний нэн шаардлагатай бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих; (2008)

Улсын Их Хурал 2011 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталжээ. Уг хуулийн 13 дугаар зүйлд “Газар тариалан эрхлэгчдийн дотооддоо тарьж борлуулсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, үйлдвэрлэсэн гурил, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрийн аргаар төхөөрч бэлтгэн дотооддоо борлуулсан тураг болон шулж ангилсан мах, боловсруулаагүй дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүн, Монгол Улсын нутаг дэвсгэрт дотоодын түүхий эдээр үйлдвэрийн аргаар боловсруулан дотооддоо боловсруулсан хүнсний сүү, сүүн бүтээгдэхүүнийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх”; 14 дүгээр зүйлийн 14.1.4-д “мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, хуулийн этгээд өөрөө бэлтгэсэн буюу тариалсан бөгөөд үйлдвэрлэлийн анхан шатны боловсруулалтад ороогүй мах, өндөг, арьс шир, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ болон дотооддоо үйлдвэрлэсэн гурилыг дотоодын үйлдвэрлэгчдэд борлуулсан бол үнэд нь 10 хувийн нэмэгдсэн өртгийн албан татвар шингэсэн гэж үзэж, тэдгээрийг худалдан авсан этгээдийн төлөх нэмэгдсэн өртгийн албан татварыг уг хувиар хасч тус тус тооцох” гэж тус тус заасан байна.

Эдгээр зохицуулалт нь дотоодын үйлдвэрлэгчдийн татварын дарамтыг багасгах, дотоодын тариаланчид, гурил, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийг хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан, хямд бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой болжээ.

Мөн “Сүү” Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сүүний чанар, эрүүл ахуйн шаардлагыг хангасан үйлдвэрлэл, борлуулалт, хэрэглээ нэмэгдэж, улмаар сүүг цуглуулах, хөргөх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулах тогтвортой, бүтцийг бий болгосноор хүн амын эрүүл мэндийн байдалд нааштай өөрчлөлт гарна гэж үзжээ.⁹⁹

Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд “Улсын болон орон нутгийн төсөв, банкны зээл, гадаадын зээл, тусламжийн хүрээнд хөтөлбөрийн санхүүжилтэд

⁹⁹ “Сүү” үндэсний хөтөлбөр, Засгийн газрын тогтоол, №239, 2006 он, хавсралт 1, 6 дахь тал.

мэдэгдэхүйц ахиц гарснаар сүү үйлдвэрлэл, боловсруулалтын бизнес эрхлэгчдийн болон сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйн тоо, боловсруулсан сүүний хэмжээ нэмэгдэж байна. Улсын төсвөөс оруулсан хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжийг ашиглан сүүг үйлдвэрийн аргаар боловсруулах хүчин чадал аймаг, сумдад сайжрах боломжийг бүрдүүлж байна. 2009 он гэхэд 7,4 сая литр сүү боловсруулах хүчин чадлыг шинээр бий болгож, 710 орчим малчид фермерүүдээс сүү авч боловсруулах боломж бүрдүүлсэн” гэж дурджээ.¹⁰⁰

3.5 Нийгмийн халамж, хамгаалал хүртэх эрх

Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй.

(Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь хэсэг)

Зөвлөмж: *Нийгмийн эмзэг бүлэг (хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нэн ядуу иргэд)-д чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээг хүртээмжтэй болгох, чанарыг дээшлүүлэх, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн дэмжлэг, оролцоог нэмэгдүүлэх; (2004)*

Зөвлөмжийн хүрээнд Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам, Хөдөлмөр, Халамж Үйлчилгээний Газар, хөдөө орон нутгийн салбар хэлтсүүд, төрийн бус болон олон улсын байгууллагууд идэвх санаачлага гарган ажиллажээ.

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооны Ажлын алба 2009-2010 онд “Ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг багасгах замаар амьдралын түвшинг сайжруулах үндэсний болон орон нутгийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ эмзэг бүлгийн хүмүүсийн нөхцөл байдлыг сайжруулахад онцгой анхаарал тавина” гэсэн Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн зорилтын хүрээнд “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн үйл ажиллагааны болон төсвийн төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Мөн нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг хувийн хэвшил төрийн бус байгууллага, иргэдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр төрийн бус байгууллагаас боловсруулан ирүүлсэн 38 төслийг Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулсан Зөвлөл хэлэлцэн сонгон шалгаруулж, 17 төслийн ажил үйлчилгээг дэмжиж, зохих санхүүжилтийг олгосон байна.¹⁰¹

¹⁰⁰ “Сүү” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, УБ., 2009 он.

¹⁰¹ Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2009-2010 оны төлөвлөгөөний биелэлт, 17 дахь тал.

Нийгмийн халамжийн тухай (2005 он) хуульд оруулсан 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөд байнгын асаргаатай хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настнуудад улирал бүр, тэднийг асарч байгаа иргэдэд сар бүр тэтгэмж, бүтэн өнчин хүүхэд болон хүнд нөхцөлд байгаа хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд сар бүр тэтгэмж олгохоор нэмж тусгажээ. Мөн 14 хүртэлх насны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд нэг удаа 60,0 мянган төгрөг, бүтэн өнчин өссөн залуучууд, гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон иргэдийг орон гэртэй болоход нь туслан нэг удаа 500,0 мянган төгрөгийн тусламж үзүүлж байна.

Хүний хөгжил сангийн тухай хууль, Улсын Их Хурлын 2010 оны 99, 100 дугаар тогтоол, Засгийн Газрын 2010 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын иргэн бүрт хишиг, хувь хүртээх журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор 2010 оны 2 дугаар сараас эхлэн хишиг хувь хүртээх ажлыг эхлүүлж, Хүний хөгжил сангаас 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсын нийт иргэдийн 97,6 хувь нь хишиг, хувиа хүртсэн байна.¹⁰²

Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар нь халамж үйлчилгээний зохион байгуулалт, менежментийг сайжруулах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүнд нөхцөлд байгаа хүүхдэд гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ, сэргээн засах үйлчилгээ, түр байрлуулан асрах, хамгаалах байрны үйлчилгээ, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах зэрэг ажил үйлчилгээнд хамруулахаар нийт 36 төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай гэрээний үндсэн дээр мэргэжил арга зүйн удирдлагаар ханган хамтарч ажиллаж байна.

Зөвлөмж: Нэн ядуу, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олгогдож буй халамжийн тэтгэврийн хэмжээ бага, амьдралд хүрэлцэхгүй байгааг нэмэгдүүлэх; (2004)

Нийгмийн халамжийн тэтгэвэр нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй, асарч халамжлах хүнгүй, амьдралын хүнд нөхцөлд амьдарч буй иргэдэд мөнгөн тусламж олгож, амьжиргаанд дэмжлэг үзүүлэх нийгмийн хамгааллын арга хэмжээний нэг хэлбэр юм. Нийгмийн халамжийн тухай хуулиар халамжийн тэтгэвэрт ганц бие ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхэд, 16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг хамрагдаж байна.


Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжид хамрагдсан хүний тоо 2009 онд 1,4 сая болж өмнөх оныхоос 1,0 хувиар буурсан байна.¹⁰³ Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны 2010 оны тайлангаар 56,7 мянган хүнд 27,6 тэрбум төгрөгийн

¹⁰² Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны үйл ажиллагааны тайлан, УБ., 2010 он, 14 дэх тал.

¹⁰³ Монгол Улсын Статистикийн эмхтгэл, УБ., 2009 он, 38 дахь тал.

тэтгэвэр олгожээ. Нийгмийн халамжийн тэтгэвэр нь 2004-2010 онд 3,8 дахин буюу 53 800 төгрөг хүртэл нэмэгдсэнийг дараах хүснэгт 1-ээс харж болно.¹⁰⁴

Хүснэгт 1



Гэвч халамжийн тэтгэврийн хэмжээ өнөөгийн зах зээлийн эдийн засгийн өсөлтийн хурдацтай нийцэхгүй, иргэдийн амьжиргааны хэрэглээний түвшинд хүрэлцэхгүй хэвээр байна. Иймээс цаашид нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг орлогын байдалтай уялдуулан ялгаатай тогтоох асуудлыг судлан шийдвэрлэхээр төрөөс анхаарах зайлшгүй шаардлагатай байна.

Зөвлөмж: Халамжийн үйлчилгээний хяналтыг чангатгах; (2004)

Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу нийгмийн халамжийн мэргэжлийн хяналтыг Мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлэх бөгөөд нийгмийн халамж үйлчилгээний анхан, дунд шатны байгууллагын үйл ажиллагааны талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, нөхцөлт мөнгөн тэтгэмж, мөнгөн тусламж болон нийгмийн халамжийн зориулалттай хөрөнгийн, зээлийн, хандивын зарцуулалтад хяналт тавих, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага ногдуулах саналаа мэргэжлийн хяналтын байгууллагад тавих чиг үүрэг бүхий хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжтэй байхаар зааж, 2008 оноос байгуулан ажиллуулж, халамжийн үйлчилгээний хяналтыг чангатгах зөвлөмжийн дагуу аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний газруудад 2009 оноос эхлэн хяналт, шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан ажилтан ажиллаж байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн өөрчлөлтийн дагуу 2005 оноос сум, хороо бүрт халамжийн үйлчилгээнд хамрагдагсдыг хянах, тодорхойлох зэрэг үүрэг бүхий “Амьжиргааг дэмжих зөвлөл”-ийг иргэний нийгмийн болон нутгийн захиргааны байгууллагын төлөөлөлтэйгээр байгуулан ажиллуулжээ.

¹⁰⁴ Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны албан бичиг, 2011.03.30, №05/683, 2 дахь тал.

Зөвлөмж: *Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж “Ядуучуудын хөдөлмөр эрхлэлт” гэсэн сан байгуулах; (2005)*

Нийгмийн халамжийн тухай хуулиар нийгмийн халамжийн сан нь тэтгэврийн, амьжиргааг дэмжих гэсэн хоёр төрлийн сантай. Комиссоос өгсөн зөвлөмжийн дагуу тус хуульд “Ядуучуудын хөдөлмөр эрхлэлт” гэсэн сан байгуулаагүй тул энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэх боломжгүй байна.

Монгол Улсад ядуурлын түвшин сүүлийн 14 жилийн хугацаанд дөнгөж 1,1 нэгжээр буурсан бөгөөд үлдэж байгаа хугацаанд амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэдийн тоог 2 дахин бууруулах зорилтод хүрэхэд багагүй бэрхшээл учрахаар байна.¹⁰⁵ Иймээс зөвлөмжийн дагуу цаашид ажилгүй ядуу иргэдэд мэргэжил, ажлын дадлага, туршлага эзэмшүүлэн амьжиргааны эх үүсвэртэй болгох, орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, зохистой ажлын байрыг олноор бий болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Зөвлөмж: *Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг дэмжихэд болон ажилгүйчүүд, ажилгүйдэлд өртөж болзошгүй ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд зарцуулдаг болгох; (2005)*

Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг нийтдээ 24 сар, үүнээс сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг ажлын 126 өдрөөр тооцон олгох, даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авснаас хойш 6 сар шимтгэл төлсний дараа дахин ажилгүйдлийн тэтгэмж авдаг эрх үүсдэг байхаар тусгажээ. Ингэснээр даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсэхэд шимтгэл төлсөн байх хугацаа 3 сараар буурч, тэтгэмж авах хугацаа 50 өдрөөр нэмэгдэж ажилгүйдлийн тэтгэмж авах болзлыг зөөлрүүлсэн байна.¹⁰⁶

Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг дэмжихэд болон ажилгүйчүүд, ажилгүйдэлд өртөж болзошгүй ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор мэргэжил олгох, давтан сургалтад 2003-2010 оны хооронд 6 625 хүн хамрагдсан ба 318,4 сая төгрөгийг зарцуулсан байна.¹⁰⁷

¹⁰⁵ Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, Үндэсний 3 дахь илтгэл, 2009 он, 26 дахь тал.

¹⁰⁶ Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны үйл ажиллагааны тайлан, УБ., 2009 он, 3 дахь тал.

¹⁰⁷ Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт 2009-2010, 2010 он, 39 дахь тал.

Ахмад настны эрх

Монгол Улсын иргэн өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй.

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь хэсэг)

Зөвлөмж: Ахмад настны эрхийн асуудалд төрөөс анхаарал хандуулж, тэднийг нийгмийн амьдралд оролцох явдлыг дэмжих, чөлөөт цагаа өнгөрүүлэхэд зориулсан төвүүдийг байгуулах; Харж хандах хүнгүй ахмадуудын асрамжийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; (2009)

Сүүлийн жилүүдэд Засгийн газраас ахмад настны нийгмийн хамгааллын асуудалд түлхүү анхаарч, ахмадуудад зориулсан шуурхай үйлчилгээ үзүүлэх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Засгийн газраас “Монгол Улсын хүн амын насжилтын стратеги”-ийг 2009 онд баталсан нь ахмад настны аж байдлыг сайжруулах, тэдний нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, эрүүл насжих нөхцөл боломжийг нэмэгдүүлэх талаар бодлогын чиглэлийг тусгасан анхны урт хугацааны бодлогын баримт бичиг болсон байна. Мөн Засгийн газраас тэтгэврийг нэмэгдүүлэх талаар үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын хүрээнд 2010 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нийгмийн даатгалын болон халамжийн сангаас олгох тэтгэврийг 30 хувиар нэмэгдүүлсэн ба дайнд оролцсон ахмад настнуудад орон сууц олгох ажлыг 2009 оноос эхлүүлж, одоогийн байдлаар 992 ахмад дайчин энэ арга хэмжээнд хамрагдаж, орон сууцтай болжээ.¹⁰⁸

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4-т “Ахмад настны кабинет, төв байгуулж ажиллах, энэ арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг орон нутгийн жил бүрийн төсөвт тусгах” үүргийг бүх шатны засаг даргад хүлээлгэхээр заасан байна. Гэвч Комиссын зөвлөмжид тусгагдсан чөлөөт цагаа өнгөрүүлэхэд зориулсан төвүүдийг байгуулах талаар төдийлөн анхаарч ажиллаагүй байна. Төрөөс ахмад настны талаар авч буй арга хэмжээ тусламж, дэмжлэг, тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхэд голчлон чиглэж, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, чөлөөт цагаа зохистой өнгөрүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр дорвитой ажил хийгдэхгүй байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д асран хамгаалах харгалзан дэмжих төрөл садангүй бөгөөд бие даах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байршуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл

¹⁰⁸ Монгол Улсын Ерөнхий Сайд С.Батболдын хэлсэн үгнээс www.open-government.mn

ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилгаа үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагааг “төрөлжсөн асрамжийн үйлчилгээ” гэжээ.

Мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг “нийгмийн халамж, дэмжлэг, туслалцаа шаардлагатай хүн”-д оруулан тооцож, харж хандах хүнгүй ахмадад үзүүлэх төрөлжсөн асрамжийн үйлчилгээг Төв аймгийн Батсүмбэр сум дахь Ахмад настны асрамж, үйлчилгээний төв үзүүлж, тус төвд 2011 оны 4 дүгээр сарын байдлаар 130 ахмад настан асруулж байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

4. БҮЛГИЙН ЭРХ

4.1 Үндэстний цөөнхийн эрх

Цаатан иргэдийн эрх

Зөвлөмж: Цаатан иргэдийн нийгмийн асуудлыг нэн даруй шийдвэрлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээг сум орон нутгийн удирдлагуудтай хамтран боловсруулан хэрэгжүүлэх; Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын санал санаачлагыг бодитойгоор дэмжин ажиллах; (2010)

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2009 оны 3 дугаар тогтоолоороо “Цагааннуур сумын эдийн засаг, нийгмийг 2009-2015 онд хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр”-ийг баталж, уг хөтөлбөрийг дэмжих тухай 75 дугаар тогтоолыг Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2010 онд баталжээ.

Засгийн газрын 2007 оны 255 дугаар тогтоолоор баталсан “Цаа бугын аж ахуйг сэргээх, цаачдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхийн тулд Хүнс, Хөдөө, Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн сайдын багцаас цаатан иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулах, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор Сайд, Хөвсгөл аймгийн Засаг дарга нар жил бүр гэрээ байгуулан ажиллаж байна.¹⁰⁹

2010 онд гэрээний дагуу олгох 35 сая төгрөгөөс 28 сая төгрөгийн санхүүжилт орон нутагт ирснээс цаатан иргэдийн оюутны сургалтын төлбөрт 6,608 мянган төгрөг, 1000 цааны баяр тэмдэглэхэд зориулж, сумын Засаг Даргын Тамгын Газарт 3,500 мянган төгрөг, цаатан иргэдийн ахуй амьдралыг сурталчлах “Монголын цаачид” зургийн цомог хэвлүүлэхэд 2 сая төгрөг зарцуулж, цаатан иргэдийн угсаатны зүйн музейн барилга барих зураг төсвийг хийлгэх тендер зарлаж, музейн барилгыг шинээр барихад 20 сая, тайгын багийн холбоожуулалтад 8,1 сая, нийт 28,1 сая төгрөгийн ажил хийлгэхээр “Мөнх-Өргөө” ХХК-тай гэрээ байгуулж, барилгын санхүүжилтэд 12,027,8 мянган төгрөг олгожээ. Хүнс, Хөдөө, Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамнаас авсан хөрөнгөөс 2010 оны жилийн эцэст Цаа Буга сангийн дансанд 3,864,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба дуусаагүй барилгын үлдэгдэл санхүүжилт 7,972,2 мянган төгрөг, холбоожуулалтын үлдэгдэл санхүүжилт 8,100 сая төгрөг, нийт 1,6106,9 сая төгрөгийг нэмж гаргахаар байна.¹¹⁰

¹⁰⁹ Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамны Мал аж ахуй, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас гаргасан “Цаа бугын аж ахуйг сэргээх, цаачдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн тайлан, 2011 он, УБ.

¹¹⁰ Хөвсгөл аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн гэрээний гүйцэтгэлийн тайлан, УБ., 2011 он.

Цаашид Цагааннуур сумын эдийн засаг, нийгмийг 2009-2015 онд хөгжүүлэх, дунд хугацааны хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх, хийж гүйцэтгэх ажлын жагсаалт, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх талаар сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж жил, жилээр төлөвлөн ажиллаж байна.

Зөвлөмж: 2005 онд батлагдсан Тува хэлний хөтөлбөрийг хэрэгжүүлэн тува хэл дээр хэвлэгдсэн ном, сурах бичгээр сумын дунд сургуулийн хүүхдүүдийг хангах; (2010)

...хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө.

(Монгол Улсын Үндсэн хуулийн Наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг)

2003 онд Комиссоос цаатан иргэдийн эрхийн хэрэгжилтэд хийсэн судалгааны үр дүнд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын 2005 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 387 дугаар тушаалаар “Тува хэлний сургалтын хөтөлбөр”-ийг батлуулсан билээ.

Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг Комисс 2009 онд хийсэн судалгааны ажлын хүрээнд тодруулж үзэхэд, Цагааннуур сумын 9-н жилийн дунд сургуульд уг хөтөлбөр хэрэгжээгүй ба тус сургуульд тува хэлийг зөвхөн сонгон суралцах хэлбэрээр зааж, тува хэлнээ орчуулсан ном, сурах бичгүүд байхгүй байна.

Зөвлөмж: Амьжиргааны эх үүсвэртэй болгоход нутгийн болон иргэдийн санал санаачлагыг дэмжин туслах; Засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих хөндлөнгийн хяналтын механизмыг цаатан иргэдийн оролцоотойгоор бий болгон ажиллуулах; (2010)

Цаатан иргэдийн амьжиргааны эх үүсвэр нь цаа буга юм. Сүүлийн жилүүдэд цаа бугын тоо толгой нэмэгдэж, 2009 онд 1 178, 2010 онд 1 286 болж өсчээ.

Мал Аж Ахуйн Эрдэм Шинжилгээний Хүрээлэн, Шинжлэх Ухааны Академи, Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэн зэрэг байгууллагууд хамтран “Цаа бугын удмын санг сэргээх, цаатны нийгэм, соёлын амьдралын түвшинг дээшлүүлэх нь” төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд төслийн хүрээнд цаа бугын үржлийн ангилал, шилэн сонголт хийх, хээлтүүлгийн тохироо гаргах замаар шилмэл үржлийн 300 цаа буга бүрдүүлэх, үржлийн шилмэл эм цаа буга 15 (мянджиг),

хээлтүүлэгч этэр 1-ийг худалдан авч, судалгааны сүрэг бүрдүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.¹¹¹

Цагааннуур сумын Засаг Даргын Тамгын Газраас цаатан иргэдэд “Цаа бугын аж ахуйг сэргээх, цаачдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн 2009-2010 онуудын тайланг танилцуулж, 2011 онд хэрэгжүүлэх ажлын саналыг авч ажилласан байна.

Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн сайд, Хөвсгөл аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээний дагуу хийж байгаа ажлын явцтай тус яамнаас газар дээр нь танилцаж, орон нутгийн удирдлага, цаатан иргэдийн санал, хүсэлтийг судалж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор жил бүрийн ажлын тайлангаа хөтөлбөрийн Үндэсний зөвлөлд танилцуулж байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцох талууд болох бусад яамдын уялдаа холбоо хангалтгүй, төлөвлөгдсөн ажлууд цаг хугацаандаа хэрэгжихгүй байгаад анхаарал хандуулж, цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын оролцоог хангаж ажиллах шаардлагатай.

Зөвлөмж: Цагааннуур сумын хүүхдийн дотуур байрыг шинээр барьж байгуулах, дотуур байранд мөрдөгдөх стандарт дүрмийг шинэчлэн тогтоох; (2010)

“Цаа бугын аж ахуйг сэргээх, цаачдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс гарах зардлын хэмжээг хөтөлбөрийн хавсралтаар баталж, хугацааг тодорхой зааж, энэ хүрээнд Цагааннуур сумын сургуулийн дотуур байрыг өргөтгөн тохижуулах ажлыг 2009-2010 онд хийхээр төлөвлөсөн боловч одоогийн байдлаар ямар нэгэн ажил хийгдээгүй байна.

Захиргааны зориулалтаар 1987 онд баригдсан, хана тааз нь суусан, цууралттай, хүйтний улиралд цан их цохидог, гэрэлтүүлэг муутай, өрөөний багтаамж хангалтгүй байшинг сургуулийн дотуур байрны зориулалтаар ашиглаж байна. Өнөөдөр 63 хүүхдийн багтаамжтай байранд 125 хүүхэд амьдарч байна.

Цагааннуур сумын эдийн засаг, нийгмийг 2009-2015 онд хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрт тусгасан арга хэмжээний жагсаалтад зааснаар сурагчдын 100 ортой дотуур байр барих ажлыг 2013 онд хийхээр төлөвлөжээ.¹¹²

¹¹¹ Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамны Мал аж ахуй, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас гаргасан “Цаа бугын аж, ахуйг сэргээх, цаачдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн тайлан, УБ., 2011 он.

¹¹² Хөвсгөл аймгийн Засаг Даргын Тамгын Газрын хуулийн хэлтсийн албан бичиг, 2010 он, №5/1765

Зөвлөмж: Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангахын тулд сумын эмнэлгийн стандартыг тогтоон эмчлэх эрхийн лиценз олгох боломжийг судлан хэрэгжүүлэх; (2010)

Цагааннуур сумын хүн эмнэлгийн өргөтгөлийн ажлыг 40 сая төгрөгийн санхүүжилтээр хийж, “Тогтвортой амьжиргаа” төслийн хүрээнд хүн эмнэлгийг зөөлөн эдлэлээр хангахад 2 сая төгрөг зарцуулжээ. 2011 онд сумын хүн эмнэлгийг магадлан итгэмжлэлд оруулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Зөвлөмж: Ядуурлыг бууруулах төсөл хөтөлбөрүүдэд цаатан ажилгүй иргэдийг хамруулан ажлын байраар хангах, улирлын чанартай ажил гүйцэтгэх боломжийг судлан гаргаж хэрэгжүүлэх; Цаатан иргэдийн нарийвчилсан судалгааг гаргаж нэг төрлийн судалгаатай болгох; (2010)

Цагааннуур сумын Засаг Даргын Тамгын Газраас цаатан иргэдийн талаарх нарийвчилсан судалгааг гаргаж, нэг төрлийн судалгаатай болжээ. Энэхүү судалгааг жил бүр шинэчлэн хийж байхаар төлөвлөсний дагуу 2011 оны судалгааг дахин шинэчлэн гаргахаар ажиллаж байна.

Мөн аймаг, орон нутгийн хүрээнд иргэдийн амьжиргааг дэмжих арга хэмжээнд 5,7 сая, хөдөлмөр эрхлэлтийн мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулахад 1,450 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ. Цаатан иргэдийг ажлын байраар хангах, улирлын чанартай ажил гүйцэтгэх талаар ямар нэгэн дорвитой ажил хийгээгүй байна.

Үндэстний цөөнх тыва-урианхайчуудын хувьд

Зөвлөмж: Тыва иргэдийн үндэстний цөөнхийн байдлын талаарх нэгдсэн судалгааг хийх, нөхцөл байдлыг тодорхойлон гаргах; (2010)

Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд оршин суудаг тыва-урианхайчуудын талаар нэгдсэн судалгаа хийгээгүй байна.

Зөвлөмж: Соёл, зан заншил, уламжлал, амьдралын өвөрмөц шинжээ хадгалан үлдэх гэсэн чин эрмэлзлэлийг нь хөхиүлэн дэмжиж энэ чиглэлээр тусламж дэмжлэг үзүүлэх; хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх; (2010)

Энэхүү санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр мөн адил тодорхой ахиц, дэвшил гараагүй байх тул зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтнууд анхаарах шаардлагатай.

Харин “Чинагийн Галсан” Сан төрийн бус байгууллага 2005 оноос эхлэн жилд нэг удаа Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын тывачуудыг түшиглэн эко-туризмын үйл ажиллагааг явуулж байна. Энэ үйл ажиллагааны гол зорилго нь тыва иргэдийн хүүхдийг гадаадад сурч боловсрох арга замыг нь нээж өгөх, тэдний амьдралд удаан хугацаагаар туслалцаа үзүүлэх хүмүүстэй танилцуулах, бүхий л талаар дэмжиж туслахад чиглэдэг байна.

Цаашид үндэстний цөөнхийн эрхийн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудад төрөөс зохих тусгамж, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах шаардлагатай.

Зөвлөмж: *Эх хэлээрээ ярих, унших, мэдээлэл авах эрхийг хангахын тулд сумын бага сургуульд суралцаж байгаа сурагчдад тыва хэл заах, хэлний сургалтын арга зүйтэй болгох; тыва хэлний сурах бичгийг зохиох, хэвлэх, монгол хэлнээс тыва хэл рүү сурах бичиг орчуулах ажлыг зохион байгуулах; (2010)*

Тодорхой ажил хийгээгүй. Дунд сургуулиудад ашигладаг хэлний сурах бичгийг зохиох, хэвлэх болон монгол хэлнээс тыва хэл рүү орчуулах ажлыг зохион байгуулаагүй байна.

Зөвлөмж: *Хүүхдүүдийн сурах орчныг бүрдүүлэх нөхцөлөөр хангах; Сурах бичиг, сургалтын стандарт, хөтөлбөр, арга зүйн зөвлөмжийг боловсруулан мөрдүүлэх; (2010)*

2009-2010 оны хичээлийн жилд Азийн Хөгжлийн Банкны дэмжлэгтэйгээр Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын тыва бага сургуулийн дотуур байрны их засвар болон гүний худаг гаргахад 143,645,1 мянган төгрөг, дотуур байранд тавих тоног төхөөрөмжид 29,400 мянган төгрөгийг тус тус зарцуулан засварлаж, иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангасан байна.

Харин Боловсрол, Соёл Шинжлэх Ухааны Яамны харьяа Боловсролын хүрээлэнгээс казах, тыва сургуулиудын хичээлийн агуулга, арга зүйг судлах нэгжийг байгуулах, тус нэгжид ажиллах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулжээ. Одоогоор казах хэлний 4 багш судлаач, тыва хэлний 1 багшийг сонгон авсан байна.

Казах иргэдийн эрх

Зөвлөмж: *Улсын хэмжээнд үндэстний цөөнх казах иргэдийн иргэний бүртгэлийн нэгдсэн статистик судалгааг нарийвчлан гаргах; (2010)*

2010 онд Засгийн газраас Монгол Улсын хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг явуулсан ба тус тооллогоор казах иргэдийн иргэний бүртгэлийн талаарх дэлгэрэнгүй

судалгаа гаргах боломжтой бөгөөд тус тооллогын дүнг Үндэсний статистикийн хорооноос энэ оны 6 дугаар сард гаргана.

Дээрх тооллогоор Баян-Өлгий аймагт урьдчилсан байдлаар 84 мянган казах иргэн тоологджээ.

Зөвлөмж: Тухайн аймаг, орон нутгийн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудыг төр засгийн хэмжээнд дэмжин ажиллах; (2010)

Монгол Улсын 2011 оны Төсвийн тухай хууль¹¹³-д улсын төсвөөс 2011 онд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг Баян-Өлгий аймагт 2,338,5 сая төгрөгөөр тогтоосон нь 2010 оныхоос 755,2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Баян-Өлгий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд төрийн бус байгууллагуудын зөвлөлийг 13 төрийн бус байгууллагын удирдлагыг оролцуулан 2010 оны 1 дүгээр сард байгуулан ажиллаж байна.

Мөн тэдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай хөрөнгийн талаар мэдээлэл цуглуулан улмаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хэлэлцэн 11,2 сая төгрөгийг батлан хуваарилсан байна. Ингэснээр аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа зарим төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулах боломжийг бүрдүүлсэн байна.

Зөвлөмж: Аймаг, орон нутагт төрийн зүгээс хэрэгжиж байгаа хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналтыг цөөнхийн төлөөллийг оролцуулан шалгалтын ажлыг зохион байгуулах; (2010)

Баян-Өлгий аймагт хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүд санхүүжилтгүйн улмаас хэрэгжилт хангалтгүй байна. Зөвхөн "Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр" одоогоор хэрэгжиж байна. Энэхүү хөтөлбөрийг Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамнаас хэрэгжүүлдэг. Тус аймагт хэрэгжиж буй хөтөлбөрийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын Тамгын Газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний тасаг, цөөнхийн төлөөллөөс 10 гаруй иргэнийг оролцуулсан хяналт тавьж ажиллаж байна.

Казах хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах, хэлний ялгаатай байдлыг арилгах, хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах асуудлыг боловсруулж, Засгийн газрын 2010 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, "Казах хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 66 дугаар тогтоол баталсан байна. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор "Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр"-г өөрчлөлт оруулсны зэрэгцээ "Баян-Өлгий аймгийн боловсролын үйлчилгээний чанарыг

¹¹³ Монгол Улсын 2011 оны Төсвийн тухай хууль.

сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын 2010 оны 106 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж байна.¹¹⁴

Зөвлөмж: *Казах хүүхдүүдийн сурах бичгийг орчуулах буюу шинээр хэвлэн гаргах, казах хүүхдүүдийн суралцдаг сургуулиудын хичээлийн сургалтын хөтөлбөрийг дахин шинэчлэн боловсруулж батлан хэрэгжүүлэх, Үндэстний цөөнхийн хүүхдүүдэд боловсрол эзэмшүүлэх асуудалд бодлогын чанартай өөрчлөлтүүдийг тусган хэрэгжүүлэх; (2010)*

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамны Ерөнхий боловсролын газраас ирүүлсэн мэдээнээс үзэхэд казах хүүхдүүдийн сурах бичгийг орчуулах ажил 2008 оноос хойш ерөнхий боловсролын 12 жилийн тогтолцоотой уялдуулан шат дараатайгаар хийж байна. 2010 онд 2 дугаар ангийн математик, хүн орчин, дүрслэх урлаг, технологи, 3 дугаар ангийн математик, хүн орчин, хөгжим, дүрслэх урлаг, технологийн сурах бичгүүдийг монгол хэлнээс казах хэл рүү орчуулж хэвлүүлсэн, 2 ба 3 дугаар ангийн эх хэл сурах бичиг казах хэлээр хэвлүүлэн, 4 дүгээр ангийн математик, хүн орчин, хөгжим, дүрслэх урлаг, технологийн сурах бичгийн хэвлэлийн эхийг монгол хэлээр бэлтгэж, казах хэл рүү орчуулах ажлыг хийж байгаа юм байна.

Тус газраас энэ онд орчуулах сурах бичгийн жагсаалтыг гаргаж, дээрх сурах бичгүүдийг орчуулах багийг сонгон шалгаруулж бүрдүүлсэн байна. Мөн орчуулсан сурах бичгүүдийг хэвлэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарласан байна.

Засгийн газрын 2010 оны 66 дугаар тогтоол, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын 2010 оны 106 дугаар тушаалаар тус тус баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу Боловсрол, Соёл Шинжлэх Ухааны Яамны харьяа Боловсролын хүрээлэнгээс казах, тыва сургуулиудын хичээлийн агуулга, арга зүйг судлах нэгжийг байгуулах, тус нэгжид ажиллах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулжээ. Одоогоор казах хэлний багш судлаач 4, тыва хэлний 1 багшийг сонгон авсан байна. Тус нэгж нь казах сургуулийн хичээлийн сургалтын хөтөлбөрийн агуулга, сургалтын арга зүйг боловсронгуй болгох, шинэчлэх асуудлыг судлан боловсруулахаар төлөвлөсөн байна.

Казах хүүхдүүдэд боловсрол эзэмшүүлэх асуудалд бодлогын чанартай өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх үүднээс Баян-Өлгий аймгийн Засаг даргаас тус аймгийн сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулж, сургууль завсардалтыг арилгах чиглэлээр ажиллаж байна. Баян-Өлгий аймгийн Засаг Даргын Тамгын Газраас казах сургуулиудын сурах бичгийн агуулгад судалгаа хийж, дүгнэлт гарган “Казах сургуулийн сургалтын агуулга” төслийн хүрээнд сурах бичгийн талаар аймгаас

¹¹⁴ Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамны үйл ажиллагааны тайлан, УБ., 2010 он.

баримтлах бодлогын төслийг гаргаж, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яаманд танилцуулжээ.

Казах хүүхдүүд эх хэлээрээ суралцахаас гадна тэдэнд монгол хэлний хичээл заах цагийг нэмэгдүүлэх, монгол хэл заах, багшлах боловсон хүчнийг бэлтгэн Баян-Өлгий аймагт ажиллуулах шаардлагатай байна.

Зөвлөмж: *Казах иргэдийг орлогын эх үүсвэртэй болгоход төр засгийн зүгээс анхааран тэдний санал, санаачлагыг дэмжин ажиллах; (2010)*

Казах иргэдийг орлогын эх үүсвэртэй болгох үүднээс Баян-Өлгий аймгийн Засаг Даргын Тамгын Газраас жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх талаар хөтөлбөр хэрэгжиж, Тогтвортой Амьжиргаа, Дэлхийн Зөн Олон Улсын Байгууллага, Мерси Кор Олон Улсын Байгууллагууд төсөл хэрэгжүүлж эхэлжээ.

Казахстан Улс руу шилжин нүүсэн иргэдээс буцаж ирсэн иргэдэд эсгий гэр авахад Засгийн газраас 180,4 сая төгрөг, 300 тн гурил олгосон байна.

4.2 Цэргийн алба хаагчдын эрхийн хэрэгжилт

Зөвлөмж: *Хугацаат цэргийн алба хаагчдыг дарамтлах, айлган сүрдүүлэх, мөнгө, эд зүйл шаардах, хувийн ажлаа хийлгэх зэргээр хууль бус харьцдаг зөрчлийг таслан зогсооход чиглэсэн удирдлага, зохион байгуулалт, хяналт шалгалтын үр дүнтэй тогтолцоог бий болгох; (2008)*

Цэргийн алба хаагч, албан тушаалтны нийтлэг эрх, үүрэг, тэдний хоорондын харилцаа, цэргийн анги, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг “Цэргийн нийтлэг дүрмүүд”-ийн хүрээнд зохицуулдаг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 379 дүгээр зарлигаар “Цэргийн нийтлэг дүрмүүд”¹¹⁵ шинэчлэн баталж, цэргийн алба хаагчдын эрх, үүрэг, харилцааг нарийвчлан зохицуулж, зарим зүйл, заалтыг нэмж тодотгож тусгасан нь цэргийн алба хаагчдын эрх ашиг зөрчигдөх, хууль бус үйлдлээс хамгаалахад чухал ач холбогдолтой болжээ.

Энэхүү “Цэргийн нийтлэг дүрмүүд”-д нийцүүлэн “Цэргийн албыг зохион байгуулах заавар”, “Зэвсэгт хүчинд хийгдэх дотоодын хяналт шалгалтын нийтлэг журам”-ыг Зэвсэгт Хүчний Жанжин Штабын даргын тушаалаар тус тус батлан цэргийн анги, байгууллагад хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж байна. Түүнчлэн хугацаат цэргийн алба хаагчдын эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, Хүний эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн албан шаардлагын хэрэгжилтийг хангах, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн удирдамж, албан даалгавруудыг

¹¹⁵ “Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд” нь Цэргийн дотоод албаны, Цэргийн сахилгын, Цэргийн хүрээний ба харуулын албаны, Цэргийн жагсаалын дүрмээс тус тус бүрддэг.

боловсруулан анги, байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтийг шалгаж, гарсан зөрчлүүдийг таслан зогсоох, дахин гаргахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр¹¹⁶ цэргийн байгууллага дахь хүний эрхийн нөхцөл байдал сайжирч байна.

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд цэргийн алба хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулах зорилгоор Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдын 2010 оны 46, 218 дугаар тушаалаар “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цэргийн сахилгыг бэхжүүлэх алба”-ыг шинээр байгуулж, албаны чиг үүрэг, бүтцийг бий болгон албан тушаалтнуудыг томилон ажиллуулж байна. Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Улсын хилийг хугацаат цэргийн алба хаагчаар хамгаалуулдаг тогтолцоог өөрчилж, хил хамгаалах албыг мэргэжлийн байгууллагаар удирдан зохион байгуулж, улсын хилийг мэргэшсэн гэрээт хилчнээр гүйцэтгүүлэх тогтолцоонд үе шаттай шилжүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Иргэний цэргийн үүргийн болон цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын 2008 оны 194 дүгээр тогтоолоор батласан “Цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаах журам”-ыг үндэслэн Хил Хамгаалах Ерөнхий Газрын даргын 2010 оны А/10 дугаар тушаалаар “Хил хамгаалах байгууллагад гэрээт хилчний албыг зохион байгуулах журам”-ыг баталснаар 2010 онд Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн бүх заставыг, Хилийн цэргийн 18 ангийн 40 заставт гэрээт хилчний албыг зохион байгуулжээ.¹¹⁷

Сүүлийн жилүүдэд Зэвсэгт хүчин, хил хамгаалах байгууллагын хэмжээнд цэргийн албаны бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр хийж байгаа өөрчлөлт, шинэчлэлт, мөн цэргийн алба хаагчид Монгол Улсыг төлөөлөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд тогтмол оролцож байгаагаас цэргийн албаны нэр хүнд дээшилж, залуучуудын цэргийн алба хаах сонирхол нэмэгдэж байна.

Цэргийн алба хаагчид тэр дундаа хугацаат цэргийн алба хаагчидтай хууль бусаар харьцдаг зөрчлийг таслан зогсоох чиглэлээр удирдлага, зохион байгуулалт, хяналт шалгалтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж ажиллах нь элдэв хууль бус үйлдэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэй.

Гэвч сүүлийн жилүүдэд цэргийн алба хаагчидтай холбоотой галт зэвсэг хэрэглэн бусдын амь насыг бусниулах, цэргийн алба хаагчид өөрийгөө буудах, боомилох, угаартах зэргээр амиа егүүтгэх, өөрийн болон бусдын биед санаатайгаар гэмтэл учруулах зэрэг онц хүнд гэмт хэрэг гарсаар байна.

2010 онд Монгол Улсын Хил хамгаалах байгууллагад гарч буй гэмт хэрэг, түүний дотор хүнд, онц хүнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлан дүгнэж,

¹¹⁶ Монгол Улсын Батлан Хамгаалахын сайдын албан бичиг, 2010.12.16, №1а/2795.

¹¹⁷ Хил Хамгаалах Ерөнхий Газрын үйл ажиллагааны тайлан, УБ., 2011.02.23, №1-3/604.

офицер, ахлагч, хугацаат цэргийн алба хаагчийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хилийн анги, заставт зохион байгуулах талаар санал, зөвлөмж, богино, дунд хугацааны хөтөлбөр боловсруулах зорилгоор Хууль Зүйн Үндэсний Хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн сектор, Хил Хамгаалах Ерөнхий Газрын Улсын хил судлалын сектороос судалгаа хийжээ.

Судалгаанд “...сүүлийн үед цэргийн алба хааж байх үедээ амиа хорлох явдал өсөх хандлагатай байна. Сэтгэцийн гэм судлаачид “Хүн амиа хорлох нь сэтгэл гутралын хамгийн эцсийн үе шат (депресс) бөгөөд энэ шат хүртлээ хүн тодорхой үе шатыг дамждаа” гэжээ. Тиймээс зөвхөн амиа хорлох талаас нь биш онц хүнд гэмт хэрэг үйлдэж болох байсан тэр эрсдэлийг ч гэсэн харах хэрэгтэй юм. Хүний сэтгэл зүйн янз бүрийн темпераментээс хамааран зарим нь амиа хорлох тухай боддог байхад, нөгөө хэсэг нь ямар нэг байдлаар түүнийгээ гадагш гаргадаг байна. Амиа хорлох болсон шалтгааныг бодитойгоор тогтоож, нэг удаа болоод өнгөрсөн хэрэг явдал мэтээр орхигдуулахгүй байх хэрэгтэй”.¹¹⁸ Нийгэмд цэргийн алба хаагч амиа хорлож байгаа тохиолдлыг илүү соргогоор хүлээн авдаг. Нэн ялангуяа ийм тохиолдол бүрийн ард “дэглэлт” буюу дүрмийн бус харилцаа байдаг гэсэн өрөөсгөл ойлголт тогтжээ. Зөвхөн судалгааны ажлын 4 сарын хугацаанд гэхэд зэвсэгт хүчин, дотоодын, хилийн цэргийн салбарт нийтдээ 4 цэрэг, алба хаагч амиа хорлосон тохиолдол гарчээ. Энэ нь алба хаагчдын хооронд даамжирч, ужгирсан нуугдмал дүрмийн бус харилцаанаас гадна тэдгээрийн хоорондын хувийн таарамжгүй харилцаа, гэр бүлийн шинжтэй маргаанаас үүдэлтэй байгааг анхаарах хэрэгтэй байна...” гэжээ.

Улсын Дээд Шүүхийн Судалгааны төвөөс гаргасан цэргийн албаны эсрэг гэмт хэргийн талаарх шүүхээр таслан шийдвэрлэсэн хэргийн тоон мэдээтэй танилцахад, Эрүүгийн хуулийн 276 дугаар зүйлээр (Захирагчийг заналхийлэх, эсэргүүцэх, хүч хэрэглэх) 2008 онд 1, Эрүүгийн хуулийн 277 дугаар зүйлээр (Захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх) 2008 онд 2, 2010 онд 3, Эрүүгийн хуулийн 278 дугаар зүйлээр (Бие биедээ захирагдахгүй цэргийн алба хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих) 2008 онд 1, 2009 онд 2, 2010 онд 2, Эрүүгийн хуулийн 279 дүгээр зүйлээр (Цэргийн албанаас оргон зайлах) 2008 онд 5, 2009 онд 2, 2010 онд 3 цэргийн алба хаагч тус тус шийтгүүлсэн байна.

Түүнчлэн судалгааны тайланд “...сүүлийн 10 жилийн хугацаанд хил хамгаалах байгууллагад гарсан 15 онц хүнд буюу хилчид нэг нэгнийхээ амь насыг хөнөөсөн гэмт хэргийг судлан үзэж, уг 15 гэмт хэрэг үйлдэгчдийг цол, албан тушаалаар нь ангилбал, нийт 15 байлдагч буюу хугацаат цэргийн алба хаагчид, ахлагч 3 байсан бол хохирогчийн албан тушаал, цолоор ангилбал хугацаат цэргийн алба хаагч 4, гэрээт цэргийн алба хаагч 3, дэд хурандаа 1, ар талын дарга, ахлагч 8, харуулын дарга,

¹¹⁸ Монгол Улсын Хил хамгаалах байгууллагад үйлдэгдэж байгаа онц хүнд гэмт хэргийн шалтгаан нөхцөлд Хууль Зүйн Үндэсний Хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн сектор, Хил Хамгаалах Ерөнхий Газрын Улсын хил судлалын сектороос хийсэн судалгаа, УБ., 2010 он.

заставын дарга хошууч 1, хилийн цэргийн ангийн албаны дарга ахмад 1, заставын орлогч, дэслэгч 1, энгийн ажилчин 1 байна. Дээрх 15 гэмт хэргийн улмаас нийт 22 хүний амь нас хохирч, 4 хүн хүнд гэмтэж, 8 нь хилийн харуулд, 4 нь заставт, 3 нь хилийн цэргийн ангийн төвд үйлдэгджээ. Үүний 9 нь захирах, захирагдах ёсыг зөрчсөн зүй бус харьцаанаас, 2 нь цэрэгт ирэхийн өмнө хулгайн болон танхайн хэргээр ял шийтгүүлж байсан хугацаат цэргийн алба хаагчдаас, 3 нь архидалтаас, нэгнийх нь шалтгааныг хууль хяналтын байгууллага хараахан тогтоогоогүй байна. Захирах, захирагдах ёсыг зөрчсөн хүнлэг бус харьцаанаас үүдэн гарсан хэргүүд нь голчлон хилийн харуул дээр хугацаат цэргийн алба хаагч, харуулын дарга нарын хооронд гарсан байна...”¹¹⁹ гэж дурджээ.

Иймд цэргийн алба хаагчдын хоорондын харилцааг захирах, захирагдах ёс, журмын дагуу хэвшүүлэх, тэдний сахилга, хариуцлагыг сайжруулах, цэргийн алба хаагчдыг дүрмийн бус харилцааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дүрмийн бус харилцааны зөрчил дутагдлаас үүдэн гарч байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, таслан зогсоох чиглэлээр хууль хяналтын байгууллагуудтай хамтран үр дүнд хүрэхүйц ажлуудыг зохиох шаардлагатай.

Зөвлөмж: Цэргийн алба хаагчдад сахилгын шийтгэл оногдуулахтай холбогдсон дүрэм, журмууд болон сахилгын хорих байрны стандартыг хүний эрхийн зарчим, шаардлагад нийцүүлэн өөрчилж, цэргийн алба хаагчдыг тусгаарлан саатуулах шийтгэлийг прокурорын байнгын хяналтад гүйцэтгэдэг дадлыг хэвшүүлэх; (2008)

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 379 дүгээр зарлигаар баталсан Цэргийн сахилгын дүрмийн “Цэргийн алба хаагчийг тусгаарлан саатуулах журам”-ын 72-т “Прокурорын байгууллагаас зөвшөөрөл олгосон сахилгын хорих байранд цэргийн албан хаагчийг тусгаарлан саатуулах шийтгэл эдлүүлнэ” гэж зааж, Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрэмд сахилгын хорих байрны стандарт, төхөөрөмжлөлийг тогтоож, тусгаарлан саатуулах сахилгын шийтгэл хүлээсэн, гэмт хэрэгт сэжигтнээр татагдан, албадан саатуулагдсан, согтуугаар цэргийн сахилга, нийгмийн хэв журмын зөрчил гаргасан зэрэг цэргийн алба хаагчдын бүртгэл, тэмдэглэгээг хэрхэн хийх талаар нилээд өөрчлөлт оруулжээ.

Цэргийн алба хаагчдад сахилгын шийтгэл оногдуулахтай холбогдсон асуудлыг Цэргийн сахилгын дүрэмд оруулсан өөрчлөлтөөр зохицуулж, цэргийн анги, байгууллагуудын ажиллуулж байсан сахилгын хорих байруудыг татан буулгаж, Улаанбаатар цэргийн хүрээнд сахилгын нэг хорих байрыг ашиглахаар зохион

¹¹⁹ Монгол Улсын Хил хамгаалах байгууллагад үйлдэгдэж байгаа онц хүнд гэмт хэргийн шалтгаан нөхцөлд Хууль Зүйн Үндэсний Хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн сектор, Хил Хамгаалах Ерөнхий Газрын Улсын хил судлалын сектороос хийсэн судалгаа, УБ., 2010 он.

байгуулжээ. Зэвсэгт хүчний 32 дугаар ангийн дэргэдэх уг хорих байрын стандартыг хүний эрхийн зарчим, стандартад нийцүүлэн өөрчилж, прокурорын байгууллагад шалгуулан холбогдох зөвшөөрлийг авч, цэргийн алба хаагчдын тусгаарлан саатуулах шийтгэлийг нийслэлийн Баянзүрх дүүргийн прокурорын газрын байнгын хяналтад гүйцэтгэдэг болсон байна.

Хилийн цэргийн ангиуд дахь сахилгын хорих байрыг хааж, цэргийн алба хаагчдыг хорьж, шийтгэх ажиллагааг зогсоожээ.

Цэргийн алба хаагчдын гаргаж байгаа сахилгын зөрчлийг бүртгэх, судлах, дүн шинжилгээ хийх, сахилгын зөрчил, дутагдлын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, цаашид дахин энэ төрлийн зөрчлийг гаргуулахгүй байх, урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулах шаардлагатай.

***Зөвлөмж:** Батлан Хамгаалахын Их Сургууль, Хилийн Цэргийн Дээд Сургууль болон цэргийн алба хаагчдад зориулан зохион байгуулагддаг сургалтын төлөвлөгөөнд хүний эрхийн боловсролын чиглэлээр тусгай хичээл оруулж байх; (2008)*

Батлан Хамгаалахын Их Сургуулийн хэмжээнд сургуулийн удирдлага, багшлах бүрэлдэхүүний эрх зүйн мэдлэг, түүний дотор хүний эрх, эрх чөлөөний талаарх боловсрол, ойлголтыг дээшлүүлэхэд анхаарч байна. Цэргийн командын сургуулийн Төрийн захиргаа, эрх зүйн тэнхимийн 2,3 дугаар дамжааны сургалтын хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж, “Хүний эрх” хичээлийг тус бүр 2 кредит цагаар тооцон заавал судлах хичээл болгож, сүүлийн 2 жил зааж байна.

Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам, Хүйсийн Тэгш Эрхийн Төв төрийн бус байгууллагаас зохион байгуулсан сертификаттай сургалтад 2 багшийг хамруулан, оюутан, сонсогч, сурагчдад сургалт, сурталчилгаа хийх, цэргийн алба хаагчдад эрх зүйн мэдлэг олгох, соёл, хүмүүжлийн ажлын цагаар хүний эрх, эрх чөлөөний талаар ойлголт өгөх, харилцан бие биесээ хүндлэх, бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэж сурах, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, цэргийн дүрмийн дагуу харилцах явдлыг хэвшүүлэхэд чиглэгдсэн олон ажлыг зохион байгуулж, мөн сургууль, цэргийн байр, амьдрах орчны мэдээллийн самбаруудад сурталчилгааны буланг тогтмол ажиллуулж, энэ сэдвийн хүрээнд ярилцлага, маргаан, мэтгэлцээн, хэлэлцүүлэг, тэмцээн уралдааныг төрөл бүрийн хэлбэрээр явуулдаг болжээ.

Батлан хамгаалах салбар, цэргийн байгууллагын онцлог, цэргийн алба хаагчдын хоорондын харилцааны дүрмээр тогтоосон хэм хэмжээ, захирах, захирагдах ёсны онцлог байдлаас үүдэн зохицуулах шаардлагатай зүйлс цөөнгүй гарч буйг судалж, мөн сургуулийн сургалтын агуулга, хөтөлбөр, хичээлийн цагийн багтаамжаас хамаарч “Хүний эрх” хичээлийг заавал судлах цэргийн ерөнхий эрдмийн хичээлд оруулаагүй, зөвхөн сонгон судлах хичээлээр тооцон хөтөлбөр төлөвлөгөөнд

тусгасан нь суралцагсдыг бүрэн хамарсан мэдлэг өгч чадахгүй байна. Цаашид цэргийн алба хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах, сургалтын хөтөлбөрт уг хичээлийг зайлшгүй оруулж байх нь зүйтэй гэж үзэж байна.

Хилийн Цэргийн Дээд Сургууль сургалтын хөтөлбөртөө 24 цагийн багтаамж бүхий хүний эрхийн боловсрол олгох хичээлийг оруулдаг болсон байна.

Зөвлөмж: *Цэргийн байгууллагын барилга байгууламжийн ашиглалт стандартад нийцэж байгаа эсэхийг шалган тогтоох нэгдсэн үзлэг зохион байгуулж, цэргийн алба хаагчдын ажиллах, амьдрах нөхцөл байдлыг сайжруулах талаар дэс дараатай арга хэмжээ авах; (2008)*

Цэргийн анги, байгууллагын барилга, байгууламжийн ашиглалтыг сайжруулж, цэргийн алба хаагчдын ая тухтай нөхцөлийг хангахын тулд Зэвсэгт хүчний 5 ангийг жишиг хотхон болгон тохижуулсны дээр “Цэргийн хотхон тохижилтын стандарт”-ыг мөрдүүлсний үр дүнд анги, байгууллагуудын тохижилт, соёлжилт эрс дээшилж, эрүүл аюулгүй орчинг бүрдүүлж байна.

Зэвсэгт хүчний 186 дугаар ангид 200 хүний багтаамжтай цэргийн байр, 015 дугаар ангийн цэргийн байр, штабын барилга, Цэргийн төв госпиталийн амбулаторийн барилга, 014 дүгээр анги, 327 дугаар ангиудад гэрээт цэргийн алба хаагчдын цэргийн байрны барилгуудыг шинээр ашиглалтад оруулж, 2010 оны хөрөнгө оруулалтын зардлаар Зэвсэгт хүчний 13 ангийн барилга байгууламжийн дээврийн засвар, урсгал засварын хөрөнгөөр Зэвсэгт хүчний 19 ангийн 23 барилга байгууламжийн засварыг тус тус хийжээ.

Хил хамгаалах байгууллагын “Барилга, байгууламжийн шинэчлэл” хөтөлбөрийн хүрээнд хилийн анги, заставуудын барилга байгууламжийн ашиглалт, чанарын байдалд дүгнэлт хийх, цаашид авах арга хэмжээг төлөвлөх зорилгоор барилга байгууламжид аттестатчилал явуулах ажлыг зохион байгуулж байна.

2010 онд хилийн цэргийн ангиудад шинээр 33 айлын орон сууц, 13 харуулын байр, 29 агуулах, тавиулан зэрэг барилга байгууламжийг барьж, гэрээт хилчний 3 шинэ байр барьж, цэргийн 9 байрыг гэрээт хилчний байр болгон засварлаж, 2-4 хилчин нэг өрөөнд амьдрах орчинг бүрдүүлж, шаардлагатай тавилга хэрэгслээр бүрэн хангаж, ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлжээ.¹²⁰

Цэргийн анги, байгууллагын барилга байгууламжийг шинээр барих, засвар хийх зэргээр цэргийн алба хаагчдын ажиллах, амьдрах нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр тодорхой үр дүнд хүрэхүйц ажлуудыг хийж гүйцэтгэн цаашид цэргийн анги, байгууллагын анхан шатны нэгжүүдийг бэхжүүлэх, бие бүрэлдэхүүний алба хаах,

¹²⁰ Хил Хамгаалах Ерөнхий Газрын албан бичиг, 2011.02.23, №1-3/604.

ажиллах, орчин нөхцөлийг улам бүр сайжруулах чиглэлээр тодорхой ажлуудыг төлөвлөсөн байна.

Зөвлөмж: *Цэргийн алба хаагчдыг чанартай, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол, хүнс, хувцас, хэрэгслээр хангахад онцгой анхаарч, тэдгээрийн нийлүүлэлт, түгээлтэд тавих хяналтыг сайжруулах; Цэргийн хоол хүнс, хувцасны норм, нормативыг мэргэжлийн хяналтын байгууллагаар шинэчлэн тогтоолгож, мөрдөх; (2008)*

Цэргийн алба хаагчдын хүнс, хувцасны норм, нормативыг мэргэжлийн хяналтын байгууллагаар шинэчлэн тогтоолгож, мөрдөх ажлын хүрээнд Засгийн газрын 2006 оны 130 дугаар тогтоолоор баталсан “Ерөнхий зориулалтын болон дотоодын цэргийн алба хаагчдын хүнсний хангамжийн хэмжээ”-нд нийцүүлэн “Хүнсний нэг бүтээгдэхүүнийг нөгөө бүтээгдэхүүнээр орлуулах тухай”, “Хүнсний хангалтын журмыг хэрэглэх тухай” заавруудыг шинэчлэн боловсруулж, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн байна.¹²¹

Орчин үеийн шинжлэх ухааны ололтыг хил хамгаалах байгууллагын хүнсний бодлогод тусгах, хангалтыг үе шаттай төлөвлөн хэрэгжүүлэх, бүсчилсэн, төвлөрсөн, орон нутгийн хэлбэрээр зохион байгуулах, өөрсдийн нөөц бололцоог ашиглан туслах аж ахуйг хөгжүүлэх, газар тариалан эрхэлж, төсвийн хүрэлцээг нэмэгдүүлэхийг зорьж, Хил Хамгаалах Ерөнхий Газрын даргын 2010 оны А/12 тоот тушаалаар “Гэрээт хилчдийн хүнсний хангалтыг зохион байгуулах заавар”-ыг шинэчлэн баталж, хэрэгжүүлж эхэлжээ.¹²²

Цэргийн алба хаагчдын хоол, хүнс, хувцасны чанар, хүрэлцээ, хангамжийг сайжруулах чиглэлээр хийж буй ажлыг улам эрчимжүүлж, дотоодын хяналтыг мэргэжлийн байгууллагын хяналттай зөв хослуулж, цэргийн алба хаагчдын хоол, хүнс, хувцасны хангалтаас завших, тонох, ашиг олох аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ийм зөрчил гаргахгүй байх талаар түлхүү анхаарч ажиллах шаардлагатай.

Зөвлөмж: *Цэргийн анги, байгууллагад цэргийн алба хаагчид албаны бэлтгэл сургуулилтыг хангахаас гадна хөгжих, сурч боловсрох, биеийн тамир, спортоор хичээллэх, амралт, чөлөөт цагаа үр өгөөжтэй өнгөрүүлэх боломжтой орчныг бүрдүүлэхэд шаардагдах материаллаг нөхцөлийг бий болгоход дэмжлэг тусалцаа үзүүлэх; (2008)*

Цэргийн алба хаагчид алба хааж буй анги байгууллагадаа хөгжих, сурч боловсрох, биеийн тамир, спортоор хичээллэх, амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх үр өгөөжтэй орчныг бүрдүүлэхийн тулд Зэвсэгт хүчний анги, байгууллагад биеийн тамирын хотхон байгуулах нэгдсэн стандартыг боловсруулан мөрдүүлэх, бүх

¹²¹ Монгол Улсын Батлан Хамгаалахын сайдын албан бичиг, 2010.12.16, №1а/2795.

¹²² Хил Хамгаалах Ерөнхий Газрын албан бичиг, 2011.02.23, №1-3/604.

ангиудад биеийн тамир, чийрэгжүүлэлтийн танхимуудыг байгуулан, шаардлагатай материал хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдыг биеийн тамирын хувцсаар хангах асуудлыг боловсруулж, Зэвсэгт хүчний 4 ангид шинээр спорт заал барьж ашиглалтад оруулжээ.

Цэргийн алба хаагчдын сурч боловсрох, хөгжих нөхцөл бололцоог бүрдүүлэхэд анги бүрт интернэтийн танхим байгуулан, соёлын төв, номын сан, амралт, соёлжилтын танхимуудыг засварлан тохижуулж, шаардлагатай техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, шинэ ном, гарын авлагаар хангах ажлуудыг зохион байгуулж, цэргийн албанд бичиг үсэг тайлагдаагүй ирж байгаа залуучуудад орон нутгийн дунд сургуулиудтай хамтран боловсрол олгох асуудлыг шийдвэрлэж эхэлжээ.

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд сургалтын бэлтгэл 2012 хөтөлбөр, сургалт зохион байгуулах заавар, хичээл хөтөлбөрийн стандарт, сургалтын хэрэглэгдэхүүний стандарт, сургалтын бэлтгэлийг шалгаж үнэлэх заавар, сургалтын бэлтгэлийн хөтөлбөрийн дагуу бие бүрэлдэхүүнд сургалт бэлтгэлийг зохион байгуулж, жил бүр ангийн захирагчийн нэрэмжит шалгалтад хамруулж, хоёр жил тутамд нийт бие бүрэлдэхүүнээс түвшин тогтоох шалгалт авч, хил хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг 2011-2012 онд зохион байгуулах зааврыг шинэчлэн хилийн цэргийн ангиудад хүргэж, хэрэгжилтийг зохион байгуулж, хилийн цэргийн ангиудын биеийн тамирын заалыг байнгын ажиллагаатай байлгаж, хилчдийн дунд урлаг, соёлын авъяас түгээн дэлгэрүүлэх зорилгоор хилчдийн урлагийн наадмыг 3 үе шаттай явуулж, хил хамгаалах байгууллагын хэмжээнд хилчдийн спортын их наадам хийхээр төлөвлөжээ.

Цэргийн алба хаагчдыг сурч боловсрох, хөгжих, урлаг, спортоор хичээллэж, бие бялдраа хөгжүүлэх зэргээр чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин, ахуй нөхцөлийг бүрдүүлэх нь элдэв хэрэг зөрчил гарах, чөлөөт цагаа хууль бус, буруу зүйлд зарцуулахаас урьдчилан сэргийлэх хамгийн чухал нөхцөл болох тул энэ ажлыг тогтмол зохион байгуулж, цэргийн алба хаагчдыг жигд хамруулахад байнга анхаарал тавьж байх нь зүйтэй.

Зөвлөмж: *Цэргийн алба хаагчдын цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн хамгааллыг сайжруулах, ялангуяа, алслагдсан хөдөө, орон нутагт ажиллаж буй цэргийн алба хаагчид хот суурин газарт үл хөдлөх эд хөрөнгө эзэмших боломжийг нэмэгдүүлэх, тэдний гэр бүлийн гишүүдийн эрхээ эдлэх боломж нөхцөлийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах; (2008)*

Цэргийн алба хаагчдын цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн хамгааллыг сайжруулахын тулд хугацаат цэргийн алба хаагчдад олгох цалин хөлсийг нэмэгдүүлж, сард дунджаар 8 150 төгрөг болгон, хадгаламжийн дэвтэрт нь 6 000 төгрөгийг

шилжүүлж, 2 150 төгрөгийг өөрт нь олгодог журам тогтоож, офицер, ахлагч, ажилтан, алба хаагчдын цалин хөлсийг Засгийн газрын тогтоолын дагуу нэмэгдүүлж, цэргийн алба хаагчдын тэтгэврийг сарын дундаж цалин хөлсний 80 хувиар бодож, тэтгэвэр тогтоох, хөдөө алслагдсан газарт алба хааж байгаа офицер, ахлагч нарын ажил эрхлээгүй гэр бүлийн гишүүнд улирал бүр тэтгэмж олгож байхаар хуульд өөрчлөлт оруулж мөрдөж эхэлжээ.

Батлан хамгаалахын салбарт ажиллаж байгаа офицер, ахлагч нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 2006 онд 86, 2007 онд 58, 2008 онд 95 айлын орон сууцыг тус бүр ашиглалтад оруулж, 2010 онд 454 алба хаагчийг орон сууцаар хангажээ.

Засгийн газрын 2009 оны 368 дугаар тогтоолоор баталсан “4000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газраас Батлан хамгаалахын салбарт 285 байрны квотыг яам болон яамны харьяа аж ахуйн нэгж, байгууллагууд, Зэвсэгт хүчний Жанжин Штаб, цэргийн анги, салбаруудад хуваарилснаас 122 офицер, ахлагч, ажилтан, албан хаагч орон сууцны зээлд хамрагдаж 3,7 тэрбум төгрөгийн санхүүжилт авчээ.

Хил хамгаалах байгууллагаас “4000 айл орон сууц” хөтөлбөрт 185 ажилтан, алба хаагч хамрагдаж, “Хилчний өргөө” цогцолборт 320 айлын орон сууцыг барьж, алба хаагчид, ахмад хилчдийг орон сууцаар хангаж, мөн орон нутагт амьдарч байгаа алба хаагчдын нийт 119 өрхөд өрхийн хэрэгцээний газар олгож эзэмшүүлсэн байна.

Цэргийн алба хаагчдын цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн баталгааг сайжруулах тухай Комиссоос дэвшүүлсэн зөвлөмжийн дагуу Засгийн газраас олон чухал арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.

Зөвлөмж: Цэргийн байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажиллагсдын үйлдвэрчний эвлэлийн байгууллагыг үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах; (2008)

Цэргийн анги, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэд, Үйлдвэрчний Эвлэлийн Байгууллагын үйл ажиллагаанд оролцох нөхцөл, бололцоогоор бүрэн хангагдсан гэж цэргийн анги, байгууллагууд тайлбарлаж байгаа боловч үнэн хэрэгтээ энгийн ажилтан олонтой цэргийн анги, байгууллагад үйлдвэрчний эвлэлийн байгууллага байхгүй, түүнийг байгуулах боломж, нөхцөл хангагдаагүй байна.

Харин хил хамгаалах байгууллагын хэмжээнд Ахмадын Холбоо, Эмэгтэйчүүдийн Холбоо, Ахлагчийн Зөвлөл зэрэг төрийн бус байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг байна.

Цэргийн анги, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажилтнуудын эвлэлдэн нэгдэх эрхийг хангах, тийм нөхцөл бүрдүүлэх, тэдний хөдөлмөрлөх эрхийг хангаж, хөдөлмөрийн харилцаанд нь Хөдөлмөрийн тухай хууль болон хөдөлмөрийн гэрээний заалт, шаардлагыг хатуу мөрдөж, ажилладаг болох шаардлагатай.

4.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх

Зөвлөмж: *Хөгжлийн бэрхшээлтэй хүн иргэний, улс төрийн, эдийн засгийн болон соёлын бүхий л эрх, эрх чөлөөгөө бусдын адил эдлэх нөхцөлийг бий болгоход чиглэгдсэн, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2006 оны А/61/611 дугаар тогтоолоор батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийг соёрхон батлах асуудлыг судлан шийдвэрлэх; (2008)*

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2006 оны А/61/611 дугаар тогтоолоор батласан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, конвенцийн Нэмэлт Протоколд Монгол Улс 2009 онд нэгдэн орсон.

Зөвлөмж: *Нэр томъёоны хэт ерөнхий байдлаас үүдэн гарч буй сөрөг үр дагаврыг арилгахын тулд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэсэн тодорхойлолтыг тодорхой, ойлгомжтой болгон өөрчлөх; (2008)*

“Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэсэн тодорхойлолт нэг мөр болоогүйгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх статистик мэдээллийг гаргах, улмаар тэдэнд чиглэсэн төрийн бодлого, авах арга хэмжээг тодорхойлоход төвөгтэй байдал үүсдэг тухай Комиссын 2007 оны илтгэлд дурдаж байсан. Одоогийн байдлаар манай улсад хамааралтай “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэсэн 4 төрлийн тодорхойлолт үйлчилж байна.

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ. (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 1 дүгээр зүйл)
2. “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэж бие бялдар, оюун санааны чадавх нь төрөлхийн болон олдмол шалтгаанаар дутмаг болсны улмаас нийгмийн болон хувийн амьдралын хэвийн шаардлагаа бие даан хангаж чадахгүй хүнийг хэлнэ. (Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага)
3. Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэж ойлгоно.

(Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг)

4. “Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч” гэж төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавх нь алдагдсан, бие эрхтэн нь гэмтсэнээс суралцах боломж нь хязгаарлагдсан суралцагчийг хэлнэ. (Боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйл 3.1.9 дэх хэсэг)

Дээрх тодорхойлолтуудаас Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нэгдүгээр тодорхойлолтоос бусад нь хөгжлийн бэрхшээлийн талаарх “эмнэлгийн загвар”-т суурилсан байна. Өөрөөр хэлбэл, тэдгээр тодорхойлолт хүн хөгжлийн бэрхшээлтэй болж байгаагийн шалтгааныг эмгэг өөрчлөлт, гэмтэл зэрэг зөвхөн биологийн хүчин зүйлтэй холбож үзсэн байгаа бөгөөд тэдгээр гэмтлийг нөхөх нийгмийн хүчин зүйлийн талаар ямар нэгэн ойлголт агуулаагүй байна. Зүй нь сул хараатай юм уу, сул сонсголтой хүн Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэйд тооцогдож болох ч өндөр хөгжилтэй зарим улсад тохирох линз, сонсгол дэмжих хэрэгсэлтэй бол нийгмийн амьдралд ямар ч саад бэрхшээлгүй оролцож чадах билээ. Энэ нь хөгжлийн бэрхшээл нэг талаас биологийн, нөгөө талаас нийгмийн ойлголт болохыг харуулж байна. Конвенцийн “...байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас...” гэж заасны “бусад төрлийн бэрхшээл” гэдэг нь нийгмийн орчноос үүдэлтэй бэрхшээлийг хэлж байгаа хэрэг юм.¹²³

Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын тухай, Боловсролын тухай хуулиуд болон Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын тодорхойлолтын аль нь ч конвенцийн заалтад нийцэхгүй байна.

Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог нь 12 сар буюу түүнээс дээш хугацаагаар үргэлжлэхүйц байж хөгжлийн бэрхшээлтэйд тооцогдохоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын тухай хуульд заасан нь боломжийн зохицуулалт гэж үзэж байна. Харин хүнийг хөгжлийн бэрхшээлтэй болгоход нөлөөлөх нийгмийн хүчин зүйлийг тодорхойлох нь хөгжлийн бэрхшээлтэй хүн гэсэн тодорхойлолтыг нэг мөр болгоход тулгарч байгаа гол бэрхшээл юм. Ийм үнэлгээг хийх нарийн мэдлэг, мэргэшил манай улсад хараахан бүрдээгүй байгааг анхаарч, энэ талаар олон улсын экспертийн тусламжийг авах, ингэхдээ үндэсний нөхцөл байдал, улс орныхоо нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийг сайтар тусгах нь зүйтэй.

¹²³ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголтыг эцсийн байдлаар тодорхойлоогүй болохыг анхаарах ёстой. Конвенцийн удиртгал хэсэгт “хөгжлийн бэрхшээл гэдэг нь өөрчлөгдөн хувьсаж байдаг ойлголт бөгөөд нийгмийн амьдралд бусдын нэгэн адил бүрэн дүүрэн чөлөөтэй оролцоход саад тотгор учруулахуйц бие эрхтний согог, нийгмийн хандлагын болон орчны хязгаарлалтаас үүдэн бий болж байгаа...” гэж заасан. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт аливаа улсын нийгмийн хөгжлөөс хамаарч, харилцан адилгүй байх бөгөөд өөрчлөгдөн хувьсах шинжтэй болохыг Конвенц тодорхойлсон.

Зөвлөмж: Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан болон Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны боловсруулсан салбарын хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхдээ Хүний эрхийн Үндэсний Комиссын энэхүү илтгэлд тусгагдсан асуудлуудыг харгалзан үзэх; (2008)

Монгол Улсын Ерөнхийлөгч санаачлан Авто замын тухай, Эрүүл мэндийн тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Хөдөлмөрийн тухай, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай, Авто тээврийн тухай, Биеийн тамир, спортын тухай зэрэг 9 хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн барьж Улсын Их Хурал 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдөр баталжээ.

2008 оны 1 дүгээр сард Нийгмийн халамжийн багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Нийгмийн халамжийн багц хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулснаар нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдаж байсан хөдөлмөрийн чадвараа 50-70 хүртэл хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэжээгч нь нас барсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд, нийгмийн халамжийн тэтгэмжид хамрагдаж байсан бүтэн өнчин хүүхэд, ихэр хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зэргийг нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээнд хамруулах болсон нь нааштай үзүүлэлт боллоо.

Нийгмийн халамжийн тухай хуульд байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж, дэмжлэг үзүүлэхэд “ядуу, нэн ядуу байх” гэсэн шалгуур тавьсан нь бодит байдалд гажуудал үүсгэж байсныг Комисс 2007 оны илтгэлдээ шүүмжилж байв. Харин хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар энэ гажуудал засагджээ. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ авч байгаа нь тэдгээр иргэдийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцоход нааштайгаар нөлөөлж байна.

Зөвлөмж: Энэхүү илтгэлд дурдсан асуудлуудыг харгалзан Нийгмийн халамжийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиудын зарим зүйл заалт болон Шагнал, урамшууллын хэмжээ тогтоох тухай Засгийн газрын 208 дугаар тогтоол (2005), Мэргэжлээс шалтгаалах болон энгийн өвчин, гэмтлийн жагсаалт (1997), Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм (1994), Амбулатори, поликлиникээр үнэ төлбөргүй эмчлэх өвчин, түүнд хэрэглэх эмийн жагсаалт (2003) зэрэг хуульчилсан актуудыг аль болох хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрхээ эдлэх тэгш боломжоор хангасан, тэдний эрх зүйн байдлыг дээрдүүлсэн байхаар өөрчлөх; (2008)

Эрүүл Мэндийн сайд, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2008 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 274/135 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар “Ердийн өвчний жагсаалт”, 2 дугаар хавсралтаар “Мэргэжлээс шалтгаалах өвчний жагсаалт”-ыг тус тус баталсан байна. Засгийн Газрын 2008 оны

304 дүгээр тогтоолоор “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийг шинэчлэн баталжээ. Мөн Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2009 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 407/265/159 дугаар хамтарсан тушаалаар “Даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээ”-г батлан гаргаж, “Амбулатори, поликлиникээр үнэ төлбөргүй эмчлэх өвчин, түүнд хэрэглэх эмийн жагсаалт”-ыг шинэчилсэн байна. Одоогийн байдлаар шинэчлэн баталсан эдгээр дүрэм журмын талаарх гомдол, мэдээлэл Комисст ирээгүй байна.

Зөвлөмж: Хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээнд нийцсэн барилга, талбай, зам, гүүр, харилцаа холбоо, ажлын байр, тээврийн хэрэгсэл зэрэг нэн шаардлагатай дэд бүтэц, байгууламжийн стандартыг боловсруулж, хэрэгжүүлэх; (2008)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрүүл иргэдийн нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцоход, нэн тэргүүнд тэдэнд зориулсан дэд бүтцийг бий болгох шаардлагатай. Энэ үүднээс Стандартчилал, Хэмжил зүйн Үндэсний Зөвлөл 2009 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS6056:2009; “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шаардлагыг тооцсон орон зай, орчин” MNS6055:2009 стандартуудыг баталжээ. Стандартуудыг 2010 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн байна. Түүнчлэн “Амаржих газрын бүтэц, үйл ажиллагаа” MNS6188:2010 стандартыг боловсруулахдаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулсан дэд бүтцийн асуудлыг тусган оруулжээ.

Стандартыг хэрэгжүүлэх, сурталчлахад чиглэсэн арга хэмжээ авч байна. Эдгээр стандартуудыг мөрдүүлэхэд чиглэгдсэн бодлогын зөвлөмжийг боловсруулах, энэ талаарх хичээлийг Архитекторын мэргэшсэн зэрэг горилогчдод зориулсан сургалтын хөтөлбөрт оруулах, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагуудад стандартыг танилцуулах уулзалт зохион байгуулах арга хэмжээг авч байна. Төрийн захиалгаар баригдах барилгуудад дээрх стандартуудыг чанд мөрдүүлэх талаар анхааран ажиллаж байна.¹²⁴

Зам, Тээвэр, Барилга, Хот Байгуулалтын Яамнаас 2009 онд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан их багтаамжийн 400 автобусанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай суудлыг бий болгож, хараагүй хүмүүст зориулан автобусны буудлуудад зарлах төхөөрөмжийг суурилуулан ашиглаж байна. Мөн сонсголын

¹²⁴ Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам, Засгийн газрын 2010 оны 302 дугаар тогтоолоор батлан Эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “Шинээр барих сургуулийн барилгад Монгол Улсын MNS6055:2009, MNS6056:2009 стандартыг мөрдүүлэхээр тусган батлуулжээ.

бэрхшээлтэй иргэдэд зориулж, буудал бүрт нэр хаяг, чиглэлийг бичмэл болон зургийн хэлбэрээр байрлуулах ажлыг гүйцэтгэжээ.

Хэдийгээр стандарт боловсруулан мөрдөж байгаа ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн санхүүжилт, хөрөнгө оруулалт болон холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, хуулийн заалт, норм, дүрэм, стандартуудын хэрэгжилт тааруу байна. Ялангуяа зураг төсөл боловсруулах, зураг төсөлд улсын экспертиз хийх, барилга байгууламж барих, барилга байгууламжийг улсын комисс хүлээн авах зэрэг шатанд зөрчил их гарч, хууль хэрэгжихгүй байна.

Барилга байгууламжид тохируулга өөрчлөлт хийх нь зөвхөн тодорхой бүлгийн хүмүүсийн асуудал биш, нийгмийн бүх гишүүдэд хэрэгцээ, шаардлагатай гэдгийг олон нийтэд ойлгуулах нь зүйтэй юм. Хүн амьдралынхаа туршид янз бүрийн шалтгаанаар, урт, богино хугацаагаар тусгай тохируулга, тоноглол хэрэглэх шаардлага гардаг. Тэргэнцрийн зам, орон зай, тохируулга хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст төдийгүй өндөр настан, тэрэгтэй хүүхэд, тэргэнцэртэй, ачаатай хэн бүхэнд хэрэгтэй. Иймд энэ мэт тохируулга өөрчлөлт нь нийгмийн шаардлага болохыг шат шатандаа ухамсарлах, арга хэмжээ авах шаардлагатай байна.

Зөвлөмж: Аливаа хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг батлахдаа тэдгээрийг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц санхүүжилтийн асуудал, механизмыг цогцоор нь шийдвэрлэж байх; (2008)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг батлахдаа шаардлагатай санхүүжилт, хэрэгжүүлэх механизмыг нь шийдвэрлэж байгаа ололт байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгайлсан үйлчилгээ, арга хэмжээ бий болгох зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Уг хуульд хөдөлмөрийн харилцаанд бие даан оролцох боломжгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөдөлмөр сургалтын төв, аж ахуйн нэгж байгууллагын дэргэдэх үйлдвэрлэлийн тусгай цех, тасгийн үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, мэргэжлийн сургалтад хамруулах, тэднийг ажилд авсан ажил олгогчдыг урамшуулах зэрэг арга хэмжээг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэхээр болжээ.¹²⁵

Харин өмнөх хэсэгт дурдсан стандартуудыг хэрэгжүүлэхэд зарцуулагдах санхүүжилтийг шийдвэрлээгүй байна.

Улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын Хорооноос Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2009 оны илтгэлийг хэлэлцсэн тухай 2010 оны 6

¹²⁵ Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яамны 100 хоногт хийсэн ажлын тайлан, 2008 он. Уг мэдээллийг www.mswl.gov.mn цахим хуудаснаас үзэх боломжтой. 2011 оны 4 дүгээр сарын 8-нд үзсэн.

дугаар сарын 24-ний өдрийн 13 дугаар тогтоолд “Үндэстний цөөнхийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангахтай холбогдсон арга хэмжээг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцон Монгол Улсын тухайн жилийн төсөвт тус тус тусгаж байх” тухай заасан нь хэрэгжих шатандаа явж байна.¹²⁶

Зөвлөмж: 2010 онд Үндэсний Статистикийн Газраас явуулах хүн амын нэгдсэн тооллоготой хамтатган хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар нарийн тоо баримт гаргаж, төрийн бодлогыг зохистой хэрэгжүүлэх, үйлчилгээг үр дүнтэй хүргэх, үр дүнг бодитойгоор үнэлэх нөхцөл бололцоог бий болгох; (2008)

Монгол Улсын Хүн ам, орон сууцны улсын тооллогыг 2010 оны 11 дүгээр сарын 11-нээс 17-ны өдрүүдэд зохион явуулсан бөгөөд тооллогын дүнг 2011 оны 7 дугаар сард нийтэд мэдээлнэ.¹²⁷ Энэ тооллогоор иргэдээс хөгжлийн бэрхшээлтэй эсэх хийгээд хөгжлийн бэрхшээлтэй бол энэ нь төрөлхийн буюу олдмолын алин болохыг асууж, бүртгэсэн. Энэ ажил хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бодитой тоо, мэдээллийг нэг мөр болгоход, зохих хувь нэмрээ оруулна гэж үзэж байна.

Улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын Хороо Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2009 оны илтгэлийг хэлэлцээд 2010 оны 06 дугаар сарын 24-ний өдөр гаргасан 13 дугаар тогтоолдоо “Төрийн холбогдох байгууллагуудаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой гаргаж байгаа статистик тоо, мэдээ зөрүүтэй байгаад анхаарч, дахин тооллого явуулж, дүнг тус Байнгын хороонд 2011 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулах” үүргийг Засгийн газарт өгсөн.

Зөвлөмж: Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв, Сэргээн Заслын Үндэсний Төв, Тусгай Хэрэгцээт Боловсролын Байгууллагууд зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулагдсан байгууллагуудад онцгойлон анхаарал хандуулж, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоог хангах талаар арга хэмжээ авах; (2008)

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан эмнэлгийн, сэргээх, нөхөн сэргээх байгууллагуудад төрөөс анхаарал хандуулж байна. Эрүүл Мэндийн сайдын 2011 оны 2 дугаар сарын 2-ны 56 дугаар тушаалаар “Сэргээн засах, тусламж үйлчилгээний стратеги” батлагдан гарчээ. Сэргээн засалтын үндэсний төвд 900 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гурван давхар байр бариулж, дуусах шатандаа явж байна. Шинэ байрыг ашиглалтад ормогц хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалтын төв

¹²⁶ Байнгын хороодын тогтоолоор Засгийн газарт үүрэг болгосон заалтын хэрэгжилтийн мэдээ 2010.01.01 – 2010.09.27.

¹²⁷ Үндэсний Статистикийн Газрын www.toollogo2010.mn цахим хуудаснаас авсан мэдээлэл.

байгуулахаар төлөвлөжээ. Түүнчлэн, Германы протезийн үйлдвэрийн технологийг нэвтрүүлэх асуудлыг шийдвэрлэж байна.¹²⁸

Ортопедийн цехийг 21 аймаг, Улаанбаатар хотын Тархины саажилттай хүүхдийг сэргээн засах 10 дугаар цогцолбор, Сэргээн засалтын Үндэсний төвд байгуулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн боловсрол олгох төвийг зүүн бүсийн 9 аймгийн Эрүүл мэндийн газар, Улаанбаатар хотод Сэргээн Засалтын Үндэсний Төв дээр тус тус байгуулсан байна.

Зөвлөмж: Сэтгэцийн өвчтэй хүмүүст зориулсан тусгай асрамжийн газар бий болгох; (2008)

Засгийн газрын 2009 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 303 дугаар тогтоолоор “Сэтгэцийн эрүүл мэнд” үндэсний хоёр дахь хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийг 2010-2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.1.6-д “Эрх зүйн чадамжгүй, асран хамгаалагч шаардлагатай боловч асран хамгаалагчгүй сэтгэцийн эмгэгтэй өвчтөнүүдэд зориулсан асрамжийн газар байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх” тухай заасан байна. Энэ ажлыг Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам хариуцан гүйцэтгэх бөгөөд Эрүүл Мэндийн Яам, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагууд хамтран 2011-2012 онд хийж гүйцэтгэнэ.

Одоогоор хуучин Мааньтад байсан сэтгэцийн өвчтэй хүмүүст зориулсан тусгай асрамжийн газрыг сэргээн шинэчлэх буюу шинээр байгуулах эсэх талаар яриа хэлэлцээр явж байна.

Зөвлөмж: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөр болон 2006 оны Хүний эрхийн байгууллагуудын үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих;(2008)

Ази, номхон далайн бүсээс батлан гаргасан “Бивакогийн Мянганы Хөтөлбөр”-ийн зарчим, үзэл санаанд нийцүүлэн Засгийн газраас 2006 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 283 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих Үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн гол зорилго нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчинг бүрдүүлэхэд төр, иргэний нийгэм болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулахад оршиж байгаа бөгөөд 2012 оныг хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Уг хөтөлбөрийн хэрэгжилтэд Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газар хяналт тавьж байна. Гэхдээ хамгийн

¹²⁸ <http://www.medee.mn/content/17115.shtml>

сүүлд уг хөтөлбөрийн хэрэгжилтийг 2009 онд үнэлсэн, үнэлгээг хөтөлбөрийн зүйл бүрээр бус, нилээд ерөнхий байдлаар хийсэн нь хангалтгүй байна. Цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулахад анхаарах шаардлагатай юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн аж байдлыг сайжруулахад хүүхдийн оролцоо, эцэг, эх, нийгэм, хамт олны хандлага, хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс цогц хөтөлбөр бий болгох, хэрэгжүүлэх шаардлагын улмаас Засгийн газрын 2006 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 283 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрийг баталсан.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам¹²⁹ болон Хүүхдийн Төлөө Газар хяналт тавьж байна. Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам уг хөтөлбөрийн эхний үе шатыг 86,7 хувийн биелэлттэй гэж дүгнэжээ.¹³⁰ Харин Хүүхдийн Төлөө Үндэсний Газар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хуваарилагдсан санжүүжилт байхгүй байгаа нь тулгамдаж буй хамгийн хүнд асуудал гэж үзсэн байна.¹³¹

Зөвлөмж: Иргэдийг хөгжлийн бэрхшээлтэй болгож байгаа шалтгааныг судалсны үндсэн дээр урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авах; (2010)

Одоогоор хөгжлийн бэрхшээлийн шалтгааныг илрүүлэх, урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авах талаар хийгдсэн тоймтой ажил хийгээгүй байна.

Улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын Хорооноос Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2009 оны илтгэлийг хэлэлцсэн тухай 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 13 дугаар тогтоолд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэх таатай орчинг бүрдүүлэх, тэдний тусгай хэрэгцээнд нийцсэн дэд бүтэц, сургалтын орчин, нөхцөлийг болон иргэдийг хөгжлийн бэрхшээлтэй болгоход хүргэж байгаа шалтгаан нөхцөлийг улсын хэмжээнд судалж, дүгнэлт хийж, шуурхай, үр дүнтэй арга хэмжээ авах” тухай заасан нь хэрэгжих шатандаа явж байна.¹³²

¹²⁹ Хөтөлбөрт 2009 онд үнэлгээ хийжээ.

¹³⁰ Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны Хяналт шинжилгээ үнэлгээний газрын мэдээлэл, 2010.06.16.

¹³¹ Хүүхдийн Төлөө Газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, УБ., 2010 он.

¹³² Байнгын хороодын тогтоолоор Засгийн газарт үүрэг болгосон заалтын хэрэгжилтийн мэдээ 2010.01.01 – 2010.09.27.

4.4 Хүүхдийн эрх, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд

Зөвлөмж: Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах тухай үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх; (2004)

Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр”-ийг баталж, 2002-2010 оныг хүртэл 3 үе шаттай хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Засгийн газар, Хүүхдийн Төлөө Газар уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлэхэд эхэн үедээ харьцангуй идэвхтэй хандаж байсан. Жишээлбэл 2004, 2005 онд уг хөтөлбөрийн эхний шатны хэрэгжилтийг Үндэсний чуулган зохион байгуулан олон нийтээр хэлэлцүүлж байв. Гэвч ихэнх бодлого, хөтөлбөрүүдэд тулгардаг “Санхүүгийн бэрхшээл” Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг ч тойроогүй. Өөрөөр хэлбэл, уг хөтөлбөрийг батлахдаа хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт суулгаагүйгээс төлөвлөсөн олон ажил цаасан дээр үлдсэн. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн цогц үнэлгээ байхгүй байна. Энэ байдлыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Эрхийн Хороо 2010 оны 1 дүгээр сард Хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 3, 4 дэх илтгэлийг хэлэлцэхдээ шүүмжилж, “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийхийг Засгийн газарт зөвлөжээ.¹³³

Хүүхэд ажил хөдөлмөр хийх нь байнга сөрөг үр дагавар дагуулдаггүй, зарим төрлийн хөдөлмөр хүүхдийн хөгжил, оролцоонд эерэг нөлөөтэй байж болохыг Хүний эрхийн Үндэсний Комисс үгүйсгэдэггүй. Гэвч мөлжлөгийн чанартай, олон цагаар үргэлжилсэн, хүнд нөхцөлтэй, хүүхдийн бие махбодь, сэтгэл санаанд муугаар нөлөөлж, эрүүл мэндэд харшилсан, боловсрол эзэмшихэд нь саад болж байгаа хөдөлмөрийг устгах нь хүний эрхийн зарчимд нийцнэ.

Хүүхэд тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэхийг таслан зогсооход чиглэсэн бодлого, хөтөлбөрийг бий болгоход Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам анхаарч, арга хэмжээ авчээ. Үндэсний Статистикийн Газар, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар зэрэг байгууллагууд бүрэн эрхийнхээ хүрээнд мэдээлэл, статистик гаргах, хяналт шалгалт зохион байгуулах зэргээр ажиллаж байна. Харин хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг устгахад чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг улсын хэмжээнд Хүүхдийн Төлөө Газар явуулж байна.

Тус газар 21 аймаг дахь төвүүдээрээ дамжуулан хөдөө, орон нутагт судалгаа, сургалт, сурталчилгааны ажил явуулж байгаа нь зохих үр дүнд хүрч байна. Нийслэлийн Хүүхдийн Төлөө Төвөөс гадна Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын

¹³³ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Эрхийн Хороо, Конвенцийн 44 дүгээр зүйлийн дагуу гаргасан Оролцогч улсын илтгэлийг хэлэлцсэн тухай зөвлөмж (CRC/C/MNG/CO/3-4), Монгол Улс, 2010 оны 3 дугаар сар, 13-14 дүгээр догол мөр.

дэргэд Хүүхдийг тэвчишгүй хүнд хөдөлмөр эрхлэхээс урьдчилан сэргийлэх Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэгт Нийслэлийн Цагдаагийн Газрын Хэв журмын хэлтсийг оролцуулан, хамтран ажиллаж байгаа нь ач холбогдолтой болжээ. Хүүхэд тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэх явдлыг таслан зогсоох ажилд Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо, Монголын Улаан Загалмай Нийгэмлэг болон бусад иргэний нийгмийн байгууллагууд зохих хувь нэмрээ оруулж байна.

Сүүлийн жилүүдэд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдтэй тэмцэх чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийж, тодорхой арга хэмжээ авч, үр дүн гарч байгаа нь талархуштай боловч ололт амжилтын ихэнх нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, Америкийн Нэгдсэн Улсын Хөдөлмөрийн Сангийн санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлсэн “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдтэй тэмцэх үндэсний хугацаат хөтөлбөрийг дэмжих төсөл” (АЙПЕК)-тэй холбоотой байна. Харин төрөөс төсөв хөрөнгө зарцуулж, анхаарсан нь чамлалтай байгаа юм. Хүүхдээр хориглосон хөдөлмөр эрхлүүлдэг зөрчлийг таслан зогсооход Засгийн газар цаашид анхаарч ажиллах, хүчин чармайлт гаргах шаардлагатай гэж үзэж байна.

Зөвлөмж: Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенцийг хэрэгжүүлж, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн жагсаалтыг шинэчлэн баталж гаргах; (2008)

Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2008 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 107 дугаар тушаалаар “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг олон улсын гэрээнд нийцүүлэн, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, зах зээлийн өнөөгийн байдлыг харгалзан шинэчлэн баталжээ. Ялангуяа, уг жагсаалтыг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар конвенцийн 3 дугаар зүйлийн “г” хэсэгт заасантай нийцүүлэх байдлаар томъёолсон нь чухал юм. Уг жагсаалтад манай улс дахь хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн түгээмэл хэлбэрүүд¹³⁴ болох хамгаалагч, тайчигч, массажистаар ажиллуулах, гуйлга гуйлгах, хэт халуун, хэт хүйтэн нөхцөлд ажиллуулах, тодорхой жинтэй ачаа ачих, өргөх, зөөлгөх гэх мэт ажил хөдөлмөрийг хориглосон нь ач холбогдолтой юм.

Цаашид жагсаалтыг олон нийтэд сурталчлахад, Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яам, Хүүхдийн Төлөө Газар болон бусад иргэний нийгмийн байгууллагууд, хэрэгжилтэд нь хяналт тавихад Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, түүний харьяа албад анхаарах шаардлагатай байна.

¹³⁴ Дэлгэрэнгүй мэдээллийг Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2008 оны илтгэлээс үзнэ үү.

Зөвлөмж: Хүүхдийн хөдөлмөрийн жагсаалтыг үндэслэн тийм хэлбэрийн хөдөлмөр оршин байгаа газрыг тодорхойлж, түүнийг устгах, урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх; (2008)

Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг шинэчлэн баталсан боловч уг баримт бичгийг хэрэгжүүлэх, жагсаалтаар хориглосон хөдөлмөр оршин байгаа газрын тодорхойлох, хөдөлмөрийг устгах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулаагүй байна. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэртэй тэмцэх хүрээнд гаргасан ганц бодлогын баримт бичиг бол Хүүхдийн Төлөө Газраас батлан хэрэгжүүлж буй Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад чиглэсэн нөлөөллийн стратеги юм.

Гэвч уг хөтөлбөр жагсаалт гарахаас өмнө буюу 2007 онд баталжээ. Харин 2010 онд нийгмийн зөвшлийн 3 талын уулзалт зохион байгуулж, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах Үндэсний хөтөлбөр боловсруулах хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан нь сайшаалтай боловч тус үйл ажиллагаа нь удаашралтай байна. Цаашид Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах Үндэсний хөтөлбөр боловсруулах, батлуулах ажлыг эрчимжүүлж, энэ талаар байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь зүйтэй.

Зөвлөмж: Улсын хэмжээнд хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар нэгдсэн судалгаа явуулж, хүүхэд тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэхэд нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг тогтоож, түүнийг арилгах арга хэмжээ авах, тухайн орон нутаг дахь хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг судлан үзэж, хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс ангижруулах орон нутгийн засаг захиргааны байгууллагын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх; (2008)

2002-2010 онд “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах үндэсний хугацаат хөтөлбөр (АЙПЕК)-ийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр нилээд төрлийн судалгаа, шинжилгээний ажлыг холбогдох байгууллагууд явуулж, Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн нөхцөл байдлыг үндсэнд нь тодорхойлжээ.¹³⁵ Эдгээр судалгаа мэдээлэлд тулгуурлан Хүүхдийн Төлөө Газар хүүхдийн аж байдлын мэдээллийн нэгдсэн санд үзүүлэлт бий болгож, мэдээллийг нэгтгэж байгаа нь сайшаалтай. Цаашид Мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт зохицуулалтыг илүү боловсронгуй болгож, статистик мэдээлэлд үндэслэн төрийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх нь чухал юм.

¹³⁵ Хүн ам зүй, сургалт, судалгааны төв “Айлд гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа хүүхдүүдийн суурь судалгаа” (2005 он), Хүний эрхийн Үндэсний Комисс “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд” (2008 он), Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам “Хүүхдийн хөдөлмөрийн талаарх олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа” (2008 он), Ажил Олгогч, Эздийн Нэгдсэн Холбоо, “Уул уурхайн салбарт хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн судалгаа” (2005-2008 он), Үндэсний Статистикийн Хороо, “Насанд хүрээгүй болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгаа” (2010 он), Хүүхдийн Төлөө Газар “Хурдан морь унаач хүүхдийн аюулгүй байдал, судалгааны тайлан” (2010 он) гэх мэт.

Дээр өгүүлсэн судалгаа, мэдээлэлд тулгуурлан хүүхдийн хөдөлмөрийн талаар явуулах төрийн бодлогыг нэн даруй тодорхойлох хэрэгтэй байна. Нэгэнт хүүхдийн тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэхийг таслан зогсооход чиглэсэн эрх зүйн зохицуулалт, бодлого, хөтөлбөр боловсруулаагүй тул энэ талаар орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хүлээх үүрэг, авах эрх хэмжээ тодорхой биш хэвээр байна. Комиссын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна гэж үзлээ.

Зөвлөмж: *Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар конвенцийн 3 дугаар зүйлийн "а", "б", "в" хэсэгт заасан хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг Эрүүгийн хууль тогтоомжид бүрэн тусгах; Эрүүгийн хуулийн зарим зүйл ангийг илтгэлд дурдсан үндэслэлээр өөрчлөх; (2008)*

Эрүүгийн хуульд хүүхдийг биеэ үнэлэх, гуйланчлалд татан оролцуулах (115 дугаар зүйл), албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх (121 дүгээр зүйл) зэрэг үйлдэлд ял шийтгэл оногдуулах заалт байдаг боловч нь хүүхдийн тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрийн эсрэг үр дүнтэй зохицуулалт болж чадахгүй байна. Энэ байдал нь эдгээр зүйлээр эрүүгийн хэрэг үүсгэсэн, ял шийтгүүлсэн тохиолдол тэр бүр гардаггүйгээс харагдаж байна. Жишээлбэл, 2010 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 115 болон 121 дүгээр зүйлийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан хэрэг байхгүй байна.¹³⁶ Гэтэл бодит байдал дээр хүүхдийн биеийг хүчээр үнэлүүлэх, гуйлга гуйлгах болон бусад хүнд хүчир хөдөлмөр эрхлүүлэх явдал түгээмэл байгаа нь холбогдох байгууллагуудын судалгаа, мэдээллээс илт байна.¹³⁷ Иймд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар конвенцид заасан хүүхдийг худалдаалах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, цэргийн албанд татах гэх мэт боолчлолын хэлбэрүүд, хүүхдийн биеийг үнэлүүлэх үйл ажиллагаа, садар самууны сурталчилгаа болон үзүүлбэрт ашиглах, элсүүлэн авах, санал болгох, мансууруулах бодис үйлдвэрлэх, нууцаар наймаалах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, элсүүлэн авах, санал болгох зэрэг үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцож, хуульчлах нь зохистой гэж үзэж байна.

Зөвлөмж: *Хүүхэд худалдаалах, худалдан авах, хүүхдийг бэлгийн мөлжлөг, садар самууны үйлдвэрлэл, сурталчилгаанд ашиглах, хүүхдийн хөдөлмөрийг мөлжих гэмт хэрэгтэй тэмцэх, энэ талаар гарсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулж, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөх, шалгах, шийдвэрлэх чадавхийг дээшлүүлж, холбогдох төрийн байгууллагуудын ажилтнуудыг мэргэшүүлэх, сургах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (2008)*

Насанд хүрээгүй хүүхдийг хил дамжуулан худалдаалах, бэлгийн мөлжлөгт ашиглагдахаас урьдчилан сэргийлэх үүднээс гадаадын иргэдэд хүүхэд үрчлүүлэх

¹³⁶ Цагдаагийн Ерөнхий Газраас 2011 оны 4 сард ирүүлсэн мэдээлэл.

¹³⁷ Энэ талаарх судалгаа, мэдээллийг энэхүү илтгэлийн "Хүн худалдаалах гэмт хэрэг" хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

журам, дүрмийг хянан үзэж, гадаадад үрчлэгдсэн хүүхдийн эрхийн хэрэгжилтэд эрх бүхий байгууллагаас тавих хяналтыг сайжруулах; (2008)

Худалдаалагдах, бэлгийн мөлжлөгт ашиглагдах, гэмт хэргийн золиос болох магадлал өндөртэй, хараа хяналтгүй байгаа хүүхдийн нэгдсэн бүртгэл, судалгааг гаргаж, хөдөлгөөнд нь хяналт тавих тогтолцоог бий болгож, гадагшаа зорчиж буй хүүхдүүд эргэн ирж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах; (2008)

Хүүхдийг худалдаалах, бэлгийн мөлжлөгт ашиглахтай холбоотой дээрх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг энэ илтгэлийн “Хүн худалдаалах гэмт хэрэг” хэсгээс үзнэ үү.

Зөвлөмж: *Хүүхдүүд нь тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй ядуу, нэн ядуу өрхийн насанд хүрсэн гишүүдийг ажлын байраар хангах, төсөл хөтөлбөрт хамруулах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлж, хүүхдүүдийг нь тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс хөндийрүүлэх арга хэмжээ авах; (2008)*

Хүүхэд тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэх явдлыг бууруулах, улмаар таслан зогсоох хамгийн үр дүнтэй арга бол ядуурлыг бууруулах, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх явдал юм. Хүүхдүүд нь тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй ядуу, нэн ядуу өрхийн насанд хүрсэн гишүүдийг ажлын байраар хангах, төсөл хөтөлбөрт хамруулах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх талаар АЙПЕК төслийн хүрээнд зарим ажлыг хийжээ.¹³⁸

Гэвч хүнд хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн ар гэртэй ажиллах, өрхийн амьжиргааг дээшлүүлэх талаар бодлого, үе шаттай авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалтгүй байна. Харин Хүүхдийн Төлөө Газар санаачлан хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн эцэг, эх, гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийг хөдөлмөр эрхлэлт, орлого нэмэгдүүлэх үйлчилгээнд хамруулж, хүүхдийн хүнд тэвчишгүй хөдөлмөрийг устгахад чиглэсэн Үндэсний дэд хөтөлбөрийг боловсруулах, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам хэлэлцүүлэх арга хэмжээ авч байгаа тухайгаа Комисст мэдээлжээ.¹³⁹ Өрхийн амьжиргааг дээшлүүлэхгүйгээр хүүхэд хүнд хөдөлмөр эрхлэх явдлыг бодитойгоор бууруулах боломж хомс тул энэ мэт чухал санал, санаачлагыг дэмжих шаардлагатай байна.

Зөвлөмж: *Хүүхдийн хөдөлмөрийн ялангуяа, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрийн талаарх олон улсын болон дотоодын хууль тогтоомжийн заалт, хүүхдийн хөдөлмөрийн сөрөг үр дагавар, хор уршгийн талаар эцэг, эхчүүд, олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг сайтар зохион байгуулж, тэдний хүүхдийн хөдөлмөрт хандах хандлагыг өөрчлөх;(2008)*

¹³⁸ 11 дүгээр зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээллээс үзнэ үү.

¹³⁹ Хүүхдийн Төлөө Газрын албан бичиг, 2010.11.18, №А1/454.

Сургалт, сурталчилгааны ажил, ялангуяа “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах үндэсний хугацаат хөтөлбөр (АЙПЕК)-ийг дэмжих төсөл” хэрэгжсэн орон нутаг, томоохон захуудад амжилттай явагджээ. Жишээлбэл, Улаанбаатар хотын Нарантуул олон улсын худалдааны төв дээр 2007 оны 2 дугаар сарын 15-наас 2010 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 3 жилийн хугацаатай хэрэгжсэн “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах цогц үйл ажиллагаа, хүүхдийн хөдөлмөрийн мониторингийг турших нь” төслийн үр дүнд тус захад хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн тоо 2007 онд 605, 2008 онд 230, 2009 онд 130, 2010 оны эхний 4 сарын байдлаар 90 болж буурч, хөдөлмөр эрхлэгч 120 хүүхдийн ажлын цаг багасч, 180 хүүхдийг хөдөлмөр эрхлэхээс урьдчилан сэргийлж, 200 хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлсэн гэсэн мэдээг Нийслэлийн Цагдаагийн Газраас Комисст ирүүлсэн байна.¹⁴⁰

Дүүргүүдийн Цагдаагийн хэлтсийн оролцоотойгоор зохион явуулж буй хүүхэд амь нас, эрүүл мэнд, хөгжилдөө харш, аюултай хөдөлмөр эрхлэхийн хор уршгийг эцэг, эх, олон нийтэд ойлгуулахад чиглэсэн сургалт, гэгээрлийн ажлыг зохион байгуулах, хүүхдүүдийг мэргэжлийн сургалтад хамруулах аргаар асуудлыг шийдвэрлэхэд анхаарч байгаа нь хөдөлмөр эрхлэж буй хүүхдийг учир шалтгааныг тайлбарлахгүйгээр ажлын байрнаас хөөдөг, торгууль, албадлагын бусад арга хэмжээгээр айлгадаг “хуучин” арга барилаас илүү үр нөлөөтэй юм.¹⁴¹

Хүүхдийн хөдөлмөрт хандах цагдаагийн байгууллагын ажилтнуудын үзэл хандлагад эерэг өөрчлөлт гарсныг харуулж байна.¹⁴² Нийслэлийн Налайх дүүрэгт сургууль завсардан хөдөлмөр эрхэлж байсан 391 хүүхдийг тус дүүргийн Боловсролын хэлтсийн дэргэдэх Гэгээрэл Хөгжил Төвд сургаснаас 118 хүүхэд бага боловсрол, 43 хүүхэд суурь боловсрол, 22 хүүхэд бүрэн дунд боловсрол нөхөн эзэмшиж, 22 хүүхэд мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд сурчээ.¹⁴³

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийг жил бүрийн 6 дугаар сарын 12-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлал тогтож байгаа нь энэ асуудалд шийдвэр гаргагчид, эцэг, эхийн анхаарлыг хандуулахад ач холбогдлоо өгч байна. Түүнчлэн Цагдаагийн байгууллагын оролцоотой зохион байгуулдаг “Сургалт”, “Хүүхэд хамгаалал” зэрэг арга хэмжээ,¹⁴⁴ Хүүхдийн Төлөө Газраас хэрэгжүүлж буй хүүхэд тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэхийг таслан зогсоох талаар орон нутгийн хүүхдийн төлөө төвүүдийн тэргүүн туршлагыг солилцуулах ажил, www.stopchildlabour.mn цахим хуудас, хэвлэл мэдээллийн кампанит ажлууд, иргэний

¹⁴⁰ Нийслэлийн Цагдаагийн Газрын албан бичиг, 2010.11.12, 2 дахь тал.

¹⁴¹ 2007-2008 онд Комиссоос явуулсан судалгаанд оролцсон зах, вокзал дээр хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн 73 хувь нь цагдаад хөөгдөх нь хамгийн түгээмэл бэрхшээлүүдийн нэг гэж хариулж байсан.

¹⁴² Энэ талаарх улсын хэмжээний нэгдсэн тоон мэдээллийг 9 дүгээр зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх хэсгээс үзнэ үү.

¹⁴³ Нийслэлийн Цагдаагийн Газрын албан бичиг, 2010.11.12, 2 дахь тал.

¹⁴⁴ Мөн тэнд.

нийгмийн байгууллагуудын өргөн хүрээтэй сургалт, сурталчилгааны ажлууд нь хүүхдийн хөдөлмөрийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд дөхөм болжээ.

Сургалт, сурталчилгааны ажлын үр дүнд хүүхэд нь хориглосон хөдөлмөр эрхэлдэг эцэг эхийн хандлага өөрчлөгдсөн эсэхийг үнэлэх судалгааны ажил одоогоор хийгдээгүй. Дээр дурдсан ажлууд үндсэндээ Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын төслийн хүрээнд зохион байгуулагдсан, мөн төсөл 2010 оны 9 дүгээр сард дууссан тул цаашид хүүхдийн тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрийг таслан зогсоох, эцэг, эх, асран хамгаалагчийн хандлагыг өөрчлөх сургалт, сурталчилгааны ажлыг үргэлжлүүлэн явуулахад төрөөс анхаарах хэрэгтэй байна.

Зөвлөмж: Уул уурхайн албан болон албан бус салбарт алт, жонш, нүүрс олборлох, хог цуглуулах ажилд хүүхэд хөдөлмөрлөх явдлыг нэн даруй хориглож, тэнд ажиллаж буй хүүхдүүдийг тухайн хөдөлмөрөөс хөндийрүүлэх, сургуульд хамруулах арга хэмжээ авч, хүүхдээрээ ийм төрлийн хөдөлмөр эрхлүүлсэн эцэг, эхэд нөлөөлж, хариуцлага тооцох тогтолцоог бий болгох; (2008)

Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтад уурхайн бүх төрлийн ажил, газрын доорх бүх төрлийн ажил, газрын тос олборлолт, давс олборлолт, тэсэлгээчин, ил ба далд уурхайн ажилчин, чулуучин, өрөмдөгч болон хогийн цэгт ажиллах, хог хаягдал цуглуулах, ариутгах, ялгах, боловсруулах, цэвэрлэх, устгах ажлыг хамруулжээ.¹⁴⁵

Уул уурхайн салбарт, хогийн цэгт хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх, сургуульд хамруулах талаар төрийн болон төрийн бус байгууллагууд зарим нэг арга хэмжээ авч байна. 2010 онд Хүүхдийн Төлөө Газар хогийн цэгт хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэхэд анхаарч, Ажлын хэсгийг байгуулжээ. Ажлын хэсэг Нарангийн хогийн цэгт хөдөлмөр эрхэлж байгаа 40 өрхийн амьдралын хэрэгцээг тодорхойлох судалгаа явуулж, тэдгээр гэр бүлийн хүүхдүүдийг хог түүх ажлаас хөндийрүүлэх талаар авах арга хэмжээгээ тодорхойлжээ.

Уул уурхайн салбарт, хогийн цэгт хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн эцэг, эхэд зориулсан сурталчилгааны ажил төрийн, төрийн бус байгууллагуудаас хэрэгжүүлдэг төслийн хүрээнд зохион байгуулж байгаа боловч энэ арга хэмжээ хөдөө орон нутгийг бүрэн хамарч чадаж байгаа эсэх нь эргэлзээтэй. Харин хүүхэд хогийн цэгт хөдөлмөр эрхлэх явдал хот суурин газруудад түгээмэл учраас хогийн цэгт хөдөлмөр эрхлэгч

¹⁴⁵ Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайдын тушаалаар баталсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”, 2008.09.26, №107.

хүүхдийн эцэг, эхэд мэдээлэл, сурталчилгаа боломжийн хэмжээнд хүрч байна.¹⁴⁶ Ашигт малтмал олборлох, хог ялгах цуглуулах ажлыг хүүхдээрээ хийлгэж байгаа эцэг эх, асран хамгаалагчид хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалт байхгүй. Зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Зөвлөмж: Хот суурин газарт хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх, албан болон албан бус сургалтад хамруулах, эрх ашгийг нь хамгаалах, сургалт сурталчилгааны чиглэлээр ажиллаж байгаа иргэд, төрийн бус байгууллагууд, төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж хамтарч ажиллах; (2008)

“Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах үндэсний хугацаат хөтөлбөр (АЙПЕК)-ийг дэмжих төсөл”-ийн хүрээнд хөдөлмөр эрхэлж байгаа болон эрхлэх эрсдэлтэй хүүхдэд чиглэсэн шууд туслалцаа, үйлчилгээний хөтөлбөрийг Улаанбаатар хот, Баянхонгор, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Төв аймгуудад хэрэгжүүлсэн байна. Үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжсэн 5 аймаг, нийслэлд нийт 8 056 хүүхдэд боловсрол, сургалтын болон бусад үйлчилгээг хүргэснээр 4 425 хүүхдийг албан бус боловсролын сургалтад хамруулж, нийт 4 342 хүүхдийг ерөнхий боловсролын сургууль болон дүүргүүдийн Боловсролын хэлтсийн дэргэдэх Гэгээрэл төвийн байнгын сургалтад шилжүүлж, 701 хүүхдийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулжээ. Хөтөлбөр хэрэгжсэн газруудад хөдөлмөр эрхлэгч хүүхдийн тоо буурч байгааг Хүүхдийн Төлөө Газар мэдээлж байна.

Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, сургуулийн гадна байгаа хүүхдэд суурь боловсрол олгох хөрөнгийг хувьсах зардлаар санхүүжүүлэх тухай заалтыг тусгасан нь хөдөлмөр эрхлэгч хүүхдийн боловсролын үйлчилгээнд хамруулах асуудлыг шийдэхэд чухал алхам болжээ. Үүний зэрэгцээ сургуульд хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийн талаар авах төрийн бодлогыг тодорхойлж, “Суурь боловсрол эзэмших насны хүүхдийг боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулах талаар баримтлах чиглэл”, “Суурь боловсролыг дүйцсэн хөтөлбөрөөр олгох журам” зэргийг батлан гаргасан нь ач тусаа өгч байна.¹⁴⁷

Зөвлөмж: 14-өөс доош настай хүүхэд зах, төмөр замын вокзалуудад хүнд ачаа, өргөх, зөөх хөдөлмөр эрхлэхийг таслан зогсоох зорилгоор эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох; 14-өөс доош настай хүүхдийг хүнд хөдөлмөр эрхлүүлсэн эцэг, эх, асран хамгаалагчид бусад хүмүүст тооцох хариуцлагыг чангатгах, сурталчилгааны өргөн хүрээтэй арга хэмжээ зохион байгуулах; (2008)

¹⁴⁶ Нийслэлийн Цагдаагийн Газар, Хүүхдийн Төлөө Газруудаас Комисст ирүүлсэн албан бичигт хогийн цэгт хөдөлмөр эрхлэгчид, ялангуяа хүүхдээ хөдөлмөр эрхлүүлж буй эцэг эхчүүдийг хамруулан жижиг төсөл хэрэгжүүлсэн, Улаан Загалмайн Хороо зэрэг байгууллагууд арга хэмжээ авсан талаар дурджээ.

¹⁴⁷ Журмын хэрэгжилтэд Албан бус боловсрол, Зайны сургалтын Төв дүн шинжилгээ хийжээ.

2010 оны байдлаар Улаанбаатар хотод насанд хүрээгүй 1 300 орчим хүмүүс хөдөлмөр эрхэлж байгаагийн 65 орчим хувь нь Нарантуул Олон Улсын Худалдааны Төв, Да хүрээ, Хархорин, Барс, Хүчит шонхор, Цайз, Баянзүрх, Өгөөмөр захууд дээр тэрэг түрэх, ном, сонин, хоол хүнс зарах, машин угаах, мод, нүүрс зарах, ачаа бараа зөөх зэрэг ажил хийж байна.¹⁴⁸

Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтын 3 дугаар бүлэгт насанд хүрээгүй хүнээр “16 нас хүртэл: эрэгтэй 8-аас дээш килограмм, эмэгтэй 5-аас дээш килограмм; 16-18 нас: эрэгтэй 16-аас дээш килограмм, эмэгтэй 10-аас дээш килограмм” ачааг гараар өргүүлэх, зөөлгөхийг хориглосон. Харин хүүхдээр ийм хөдөлмөр хийлгэсэн эцэг эх, харгалзан дэмжигчид хариуцлага тооцох тухай хуулийн зохицуулалт одоогоор байхгүй байна.

Зөвлөмж: Урлагийн салбарт ялангуяа цирк (уран нугаралт, акробат), хувцас загварын чиглэлээр хүүхдүүдийн дунд сургалт явуулж, тэдний хөдөлмөрийг ашиглан орлого олж буй үйл ажиллагаанд анхаарч, сургалт явуулах, үзүүлбэр үзүүлэх зөвшөөрөл олгоход төрийн зүгээс тавих хяналтыг сайжруулж, хүүхдийн хөдөлмөрийг мөлжих, хүүхдийн амь нас, эрүүл мэндэд сөрөг үр дагавар гарахаас урьдчилан сэргийлэх; (2008)

Циркийн албан бус сургалтад анхаарал хандуулж, сургалтын хөтөлбөр, байр, багшид тавигдах нийтлэг шаардлага, стандартыг боловсруулж, хэрэгжилтэд нь хяналт тавих; (2008)

Комиссын илтгэл гарснаас хойш өнөөг хүртэлх хугацаанд төрийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагууд урлагийн салбарт, ялангуяа цирк, хувцас загварын чиглэлээр хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийн асуудалд анхаарч ажиллаагүй байна.

Зөвлөмж: Бага насны буюу суурь боловсрол эзэмших насны хүүхдүүдийг айлд мал маллуулах, гэрийн үйлчлэгчээр ажиллуулахыг хориглож, бага насны хүүхдийг хөдөлмөрлүүлж буй эзэдтэй хариуцлага тооцдог болох; (2008)

Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтад өрхөөс тусгаар орчинд хүүхдийг гэрийн үйлчлэгч, асрагчаар ажиллуулахыг хориглосон байна. Харин уг жагсаалтад айлд мал маллуулах ажлыг тусгайлан заагаагүй боловч насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтад хүүхдийг лабораторийн малчин, эмнэг сургагч гэх мэт малчин хүний гүйцэтгэх зарим төрлийн ажлыг нэрэлж, дулааны улиралд ажлын байранд цельсийн +25-аас дээш, гадаа талбайд +32-аас дээш хэмийн халуунд, хүйтний улиралд ажлын байранд +16-аас доош хэмийн дулаан, гадаа талбайд -21-ээс доош хэмийн хүйтэнд хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон нь сайшаалтай байна. Бага насны хүүхдийг

¹⁴⁸ Хүүхдийн Төлөө Газрын албан бичиг, 2010.11.18, №А1/454.

хөдөлмөрлүүлж буй эзэдтэй хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэх талаар арга хэмжээ аваагүй байна.

Зөвлөмж: Хурдан морины хүүхдийн хөдөлмөрийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрт хамруулах эсэхийг Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, хэрвээ ийм төрлийн хөдөлмөрт хамруулах боломжгүй гэж үзвэл хурдан морины уралдааны тухай асуудлыг хуулиар зохицуулж, хурдан морь унах хүүхдийн насны хязгаарыг 9-өөс доошгүй байхаар тогтоох; (2008)

Хурдан морь унаач хүүхдийн насны хязгаарыг 9 наснаас доошгүй байхаар тогтоох тухай Комиссын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. 2003 онд батлагдсан Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Баяр наадмын хурдан морийг 7-оос дээш насны хүүхэд унах бөгөөд ослын даатгалд даатгуулсан байна” гэж заажээ. Уг хуульд нийцүүлж гаргасан “Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны дүрэмд унаач хүүхдийг хамгаалах талаар хэд хэдэн чухал заалт оржээ. Дүрмийн 2 дугаар зүйлийн 2.5.3-т Хурдан морины уралдааны салбар хороо унаач хүүхдийг ослын даатгалд хамруулсан байдал, тусгай зориулалтын хамгаалалтын малгай, цээживч, өвдөг, тохойны хамгаалалт, хүүхдийн гуталд таарсан хамгаалалт бүхий дөрөөтэй эмээл зэргээр хангасан эсэхийг хянаж, уралдааны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах”, 3 дугаар зүйлийн 3.1.6-т “унаач хүүхэд тухайн морийг унаж уралдахаас татгалзвал уяач, эцэг, эх, асран хамгаалагч нь албадахгүй байх”, 3.1.8-т “уяач нь уралдаанд оролцох үед мориноос унаж бэртэж гэмтсэн унаач хүүхдийн талаар эрүүл мэндийн болон хүний эрхийн байгууллагад заавал мэдэгдэж, дэмжлэг туслалцаа үзүүлсэн байх” гэж тус тус заасан байна.¹⁴⁹

Үүний зэрэгцээ хурдан морь унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд зарим ахиц дэвшил гарч байна. Баяр наадмын өмнөх сорилго-сунгааны үеэр Хүүхдийн Төлөө Газар, аймаг, сум, дүүргийн хүүхдийн байгууллагын мэргэжилтнүүд хүүхдийн аюулгүй байдлыг хангасан эсэхэд хяналт тавьж, нөлөөлөл, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, мэдээлэл, гарын авлагыг түгээж заншсанаар унаач хүүхдийг гэнэтийн ослын даатгалд хамруулах хүрээ нэмэгдэж, эмчилгээний зардлын нөхөн олговрыг гэрээний дагуу олгох болсон, осол гэмтлийн тоо буурсан зэрэг нааштай үзүүлэлт гарчээ.

¹⁴⁹ Хурдан морь унаач хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр сүүлийн жилүүдэд чамгүй олон тооны тушаал, шийдвэр гарчээ. Тухайлбал, “Дүрэм батлах тухай” Засгийн газрын 2003 оны 164 дүгээр тогтоол, “Дүрэм шинэчлэн батлах тухай” 2005 оны 119 дүгээр тогтоол, “Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2006 оны 148 дүгээр тогтоол, “Үндэсний их баяр наадмын талаар авах зарим арга хэмжээний” тухай 2009 оны 169 дүгээр тогтоол, “Хурдан морины уралдаанд оролцох хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай” Монгол Улсын Шадар сайдын 2005 оны 5 дугаар тушаал, “Хурдан морь унаач хүүхдийн хамгааллыг сайжруулах тухай” Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн 2006 оны 2 дугаар тогтоол, уг тогтоолын 1 дэх заалтын дагуу батлагдсан “Орон нутагт болох хурдан морины уралдааны явцад унаач хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах журам” гэх мэт.

Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх талаар ахиц дэвшил гарч буй боловч хуулийн хэрэгжилт хангалтгүйгээс хурдан морь унаач хүүхэд амь насаа алдах, эрүүл мэндээрээ хохирч эрх нь ноцтойгоор зөрчигдөж байна. Хамгийн сүүлийн жишээ гэхэд 2011 оны 2 дугаар сард Төв аймгийн Баянцогт сумын 10 настай хүүхэд мориноос унаж, амь насаа алджээ. 2011 оны өвлийн уралдаанаар 2 хүүхэд амь насаа алдсан тухай мэдээлэл цацагдсан боловч нөгөө хүүхдийн талаарх тодорхой мэдээлэл ямар ч эх сурвалжаас олдохгүй байна.

2010 оны Үндэсний их баяр наадмын үеэр Хүүхдийн Төлөө Газар 21 аймагт болсон хурдан морины уралдаанд морь унасан хүүхдүүдийн дунд судалгаа хийхэд 5-7 настай хүүхэд хурдан морь унасан тохиолдол гарчээ. Ялангуяа, орон нутагт бүртгүүлсэн нийт хүүхдийн 50,8 хувь нь уралдахаар бүртгүүлэхдээ төрсний гэрчилгээгүй, Хүй долоон худагт болсон Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдаанд 1 185 хүүхэд морь унасны ердөө 12 нь л төрсний гэрчилгээтэй байжээ. Дүн шинжилгээ хийсэн багийн гишүүд холбогдох хуулийг биелүүлэх шаардлага тавихад уяачид буюу унаач хүүхдээ бүртгүүлж байсан насанд хүрэгчид эсэргүүцэх, уурлах зэрэг зан авир гаргах нь олонтаа тохиолджээ. Энэ мэт байдал нь хуулиар зөвшөөрөгдсөнөөс доош настай хүүхэд морь унах явдал түгээмэл, уяачдын дунд хэвийн, байх ёстой юм шиг сэтгэлгээ амь бөхтэй байгаагийн илрэл юм.

2010 оны Үндэсний их баяр наадмын үеэр хөдөө, орон нутгийн уралдаануудад нийт 14 180 хүүхэд хурдан морь унасны 9 716 нь буюу 68,5 хувь нь гэнэтийн ослын даатгалд хамрагдаагүй байжээ.¹⁵⁰ Харин улсын наадамд морь унасан бүх хүүхдийг гэнэтийн ослын даатгалд хамруулсан байна. Хурдан морь унаач хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт хангалтгүй, хуулийн хэрэгжилт сулаас хүүхэд хүндээр бэртэж гэмтэх, хөгжлийн бэрхшээлтэй болох, амь насаа алдах гашуун тохиолдол гарсаар байна. Түүнчлэн, хурдан морь унаач хүүхэд хохирсон тохиолдолд хохирлоо бүрэн дүүрэн нөхөн төлүүлэх эрх зүй, хариуцлагын тогтолцоо бий болгох талаар анхаарах шаардлагатай юм.

4.5 Хохирогчийн эрх

“Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ...эрхтэй”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгээс)

¹⁵⁰ Хүүхдийн Төлөө Газар “Үндэсний баяр наадмын хурдан морины уралдаанд хийсэн мониторинг” 2010 он.

Зөвлөмж: Бусдын хууль бус үйлдлийн улмаас амь нас, бие эрхтэнээрээ хохирох, сэтгэл санаа, эрүүл мэндийн хохирол учрахад нөхөн төлүүлэх, үнэлүүлэх боломж, нөхцөл, шалгуурыг хууль тогтоомжид тусгаж өгөх; (2005)

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор “Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчийн талаарх шүүн таслах ажиллагааны үндсэн зарчмуудын тухай тунхаглал”-ыг баталсан нь эдүгээ эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн этгээдийн хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх талаарх олон улсад мөрдөгддөг бие даасан үндсэн стандарт, хэм хэмжээ болж байна. Уг тунхаглалд гэмт хэргийн улмаас учирсан бие махбодийн ба сэтгэцийн гэмтэл, сэтгэл зүйн хор уршиг, алдагдсан орлого, эмчилгээний төлбөр, мөн төрөөс тогтоосон нийгмийн халамжийн тогтолцооноос нөхөн төлбөр авах чиглэл, хандлагыг тогтоож өгсөн билээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ”, 42 дугаар зүйлийн 42.3.9-т “хохирогч түүний төлөөлөгч нь гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх эдлэнэ” 43 дугаар зүйлийн 43.1-т “Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн, түүнийгээ нөхөн төлүүлэх буюу сэргээлэхээр шаардлага тавьж байгаа иргэн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ” гэж эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг бататган хуульчилсан боловч Иргэний хуулийн 230, 511 дүгээр зүйл, заалтаар эдийн бус хохирлыг зөвхөн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирлоор хязгаарлан зохицуулсан төдийгүй тухайн заалтыг хэрэгжүүлэх механизм нь бүрэн төгөлдөржөөгүй хэвээр байна.¹⁵¹ Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 230, 511 дүгээр зүйлд “Эдийн бус гэм хорыг арилгах” тухай хуульчлахдаа эдийн бус хохирлыг шаардах эрх, эдийн бус хохирлыг нөхөн төлөх хэлбэр, гэм хорыг арилгах болон гэм хорын хэмжээг тогтооход харгалзах зүйлийг тусгасан боловч эдийн бус гэм хорыг зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирлоор хязгаарлан тодорхойлсон байна.

Ийнхүү Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 391 дүгээр зүйлд “Эдийн бус хохирлыг Иргэний хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө”, “Эдийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан Иргэний хуульд заасан журмаар тодорхойлно” гэж заасан боловч Иргэний хуульд өөрт нь “...эдийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан...тодорхойлох” журмыг нарийвчлан заагаагүй учир хохирлын хэмжээг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасанчлан шийдвэрлэх боломжгүй байна.

¹⁵¹ “Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирогчдод учирсан сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоох аргачлал судалгаа”, 2010 он, УБ., 42 дахь тал.

Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зохицуулалтыг хэрхэн нэг мөр ойлгож, шүүхийн практикт зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Улсын Дээд Шүүхээс 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 15 дугаар тогтоол гаргажээ. Уг тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1-т Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 115 дугаар зүйлийн 115.1-д заасан “эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол” гэдэгт Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д зааснаар бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд ... учруулсан гэм хорыг ойлгоно” гэж, мөн тогтоолын 6 дугаар зүйлийн 6.2.4-т Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөхөөр заасан ба хүний амь, нас, бие эрхтэн, өвчин, зовиур шаналал, сэтгэл санааны байдал зэрэг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй хэмээн заажээ.

Улсын Дээд Шүүхийн дээрх тайлбарын хэсэгт дүн шинжилгээ хийхэд Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хохирогчид олгосон эдийн бус хохирол нэхэмжлэх эрхийг зөвхөн нэр төр, алдар, хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирлоор хязгаарлан тайлбарласан нь Үндсэн хуульд харш, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтыг хязгаарласан, хуульд төдийлөн нийцэхгүй тайлбар болжээ. Хэдийгээр Улсын Дээд Шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж мөрдөх боловч өнөөдөр хууль хэрэглэгчид тайлбарын заалтыг хэрэглэсээр байгааг анхаарах хэрэгтэй байна.¹⁵²

Мөн Иргэний хуулийн дээрх заалтаар эдийн бус хохиролд сэтгэл зүйн хохирол хамаарахгүйгээр зохицуулсан атлаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэгт хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан сэтгэл санааны болон тодорхой үр дагаварыг арилгуулах эрхийг заан хуульчилсан нь хохирол учруулсан этгээд субъектээс шалтгаалан сэтгэл зүйн хохирол олгох, эсвэл олгохгүйг зохицуулсан тэгш бус зохицуулалт болжээ. Энэ нь Үндсэн хуулийн Арван зургадугаар, Арван есдүгээр зүйлийн заалтаар бусдын хууль бусаар учруулсан хохирлыг хэн учруулснаас үл хамааран нөхөн төлүүлэх эрхийг олгосонтой зарчмын хувьд нийцэхгүй байна.

Хохирлын бодит хэмжээг тодорхойлох талаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын зарчмуудад нөхөн төлбөр нь хүний эрх, эрх чөлөөний зөрчлийн хэр хэмжээ, учруулсан хор уршигт дүйцэхүйц байх ёстой бөгөөд хохирогчийн эрх, эрх чөлөө, хувийн байдал, гэр бүл, эд хөрөнгө, хөдөлмөр эрхлэлт, сургууль боловсролын түвшинг аль болох өмнө нь байсан хэмжээнд сэргээн бүрдүүлсэн байх учиртай. Хохирогчид олгох нөхөн төлбөр нь бие махбодийн болон сэтгэл санааны хохирол, ажил хөдөлмөр, сургууль боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ зэрэг алдагдсан боломж, бодит орлого, боломжит орлогыг оролцуулан эд материалын

¹⁵² “Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирогчдод учирсан сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоох аргачлал судалгаа”, 2010 он, УБ., 12 дахь тал.

хохирол, зан суртахуунд учирсан хохирол, хууль зүй, эмнэлэг, сэтгэл зүй, нийгмийн үйлчилгээний төлбөр зэргийг бүрэн гүйцэд барагдуулах ёстой болохыг тунхаглал, зарчимд заажээ. Харин манай улсын хууль тогтоомжоор хохирогчид зөвхөн бодитойгоор учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр хуульчилсан байна.

Бусдын эрүүл мэндэд учирсан гэм хорыг арилгах талаарх эрх зүйн зохицуулалт ч боловсронгуй бус хэвээр байна. Бусдын хууль бус үйлдлийн улмаас эд эрхтнээсээ хагацсан хохирогчид эд, эрхтэнээсээ салах, биеийн хэвийн үйл ажиллагаа нь алдагдах, гоо сайхандаа засаршгүй гэмтэл авах, сэтгэл санаа зэргээр эрүүл мэндийнхээ хувьд ноцтой хохирч үлдэж байна. Тэд зөвхөн авч чадаагүй цалин хөлс, эмчилгээний зардал, хиймэл эрхтэн нэг удаа хийхэд шаардлагатай зардлаа төлүүлж байгаа нь тухайн хүний эрүүл, бүрэн бүтэн байсан эд эрхтний алдагдсан чадварыг нөхөн төлж байгаа хэрэг биш гэж үзэхээс аргагүй.

Үүнээс үзэхэд хууль тогтоомжид зөвхөн эд хөрөнгийн бодитой хохирол гарсан зардлыг төлүүлэх эрх зүйн орчин бүрдэж, харин эдийн бус хохирлыг арилгах хууль, эрх зүйн орчин бүрдээгүйн дээр өнөөдрийг хүртэл энэ талаар нарийвчилсан зохицуулалтгүй хэвээр байна.

Хэдийгээр энэ асуудлыг зохицуулсан дотоодын хууль эрх зүйн орчин хангалтгүй, Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор зохицуулах боломжийг Үндсэн хуулиар бий болгосон хэдий ч манай шүүхийн практикт олон улсын эрх зүйн зохицуулалтыг хэрэглэж чадаагүй байна.

Ийнхүү энэ асуудлыг зохицуулж буй хуулийн зохицуулалт зөрүүтэй, өнөөг хүртэл нарийвчилсан зохицуулалтгүй байгаа нь практикт энэ төрлийн хохирлыг шийдвэрлэх талаарх хуульчдын мэдлэг ойлголтын зөрүүг бий болгож, сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтооход бэрхшээл учруулахын зэрэгцээ энэ асуудлыг шийдвэрлэхэд төвөгтэй байдалд хүргэж байна. Түүнчлэн сэтгэл санааны хохирлыг тогтоох арга аргачлал өнөөдрийг хүртэл байхгүй хэвээр байна. Хүний Аюулгүй Байдлын Судалгааны Төв, Хохирогчийн Эрхийн Судалгааны Төв зэрэг төрийн бус байгууллагуудаас хохирол нөхөн төлөх талаар олон улсын туршлага арга аргачлалыг судлан “хохирогчийн сэтгэл зүйд учирсан хохирол”-ын хэмжээг тогтоох” талаар 2 хувилбар бүхий санал боловсруулан гаргасан нь сайшаалтай.

Иймд хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлын талаар хуулийн зөрүүтэй заалтуудыг тодорхой болгон сэтгэл санааны хохирлыг арилгах, эрхийг нь сэргээхэд анхаарал хандуулж, энэ талаар шийдвэртэй арга хэмжээ авах нь Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг бодитой эдлүүлэх баталгааг хангахад нэн чухал юм.

Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах асуудлаар Комиссын зөвлөмж гарснаас хойш Улсын Их Хурлаас 2007 оны 8 дугаар сарын 3-ны

өдөр Хохирлыг эргэн төлөх нөхцөлөөр барагдуулах тухай хууль, 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулийг тус тус баталжээ.

Хохирлыг эргэн төлөх нөхцөлөөр барагдуулах тухай хуульд хадгаламж, зээлийн зарим хоршооны үүсгэн байгуулагчдын буруутай үйл ажиллагааны улмаас хадгаламж төлөгдөх нөхцөлөөр барагдуулах асуудлыг хуульчилсан бол Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуульд 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт гарсан нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самууны үеэр амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон иргэн, цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагч (цаашид төрийн тусгай албан хаагч гэх), хуулийн этгээдэд нөхөн олговор олгох нэг удаагийн шинжтэй асуудлыг зохицуулсан байна.

Хохирлыг эргэн төлөх нөхцөлөөр барагдуулах тухай хуульд эд хөрөнгийн хохирлын асуудлыг хуульчилсан бол Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулиар хохирогч нарт төрөөс нэг удаа, учирсан хохирлын төрлөөс хамааран нөхөн олговор олгохоор заасан боловч хохиролд сэтгэл зүйн хохирлыг хамааруулаагүйн дээр хохиролын хэмжээг бодитойгоор тогтоолгүйгээр нөхөн олгох төлбөрийн хэмжээг заан хуульчилсан байна.¹⁵³

Хохирлыг эргэн төлөх нөхцөлөөр барагдуулах тухай хуулийн хүрээнд шүүхээр эцэслэн шийдэгдсэн 26 хадгаламж зээлийн хоршооны 8 301 хохирогчид холбогдох 72,4 тэрбум төгрөгийн төлбөртэй гүйцэтгэх баримт бичгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хүлээн авчээ. 22 хадгаламж зээлийн хоршооны хохирогчидтой зохих гэрээ байгуулж, 2007-2010 оны төсөвт тусгагдсан 35 тэрбум 68 сая 766 мянга 859 төгрөгийг хүлээн авч 7 290 хохирогчид 34 тэрбум 579 сая 312 мянга 794 төгрөгийг журмын дагуу олгосон байна. Эргэн төлөгдөх нөхцөлөөр хохирлын мөнгө олгох ажил 98,6 хувьтай явагдаж байгаа бөгөөд 10 гаруй тэрбум төгрөгийн эд хөрөнгийг худалдан борлуулж, улсын төсөвт суулгах ажил хийгдсэн байна.¹⁵⁴

Үүнээс үзэхэд төрөөс Хохирлыг эргэн төлөх нөхцөлөөр барагдуулах тухай, Хохирогчид нөхөн олговор олгох тухай хуулиудыг батлан гаргаснаар гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчид учирсан хохирлыг төр хариуцан нөхөн барагдуулахыг хуульчилсан нь дэвшилттэй алхам болжээ. Гэвч хохирогчид учирсан хохирлын бодит хэмжээг тогтоолгүйгээр хохирогчид их, бага хохирол учирснаас үл хамааран ижил хэмжээний нөхөн төлбөр олгохоор хуульчилсан нь учирсан бодит хохирлыг нөхөн төлөх зарчимд нийцэхгүй байна.

¹⁵³ “Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирогчдод учирсан сэтгэл зүйн хохиролын хэмжээг тогтоох аргачлал судалгаа”, УБ., 2010 он, 12 дахь тал.

¹⁵⁴ www.open-parliament.mn 2011.01.07.

Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах асуудалд гарсан нэг гол ололт бол Улсын Их Хурлаас 2010 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, "Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан" бий болгожээ. Уг хуульд заасны дагуу энэхүү сангаас 2011 оноос хойш тус улсын нутаг дэвсгэрт хүч хэрэглэн, санаатай үйлдсэн, Эрүүгийн хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1, 81.2-т заасан (Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах), 91 дүгээр зүйлийн 91.1, 91.2-т заасан (Хүнийг санаатай алах), 96 дугаар зүйлийн 96.1, 96.2-т заасан (Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах), 108 дугаар зүйлийн 108.3-т заасан (Хүн хулгайлах), 190 дүгээр зүйлийн 190.3-т заасан (Хүнийг хууль бусаар хорих), 112 дугаар зүйлийн 112.3-т заасан (Хүнийг барьцаалах), 113 дугаар зүйлийн 113.3-т заасан (Хүн худалдаалах), 126 дугаар зүйлийн 126.2, 126.3 -т заасан (Хүчиндэх), 147 дугаар зүйлийн 147.3-т заасан (Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх), 177 дугаар зүйлийн 177.2-т заасан (Зандалчлах), 178 дугаар зүйлийн 178¹.2 -т заасан (Терроризм), 251 дугаар зүйлийн 251.2, 251.3 -т заасан (Эрүү шүүлт тулгах) гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хохирогчийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид төрөөс шүүхийн шийдвэрийг үндэслэн тодорхой хэмжээний нөхөн төлбөр олгохоор тусгажээ.

Хохирогчид нөхөн төлбөрийг олгохтой холбогдсон харилцааг зохицуулах нарийвчилсан журмын төслийг Засгийн газраас боловсруулж байна.¹⁵⁵ Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Засгийн газрын тусгай санд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүч хэрэглэн үйлдсэн, Эрүүгийн хуульд заасан зарим төрлийн онц хүнд гэмт хэргийн улмаас амь нас нь хохирсон, мөн хүнд гэмтэл авч тахир дутуу болсон хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд нөхөн төлбөр олгохоор сан нээсэн нь гэмт хэргийн хохирогчийн эрхийн байдалд томоохон өөрчлөлтийг бий болгожээ. Хүнд, онц хүнд гэмт хэргийн хохирогчдод учирсан эмчилгээ болон оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас аваагүй цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг энэхүү сангаас олгохоор заасан нь бусдын хууль бус үйлдлийн улмаас амь нас, бие эрхтнээрээ хохирох, сэтгэл санаа, эрүүл мэндийн хохирол учрахад нөхөн төлүүлэх эрх зүйн үндсийг бий болгох гэсэн Комиссын зөвлөмжийн хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой болжээ. Ийнхүү бие даасан эрх зүйн зохцуулалт зайлшгүй шаардлагатайг анхаарах хэрэгтэй байна.

Зөвлөмж: Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн буруутай ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг нөхөн төлөх хуулийн заалтыг мөрдлөг болгож хэвшүүлэх; (2004)

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн буруутай ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж

¹⁵⁵ Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооны албан бичиг, 2011.02.12, №4/96.

шийтгэхийн эсрэг конвенцийн¹⁵⁶ 14 дүгээр зүйлд зааснаар “Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран хамгаалагч нөхөн төлбөр авах эрхтэй” байна.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын¹⁵⁷ 9 дүгээр зүйлд “Баривчлагдаж эсхүл цагдан хоригдож эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр ийнхүү хорьж саатуулсан нь хууль ёсны эсэхийг шүүхээр даруй тогтоолгох, хууль бусаар хорьсон бол суллуулах шийдвэр гаргуулах эрхтэй. Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй”, 14 дүгээр зүйлд “Эрүүгийн хэрэг үйлдэж, шүүхийн эцсийн шийдвэрээр ял заагдсан бөгөөд шинэ буюу шинээр илэрсэн үйл баримт шүүн таслах ажиллагааны алдааг хөдөлбөргүй нотолсны учир оногдуулсан ялыг хожим хүчингүй болгосон буюу хэргийг цагаатгасан бол тэрхүү мэдэгдээгүй байсан үйл баримт тухайн үедээ илрээгүй нь бүхэлдээ буюу зарим талаар уг хүний буруугаас болсон гэдэг нь батлагдаагүй бол тийнхүү шийтгүүлсэн этгээд хуулийн дагуу хохирлоо нөхөн төлүүлнэ” гэж тус тус заасан.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах тухай зохицуулж, хуулийн 388 дугаар зүйлд “...иргэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлоо нөхөн төлүүлэх, сэтгэл санааны үр дагавраа арилгуулах болон тэтгэвэр тэтгэмж авах, орон сууц эзэмших хийгээд бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй”, хуулийн 389 дүгээр зүйлийн 389.1-т “иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсний улмаас учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгах”-аар тус тус заасан байна.

Улсын Дээд Шүүхийн 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 45 дугаар тогтоолоор хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах тухай Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зарим, зүйл, заалтыг тайлбарлах тухай тогтоолд

¹⁵⁶ “Төрийн мэдээлэл” сэтгүүл, Тусгай дугаар I боть, 2004 он, 109-120 дахь тал, Энэ конвенц 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо батлагдаж, 1987 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон ба Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр нэгдэж орсон.

¹⁵⁷ “Төрийн мэдээлэл” сэтгүүл, Тусгай дугаар I боть. 2004 он, 11-28 дахь тал, Ерөнхий Ассемблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200A (XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталсан.

байцаан шийтгэх ажиллагааны явцад эрүүдэн шүүгдэж, хэрцгий хүнлэг бус харьцаанд өртөж санаа сэтгэл, эрүүл мэнд, амь насаараа хохирсон явдлыг хамруулсан нь конвенцийн шаардлагад нийцсэн чухал ач холбогдолтой арга хэмжээ болжээ.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн буруутай ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэгт хуульчилж өгсөн нь хүний эрхийг хангахад чиглэсэн чухал зохицуулалт юм.

Комисс 2003 оны илтгэлдээ энэхүү хуулийн заалт нь шүүн таслах ажиллагааны явцад иргэнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг баталгаатай болгоход чиглэсэн чухал зохицуулалт болохыг онцлон тэмдэглэж, уг зохицуулалтыг хуулийн практикт мөрдлөг болгож хэвшүүлэх явдлыг зөвлөсөн.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэгт хэрэг, бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах тухай хуулийн заалтыг шүүхийн практикт хэрэглэж шийдвэрлэсэн хэргийн дүн мэдээнээс үзэхэд 2006-2011 оны 1 дүгээр улирлын байдлаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэг, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 498 дугаар зүйлийн 498.4-т зааснаар улсын хэмжээнд нийт 61 хэрэг шийдвэрлэгдсэн байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 389 дүгээр зүйлийн 389.5-т “хууль бус ажиллагаатай холбогдож гарсан шууд бус хохирлыг төр хариуцахгүй” гэж хуульчилсан нь Үндсэн хуулийн учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх (Арван зургадугаар зүйлийн 16 дахь хэсэг) болон хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах төрийн үүрэг (Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг) нийцэхгүй байна.

Үндсэн хуульд хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг тусгахдаа шууд ба шууд бус хохирол гэж ялгаагүй ба тэр тусмаа төрийн хувьд ямар нэг ялгавар, хөнгөлөлтийг заагаагүй. Энэ заалт Үндсэн хуулийн агуулгыг зөрчихийн зэрэгцээ хохирогчийн хохирлыг бүрэн барагдуулахад саад болохоор байна.

Комисс байгуулагдсанаас хойш эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн иргэдийн нийт 1 921 гомдлыг (2011 оны 1 дүгээр сарын байдлаар) хүлээн авч шийдвэрлэсний дийлэнх нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрх зөрчсөн, ялангуяа хуулийн байгууллагын ажилтнуудын буруутай үйл ажиллагаанаас эрх нь зөрчигдсөн, үндэслэлгүйгээр гэмт хэрэгт холбон цагдан хорьсон, эрүүдэн шүүсэн, хилсээр ял тулгасан тухай гомдол иржээ.

Комисс хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан

хохирлыг нөхөн төлүүлэх асуудлаар 7 удаа төлөөлөн нэхэмжлэлийг шүүхэд гарган, 125 299 573 төгрөгийг төрөөс гаргуулан хохирогч иргэдэд олгуулжээ.

Хохирол нөхөн төлөлтийн байдлыг авч үзвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохиролд 423 175 206 төгрөг гаргуулахаар шүүхэд нэхэмжилснээс 125 299 573 төгрөг олгохоор шийдвэрлэсэн нь нэхэмжлэлийн шаардлагын 29,6 хувь болж байна.

Үүнээс үзэхэд шүүх хохирсон этгээд нэхэмжлэгчийн сэтгэл зүйн хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгуулахаар гаргасан нэхэмжлэлийн ихэнхийг нь хэрэгсэхгүй болгох, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг эрс багасгаж шийдвэрлэсэн нь энэ талын ойлголт нэг мөр тогтоогүйтэй холбоотой гэж үзэж байна.

Энэ нь нэг талаар Иргэний болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль, бусад хууль тогтоомжид эдийн шинжтэй буюу эд хөрөнгийн бодит хохирлыг нөхөн төлүүлэх журмыг илүүтэй зохицуулж, хохирсон амь нас, эрүүл мэндэд учирсан гэмтэл согог, хүний сэтгэл зүйд учруулсан шаналал зовиур зэргийг үнэлэх асуудлыг орхигдуулж, учирсан дээрх хохирлын хэмжээг тодорхойлоход чиглэсэн зохицуулалт үндсэндээ байхгүй байгаатай холбоотой байна.¹⁵⁸

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооны Ажлын албаны захиалгаар Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн 2009 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2010 оны 3 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд “Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, ял эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох судалгаа” явуулжээ.

Судалгаагаар нийслэлийн хэмжээнд 2006-2009 онд шийдвэрлэсэн 6 хэргийн материалд дүн шинжилгээ хийсэн байх бөгөөд уг судалгаанаас Монгол Улсад хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, ял эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоож, шийдвэрлэж буй байдлыг үзэхэд шүүх сэтгэл зүйд учирсан хохирлыг шийдвэрлэхдээ хохирлын хэмжээг хэрхэн тооцсон, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг ямар үндэслэлээр багасгаж буюу зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн талаараа хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүйгээс гадна хохирлын хэмжээ болон түүнийг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг хэрхэн тооцсон нь тодорхойгүй байна.

¹⁵⁸ “Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, ял эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох” судалгааны тайлан, УБ., 2010 он, 24 дэх тал.

Иймд хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, ял эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг шүүх тогтоохдоо Эрүүгийн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3-т "...цагдан хоригдсон этгээдэд торгох ял оногдуулсан бол цагдан хоригдсон нэг хоногийг тухайн үед мөрдөгдөж байгаа нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүүлж, торгох ялаас хасч тооцно" гэсэн заалтыг шүүх баримтлан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр жишиг тогтоон үнэлбэл илүү бодитой гарна гэж үзэж байна. Үүнээс үзэхэд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэгт хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах талаар хуулийн зохицуулалт шүүхийн практикт мөрдлөг болж хэвшсэн нь төдийлөн хангалтгүй, нэхэмжлэлийн ихэнх хэсэг хэрэгсэхгүй болдог, сэтгэл санааны хохирлыг ихэнх тохиолдолд тооцохгүй байгаа иргэдийн хуулиар олгогдсон хохирлоо бүрэн төлүүлэх эрхийн баталгаа болж чадахгүй байна.

4.6 Хүний эрхийн боловсрол

Зөвлөмж: Хүний эрхийн боловсрол олгож өнөөгийн нөхцөл байдалд цогц үнэлгээ хийж, Хүний эрхийн хангах үндэсний хөтөлбөрт заасны дагуу "Хүний эрхийн боловсрол олгох дэд хөтөлбөр"-ийг баталж хэрэгжүүлэх; (2008)

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооны 2007-2008 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд "Хүний эрхийн боловсрол олгох дэд хөтөлбөр"-ийг боловсруулж батлуулах ажил тусгагдаж ажлын хэсэг байгуулсан ч төлөвлөсөн хугацаанд хөтөлбөр боловсруулаагүй байна. Харин 2010 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Хүний эрхийг үндэсний хөтөлбөрийн хорооны 14 дүгээр тогтоолоор хүний эрхийн албан ба албан бус боловсрол олгож байгаа өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, бусад орнуудын жишигтэй харьцуулан судлахыг хорооны Ажлын албанд, "Хүний эрхийн асуудлаар мэргэшсэн үндэсний мэргэжилтэн, сургагч бэлтгэх дэд хөтөлбөр"-ийн төсөл боловсруулахыг Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамны Төрийн нарийн бичгийн даргад үүрэг болгожээ.

Дээрх тогтоолыг хэрэгжүүлэхээр 2010 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын 511 дүгээр тушаалаар хүний эрхийн албан болон албан бус сургалтын тогтолцооны загвар, Хүний эрхийн мэргэшсэн үндэсний мэргэжилтэн бэлтгэх сургагч багш бэлтгэх дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан байна.

Ажлын хэсэг "Хүний эрхийн албан ба албан бус боловсрол олгож буй өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хүрээнд хийсэн судалгааны тайлан", "Ерөнхий боловсролын стандарт, агуулга дахь хүний эрхийн боловсрол" (шинжилгээ), "Багш бэлтгэдэг их дээд сургуулийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр дэх "Хүний эрх,

хүүхдийн эрх"-ийн үзэл санаа, агуулгад хийсэн дүн шинжилгээ” зэрэг судалгаа хийж, нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгсөн байна.

Багш бэлтгэдэг их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулийн 12 жилийн сургалтын хөтөлбөр, сурах бичгүүдэд хүний эрхийн боловсролын агуулга хэрхэн туссан байдалд дүгнэлт хийн, судалгааны дүнг үндэслэж, нийт багш бэлтгэдэг сургуулиудын багш хөтөлбөрийн агуулгад багтаан багш нарын арга зүйг дээшлүүлэх зөвлөмж боловсруулсан байна.

Хүний эрхийн дэд хөтөлбөр батлан гаргах асуудлаар яамд нэгдсэн байр суурьгүй байгаа учир хөтөлбөр батлагдаагүй байна. Харин хүний эрхийн боловсрол олгох албан болон албан бус сургалтын загвар боловсруулах, хүний эрхийн сургагч багш бэлтгэхээр үйл ажиллагаа явуулж байна. Иймд энэ үйл ажиллагааг идэвхжүүлж, эн тэргүүнд хүний эрхийн боловсрол олгох албан болон албан бус боловсролын тогтолцоог яаралтай бий болгох шаардлагатай.

Зөвлөмж: Албан ба албан бус боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсрол олгох сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний хувилбаруудыг боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжөөр хангах; (2008)

Өнөөгийн байдлаар нэгж хичээлийн хөтөлбөрт хүний эрхийн асуудлыг тусгахад тулгамдаж байгаа асуудлуудыг тодорхойлбол:

- Хүний эрхэд холбогдох ойлголт, мэдлэг, чадвар, хандлагыг суралцагчдад эзэмшүүлэх тал дээр цогц ойлголтгүй байдал багш нарын дунд нийтлэг;
- Сургалтын явц, үйл ажиллагааны төлөвлөлт нь хэт мэдлэг тал руугаа хэвийж, асуудалд үнэлэлт дүгнэлт өгч шийдвэрлэх арга замыг эрэлхийлсэн, харьцуулан судлах, түүний үндсэн дээр өөртөө шинэ мэдлэг бүтээх арга зүй, үйл ажиллагаа дутмаг;
- Үнэлгээг хийхдээ мэдлэг чадварыг шалгах шалгуур давамгайлсан ба хэрхэн хэрэглээ болгож байгаагаар нь үнэлэх шалгуур дутмаг;
- Хичээлийн арга зүй, үнэлгээ нь уламжлалт байдалтай, бодитой биш, хүртээмжтэй биш (Ахицаар нь үнэлэх шалгуур дутмаг).

Эмнести Интернэшнл байгууллагаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дэлхийн хөтөлбөрийн хүрээнд “Бага, дунд боловсролын байгууллагын багш нарт зориулсан хүний эрхийн боловсрол” төслийг хэрэгжүүлж, төслийн хүрээнд нийслэл болон орон нутгийн нийт 763 багш, сургалтын менежерүүдэд сургалт явуулсан ба “Ерөнхий боловсролын сургуулийн ерөнхий эрдмийн хичээлүүдээр шинжлэх ухааны суурь ойлголтуудыг хүний эрхийн хэрэгжилтийн үзүүлэлтүүд, бодит байдалтай холбон заах боломжтой төдийгүй энэ нь амьдралд ойр, суралцагчдын эрэлт хэрэгцээг хангасан бүтээлч арга зүй болно” гэж сургалтад оролцогчид дүгнэсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн сургалтын гол зорилго нь дээрх стандартыг хангахад чиглэх учиртай. Сургалтаар зөвхөн хүний эрхийн мэдлэг олгоод зогсохгүй хүний эрх, эрх чөлөөнд хүндэтгэлтэй ханддаг, эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн тохиолдолд ямар арга замыг ашиглан хаана, хэнд, хэрхэн хандахыг мэддэг, түүнийгээ хэрэглэх чадвар бүхий цогц чадамжийг суралцагчдад эзэмшүүлэх нь хүний эрхийн боловсролын стандартын гол зорилго билээ.

Ерөнхий боловсролын сургуулиуд дахь хүний эрхийн сургалтаар суралцагчдыг стандарт ба стандарт бусаар үнэлж байна. Үнэлгээний стандартад агуулгын ай бүрээр эзэмших цогц чадамжийг үнэлэх үнэлгээний шалгуурыг боловсруулж өгсөн нь тухайн шалгуурыг баримжаа болгон үнэлэх даалгаврыг боловсруулахад багшид туслах, суралцагчид бие даан суралцах, шалгалтад бэлтгэх, эцэг, эх асран хамгаалагчид хүүхдийнхээ хичээлд туслах, бодлого боловсруулагчид болон сургуулийн удирдлага хяналт шинжилгээ хийх зэрэгт удирдамж болох ач холбогдолтой юм.

Хүний эрхийн боловсролын чиглэлээр хөндөгдөж буй нэгэн асуудал бол энэхүү боловсролыг зөвхөн Нийгмийн ухаан, Иргэний боловсрол хичээлүүдээр дагнан олгохоос илүүтэй ерөнхий боловсролын сургуульд судалж буй бусад хичээлийн агуулга, хэрэглэгдэхүүн, заах арга зүйгээр дамжуулан дэмжих тухай асуудал юм. Энэ хандлага нь сүүлийн үед ихээхэн хөндөгдөж буй бөгөөд илүү үр дүнтэй, зохистой хувилбар гэж үздэг. Иймээс 12 жилийн сургалтад хэрэгжүүлэхээр Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамнаас баталсан албан боловсролын сургалтын хөтөлбөрүүд болон албан бус боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөр, зарим сурах бичгийн хүрээнд энэхүү шинжилгээг хийсэн байна.

Албан боловсролын агуулга дахь хүний эрхийн боловсролын тухайд, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын 2010 оны 511 дүгээр тушаалын дагуу байгуулсан хүний эрхийн албан болон албан бус сургалтын тогтолцооны загвар боловсруулах ажлын хэсэг болон Хүний эрхийн мэргэшсэн үндэсний мэргэжилтэн бэлтгэх сургагч багш бэлтгэх дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн гишүүд ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн задлан шинжилсний үр дүнд сургалтын хөтөлбөрийн хүрээнд хүний эрхийн үзэл санааг бүрэн дүүрэн бус, 33 хувиас 40 хувьд шингээж чадсан гэж үзжээ.

Албан бус боловсролын агуулга дахь хүний эрхийн боловсролын тухайд, албан бус боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөр, стандартад хүний эрхийн боловсролын үүднээс хийсэн шинжилгээнээс үзэхэд “Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөр”, стандартад хүний эрхийн боловсролын агуулга зохих түвшинд тусгасан байна. Эдгээр хөтөлбөрийн дагуу боловсруулсан гарын авлагууд ч хүний эрхийн агуулгыг тусгасан байна. Тухайлбал “Эрх чөлөө, үүрэг

хариуцлага”, “Хууль бидний амьдралд”, “Сонгууль ба оролцоо”, “Асуудал шийдвэрлэх арга зам” гэх мэт.

Албан бус боловсролын Гэгээрэл төвийн багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, шинээр боловсруулан гарч байгаа холимог бүлгээр сургалт явуулах арга зүй болон амьдрах ухаанд суурилсан бичиг үсгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйд сургах, сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглах арга барилд сургах зорилгоор зохион байгуулдаг нь бичиг үсгийн болон боловсрол нөхөн олгох дүйцсэн сургалтыг холимог бүлгээр зохион байгуулж буй тэргүүн туршлагыг багш нарт түгээн дэлгэрүүлж, сурталчлах замаар албан бус сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн онцлогтой байна.

Сургууль завсардсан, ерөнхий боловсролын сургуульд сурах нас нь хэтэрсэн хүмүүс "Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн журам"-ыг ойлгож, иргэдийн дунд эерэг ойлголт хандлага тогтож, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн эзэмших сонирхол нэмэгдэж байгаа нь хүний эрхийн хөтөлбөрийг хангах үйл ажиллагаатай нягт уялдсан ажлууд болжээ.

Дээд боловсрол эзэмшүүлэх бодлогод сургалтын агуулгын шинэчлэл онцгой байр суурь эзэлдэг бөгөөд сургалтын агуулга их, дээд сургуулиар олгож буй мэдлэг, чадвар, хандлага ба улс орны хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагын хоорондын уялдааг хангаж байх ёстой. Эдүгээ мөрдөж буй дээд боловсролын стандартуудад хүний эрхийн хичээл судлуулахаар тусгайлан заагаагүй ч сургалтын ерөнхий зорилтын хүрээнд хүний эрхийн боловсролын асуудал хөндөгдсөөр байна.

Зөвлөмж: Эрх зүйч, төрийн захиргааны болон цэргийн алба хаагчид, эмч, багш бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хүний эрхийн боловсрол олгох хичээлийг заавал судалдаг болгох; Эмчлэх, багшлах зэрэг эрх олгох шалгуурт хүний эрхийн мэдлэг, хандлагыг тодорхойлох үзүүлэлтүүдийг тусгах; (2008)

Бакалаврын боловсрол олгох стандартад төгсөгч нь хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, иргэний ардчилсан ёсны суурийг бүрдүүлэгч үнэ цэнэтэй зүйлсийг мэддэг, бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй ханддаг, өөртөө болон бусдын өмнө хариуцлага хүлээх чадвартай, харилцааны соёлтой, бүтээлчээр тасралтгүй бие дааж суралцах чадвар эзэмшсэн байхаар тусгагдсан нь хичээл нэг бүрээр болон хөтөлбөрөөр хүний эрхийн боловсролыг төлөвшүүлэх, шүүмжлэлт сэтгэлгээ, асуудал шийдвэрлэхэд хүчирхийллийн бус арга замыг сонгох чадварыг эзэмшүүлэх суурь болж байна. 2009 онд баталсан “Ерөнхий боловсролын багш бэлтгэх хөтөлбөр”-ийн стандартад төгсөгч нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай конвенцид тусгагдсан суралцагчдын эрх, эрх чөлөөг хангахад шаардлагатай суурь мэдлэгтэй байхаар

тусгасан байна. Энэ нь ерөнхий боловсролын сургуулийн багш бэлтгэх агуулгад хүний эрхийн боловсрол олгох асуудал тодорхой байр суурь эзлэхээр байна.

Төрийн болон төрийн бус зарим их, дээд сургуулиудын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэж байгаа үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээг авч үзвэл Цагдаагийн Академи 2007 онд цагдаагийн мэргэжлийн (анхан шат) сургалтад бүрэн дунд боловсролтой иргэнийг элсүүлэн 3 сарын хугацаатай сургалт явуулж байсныг өөрчлөн, хугацааг 6 сар болгон уртасгаж, сургалтын стандартад “Хүний эрх ба цагдаа” хичээлийг тусгай хичээл байхаар батлуулсан бөгөөд 2010 оны 7 дугаар сар хүртэлх хугацаанд цагдаагийн мэргэжлийн сургалтад нийт 600 гаруй сонсогчид хамрагдсан байна.¹⁵⁹

Бакалаврын зэрэглэлийн хувьд, тус академийн бакалаврын зэрэглэлийн 6 мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд Үндсэн хуулийн эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, Захиргааны процесс, Иргэний эрх зүйн процесс, Цагдаагийн эрх зүй, Цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгсэл зэрэг суурь болон мэргэшүүлэх хичээлүүдийн агуулгад хүний эрхийг хангахад анхаарах асуудлыг тусгажээ. 2010 оны 7 дугаар сард Хүний эрх ба цагдаагийн ажил, Хүний эрх ба шийдвэр гүйцэтгэлийн ажил, Шүүх шинжилгээ ба хүний эрх, Хүний эрх ба дотоодын цэргийн ажил, Хүний эрх ба онцгой байдлын байгууллагын ажил хичээлийг тус бүр 2 кредит 32 цагийн агуулга, багтаамжтай байхаар тусган батлуулж, 2010-2011 оны хичээлийн жилээс эхлэн сургалт явуулж эхэлсэн нь суралцагчдад ажиллах, албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэхдээ хүний эрхийг хангах, хамгаалах асуудлыг тусгай хөтөлбөрөөр заах боломжийг бүрдүүлсэн, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамнаас баталсан хөтөлбөрийн дагуу хүний эрхийн боловсрол олгох сургалтад ахиц гарсан гэж үзэж байна.

Батлан Хамгаалах Их Сургуулийн хувьд, Цэргийн командын сургуулийн Төрийн захиргаа, эрх зүйн тэнхимийн 2, 3 дугаар дамжаануудын сургалтын хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж, хүний эрх хичээлийг тус бүр 2 кредит цагаар тооцон заавал судлах хичээл болгон оруулж, сүүлийн 2 жилийн хугацаанд зааж байна. Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэдэг Батлан Хамгаалахын Удирдлагын Академийн сургалтад Эрх зүйн боловсрол хичээлийг оруулсан байна.

Мөн тус сургуулийн сургалтын агуулга, хөтөлбөр, хичээлийн цагийн багтаамжаас хамаарч, хүний эрх хичээлийг заавал судлах цэргийн ерөнхий эрдмийн хичээлд оруулахгүйгээр цэргийн эрх зүйн хичээлийн хүрээнд сонгон судлах хичээлээр тооцон хөтөлбөр төлөвлөгөөнд тусгасан нь бүх суралцагчдыг бүрэн хамарч чадахгүй байна.

¹⁵⁹ Цагдаагийн Академийн албан бичиг, 2010.11.22, №12/593.

Үндэсний Тагнуулын Академийн хувьд, бүх шатны сургалтад Хүний эрх хичээлийг заахаар хичээлийн хөтөлбөрт тусгаж, хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулан хэрэгжүүлж байна. Мөн Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан хүний эрхийн тулгамдаж буй асуудлаар Үндэсний Тагнуулын Академийн оюутан, сонсогч, багш нарын дунд уралдаан, тэмцээнийг жил бүр зохион байгуулж хэвшсэн байна.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн хувьд сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрүүдэд хүний эрх, хүүхдийн эрхийн талаарх ойлголт, агуулга, арга зүй хэрхэн тусгагдсан талаар дүн шинжилгээ хийхэд энэ талаарх үзэл санаа маш бага, өнгөц төдий, хүний эрхэд холбогдох ойлголт, мэдлэг, чадварыг ирээдүйн хүүхэд сургах багш нарт эзэмшүүлэх тал дээр цогц бодлогогүй байна. Мөн сургалтын төлөвлөгөөнд хүний эрхийн агуулгад шууд хамаарах курс хичээл байхгүй байна.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Хүний эрхийн боловсролын төвөөс жил бүр зохион байгуулдаг “Хүүхдийн эрхийн боловсрол” нэг өдрийн цуврал сургалтанд бүх оюутныг хамруулах боломжгүй. Мэргэжил дээшлүүлэх хичээлийн хөтөлбөр “Хүүхдийн эрхийн боловсрол”, “Хүчирхийлэлгүй сургууль” зэрэг модулийг сонгосон ч хичээл заах багш хангалтгүй байхаас гадна сургалтын хугацаа маш богино, нэгэн зэрэг заавал үзэх маш олон хичээлүүд ордог байна.

Багш мэргэжлийн багц хичээлийн хөтөлбөрүүд бусад хичээлийн хөтөлбөрүүдээс суралцагч төвтэй сургалтын арга барилд суурилсан явдал нь арай илүү хүний эрхийн мэдрэмжтэй боловсрогдсон байна гэж үзэх үндэслэл байна. “Багш боловсролын үндэс” хичээлийн хүүхэд, багш гэсэн модулиуд нь хүний эрхэд шууд хамаарах агуулгыг тусгаагүй ч, тодорхой сэдвүүд холбогдож байгаагаараа ач холбогдолтой.

Суралцагчийн сонгох эрх чөлөөг хэрхэн хангасан нь хүний эрхийн боловсрол олгоход ихээхэн чухал. Гэвч багшаа сонгох, хичээлээ сонгох боломж тун хомс байна. Сонгон суралцах хичээлүүдийг сонгохдоо хувь оюутны сонголтод тулгуурлалгүйгээр оюутны бүлгээр сонгуулах эсвэл өмнөөс нь багш, удирдлага сонгох явдал түгээмэл байгааг анхаарах нь зүйтэй байна. Үүний зэрэгцээ мэргэжлийн ёс зүйн асуудлаас гадна багшлах, эмчлэх зэрэг эрх олгох шалгуурт тусгайлан хүний эрхтэй холбоотой үзүүлэлтүүдийг тусгах шаардлагатай байна.

Зөвлөмж: Хүний эрхийн сургалтын гарын авлага, материал бусад хэрэглэгдэхүүнийг боловсруулах, сургагч багш нарыг бэлтгэх, тэдний мэргэжил, мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх ажлыг нэгдсэн бодлогоор зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; (2008)

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлж, боловсролын хүртээмж, чанарыг дээшлүүлэх зорилгоор “Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр”-ийг шинэчлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, "Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн сурах бичиг, дасгал ажлын ном"-д үнэлгээ хийж, сурах бичгүүдийг шинэчлэх чиглэлээр судалгаа явуулж, судалгааны үр дүнг үндэслэн 2009-2010 оны хичээлийн жилээс ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 1 дүгээр ангид тогтвортой мөрдөх үндсэн сурах бичгийн жагсаалтыг Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын 2009 оны 204 дүгээр тушаалаар баталжээ.

Ерөнхий боловсролын сургуулийн 7, 8, 9 дүгээр ангийн нийгмийн ухаан хичээлийн агуулгад "Хүний эрх" бүлэг сэдвийг тусган хүний эрхийн тухай ойлголтуудыг танин мэдэх, эрхээ эдлэх мэдлэг, чадвар олгох болон хүний эрхийг хангах, хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой мэдлэг, чадваруудыг эзэмшүүлэхээр сургалтын хөтөлбөрт нарийвчлан тусгаж, 7, 8 дугаар ангийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжийг боловсруулж, хичээл заах багш нарт түгээжээ. Нийгмийн ухаан хичээлийн 8 дугаар ангийн сурах бичиг боловсруулан хэвлэн тарааж, 9 дүгээр ангийн сурах бичиг боловсруулах ажил хийгдэж эхэлсэн байна.

Үүний зэрэгцээ үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа төслийн хүрээнд олон төрлийн гарын авлага, ном хэвлэгдсэнээс ялангуяа хүн худалдаалах гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон төрлийн бүтээл олны хүртээл болсон ч тогтсон стандарт байхгүй, орчуулгын шинжтэй, тайлбар толь хэлбэрийн мэдээлэл бүхий гарын авлагууд байгаа нь нэгдсэн бодлого дутмаг байгааг харуулж байна.

Сургуулиудыг зөвхөн сурах бичгээр хангаад зогсохгүй багш, сурагчид хүний эрхийн мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд шаардлагатай сонин, сэтгүүл, гарын авлага, материалаар хангах нь чухал байна. Түүнчлэн төвийн болон орон нутгийн түвшинд ажлын байрандаа багш нар хөгжих, өөрийгөө боловсруулахад анхаарал хандуулж, алсын зайн болон цахим сургалтын тохиромжит хэлбэрийг сонгон, насан туршид суралцах үйл явцыг дэмжих шаардлагатай байна.

Зөвлөмж: Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгох талаарх иргэний нийгмийн байгууллагуудын санаачлагыг дэмжих, урамшуулах, хамтран ажиллах; (2008)

Олон нийтэд болон төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдад хүний эрхийн боловсрол олгохоор иргэний нийгмийн байгууллагууд ихэвчлэн олон улсын болон гадаад орны төсөл, хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Хүний эрхийн боловсрол олгох чиглэлээр Эмнести Интернэшнл, Хүний Эрх, Хөгжил Төв, Хүйсийн Тэгш Эрхийн Төв, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, Хүүхдийн Хөдөлмөрийн Эсрэг Үндэсний Сүлжээ, Экпат үндэсний сүлжээ зэрэг төрийн бус байгууллагууд, тэдгээрийн сүлжээнүүд тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа боловч ийм үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагыг Засгийн газраас дэмжих, урамшуулах, хамтран ажиллах явдал хангалтгүй байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний Монгол Улс дахь төрөлжсөн байгууллага, гадаад улсын хөгжлийн агентлаг, гадаад улсын Хүний эрхийн үндэсний байгууллага, салбар салбарт мэргэшсэн үндэсний төрийн бус байгууллагууд, тэдгээрийн сүлжээ, хууль хяналтын болон мэргэжлийн төрийн байгууллагууд, АЙФО, Хүүхдийг Ивээх Сан, Эмнести Интернэшнл, Канад Сан, Дэлхийн Зөн зэрэг олон улсын, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо зэрэг үндэсний төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурлан, хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх ажил зохион байгуулж байна. Шүүх, прокурор, цагдаа, мөрдөн байцаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч зэрэг төрийн албан хаагчдаас гадна хүүхэд, сурагч, оюутан, иргэд, хөгжлийн бэрхшээлтэй болон бэлгийн ижил чиг баримжаатай хүмүүс гэх зэрэг зорилтот бүлгүүдэд зориулсан үндэсний, бүсчилсэн, орон нутгийн түвшний сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг уулзалт, ярилцлага, зөвлөгөөн, семинар, лекц, онол практикийн бага хурлын хэлбэрээр нөөц бололцоондоо тулгуурлан явуулж байна.

Сургалтын багийн бүрэлдэхүүнийг мэргэжлээрээ олон жил ажилласан дадлага туршлагатай, нэр хүнд бүхий шүүгч, прокурор, их, дээд сургуулийн багш, доктор, профессор зэрэг хүмүүсээр бүрдүүлэхээс гадна олон улсын түвшний зөвлөх, мэргэжилтэнтэй хамтран ажиллаж байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс 2008-2010 оны байдлаар хүний эрхийн боловсролд түлхүү анхаарч, жилд дунджаар 2 340 хүнийг танхимын сургалтад хамруулсан ба цаг хугацаа, орон зайны хувьд алслагдмал нөхцөл байдлыг арилгах, орон нутгаас олон хүнийг хамруулах зорилгоор 2011 оноос онлайн сургалтыг нэвтрүүлэхээр судалж байна.

Орон нутагт зохион байгуулсан сургалтын үйл ажиллагааны бүх зардлыг гол төлөв хүсэлт тавьсан тухайн байгууллага, эсвэл олон улсын санхүүжүүлэгч байгууллагаас гаргаж, сургалтын цаг хугацаа, оролцоо нь бүх нийтийг хамарч чадахгүй хязгаарлагдмал байдаг нь Хүний эрхийн үндэсний байгууллагын үйл ажиллагаагаа явуулах хангалттай зардлыг төсөвлөдөггүйтэй шууд холбоотой.

Комиссын зүгээс дээрх нөхцөл байдлыг арилгахын тулд Цагдаагийн Ерөнхий Газар, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар, Авлигатай Тэмцэх Газар,

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, Зэвсэгт Хүчний Жанжин Штаб, Хил Хамгаалах Ерөнхий Газар зэрэг байгууллагатай санамж бичиг байгуулах замаар хамтын ажиллагааг тодорхойлж, сургалт, судалгаа, нөлөөллийн үйл ажиллагаанд Комиссын дэргэдэх Орон тооны бус зөвлөлийн гишүүд, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг хамруулан ажиллаж байна. Санамж бичиг байгуулсан бүх байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулсан сургалтыг тусгай төлөвлөгөөний дагуу хийж байна.

ДҮГНЭЛТ

Хүний эрхийн Үндэсний Комисс нийт 9 илтгэл бичиж, Улсын Их Хуралд өргөн барьжээ.

Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх анхны илтгэлийг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг үнэлэх зорилгоор улс орны хэмжээнд явуулсан суурь судалгааны үр дүнг нэгтгэж, Үндсэн хуулиар баталгаажсан эрх, эрх чөлөөний бүх асуудлаар бичсэн юм. Удаах илтгэлүүдийг хүний эрхийн анхаарал татсан асуудлууд, тодорхой бүлгийн эрхийн хэрэгжилтийн талаар тусгаж, сэдэвчилсэн байдлаар бичсэн билээ.

Улсын Их Хурал 2006 оны илтгэлийг нэгдсэн чуулганаар, 2003, 2007, 2008, 2009 оны илтгэлүүдийг Хууль Зүйн Байнгын Хорооны хуралдаанаар тус тус хэлэлцэн тогтоол гаргаж, 4 илтгэлийг ямар нэг байдлаар хэлэлцээгүй болно.

Комиссын илтгэлд тусгагдсан дүгнэлт, санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газар, холбогдох байгууллагууд зарим арга хэмжээ авч, хүний эрхийн төлөв байдалд нааштай ахиц өөрчлөлт гарчээ. Гэхдээ Комиссын илтгэлд тусгагдсан санал, зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 9 илтгэлийн 143 санал зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож үзэхэд санал, зөвлөмжийн 41 нь буюу 28.6 хувь нь бүрэн, 45 нь буюу 31.4 хувь нь хагас хэрэгжиж, 57 нь буюу 39.6 хувь нь хэрэгжээгүй байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн талаарх 10 дахь илтгэлтэй холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2-т заасны дагуу дараах санал, зөвлөмжийг гаргаж байна.

1. Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлд тусгагдсан санал, зөвлөмжүүдээс хэрэгжээгүй болон хагас биелэлттэй байгаа санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг яаралтай авах;
2. Хүний эрхийн конвенцийн биелэлтийн талаарх Засгийн газрын илтгэлд өгсөн зөвлөмж, Хүний эрхийн Үндэсний Комиссын хүний эрх, эрх чөлөөний илтгэлд дурдсан зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүр төсвийн тухай хуульд бололцоогоороо тусгаж байх;
3. Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэрийг шүүх гаргахдаа Улсын Дээд Шүүхийн хуульд харшилсан тайлбарын заалтыг

хэрэглэсээр байгаа практикийг таслан зогсоох. Ер нь Улсын Дээд Шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж мөрдөх Үндсэн хуулийн заалт байгаа боловч эрх зүйн маргааныг эцэслэн шийдвэрлэдэг бүх шатны шүүх зөвхөн тайлбараа баримталдаг практик тогтсон учраас энэ талаар Улсын Их Хурал эрх зүйн шинэ журам тогтоох шаардлагатай байна.

4. “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”-ийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын анхдугаар илтгэлийг 2010 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 45 дугаар хуралдаанаар хэлэлцэн гаргасан “Ял завших явдлыг зогсоож, эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах явдал гаргасан төрийн албан хаагчийг буруушааж, ийм үйлдэл хийсэн хэнийг ч бай мөрдөн шалгаж, шаардлагатай бол яллах, шүүх, үйлдсэн гэмт хэргийнх нь хүнд, хөнгөнд нь таарсан ял ногдуулж байхыг Оролцогч улсаас хүсч байна. Оролцогч улс нь эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах явдал гаргагчдыг ял завшихаас сэргийлэх үүднээс үр дүнтэй, хараат бус мөрдөн шалгах механизм байгуулах хэрэгтэй байна. Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт “Заавал биелүүлэх тушаал, захирамжийг биелүүлэхдээ энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй” гэж заасныг нэн даруй хүчингүй болгох шаардлагатай. Дээд шатны албан тушаалтны тушаал Эрүүдэн шүүх аливаа үйлдлийг зөвтгөх шалтаг болохгүй гэсэн агуулгаар Оролцогч улс хууль тогтоомжоо өөрчлөх нь зүйтэй.” гэсэн зөвлөмжийг ойрын хугацаанд хэрэгжүүлэх;
5. Үндсэн Хуулийн Цэц 2011 оны 1 дүгээр сард Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт “Санал хураалтын дүнгийн талаар маргаан гарвал санал хураалт явуулсан өдрөөс хойш тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэнэ” гэснийг “эцэслэн” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14 дахь хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ...” гэж заасныг зөрчсөн байна гэж үзээд Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийн заалтаас “эцэслэн” гэснийг тогтоол гарган хүчингүй болгожээ. Монгол Улсын Их Хурлын 2008 оны сонгууль, нэг жилийн дараа болсон нөхөн сонгуулийн дүнгийн талаар нилээд маргаан гарч зарим иргэд өргөдөл гаргаж байсан боловч хуулийн дээрх заалтаас шалтгаалан Үндсэн Хуулийн Цэц болон аль ч шатны шүүх нэг ч хэргийг харьяалан шийдвэрлээгүй байна. Сонгуулийн маргаан шүүхэд эцэслэн шийдвэрлэдэг журмыг сонгуулийн хуулиудад тусгах;
6. Хуулиар тогтоосон наснаас бага насны хүүхдээр хурдан морь унуулсан, даатгалд хамруулаагүй, хамгаалалтын хувцас хэрэгсэл өмсүүлээгүй бол буруутай этгээдийг захиргааны журмаар торгууль ногдуулдаг, дээрх шаардлагыг хангаагүйн

улмаас хүүхдийн биед гэмтэл учирсан, амь нас нь хохирсон бол гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг эрх зүйн зохицуулалт бий болгох;

7. Замын цагдаагийн газрын урд байрлах Төмөр замын 406 дугаар километрийн авто гармын ойролцоо орон сууцны хороолол, үйлчилгээний олон барилга байгууламж баригдаж, Толгойт орчимд байрлах 396 дугаар километрийн авто гармаар нийслэлээс баруун тийш явдаг авто зам гардгаас нэвтрэн өнгөрөх авто машины урсгал, ачаалал ихсэж, жолооч, зорчигчдыг удаан хугацаагаар байнга хүлээлгэн чирэгдүүлж, замын түгжрэл үүсгэн, төмөр зам, авто замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, улмаар иргэдийн амь нас, эрүүл мэндэд аюул учирч болзошгүй байдал бий болсон учраас эдгээр гарам дээр 2 түвшинд огтлолцох автомашины гүүр барих асуудлыг нэн даруй шийдвэрлэх;

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИАС

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

Арван дөрөвдүгээр зүйл

1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

Арван тавдугаар зүйл

1. Монгол Улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно.

2. Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно.

Арван зургадугаар зүйл

Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

1/ амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно;

2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;

3/ хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;

4/ ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;

5/ өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;

6/ эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно;

7/ сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;

8/ соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;

9/ шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно.

10/ нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;

11/ улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;

12/ төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;

13/ халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;

14/ Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх

ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;

15/ шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй;

16/ итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;

17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;

18/ улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.

Арван долдугаар зүйл

1. Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ:

- 1/ Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;
- 2/ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
- 3/ хуулиар ногдуулсан албан татвар төлөх;
- 4/ эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах.

2. Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.

Арван наймдугаар зүйл

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно.

2. Монгол Улс олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална.

3. Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалалгүй хүний эрх, үүргийг өөрийн хуулиар тогтооно.

4. Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно.

5. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болно.

Арван есдүгээр зүйл

1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

2. Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.

3. Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.

ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

№	НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДСЭН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ	Батлагд сан огноо	Нэгдэн орсон буюу соёрхон баталсан огноо
1.	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	1948	
2.	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт	1966	1974
3.	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол	2008	2010
4.	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	1966	1974
5.	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын I нэмэлт протокол	1966	1991
6.	Цаазаар авах ялыг устгахад чиглэсэн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын II нэмэлт протокол	1989	-
7.	Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц	1966	1969 1969 ¹⁶⁰
8.	Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	1979	1980 1981
9.	Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт оруулсан нэмэлт өөрчлөлт	1995	1997 1997
10.	Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протокол	1999	2001 2002
11.	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц	1984	2000 2002
12.	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протокол	2006	-
13.	Хүүхдийн эрхийн тухай конвенц	1989	1990 1990
14.	Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 43 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулах нэмэлт өөрчлөлт	1995	1997 1997
15.	Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол	2000	2002 2004

¹⁶⁰ Тухайн баримт бичиг Монгол Улсын хувьд хүчин төгөлдөр болсон талаар холбогдох байгууллагаас мэдэгдсэн огноо

16.	Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчилахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол	2000	2003 2003
17.	Цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн бүх гишүүдийг хамгаалах тухай конвенц	1990	-
18.	Хүчээр сураггүй алга болохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенц	2006	2007 ¹⁶¹
19.	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц	2006	2008 2009
20.	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол	2006	2008 2009
ХҮНИЙ ЭРХИЙН БУСАД ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ			
21.	Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц	1948	1966 1967
22.	Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц	1951	-
23.	Боловсролын талаар алагчилахтай тэмцэх тухай конвенц	1960	1964
24.	Дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үл хэрэглэх тухай конвенц	1968	1969
25.	Апартеидийн гэмт хэргийг таслан зогсоох, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай олон улсын конвенц	1973	1975 1975
26.	Спортод апартеид бодлого явуулахын эсрэг олон улсын конвенц	1985	1987 1987
27.	Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай конвенц	1962	1991
28.	Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц	1993	1998
ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦУУД			
39.	Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай 59 дүгээр конвенц	1937	1969
30.	Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай 87 дугаар конвенц	1948	1969
31.	Зохион байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай 98 дугаар конвенц	1949	1969
32.	Тэгш шан хөлс олгох тухай 100 дугаар конвенц, түүний 90 дүгээр зөвлөмж	1951	1969 1970
33.	Эхчүүдийг хамгаалах тухай 103 дугаар конвенц	1952	1969 1970
34.	Алагчилахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай 111 дүгээр конвенц, (түүний 111 дүгээр зөвлөмж)	1958	1969 1970
35.	Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай 122 дугаар конвенц, (түүний 122 дугаар зөвлөмж)	1964	1976
36.	Газар доор буюу уурхайд ажиллагсадын насны доод	1965	1981

¹⁶¹ Тус гэрээнд гарын үсэг зурсан.

	хязгаарын тухай 123 дугаар конвенц		
37.	Үйлдвэрийн газарт ажилчдын төлөөлөгчдийн эрхийг хамгаалах болон тэдэнд олгогдох бололцооны тухай 135 дугаар конвенц, (түүний 143 дугаар зөвлөмж)	1971	1995
38.	Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт зөвлөлдөөний тухай 144 дүгээр конвенц, (түүний 152 дугаар зөвлөмж)	1976	1998
39.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 155 дугаар конвенц, (түүний 164 дүгээр зөвлөмж)	1981	1998
40.	Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дүгээр конвенц, (түүний 168 дугаар зөвлөмж)	1983	1998
41.	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай 182 дугаар конвенц	1999	2000
42.	Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенц, (түүний 146 дугаар зөвлөмж)	1973	2002 2002
43.	Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц	1930	2005
44.	Албадан хөдөлмөрийн тухай 105 дугаар конвенц	1957	2005
45.	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Дүрэмд оруулсан Нэмэлт өөрчлөлт	1997	2010
ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙ			
46.	Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан, өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн (I) Конвенц	1949	1958
47.	Тэнгисийн зэвсэгт хүчний шархтан, өвчтэн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийн нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн (II) Конвенц	1949	1958
48.	Дайнд олзлогдогчидтой харьцах тухай Женевийн (III) Конвенц	1949	1958
49.	Дайны үед энгийн хүмүүсийг хамгаалах тухай (IV) Конвенц	1949	1958
50.	Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай Конвенц	1954	1964
51.	Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсэдийг хамгаалах тухай 1949 оны Женевийн конвенцын 1977 Нэмэлт 1 дүгээр протокол	1977	1995
52.	Олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсэдийг хамгаалах тухай 1949 оны Женевийн конвенцуудын нэмэлт 2 дугаар протокол	1977	1995